



Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс

ХҮНИЙ ЭРХ

ОНОЛ, АРГА ЗҮЙН СЭТГҮҮЛ

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

“Хүний эрх, эрх чөлөөг орон даяар,
цаг ямагт, хүн бүрт”
[15 дахь жилдээ]

2016/01

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс

ХҮНИЙ ЭРХ

Онол, арга зүйн сэтгүүл

“Хүний эрх, эрх чөлөөг орон даяар,
цаг ямагт, хүн бүрт”

(15 дахь жилдээ)

2016/01

ДАА 331
ННА 65
Х-828

ХҮНИЙ ЭРХ сэтгүүл
2016/01(47)
Улсын бүртгэлийн дугаар 244
15 дахь жилдээ

П.Оюунчимэг Ерөнхий редактор (Монгол Улсын Хүний эрхийн
Үндэсний Комиссын гишүүн)

Ц.Адъяахишиг Хариуцлагатай нарийн бичгийн дарга (Монгол Улсын
Хүний эрхийн Үндэсний Комиссын ахлах референт)

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

© Сэтгүүлд нийтлэгдсэн бүтээл нь Хүний эрхийн
Үндэсний Комиссын бодлогыг илэрхийлэхгүй,
зөвхөн зохиогчийн үзэл бодол болно.

ISBN 978-99973-43-86-4

АГУУЛГА

**“ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА ЗҮТГЭСЭН ОН ЖИЛҮҮД”
ОНОЛ, ПРАКТИКИЙН БАГА ХУРЛЫН ИЛТГЭЛ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН МЭНДЧИЛГЭЭ.....	4
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН ИЛГЭЭЛТ.....	5
<i>Ж.Бямбадорж</i> Хүний эрхийн төлөө хамтдаа зүтгэсэн 15 жил.....	7
<i>О.Мөнхсайхан</i> Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан үндсэн эрхийн хүрээг тодорхойлох нь....	13
<i>Ж.Баярцэцэг</i> Хүний эрх, эрх чөлөөг хангах эрх зүйн шинэтгэлийн бодлого, түүний хэрэгжилт.....	23
<i>Н.Гантулга</i> Хорих ял эдлүүлэх тогтолцооны парадигм.....	28
<i>Г.Уранцоож</i> Иргэний нийгмийн байгууллага ба хүний эрхийн үндэсний байгууллагын хамтын ажиллагааны үр нөлөө, түүнийг сайжруулах нь: Олон улсын туршлага.....	38
ӨГҮҮЛЭЛ, НИЙТЛЭЛ	
<i>С.Цэрэндорж</i> Хүний эрхийн үндэсний байгууллага: Тавигдах шаардлага, чиг үүрэг.....	41
<i>Ц.Мөнхбат</i> Албадан ажил хийлгэх ял ба нийтэд тустай ажил хийлгэх ялыг харьцуулан судлах нь....	49
<i>Б.Болорсайхан</i> Хүний эрхийн үндэсний байгууллагын цаашдын төлөв.....	53
<i>С.Ганцэцэг,</i> Хөдөлмөрийн эрх зүйн зохицуулалтын хэлбэрүүдийг зөв хэрэглэх нь.....	62
<i>Б.Цэнгэл</i> Иргэний давхар харьяаллын харьцуулсан судалгаа.....	67
МОНГОЛ ХЭЛЭЭР ЗӨВХӨН МАНАЙ ХУУДАСНАА	
<i>Бригит Төүбэс</i> Хүний эрх ба нийтийн эрүүл мэнд: Тэнцвэртэй харилцааг хангахыг зорих нь.....	79
ЗОЧНЫ ЯРИА	
<i>Г.Далайжамц</i> Иргэд хүний эрхийг тунхаг хэмээн боддог байлаа.....	98
<i>Шазира Завави</i> Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний байгууллага эрх чөлөө нь хязгаарлагдсан хүн бүрт хүрч ажилладаг.....	104

**“ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА ЗҮТГЭСЭН ОН ЖИЛҮҮД”
ОНОЛ, ПРАКТИКИЙН БАГА ХУРЛЫН ИЛТГЭЛ****МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН МЭНДЧИЛГЭЭ**

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс байгуулагдсаны 15 жилийн ойд

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын ажилтан, албан хаагчид Та бүхэнд Монгол Улсад Хүний эрхийн Үндэсний Комисс байгуулагдсаны 15 жилийн ойн баярын мэндчилгээ хүргэж, ажлын их амжилт хүсэн ерөөе.

Монголчууд 1990 оны Ардчилсан хувьсгалын үр дүнд шинэ Үндсэн хуулиа баталж, Монгол Улсад хүний эрхийг олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн жишигт нийцүүлэн анх удаа томьёолж, түүний хэрэгжилтийг хангах нь төрийн нэн тэргүүний үүрэг гэдгийг тодорхойлсон билээ. Бид Үндсэн хуулиа баталснаас хойш нийгэм, улс төр, эдийн засаг, эрх зүйн орчноо суурь хуулийн үзэл санаа, зарчимд нийцүүлэн бүрэн хэмжээгээр өөрчлөн, шинэчилж чадсан билээ.

Хүний эрхийн Үндэсний Комисс нь Үндсэн хууль, бусад хууль, олон улсын гэрээ, конвенцид заасан хүний эрх, эрх чөлөөний тухай заалтын хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг сахин хамгаалах, хөхиүлэн дэмжих үүргээ зохих ёсоор биелүүлэн, хүний эрхийн төлөөх үйл ажиллагааны тэргүүн эгнээнд зогсох хараат бус, бие даасан байгууллага болон ажиллаж байгааг энэ мөчид тэмдэглэх нь зүйтэй.

Өнгөрсөн хугацаанд нийгэм, улс төр, эдийн засгийн салбарт хүний эрхийн төлөө олон тэмцэл, хөдөлгөөн өрнөснийг эргэн харахад хүний эрхийн тухай ойлголт манай иргэдийн тэмцлийн дуу хоолой болж өргөжсөнийг харуулж байна. Хүний эрхийг хангах, эрх тэгш байдлыг шаардах нь цаашид ч төрөөс анхаарах гол асуудал хэвээр байх болно.

Хүний эрхийн ойлголт хэрхэн хөгжсөөр байгааг ухамсарлан ухаарах нь хүний эрх зогсонги зүйл биш, харин ч байнга хөгжин өөрчлөгдөж, хөдөлгөөнд оршдог зүйл гэдгийг ойлгоход ихээхэн ач холбогдолтой. Хүний эрх нь бүх хүмүүсийн хувьд үүрд тодорхойлогдон зурагдсан зүйл биш, хүн гэдэг үнэт зүйлийн мөн чанарт юуг эрхэмлэх ёстойг тодорхойлоход нийгмийн оролцоо, харилцан яриа хэлэлцүүлэг байнга шаардагддаг үргэлжийн үйл явц мөн.

Иймийн тул хүн бүр эрхээ баталгаатай эдлэх, хүний эрхэм чанараа хүлээн зөвшөөрүүлэх, цаашлаад Монгол Улсад хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгмийг цогцлоон хөгжүүлэхийн төлөөх үйл хэрэгт иргэд, төр ялгаагүй адил тэгш үүрэг, хариуцлагатай байх нөхцөл бололцоог бий болгоход Хүний эрхийн Үндэсний Комисс чухал үүрэг гүйцэтгэнэ гэдэгт итгэж байна.

Та бүхний хүний эрх, эрх чөлөөг хамгаалах их үйл хэрэгт нь амжилт хүсье!

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

2016 оны 02 дугаар сарын 01-ний өдөр
Улаанбаатар хот

ИЛГЭЭЛТ

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС БАЙГУУЛАГДСАНЫ 15 ЖИЛИЙН ОЙД ЗОРИУЛСАН ОНОЛ ПРАКТИКИЙН ХУРАЛД ОРОЛЦОГЧДОД

Монгол Улсын Их Хурал 2000 оны 12 дугаар сарын 7-ны өдөр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийг баталж, УИХ-ын 2001 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 1 тоот тогтоолоор Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, гишүүдийг томилсноор Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс байгуулагдсан билээ.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 3.1-д заасанчлан “Комисс нь Монгол Улсын Үндсэн Хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний тухай заалтын хэрэгжилтэнд хяналт тавьж, хүний эрхийг сахин хамгаалах, хөхиүлэн дэмжих байгууллага” юм.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс үүсгэн байгуулагдсанаас хойш энэхүү 15 жилийн хугацаанд хуулиар хүлээсэн чиг үүргээ бүрэн биелүүлж, хараат бус, бие даан үйл ажиллагаа явуулдаг, үндэсний байгууллага болон төлөвшиж чаджээ. Хүний эрхийн Үндэсний Комисс нь хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцооны гол цөм болон ажиллаж байгааг энд сайшаан тэмдэглэж байна.

Энэхүү 15 жилийн хугацаанд Хүний эрхийн Үндэсний Комисс нь олон улсын болон бүс нутгийн хүний эрхийг хамгаалах тогтолцооны хүрээнд амжилттай хамтран ажиллаж байна. Тухайлбал, Хүний эрхийн Үндэсний Комисс нь байгуулагдсан цагаасаа эхлэн Хүний эрхийн үндэсний байгууллагуудын олон улсын зохицуулах хорооноос гурван удаа “А” статустай магадлан итгэмжлэгдсэний зэрэгцээ тус хорооны шийдвэр гаргах үндсэн бүтэц болох Товчооны гишүүнээр сонгогдсон, 2015 оны 8 дугаар сараас эхлэн Ази, Номхон Далайн бүс нутгийн Хүний эрхийн үндэсний байгууллагуудын чуулганыг даргалан ажиллаж байгаа зэрэг олон улсын тавцанд гарч буй ажил хэргийн харилцаа, нэр хүндийг энд онцлон хэлэхийг хүсэж байна.

Тиймээс ч НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссар асан хатагтай Нави Пиллай “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс нь үүсэн байгуулагдсанаас эхлэн 13 жилийн турш “А” үнэлгээтэй ажиллаж буй нь хүний эрхийн үндэсний байгууллагуудын хувьд том амжилт” хэмээн 2013 онд цохон тэмдэглэсэн байдаг.

Монгол Улсын Их Хурлын хувьд хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцийг Монгол Улс соёрхон батлах, хэрэгжүүлэх санаачлагыг тууштай дэмжин ажилладаг бөгөөд энэ хүрээнд 2008 онд Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцийн нэмэлт протокол болох Хүн, ялангуяа эмэгтэйчүүд болон хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ба шийтгэх тухай протокол, 2009 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц, 2012 онд Иргэний болон улс төрийн эрхийн тухай пактын нэмэлт II протокол, 2013 онд Хүүхдийн эрхийн тухай конвенцийн нэмэлт III протокол, 2014 онд Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцийн нэмэлт протоколыг тус тус соёрхон баталсан байна. Энэ нь хүний эрхийн олон улсын эрх зүйн хэм хэмжээг Монгол Улсад даган мөрдөх, олон улсын хүний эрхийн хөгжил дэвшилтэй хөл нийлүүлэн урагшлахад чиглэсэн бодлогын үндсэн дэвшил гэж харж байна.

Монгол Улсын Их Хурал нь байнгын хороо зэрэг өөрийн үндсэн бүтцээрээ дамжуулан Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын илтгэлийг хэлэлцэж, хүний эрхийг

хангахад чиглэсэн бодлого, хөтөлбөрийг боловсруулж, зохих шийдвэр гарган ажиллаж байна.

Мөн Улсын Их Хурлын тогтоолын дагуу 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн аймаг бүрт Хүний эрхийн Үндэсний Комиссын ахлах мэргэжилтнийг ажиллуулах болсон нь хүний эрхийн байгууллага үндэсний хэмжээнд үйл ажиллагаагаа хараат бусаар явуулах, хөдөөгийн ард иргэдэд хүрч үйлчлэхэд гарсан чухал алхам болсон.

Хүний эрхийн Үндэсний Комисс байгуулагдсаны 15 жилийн ойг тохиолдуулан “Хүний эрхийн төлөө хамтдаа зүтгэсэн 15 жил” онол, практикийн хурал зохион байгуулж, хамтран ажиллагч төр, төрийн бус байгууллага, хүний эрхийн хамгаалагчид, идэвхтнүүдийн хамт өөрийн амжилт, алдаа дутагдлаа дүгнэн хэлэлцэж байгааг сайшаахын хамт цаашид Монгол Улсад хүний эрх, эрх чөлөөг сахин хамгаалах үндэсний тогтолцоог бэхжүүлэх талаар олон чухал асуудлыг хөндөн, цаашдын хөгжил, төлөвлөлтөнд тусган зохих үр дүнд хүрнэ хэмээн найдаж байна.

“Хүний эрхийн төлөө хамтдаа зүтгэсэн 15 жил” онол, практикийн хурлын оролцогчид Та бүхэнд болон хүний эрхийг сахин хамгаалах хуулиар хүлээсэн үүргээ чин шударгаар биелүүлэхийн төлөө мэдлэг, хөдөлмөр зүтгэлээ зориулж буй Комиссын үе үеийн дарга, гишүүд, ажилтнуудад баяр хүргэж, ажлын амжилт хүсэн ерөөе!

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**ЗАНДААХҮҮГИЙН
ЭНХБОЛД**

2016 оны 02 дугаар сарын 01-ний өдөр
Улаанбаатар хот

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА ЗҮТГЭСЭН 15 ЖИЛ



Монгол Улсын Хүний эрхийн
Үндэсний Комиссын дарга,
Хууль зүйн ухааны доктор, профессор,
Монгол Улсын гавьяат хууль

Ж.БЯМБАДОРЖ

Эрхэм хүндэт зочид оо,
ХЭҮК-т ажиллаж байсан, одоо ажиллаж
буй дарга, гишүүд, ажилтнуудаа
Эрхэм хүндэт хагагтай, ноёдоо

Та бүхэндээ хүний эрхийн төлөө хамтдаа
зүтгэсэн амжилт, дурсамж дүүрэн арван
таван жилийн ойн баярын мэнд дэвшүүлж,
сайн сайхныг хүсэн ерөөе.

Эх орондоо хүний эрх, эрх чөлөөг
хамгаалах, хөхиүлэн дэмжих их үйл хэргийн
төлөө зүтгэж ирсэн үе үеийн дарга, гишүүд,
ажилтнуудынхаа итгэл сэтгэл, хүчин
чармайлтаар Монгол Улсын Хүний эрхийн
Үндэсний Комисс хараат бус, бие даасан үйл
ажиллагаатай, Монгол Улсын төр, нийгмийн
тогтолцоонд онцгой байр суурь эзэлсэн,
иргэддээ хүлээн зөвшөөрөгдсөн, олон улсад
нөлөө бүхий үндэсний байгууллага болж
чадлаа.

Бид Монгол Улсын төрийн бүх шатны
байгууллага, хэвлэл мэдээлэл, иргэний
нийгмийн байгууллага, түүнчлэн Нэгдсэн
Үндэстний Байгууллагын Хүний эрхийн
дээд комиссарын газар, Хөгжлийн хөтөлбөр,
Хүүхдийн сан, Хүний эрхийн үндэсний
байгууллагуудын Олон улсын зохицуулах

хороо, Ази Номхон далайн бүсийн орнуудын
хүний эрхийн үндэсний байгууллагуудын
чуулган зэрэг олон улсын байгууллага,
гадаад орнуудын засгийн газрын хөгжлийн
агентлаг, дипломат төлөөлөгчдийн газрын
дэмжлэг, туслалцаа, хамтын ажиллагааны үр
дүнд сэтгэл хангалуун байгаагаа бахархан
тэмдэглэж байна.

Монгол Улсын Их Хурал 2000 оны 12
дугаар сарын 7-ны өдөр Монгол Улсын
Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай
хуулийг баталж, улмаар УИХ-ын 2001 оны 2
дугаар сарын 2-ны өдрийн I тоот тогтоолоор
Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга,
гишүүдийг томилсноор Монгол Улсын
Үндсэн Хууль, олон улсын гэрээнд заасан
хүний эрх, эрх чөлөөний тухай заалтын
хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг
сахин хамгаалах, хөхиүлэн дэмжих чиг
үүрэгтэй Монгол Улсын Хүний эрхийн
Үндэсний Комисс байгуулагдсан билээ.

ХЭҮК шиг бага бүтэцтэй, санхүү төсвийн
хувьд хязгаарлагдмал байгууллагын хувьд
чамлахааргүй ололт амжилттай ажиллаж
ирснээ, ажиллаж байгаагаа тоймлон хүргэе.
Өнөөдөр Монгол Улсын ХЭҮК-г чадавхтай,
мэргэшсэн, гар нийлсэн, хүний эрхийн өндөр

мэдрэмжтэй баг хамт олон ажиллаж байгаа юуны өмнө нүүр бардам хэлмээр байна.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний нөхцөл байдлыг харах толь бол Улсын Их Хуралд жил бүр өргөн барьдаг Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний илтгэл юм. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс 2002 оноос эхлэн өөрийн болон төрийн, иргэний нийгмийн, судалгааны зэрэг байгууллагын хийсэн судалгаа, хяналт шалгалт, хянан шийдвэрлэсэн гомдлын байдалд үндэслэн Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар 14 илтгэл боловсруулж, УИХ-д өргөн барьсан байна. Эдгээр илтгэлүүдэд хүний эрх, эрх чөлөөний талаарх бүх асуудлыг хамруулсан төдийгүй зарим асуудлыг тухайн үеийн нөхцөл байдал, шаардлагыг харгалзан хэд хэдэн удаа тусгаж байв. Монгол Улсын хүний эрхийн сүүлийн арван таван жилийн төлөв байдлыг мэдэхийг хүсвэл эдгээр илтгэлийг уншихад бүрэн хангалттай гэж хэлмээр байна. Илтгэлийг “Төрийн мэдээлэл” сэтгүүлд болон монгол, англи хэлээр тусгай товхимол болгон хэвлүүлж, гадаад дотоодын байгууллага, иргэд олон нийтэд түгээхийн хамт иргэний нийгмийн байгууллагуудад уулзалт хийж танилцуулдаг ажлыг уламжлал болголоо.

УИХ-д өргөн барьсан нийт 14 удаагийн илтгэлээс 1,3,4 дэх илтгэлийг огт хэлэлцээгүй, 5 дахь илтгэлийг УИХ-ын нэгдсэн чуулганы хуралдаанаар, бусдыг нь Хууль зүйн байнгын хороогоор гэхдээ 13, 14 дэх илтгэлийг нэгтгэн хэлэлцэж байжээ. Эдгээр 14 илтгэлд дурдсан хүний эрхийн тулгамдсан асуудлаар УИХ-аас шийдвэр гаргуулахаар нийт 278 санал, зөвлөмж хүргүүлж, зарим асуудлаар шийдвэр гаргуулжээ. Сүүлийн жилүүдэд Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороогоор илтгэлийг хэлэлцэж, зайлшгүй шаардлагатай олон заалт бүхий тогтоол гаргадаг болсон нь сайн талтай боловч Засгийн газар, төрийн холбогдох бусад байгууллага огт хэрэгжүүлэхгүй байна. Монгол Улсын Их Хурал Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийг хэлэлцэхдээ онцгой анхаарч,

хүний эрхийн нөхцөл байдлыг сайжруулах бодлого, эрх зүйн орчныг сайжруулах талаар эргэлт хийх цаг болсон гэж үзэж байна..

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс хүний эрхийн олон улсын гэрээг соёрхон батлах буюу түүнд нэгдэн орохыг дэмжихэд чиглэсэн олон чухал санал санаачлагыг гаргаж ирсний үр дүнд Монгол Улс хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой 40 орчим олон улсын гэрээнд нэгдэн орж, соёрхон баталсан байна. Энэ нь хүний эрхийн олон улсын эрх зүйн хэм хэмжээг Монгол Улсад даган мөрдөх Үндсэн хуульд тусгайлан заасан шинэ үндэслэл бөгөөд олон улсын хүний эрхийн хөгжилтэй хөл нийлүүлэн урагшлах нөхцөл бүрдүүлсэн бодлогын томоохон дэвшил юм. Харамсалтай нь төрийн байгууллага, ялангуяа 2008 онд Дээд шүүхээс Монгол Улсын олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай тогтоол баталсан ч хүний эрхийг хангах эрх зүйн гол баталгаа болсон шүүх өнөөг хүртэл тэр болгон нэг мөр хэрэглэхгүй байна.

Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн хуулийн заалт хүний эрхийн зарчимд хэрхэн нийцэж байгаа талаар Комиссоос санал авдаг болсоны дагуу “Хууль тогтоомж, бодлого шийдвэрийн төсөлд хүний эрхийн үүднээс дүн шинжилгээ хийх ажлын хэсэг” байгуулан, Улсын Их Хурлаар хэлэлцэх хууль, тогтоомжийн төслүүдтэй тухай бүр танилцан, 2013-2015 онд 58 хуулийн, түүнтэй уялдан гарах журмын төслүүдэд дүн шинжилгээ хийж, холбогдох саналыг хууль санаачлагчид хүргүүлээ.

Хүний эрхийг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх талаар ХЭҮК-оос явуулдаг үйл ажиллагааны нэг үндсэн хэсэг нь иргэдийн эрх, эрх чөлөө зөрчигдсөн талаарх гомдлыг хүлээн авч шийдвэрлэх ажиллагаа байдаг билээ. Гомдлыг цаасаар авдаг уламжлалт хэлбэрээс гадна иргэдэд нээлттэй, чирэгдэлгүй үйлчлэх зорилгоор www.mn-nhrс.org цахим хуудсаар, 7000-0222 дугаарын

суурин утас, “Хүний эрх” ухаалаг гар утасны аппликейшнаар дамжуулан, хүний эрх зөрчсөн гомдлыг цаг алдалгүй хүлээн авч байна. Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас 15 жилд 4378 гомдол хүлээн авч шийдвэрлэсэн ба жилд дунджаар 200 орчим гомдол хүлээн авч шийдвэрлэж байсан бол сүүлийн гурван жилд 645-710 болж даруй 3 дахин, хууль зүйн зөвлөлгөө, мэдээлэл авахаар хандсан иргэдийн тоо жилд дунджаар 200-400 орчим байснаа сүүлийн жилүүдэд жил тутам 1500 орчим болж өсчээ. Ийнхүү гомдол гаргасан, зөвлөгөө авсан хүний тоо эрс нэмэгдэж байгаа нь ард иргэдийн хүний эрхийн талаарх мэдлэг ойлголт нэмэгдсэн, манай Комиссын нэр хүнд өссөнийг харуулж байгаа юм. Мөн 2014 оноос эхлэн орон нутагт ахлах мэргэжилтнүүд ажиллах болсон зэргээс үүдэн иргэдээс гомдол, хууль зүйн зөвлөгөө өгөх байдал тооны хувьд ч, чанар хүртээмжийн хувьд ч тасралтгүй өсөж байна.

Комисс эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн 25 иргэнийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргасан бөгөөд шүүхээс нийт 441,753,172 төгрөгийн гэм хорын хохирлыг хангаж шийдвэрлэсэн байна. Ийнхүү хилс хэргийн улмаас хүний нэр төр, сэтгэл санаа, эрүүл мэнд зэрэгт учирсан гэм хорын зэрэг асуудлаар шүүхэд хандаж эрхийг нь сэргээх практик тогтсоноор хүний эрхийг хамгаалахад нэгэн чухал дэвшил болсон билээ.

ХЭҮК, гишүүдийн бүрэн эрхэд хамаарах нэг гол асуудал бол хяналт шалгалт, мониторинг, судалгаа мөн. Хүний эрх, эрх чөлөөг зөрчиж байгаа талаарх гомдол, мэдээлэл болон тухайн үеийн нөхцөл байдал зэрэгт дүн шинжилгээ хийж, төлөвлөгөөт болон гэнэтийн хяналт шалгалт, мониторинг, судалгааг тодорхой субъектүүдийг хамруулан дангаар болон холбогдох төр, иргэний нийгмийн байгуулагатай хамтран хийдэг боллоо. ХЭҮК 15 жилийн хугацаанд 547 удаагийн хяналт шалгалт хийсэн ба хүний эрх, эрх чөлөөг сэргээж, зөрчлийг арилгуулахаар 200 шаардлага, хүний эрх, эрх чөлөөг зөрчиж болзошгүй тохиолдол шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар өөрийн

эрх хэмжээний хүрээнд 204 зөвлөмжийг холбогдох этгээдэд хүргүүлж, шаардлага зөвлөмжийн биелэлтийг хангуулж байна.

Улаанбаатар хотод шилжин ирсэн бүртгэлгүй иргэдийн эрх, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн зохицуулалт, Хүний эрхийн боловсрол, Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд, Уул уурхайн үйлдвэрлэлээс хүний эрхэд үзүүлж буй нөлөө, ЛГБТ болон ХДХВ(ДОХ-ын халдвартай хүмүүсийн эрх, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай Монгол Улсын хуулийн хэрэгжилт, Хүний эрхийг хамгаалагчдын эрх, Цаатан иргэд, үндэсний цөөнхий эрх, Цагдаагийн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны албан хаагчийн хөдөлмөрлөх эрх, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх, Ахмад настны эрх зэрэг өргөн хүрээний сэдэв, агуулгыг хамарсан 56 судалгааны ажил хийж гүйцэтгэсэн байна. Хүний эрхийн тулгамдаж буй асуудлаар судалгаа хийхдээ хөндлөнгийн үнэлгээ, бодлогын дүн шинжилгээ, хяналт шалгалт зэргээр цогц байдлаар хэрэгжүүлж, эдгээрт Засгийн газрын агентлаг, албад, иргэний нийгмийн байгууллагууд, хараат бус судлаач, шинжээч зэрэг олон талт төлөөллийг оролцуулан зохион байгуулж, үр дүнг нь үндэслэн зохих санал, зөвлөмжүүд боловсруулан Хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын илтгэлд тусган ажилладаг билээ.

Иргэд, олон нийтийн хүний эрхийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, хүний эрхийн боловсрол олгох, хүний эрхийн соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа чанарын шинэ шатанд гарлаа. Хүний эрхийн ном товхимол, эвхмэл хуудас хэвлүүлж түгээхийн зэрэгцээ телевиз, радиогийн цуврал нэвтрүүлэг, шторк, хүүхдэд зориулсан радио жүжиг, гар, фото зургийн уралдаан, мэтгэлцээн, олон нийтийн лекц, өглөөний уулзалт, хэлэлцүүлэг зэрэг олон талт үйл ажиллагааг зохион байгуулж, олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдийг ашиглан сурталчилгааны үйл ажиллагаа явуулж, “Хүний эрх” сэтгүүл гаргаж байна. Өдөр тутмын зарим сонинд “Хүний эрхийн

булан” хөтөлж, долоо хоног бүр хүний эрхийн асуудлаар нийтлэл, ярилцлага, мэдээлэл бэлтгэн иргэдэд хүргэж байна. Энэ хугацаанд Хүний эрхийн олон улсын гэрээний хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ээлжит илтгэлүүд, НҮБ-ын холбогдох хороодоос Монгол Улсын Засгийн газарт өгсөн зөвлөмжүүдийн эмхэтгэл, Хүний эрхийн товч тайлбар, Хүний эрхийн олон улсын Билл зэрэг 197 төрлийн ном товхимол, гарын авлага хэвлэн гаргалаа. Комисс 2001 оноос хойш хэвлүүлсэн монгол, англи хэл дээрх бүх ном, товхимол, судалгааны тайлан, "Хүний эрх" эрдэм шинжилгээ, онол, практикийн сэтгүүл, "Хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын талаарх илтгэл"-үүдийг багтаасан "Хүний эрхийн цахим номын сан"-г 2015 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн ажиллуулж байна.

ХЭҮК хараат бус, бие даасан үндэсний байгууллагын хувьд төрийн, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах талаар боломжийн туршлага хуримтлуулаа.

Хуулиар олгосон бүрэн эрхийг хэрэгжүүлэхдээ бие биеийнхээ дотоод үйл ажиллагаанд хутгалдан орохгүй байх зарчмыг удирдлага болгон хуулийн дагуу хүний эрхийг хязгаарладаг эрх мэдэлтэй, хөндлөнгийн хяналтгүй тохиолдолд хүний эрхийн зөрчил гаргах эрсдэлтэй гэж үздэг төрийн тусгай чиг үүргийн байгууллагуудтай тухайлбал Улсын ерөнхий прокурорын газар, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Зэвсэгт хүчний жанжин штаб, Тахарын ерөнхий газартай Хамтран ажиллах санамж бичиг байгуулан, тус бичигт дурдсан асуудлаа амжилттай хэрэгжүүлж ирлээ. Үүний үр дүнд эрүүдэн шүүх аливаа хэлбэрийг гаргуулахгүй байх, дүрмийн бус харилцааг таслан зогсооход зохих ач холбогдлоо өгдөг гэж үзэж байна.

ХЭҮК хүний эрхийн талаар үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагуудыг

гол хамтрагчаа гэж тодорхойлон олон талт хамтын ажиллагаа явуулж байна. Гадаад улсын засгийн газар, хөгжлийн агентлаг, НҮБ-ын болон бусад олон улсын байгууллагын санхүүжилтээр судалгаа хийлгэх, хамтарсан хяналт шалгалт, мониторинг хийх, тэднээс төрийн байгууллага нийгэмд хандсан хүсэлт, шаардлагыг дэмжсэн ажиллагаа хийх, санамж бичиг байгуулах зэргээр ажиллаж, хагас, бүтэн жилээр уулзалт хийж харилцан мэдээлэл солилцдог боллоо. Мөн ХЭҮК-ын тухай хуульд заасанчлан, ХЭҮК-ын дэргэд Орон тооны бус зөвлөлийг 2002 оноос хүний эрхийн чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагуудын төлөөлөлтэйгээр байгуулан ажиллуулж байна.

Иргэд, олон нийтэд хүний эрхийн боловсрол олгох, Комиссын үйл ажиллагааг иргэдэд ойртуулах, сурталчлах зорилгоор ХЭҮК нь олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдтэй нягт хамтран ажиллаж байна. ХЭҮК нь 2013 оноос эхлэн сар тутам хэвлэлийн бага хурал зохион байгуулж, сар тутмын үйл ажиллагаагаа олон нийтэд мэдээлдэг болоод байна. Жил бүрийн Хүний эрхийн олон улсын өдрийг угтан хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр тодорхой сэдэвт ажлыг зохион байгуулах, сэтгүүлчдийн дунд уралдаан зарлах, чиглэсэн сургалт хийх зэргээр ажиллаж байгаа нь зохих үр ашгаа өгч байна. Комиссын дэргэд “Хүний эрхийн төлөө сэтгүүлчид” клубыг 2012 оноос байгуулан ажиллуулж эхэлсэн бөгөөд одоогоор нийт 18 сэтгүүлчид нэгдэн ажиллаж байна. Клуб нь хүний эрхийн мэргэшсэн сэтгүүлч бэлтгэх бодлого барьж ажилладаг бөгөөд сар тутам уулзалт зохион байгуулж, хүний эрхийн анхаарал татсан асуудлаар аян зохиож, нийтлэл, нэвтрүүлгийг олон нийтийн хүртээл болгодог юм.

Төсөв санхүүгийн хүндрэлтэй явж ирсэн ч ХЭҮК-ыг зөвхөн нийслэл Улаанбаатарт үйл ажиллагаа явуулдаг байгууллага болгохгүйн тулд орон нутагт хүрч ажиллах чиглэлийг барьж ирлээ. Үүний хамгийн гол хэлбэр бол “Хүний эрхийн нээлттэй өдөр” бөгөөд өнөөдөр бүх аймагт нийт 80 удаа, нэг аймагт

дунджаар 3-4 удаа явж ажиллажээ. Нээлттэй өдрөөр иргэдэд хууль зүйн зөвлөгөө өгөх, өргөдөл, гомдол хүлээн авах, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл, иргэдтэй тус тус уулзалт хийх, аймгийн ИТХ, Засаг даргын гаргасан нийтээр дагаж мөрдөх шийдвэр, захирамж хүний эрхийн зарчимд нийцэж буй эсэхэд үнэлгээ хийх, зөвлөмж өгөх, эрүүлжүүлэх, баривчлах байр, цагдан хорих байр, хорих ангиуд, тусгай сургууль, хилийн цэргийн анги, застав, зэвсэгт хүчний анги, нэгтгэл, хүүхдийн, ахмадын асрамжийн төв зэрэг байгууллагуудад хяналт шалгалт хийх зэргээр цогц үйл ажиллагааг зохион байгуулж байна.

ХЭҮК байгуулагдсан цагаасаа олон улсын болон бүс нутгийн хүний эрхийг хамгаалах тогтолцооны хүрээнд амжилттай хамтран ажиллаж байна. ХЭҮК байгуулагдсаныхаа дараа жил Ази Номхон Далайн бүс нутгийн Хүний эрхийн үндэсний байгууллагуудын чуулганы 10 дахь гишүүнээр элсэн, бүс нутагтаа идэвхтэй үйл ажиллагаа явуулж эхэлсэн билээ.

Хүний эрхийн үндэсний байгууллагуудын Олон улсын зохицуулах хорооноос дэлхийн улс орнуудын хүний эрхийн үндэсний байгууллагуудыг магадлан итгэмжилж, Парисын зарчимд нийцсэн эсэхийг үнэлж, “А”, “В”, “С” статус олгодог бөгөөд Монгол Улсын ХЭҮК 2003, 2008, 2014 онуудад нийт гурван удаа “А” статустай магадлан итгэмжлэгдсэн нь үнэхээр том амжилт юм. НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссар хагагтай Нави Пиллай бидэнтэй уулзахдаа “Монгол Улсын ХЭҮК нь байгуулагдсанаас эхлэн үргэлж “А” үнэлгээтэй ажиллаж буй нь хүний эрхийн үндэсний байгууллагуудын хувьд том амжилт” хэмээн дүгнэж байсан билээ.

Манай Комисс 2015 онд Олон улсын зохицуулах хорооны шийдвэр гаргах үндсэн бүтэц болох Товчооны гишүүнээр сонгогдон, мөн оны 8 дугаар сараас Ази Номхон Далайн бүс нутгийн Хүний эрхийн үндэсний байгууллагуудын чуулганыг

даргалан ажиллаж байна. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн П.Оюунчимэг 2015 оны 8 дугаар сарын 28-ны өдөр Ази Номхон Далайн бүс нутгийн хүний эрхийн үндэсний байгууллагуудын Чуулганы хоёр жил тутмын бага хурлын үеэр болсон сонгуулиар Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах үндэсний байгууллагуудын Олон улсын зохицуулах хорооны Бизнес ба хүний эрхийн асуудлаарх Ажлын хэсгийн гишүүнээр сонгогдон, бүс нутгаа төлөөлөн олон улсын түвшинд үйл ажиллагаа явуулж байна. Мөн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн П.Оюунчимэг, Комиссын Бодлого дүн шинжилгээ, хүний эрхийн боловсролын хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ нар Ази Номхон далайн бүс нутаг дахь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Элчин сайд хөтөлбөрт тус тус сонгогдож Монгол Улсад эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх төслийг амжилттай хэрэгжүүлж байна.

Шинэ Зеланд, Бүгд найрамдах Солонгос Улс, Мьянмар Улсын хүний эрхийн үндэсний байгууллага, Данийн хүний эрхийн хүрээлэнтэй хүний эрхийн чиглэлээр санамж бичигбайгуулан, амжилттай хамтран ажиллаж байна. Мьянмар, Бүгд найрамдах Солонгос Улс, Тайваний Хүний эрхийн Үндэсний байгууллагын дарга, гишүүд, ажилтнуудын баг манай Комисст ирж, хүний эрхийн нээлттэй өдөр, сургалт зохион байгуулдаг, хорих байгууллагуудад хяналт шалгалт хийдэг, гомдол хүлээн авч шийдвэрлэдэг зэрэг үйл ажиллагааны туршлага судлан танилцаж байлаа. Гадаад харилцаанд тулгуурлан Ази Номхон далайн бүс нутгийн Хүний эрхийн үндэсний байгууллагуудын чуулганы Х, ХХ дахь хуралдаан, “Монгол Улс дахь уул уурхайн бизнес ба хүний эрх” олон улсын бага хурал (2012), Азийн хүүхдийн эрхийн чуулга уулзалт зэрэг олон улсын хурал, зөвлөлгөөнүүдийг эх орондоо амжилттай зохион байгууллаа. Энэ бүгдээс дүгнэн үзэхэд олон улсын түвшинд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын нэр хүнд өсөж, үйл ажиллагааны цар хүрээ өргөжсөөр байгааг харуулж байна. Ийнхүү

комиссын үйл ажиллагааны цар хүрээ, иргэдэд хүрч ажиллах боломж байнга өсөн нэмэгдэхэд хамтран ажиллагч байгууллагууд, иргэдийн үүрэг оролцоо хамгийн чухал түлхэц болж байдаг гэдгийг онцлон дурдахыг хүсэж байна. Ялангуяа НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр Монгол Улсад Хүний эрхийн Үндэсний Комисс байгуулагдсан цаг үеэс эхлэн Комиссын чадавхийг бэхжүүлэх 3-5 жилийн хугацаатай, үндэсний хэрэгжилттэй төслүүдийг санхүүжүүлж, техникийн дэмжлэг үзүүлсэн нь уг байгууллагын хөгжил, хүний нөөцийн чадавх бэхжихэд үнэлж баршгүй дэмжлэг, хувь нэмэр болсон билээ.

Хатагтай, ноёдоо !

Хүний эрхийн асуудал ардчилсан нийгмийн гол шалгуур, үнэлэмж болсон өнөөгийн нөхцөлд та бидэнд шинээр хийх, боловсронгуй болгох, сайжруулах ажил маш их байна. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Ази Номхон далайн бүс нутгийн Хүний эрхийн үндэсний байгууллагуудын чуулган хамтран 2011 онд манай Комисст чадавхийн үнэлгээ хийж, байгууллагын чадавхийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн олон төрлийн санал зөвлөмж өгсөний дээр, энэ хоёр газраас нилээд дэмжлэг туслалцаа үзүүлсэн юм. УИХ-аас 2011 оноос ХЭҮК-ын орон тоо, төсвийг нэмэгдүүлж, 2014 оны эхнээс аймаг бүрт Комиссын ахлах мэргэжилтэн ажиллуулах шийдвэр гаргасны үр дүнд Комиссын чадавх эрс нэмэгдсэн билээ. Харамсалтай нь өнгөрсөн оны хоёрдугаар хагасын болон 2016 оны төсвөөс мэдэгдэхүйц таналт хийснээс болж үр дүнтэй үйл ажиллагаа явуулах боломжгүй болоод байна. УИХ-аас энэ байдлыг харгалзан үзэж

төсвийн тодотгол хийх замаар асуудлыг шийдвэрлэж өгнө гэдэгт итгэж байна.

Хүний эрхийн талаар гарсан олон улсын баримт бичигт заасны дагуу хүний эрхийн үндэсний байгууллагад нэмэлт үүрэг ногдуулахдаа хүний нөөц, төсөв санхүүгийн асуудлыг хамтад нь шийдвэрлэж байх зарчимтай. Гэвч ХЭҮК-д хуулиар хэд хэдэн нэмэлт үүрэг хариуцуулсан боловч шаардагдах эх үүсвэрийг өнөөг хүртэл шийдвэрлээгүй байна.

Төрийн байгууллага, тэдгээрийн албан тушаалтнуудыг хүний эрхийн мэдрэмжтэй, хүний төлөө гэсэн сэтгэлтэй болгох эрх зүйн болоод зохион байгуулалтын тусгайлсан үйл ажиллагааг төрийн бодлогоор хэрэгжүүлэх шаардлагатай байна. Комиссын 2015-2020 оны Стратеги төлөвлөгөөгөөнд тусгагдсан хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах, чадваржуулах, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран хүний эрхийн үнэлгээ, шинжилгээ, нөлөөллийн үйл ажиллагаа явуулах зайлшгүй хэрэгтэй байна.

Эцэст нь Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүд, ажилтнууд бид хараат бус байр суурийг чанд баримталж, хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавих, хамгаалах, хөхиүлэн дэмжих чиг үүргээ мэргэжлийн өндөр түвшинд явуулж, хуулиар хүлээсэн үүргээ хариуцлагатай, нэр төртэй биелүүлдэг мэргэшсэн хамт олон байхын төлөө зүтгэхээ дахин илэрхийлье.

ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА
ЗҮТГЭЕ.

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИАР ХАМГААЛАГДСАН ҮНДСЭН ЭРХИЙН ХҮРЭЭГ ТОДОРХОЙЛОХ НЬ¹



Хууль зүйн доктор
Монгол Улсын Их Сургуулийн
Хууль зүйн сургуулийн багш,
дэд профессор

О.МӨНХСАЙХАН

Оршил

Хүний эрхийн Үндэсний Комисс (ХЭҮК) байгуулагдсаны 15 жилийн ойн баярын мэндийг Та бүхэнд хүргэе. Аливаа улс хэр ардчилсан бэ гэдэг нь тэр улсад хүний эрхийг хэр хамгаалж байна вэ гэдгээр хэмжигддэг. Монгол Улсад хүний эрхийг хамгаалах чиглэлд сайн ажиллаж байгаа байгууллага бол ХЭҮК юм. Яагаад гэвэл Үндсэн хууль болон олон улсын гэрээнд заасан үндсэн эрхийн заалтыг шууд хэрэглэдэг, түүний зөрчлийг тодорхойлж шийдвэрлэдэг шүүх Монголд их дутмаг. Үндсэн хуулийн цэц бол хүний эрхийн тодорхой зөрчлийг хүлээн авдаггүй, ердийн шүүх бол үндсэн эрхийн заалтыг тэр болгон барьж хэрэг, маргаан шийдвэрлэх боломж багатай. Харин энэ нөхцөлд ХЭҮК байгуулагдсан цагаасаа хойш хүний эрхийг хамгаалахад харьцангуй сайн ажиллаж ирсэн гэж хэлж болно. Үүнийг ХЭҮК-ийн жил бүрийн илтгэлээс харж болно.²

Өнөөдрийн илтгэлийн хүрээнд манай Үндсэн хуулиар хамгаалагдсан үндсэн эрх, эрх чөлөөний үндэс нь тэгш хийгээд чөлөөт байдал гэдгийг товч тайлбарлана. Үүнд тулгуурлан АНУ, ХБНГУ гэсэн ардчилал төлөвшсөн улсад үндсэн эрхийн хүрээг яаж тодорхойлдог вэ гэдгийг авч үзнэ. Эдгээр улсад үндсэн эрхийн хүрээг үндсэн хуульд шууд нэрлэн заасан эрхүүдээр хязгаарлаагүй, харин тэгш, чөлөөт байдлыг хамгаалсан ерөнхий заалтаа нийгмийн хөгжлийн хэрээр өргөжүүлэн тайлбарлах замаар шууд нэрлэгдээгүй эрхүүдийг ч хамруулан тодорхойлдог гэдгийг харуулна. Эцэст нь, Монгол Улсын хувьд тэгш, чөлөөт байдлыг хамгаалсан ерөнхий заалтууд бол Үндсэн хууль дахь тэгш байдал болон чөлөөтэй байх эрх гэдгийг нотолж, жишээн дээр ярих болно.

1. Тэгш хийгээд чөлөөт байдал

Ардчилсан улсын Үндсэн хуульд хувь хүнийг тэгш, бас чөлөөт гэж хүлээн зөвшөөрч байдаг. Өөрөөр хэлбэл, хувь хүнийг тэгш хийгээд чөлөөт гэж үзэх ёстой гэсэн норматив ойлголт үндсэн хууль, түүнийг тайлбарласан шүүхийн шийдвэр, зохиол бүтээл, улс төрийн соёл, хэлэлцүүлэгт бий. Тэгш, чөлөөт байдал нь хувь хүний үндсэн эрх, эрх чөлөөний суурь болж өгдөг.

¹ ХЭҮК-ийн 15 жилийн ойд зориулан 2016.02.01-нд Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хуульчдын танхимд зохион байгуулсан “Хүний эрхийн төлөө хамтдаа зүтгэсэн 15 жил” онол, практикийн хуралд зохиогч энэ сэдвээр илтгэл тавьсан. Энэ илтгэл нь энэ өгүүлэлд тулгуурласан. <https://www.youtube.com/watch?v=BRvJ5kB2G5g>

² Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний талаарх 13 дахь илтгэл (УБ: Хүний эрхийн Үндэсний Комисс, 2014); Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний талаарх 14 дэх илтгэл (УБ: Хүний эрхийн Үндэсний Комисс, 2015).

Тэгш байдал (equality) гэдэг нь бол хүн болгоны амьдрал адилхан чухал, адил үнэ цэнэтэй гэсэн үг. Хүн бүрийг адилхан хүн гэж хүлээн зөвшөөрч хүний ёсоор хүндлэх ёстой. Тийм учраас, хүнийг арьсны өнгө, хүйс, нас зэргээр нь дур зоргоор ялгаварлан гадуурхаж болохгүй бөгөөд үүнийг үндсэн хуулийн түвшинд хориглож өгдөг.

Үндсэн эрх, эрх чөлөөний нөгөө нэг тулгуур бол чөлөөт байдал (liberty) юм. Энэ нь юу вэ гэхээр хувь хүн өөрийнхөө амьдралыг хэрхэн авч явах вэ, амжилт гэж юу вэ, амьдралын утга учир юу вэ, яаж амьдрах вэ гэдгийг өөрөө шийдвэрлэх, үүнийхээ дагуу амьдралаа төлөвлөх, төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх боломж юм. Мөн, хэний ч хараа хяналтаас ангид байж, бие дааж өөрийнхөөрөө байх хувийн орон зай, хувийн нууцыг нь чөлөөт байдал хамгаалдаг.

Чөлөөт байдлыг тодорхой үндсэн эрх, эрх чөлөөнүүд баталгаажуулж, хамгаалдаг. Эдгээрийг бол хоёр ангилж болно: (1) хувийн эрх, эрх чөлөө, болон (2) улс төрийн эрх, эрх чөлөө. Хувийн эрх, эрх чөлөөнд шашин шүтэх, үг хэлэх, жагсах, цуглах эрх чөлөө, хувийн халдашгүй байдал зэрэг багтдаг. Улс төрийн эрх, эрх чөлөөнд сонгох, сонгогдох эрх, эвлэлдэн нэгдэх зэрэг багтдаг. Улс төрийн эрх чөлөөний гол цөм нь юу вэ гэхээр хүмүүс өөрсдөө оролцож баталсан эсвэл өөрсдийнхөө сонгосон төлөөлөгчид (хууль тогтоогчид)-ийн баталсан хуульд захирагдаж байгаа учраас чөлөөтэй гэдэг тэр суурь үзэл санаа.

Ардчилсан үндсэн хууль тогтоогчид тухайн үед хувь хүний тэгш, чөлөөт байдлыг хэрхэн ойлгож байсан бэ, ямар жишээн дээр буулгаж харж байсан бэ гэдэг дээрээ тулгуурлан үндсэн хуульд үндсэн эрх, эрх чөлөөг нэрлэж зааж өгдөг. Гэхдээ, үндсэн хуульд нэрлэсэн үндсэн эрхүүд нь тэгш байдал болон чөлөөт байдлыг бүрэн илэрхийлж хамгаалах боломжгүй юм. Яагаад гэхээр үндсэн хууль олон арван, бүр хэдэн зуун жил сахин биелүүлэх үзэл санааны баримт бичиг юм. Тэгэхээр хойч үеийн амьдрах нийгэм ямар байх вэ, шинэ нөхцөлд тэгш, чөлөөт байдал хэрхэн хэрэгжих вэ, яаж зөрчигдөх вэ гэдгийг тухайн үеийн үндсэн

хууль тогтоогчид харах боломжгүй учраас үндсэн хуульдаа тэгш, чөлөөт байдлын илэрхийрхийлэл болсон нээлттэй, ерөнхий заалтууд оруулдаг. Үе үеийнхэн үндсэн хууль дахь тэр ерөнхий заалтуудыг тайлбарлах замаар хувь хүний тэгш, чөлөөт байдлыг хамгаалахад зайлшгүй шаардлагатай эрхүүдийг үндсэн эрхийн түвшинд хүлээн зөвшөөрч хамгаалдаг. Үндсэн хууль дахь үндсэн эрхийн хамгаалалт ийнхүү байнга хөгжиж тэлж байдаг.

Үндсэн хууль тогтоогчдын ирээдүйг харах боломж, мэдлэг хязгаарлагдмал учир нэрлэж заасан үндсэн эрхийн хүрээнд тэгш, чөлөөт байдлыг бүрэн хамгаалж чадахгүй ч үндсэн эрхийн хамгаалалт дахь цоорхойг нөхөх зорилгоор ерөнхий заалтыг үндсэн хуульд багтаадаг. Үндсэн хуульд ардчиллын олон жишээ дээр үүнийг харуулж болох ч АНУ, ХБНГУ гэсэн хоёр улсын үндсэн хуулийн эрх зүйн хөгжлөөс иш татан ярья. Эхлээд америкчууд тэгш, чөлөөт байдлыг хэрхэн хамгаалж ирсэн бэ, дараа нь германчууд Дэлхийн II дайнаас хойш үүнийг хэрхэн амжилттай хийж ирсэн бэ гэдгийг өгүүлэх болно.

2. АНУ: тэгш хамгаалалт хийгээд чөлөөт байдал

АНУ-ын Үндсэн хуулиар шашин шүтэх, үг хэлэх зэрэг эрхүүдийг тодорхой заасан. Үүнийг нэрлэсэн эрхүүд гэж хэлдэг. Нөгөө талаар сүүлийн 200 гаран жил нэрлэгдээгүй үндсэн эрхүүд шүүхээр хамгаалагдаж ирсэн. Нэрлэгдээгүй үндсэн эрхийг хамгаалахад үндэс болдог хоёр гол заалт Үндсэн хуульд нь бий. Эхнийхийг нь тэгш хамгаалалтын заалт (equal protection clause) гэдэг. Хэнийг ч хуулиар тэгш хамгаалахгүй байж болохгүй (АНУ, Үндсэн хууль, XIV Нэмэлт). Хоёр дахийг нь хуулийн зохих журмын заалт (due process of law clause) гэж нэрлэдэг. “Хэний ч амьдрал, чөлөөт байдал, өмчид хуулийн зохих журамгүйгээр халдах ёсгүй” гэж АНУ-ын Үндсэн хуулийн V болон XIV Нэмэлтэд заасан.

1791 онд, мөн 1868 онд тус тус баталсан Үндсэн хуулийн нэмэлтүүд дэх энэ хоёр төрлийн заалтыг тайлбарлах замаар хувь

хүний тэгш, чөлөөт байдлыг Америкийн шүүх хамгаалж байна. АНУ-ын Дээд шүүхээс дараах есөн төрлийн дурдагдаагүй үндсэн эрхийг хүлээн зөвшөөрсөн: (1) гэр бүлийн тусгаар байдал; (2) нөхөн үржихүйн тусгаар байдал; (3) сексийн үйл болон бэлгийн баримжаа; (4) эрүүл мэндийн шийдвэр; (5) мэдээллийн хяналт; (6) зорчих; (7) сонгох; (8) шүүхэд хандах; (9) боловсрол.³ Эдгээр эрхийг заримдаа “далд эрх” (implied rights) гэж нэрлэдэг⁴ бөгөөд ихэнхдээ тэгш хамгаалалтын эсхүл(болон зохих жумын заалтад тулгуурладаг.⁵ Хууль зүйн сургуульд хэрэглэдэг үндсэн хуулийн эрх зүйн кэйсбүүк нь ихэвчлэн тэгш хамгаалалт, зохих журам, Нэгдүгээр нэмэлт (үг хэлэх болон шүтэх эрх чөлөө) гэсэн гурван бүлэгт үндсэн эрхүүдийг ангилж үздэгээс⁶ тэгш хамгаалалт болон зохих журмын заалтууд ямар чухал үүрэгтэй болох нь харагдана.

Дээр жагсаасан 9 төрлийн эрхийг тус бүрт нь дэлгэрэнгүй хэлэлцвэл нэг өгүүллийн хэмжээнд багтахгүй учраас эдгээрийн хоёрыг тайлбарлая. Юуны өмнө, гэр бүл тусгаар байх үндсэн эрхийг авч үзье. 1923 онд АНУ-ын Дээд шүүх сургуульд Анлиас өөр хэлээр хичээл заахыг хориглосон мужийн хуулийг үндсэн хуулийн бус гэдгийг тогтоосон.⁷ Зохих журмын заалт дахь “чөлөөт байдал”-ыг өргөн агуулгаар тайлбарлаж гэр бүлийн тусгаар байдлыг олон талаар хамгаалсан. Шүүх хэлэхдээ:

Эргэлзээгүйгээр [чөлөөт байдал] нь бие махбодын хязгаарлалтаас ангид байх эрх чөлөөг төдийгүй хувь хүний гэрээлэх, амьдралын эгэл үйлд оролцох, хэрэгтэй мэдлэг олж авах, гэрлэх, орон байртай болох, үр хүүхдээ өсгөх, өөрийн ухамсрын айлдсанаар Бурхныг шүтэх,

ерөнхийдөө чөлөөт эрчүүд аз жаргалаа хөөхөд амин чухал гэж нийтлэг хууль (common law)-д хүлээн зөвшөөрсөн давуу эрхүүдийг агуулдаг.⁸

Энэ шийдвэрээс хойш гэр бүлийн тусгаар байдлын олон талыг үндсэн эрхийн түвшинд хамгаалж ирсэн. Гэрлэх эрх, үр хүүхдээ асран хамгаалах эрх, гэр бүлээ хамт байлгах эрх, үр хүүхдээ хүмүүжүүлэх эрхийг чөлөөт байдалд багтаан хамгаалж ирсэн. Жишээлбэл, цагаан арьстай хүнийг цагаанаас өөр арьстай хүнтэй гэрлэхийг хориглосон хуулийг Дээд шүүх хүчингүй болгосон.⁹ Нэг талаар, энэ хориглолт нь тэгш хамгаалалтыг зөрчсөн, нөгөө талаар, өөр өөр арьсны хүмүүсийн чөлөөт байдлыг зохих журамгүйгээр хязгаарласан гэсэн. Учир нь, хүмүүс хэнтэй гэрлэх вэ гэдгээ шийдвэрлэх нь тэдний чөлөөт байдлын хамгийн гол цөм.

Мөн, зорчих эрх (travel)-ийг харья. Монгол Улсын Үндсэн хуулийн 16-р зүйлд улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих эрхийг нэрлэн хамгаалсан бол энэ эрх Америкийн Үндсэн хуульд нэрлэгдээгүй. Гэвч, АНУ-ын дээд шүүхээс энэ эрхийг үндсэн эрхийн түвшинд хамгаалж ирсэн. Жишээлбэл, мужаас гадагш төмөр зам эсхүл автобусаар тээвэрлэж буй зорчигч тус бүрт татвар ногдуулсан хуулийг үндсэн хууль зөрсөн хэмээн хүчингүй болгосон.¹⁰ Энэ татвар бодит байдал дээр зорчигчдын нуруун дээр бууж байсан учраас тэдний улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих боломжийг хязгаарласан. Энэ мэт хуулиуд чөлөөт байдлыг зөрчсөн гэж Дээд шүүх нь үзэж хүчингүй болгосон.

Үндсэн хуульд нэрлэгдээгүй ч үндсэн эрхийн түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн учраас дээрх эрхүүдийн дийлэнхэд чанд шинжилгээ (strict scrutiny) хийдэг. Эдгээр эрхэд халдсан төрийн үйл ажиллагаа нь төрийн гарцаагүй хэрэгжүүлэх ёстой зорилгод хүрэхэд зайлшгүй гэдгийг төрөөс нотлох замаар уг халдлагыг зөвтгөх ёстой гэсэн үг. Үүний тулд тухайн эрх нь үндсэн эрх мөн эсэх, уг эрхэд халдсан эсэх, уг халдлага

³ Erwin Chemerinsky, *Constitutional Law: Principles and Policies*, Third (ASPEN Publishers, 2006), 791–920.

⁴ Geoffrey R Stone et al., *Constitutional Law*, Sixth ed. (Wolters Kluwer, 2009), 711.

⁵ Chemerinsky, *Constitutional Law: Principles and Policies*, 792.

⁶ *Ibid.*, 545–1268; Stone et al., *Constitutional Law*, 441–1542; Kathleen Sullivan M. and Gerald Gunther, *Constitutional Law*, 17th ed. (Mineola, N.Y.: Foundation Press, 2010), 375–1395; Gregory E. Maggs and Peter J. Smith, *Constitutional Law: A Contemporary Approach*, 2nd ed. (Thomson Reuters, 2011), 511–1270.

⁷ *Meyer v. Nebraska*, 262 U.S. 390 (1923) 399.

⁸ Мөн тэнд, 399.

⁹ *Loving v. Virginia*, 388 U.S. 1 (1967).

¹⁰ *Crandall v. Nevada* 73 U.S. (6 Wall.) 35 (1867).

нь төрийн гарцаагүй зорилгоор зөвтгөгдөх эсэх, тухайн хууль нь зорилгод хүрэхэд зайлшгүй юу (эрхэд илүү бага халдсан өөр хувилбарыг сонгох боломжгүй юу) гэсэн асуултад хариулах шаардлагатай болдог.¹¹ Хэрэв төрөөс өөрийн гарцаагүй зорилгод хүрэхэд зайлшгүй байсан гэдгийг нотолж чадахгүй бол зохих журмын эсхүл тэгш хамгаалалтын заалт зөрчигдсөнд тооцогддог. АНУ-ын Үндсэн хуулийн эрх зүйн хөгжлийн түүхийг харвал тэгш хамгаалалт болон чөлөөт байдлын тухай заалтуудын хүрээнд нэрлэгдээгүй үндсэн эрхүүдийг хүлээн зөвшөөрч, үндсэн эрхийн хамгаалалтыг тэлж ирсэн байна.

3. ХБНГУ: эрхэм чанар, тэгш байдал, хувь чанараа хөгжүүлэх эрх

ХБНГУ одоогийн Үндсэн хуулиа 1949 онд баталсан. Германы Үндсэн хууль тогтоогчид тэгш, чөлөөт байдлыг хамгаалахад зайлшгүй шаардлагатай гэж үзсэн эрхүүдийг Үндсэн хуульдаа шууд нэрлэн зааж хамгаалсан. Тухайлбал, шашин шүтэх, үзэл бодлоо илэрхийлэх, цуглах, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөнүүд, захидал харилцааны нууц, сонгох эрх зэрэг үндсэн эрхийг хуульчилсан.

Нэрлэгдээгүй үндсэн эрхүүдийг хамгаалах боломж олгосон ерөнхий заалт Германы Үндсэн хуульд АНУ-ын Үндсэн хуультай адилхан байдаг. Ийм заалтуудаас хамгийн түгээмэл хэрэглэгддэг нь дараах гурван: (1) “Хүний эрхэм чанар бол халдашгүй. Үүнийг хүндэлж хамгаалах нь төрийн бүх байгууллагын үүрэг” (ХБНГУ, ҮХ, 2-р зүйл, 1); (2) “Бүх хүн хуулийн өмнө тэгш байна” (ХБНГУ, ҮХ, 3-р зүйл, 1); (3) “Бусдын эрхийг зөрчөөгүй эсхүл үндсэн хуулийн дэг журам, ёс суртахууны хуульд халдаагүй хэмжээнд хүн бүр хувь чанар (personality)-аа чөлөөтэй хөгжүүлэх эрхтэй” (ХБНГУ, ҮХ, 2-р зүйл, 1). Ерөнхий эрхийн заалтуудын аль нэг эсвэл аль алинд нь тулгуурлаж олон эрхийг үндсэн эрхээр хүлээн зөвшөөрч хамгаалсан байдаг. Үндсэн хуулийн эдгээр ерөнхий эрхийн хүрээнд ямар үндсэн эрх багтах вэ гэдгийг Холбооны Үндсэн хуулийн шүүх тухай бүрт

нь үндэслэлтэйгээр шийдээд явдаг. Нээлттэй, ерөнхий заалтын хүрээнд хамгаалагдсан, нэрлэгдээгүй үндсэн эрхийн жагсаалт бий болсон.

Хүний эрхэм чанар бол үндсэн хуулийн хамгийн чухал үнэт зүйл. Энэ ойлголт нь хувь хүний тусгаар байдал болон субъект байх статусыг бүх талаар хамгаалдаг.¹² 1977 онд Холбооны Үндсэн хуулийн шүүх энэ ойлголтын гол агуулгыг тодорхойлох гэж оролдсон:

Хувь хүнийг төрийн арга хэрэгсэл төдий болгох нь хүний эрхэм чанартай зөрчилддөг. “Хүн бүр дандаа өөртөө зорилго байх ёстой” гэсэн зарчим хуулийн бүх хүрээнд чөлөөтэй хэрэглэгдэнэ; хүний угийн эрхэм чанар нь түүнийг тусгаар хувь чанар гэдгийг хүлээн зөвшөөрөх гэсэн агуулгатай.¹³

Хүний эрхэм чанарыг энэ утгыг зөрчсөн нэг жишээ бол хоригдлыг хэзээ ч суллагдах боломжгүйгээр бүх насаар нь хорих явдал юм. “Төр хоригдлын хувь чанарын хөгжилд анхаарал хандуулалгүй, эрх чөлөөгөө сэргээх бүх найдварыг нь үгүйсгэж хандвал хүний эрхэм чанарын цөм рүү халдана.”¹⁴

Үндсэн эрхийн хамгаалалтад чухал үүрэгтэй өөр нэгэн эрх бол хуулийн өмнө тэгш байх эрх. Үндсэн хуулийн 3-р зүйлийн 1-д буй ерөнхий тэгш байдлын зарчим нь хуулийн хэрэглээнд төдийгүй хуулийн агуулгад хүнийг тэгш бусаар хандахыг хориглосон гэсэн өргөн агуулгаар Үндсэн хуулийн шүүх анхнаасаа тайлбарласан.¹⁵ Үндсэн хуулийн 3-р зүйлийн 2-т эрэгтэй болон эмэгтэй хүмүүс тэгш эрхтэй гэдгийг, уг зүйлийн 3-т хүйс, угсаа, арьс, хэл, төрсөн нутаг болон гарал, итгэл үнэмшил, шашны эсхүл улс төрийн үзэл бодлоор нь хэнийг дээрд эсхүл доорд үзэж болохгүй гэж заасан. Үндсэн хуулийн 3-р зүйлийн 3-т буй

¹² Warner Heun, *The Constitution of Germany: A Contextual Analysis*, Constitutional Systems of the World (Hart Publishing, 2011), 202.

¹³ David P. Currie, *The Constitution of the Federal Republic of Germany*, 1st ed. (University of Chicago Press, 1995), 314.

¹⁴ Donald P. Kommers, *The Constitutional Jurisprudence of the Federal Republic of Germany*, 2nd ed. (Duke University Press, 1997), 309.

¹⁵ Heun, *The Constitution of Germany: A Contextual Analysis*, 2008.

¹¹ Chemerinsky, *Constitutional Law: Principles and Policies*, 794–797.

жагсаалт нь ялгаварлан гадуурхаж үл болох бүх үндэслэлийг агуулаагүй. Үндсэн хуулийн шүүх 3-р зүйлийн 1-д буй ерөнхий тэгш байдлын заалтын дагуу олон үйл ажиллагааг хүчингүй болгосон. Энэ ерөнхий тэгш байдлыг Үндсэн хуулийн бусад заалттай хослуулан хэрэглэдэг. Жишээлбэл, гэрлэсэн хүмүүс, хүүхэдтэй гэр бүлийг ялгаварлан гадуурхсаныг буруушаахдаа Үндсэн хуулийн 3-р зүйлийн 1-г 6-р зүйлийн холбогдох заалттай хослуулан хэрэглэсэн.¹⁶ Түүнчлэн, Үндсэн хуульд тусгайлан дурдагдаагүй ашиг сонирхолд нөлөөлөхүйц ангилалд тэгш байдлыг хэрэглэж ирсэн. Тухайлбал, хүйсээ солиулсныг тусгах зорилгоор төрснийг гэрчлэх баримт бичгийг өөрчлөх эрхийг 25-аас доош насныханд үл эдлүүлж байсныг хүчингүй болгосон.¹⁷

Хувь чанараа чөлөөтэй хөгжүүлэх эрхийг авч үзье. Энэ эрхийг Монгол хэлээр хувь хүн өөрийн онцлог чанараа чөлөөтэй хөгжүүлэх эрх гэж хэлэх ч боломжтой. Энэ заалт нь Үндсэн хуулийн төсөлд анх “Хүн бүр хүссэн зүйлээ хийх эсхүл эс хийх нь чөлөөтэй” гэж томъёологдсон байсан боловч батлах явцад одоогийн агуулгаар найруулж эцэслэгджээ. Хувь чанараа чөлөөтэй хөгжүүлэх эрхийн хүрээнд нэрлэгдээгүй үндсэн эрхүүдийг хүлээн зөвшөөрдөг. Үндсэн хуулийн шүүх хувь чанараа чөлөөтэй хөгжүүлэх эрхийн хүрээг бүрэн тодорхойлоогүй байна. “Хөгжиж буй нийгмийн нөхцөлд нь хувь чанарын заалтын агуулгыг хэрэг тус бүрт нь тодорхойлоод явахыг илүүд үзэж ирсэн. Гэвч, хувь хүн өөрийнхөө харж байгаагаар амьдралаа чөлөөтэй хэлбэржүүлэх хувийн орон зай, халдашгүй байдлын суурь хүрээ гэж үзсэн.”¹⁸

Хувь чанарын эрх нь хоёр чиг үүрэг гүйцэтгэдэг: (1) нэмэлт үндсэн эрхийг тодорхойлох; (2) шинэ үндсэн эрхийг хөгжүүлэх. Үндсэн хуульд илэрхий нэрлэсэн эрхийн нэмэлт утгыг хүлээн зөвшөөрүүлэх чиг үүргийг хувь чанараа хөгжүүлэх эрх гүйцэтгэдэг. Өөрөөр

хэлбэл, “тухайн үйл ажиллагааг илэрхий хамгаалсан үндсэн эрх байхгүй бол Үндсэн хуулийн 2-р зүйлийн 1 нь нэмэлт эрхийн үүрэг гүйцэтгэдэг.”¹⁹ Жишээлбэл, гадаадад явах, тагтаа хооллох, ой модонд морь унах зэрэг эрхийг хамгаалсан.²⁰ Эндээс гадаадад явах эрхийг хэрхэн хөгжүүлснийг үзье. Германы Үндсэн хуулийг уншвал нутаг дэвсгэрийнхээ дотор зорчих эрхийг хамгаалсныг харж болно, харин Монгол Улсын Үндсэн хуульд байдаг шиг гадаад руу зорчих эрхийг илэрхий заагаагүй. Гомдол гаргагч нь 1947 онд Хойд Райн-Вестпалиа мужийн парламентад сонгогджээ. Тэрээр ХБНГУ-ын батлан хамгаалах болон Германыг нэгтгэх бодлогыг хурцаар шүүмжилдэг, дотоод, гадаадын хурал, цуглаан дээр энэ шүүмжлээ хурцаар хэлдэг байжээ. Гэтэл, гадаадад зорчих паспортыг түүнд өгөхөөс татгалзжээ. Тэгээд, гомдол гаргагч Үндсэн хуулийн 11-р зүйлд заасан эрх нь зөрчигдсөн гэж гомдол гарсан. Үндсэн хуулийн шүүх “эх орноо орхин явах эрх 11-р зүйлээр хамгаалагдсан зорчих эрх чөлөөний ойлголтод илэрхий агуулагдаагүй боловч энэ нь үндсэн хуулийн дэг журмын хүрээнд үйл ажиллагаа явуулах ерөнхий эрхийн илэрхийлэл болсон 2-р зүйлийн 1-ээр баталгаажсан” гэж шийдвэрлэсэн.²¹ Гадаад руу явах эрхийг хувь чанараа чөлөөтэй хөгжүүлэх эрхийн хүрээнд ийнхүү багтааж үндсэн эрхийн төвшинд хамгаалсан.

Хувь чанараа чөлөөтэй хөгжүүлэх эрхийн өөр нэг чиг үүрэг бол Үндсэн хуульд нэрлэгдээгүй, шинэ үндсэн эрхүүдийг хөгжүүлэх явдал. Үүнийг хувь чанарын ерөнхий эрх гэж нэрлэх нь ч бий. Хувийн халдашгүй байдал (privacy), нийтийн хүрээнд өөрийгөө таниулах эрх, хүний нэр хүнд болон мэдээллийн нууц, мэдээллээр өөрийгөө тодорхойлох эрх, мэдээллийн технологийн тогтолцоо цэгц, нууц байх эрх (right in confidentiality and integrity of information technology system) зэрэг шинэ

¹⁶ Currie, The Constitution of the Federal Republic of Germany, 332.

¹⁷ Ibid., 333.

¹⁸ Kommers, The Constitutional Jurisprudence of the Federal Republic of Germany, 320.

¹⁹ Heun, The Constitution of Germany: A Contextual Analysis, 204–205.

²⁰ Kommers, The Constitutional Jurisprudence of the Federal Republic of Germany, 313–326.

²¹ Ibid., 318.

үндсэн эрхийг Үндсэн хууль дахь хувь чанараа хөгжүүлэх эрхийн заалтын хүрээнд хүлээн зөвшөөрч хамгаалсан.²² Эдгээр шинэ эрхээс зөвхөн хоёрыг нь жишээ болгон авч үзье. Мэдээллээр өөрийгөө тодорхойлох эрх бол нэрлэгддэггүй боловч Үндсэн хуулийн түвшинд хамгаалагдсан үндсэн эрхийн нэг жишээ. Хувь хүн өөрийгөө олон нийтэд таниулахтай холбоотой эрх юм. Жишээлбэл, нэг хүний хэлсэн үгийг мушгиж хэвлэлээр бичих, хүний хэлснийг буруу ишлэх нь мэдээллээр өөрийгөө тодорхойлж олон нийтэд өөрийн таниулах эрхийг зөрчсөн байна гэсэн шийдвэрийг Үндсэн хуулийн шүүх гаргасан.²³

Мэдээллийн технологийн тогтолцоо (МТТ) цэгц, нууц байх эрх гэсэн өөр нэгэн нэрлэгддэггүй үндсэн эрхийг авч үзье. Интернетээр мэдээллийг хянах, шалгах, мэдээллийн технологийн тогтолцоонд нууцаар нэвтрэх бүрэн эрхийг тагнуулын байгууллагад олгосон хуулийг Германы Хойд Райн-Вестпалиа муж 2006 онд баталсан. Энэ асуудал нь үндсэн хуулийн маргаан болж Холбооны Үндсэн хуулийн шүүх дээр очиж шийдвэрлэгдсэн.²⁴ МТТ гэдэгт гар утас, смарт утас, компьютер, лаптоп, таблет, смарт ТВ зэргийг бүгд багтана. Энэ шүүх орчин үед МТТ хурдацтай хөгжиж, мэдлэгээ нэмэгдүүлэх, авьяас, ур чадвараа хөгжүүлэх, бусадтай харилцах, найзлах, ажил явуулах зэрэг боломжийг хүмүүст олгож байна гэж үзсэн. Гэвч, МТТ нь боломжийн хажуугаар асар их эрсдэлийг бий болгож байгааг Үндсэн хуулийн шүүх анхааруулсан. Тэгээд МТТ руу чөлөөтэй нэвтрэх, хянах, шалгах бүрэн эрхийг тагнуулын байгууллагад олгосон нь Үндсэн хуулийг зөрчсөн гэдгийг тогтоож, Үндсэн хуулийн 1-р зүйлийн 1-д

буй хүний эрхэм чанар, 2-р зүйлийн 1-д буй хувь чанараа хөгжүүлэх эрхэд тулгуурлан МТТ цэгц, нууц байх шинэ үндсэн эрхийг хүлээн зөвшөөрсөн. МТТ нууц, цэгц байх үндсэн эрхийг хүлээн зөвшөөрч, МТТ дотор ч хувь хүний амьдрал, хувийн орон зай хамгаалагдаж байх ёстой гэсэн жишиг тогтоосон. Хэрвээ гэмт хэрэг илрүүлэх, террорист халдлагыг зогсоох зэрэг хүний амь нас, эрүүл мэнд, үндэсний аюулгүй байдлыг хамгаалах зайлшгүй шаардлага бий болбол хууль сахиулах байгууллагаас МТТ руу нэвтэрч болох ч заавал шүүхийн зөвшөөрөл авна гэж үзсэн.

4. Монгол Улс: тэгш эрх хийгээд чөлөөтэй байх эрх

Монгол Улсын Үндсэн хуульд нэрлэн заасан эрхүүд бий. Нэрлэсэн эрхийн хувьд гурван зүйлийг анхаарах нь чухал. Нэгд, шашин шүтэх, үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, хууль зүйн туслалцаа авах зэрэг үндсэн эрх, эрх чөлөөг Үндсэн хуулийн 2-р бүлэгт жагсаасан. Эдгээр эрхийг тайлбарлахдаа тухайн эрхийг бүрэн утгажуулж, Үндсэн хууль дахь хувь хүний тэгш, чөлөөт байдал гэсэн суурь үнэт зүйлийн дагуу тайлбарлах хэрэгтэй. Жишээлбэл, Үндсэн хуулийн 16-р зүйлийн 3-т “Төр, түүний байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө” гэж заасан. Зарим судлаачид энэ заалтыг “урьдчилсан, шударга нөхөх олговор төлнө” гэж өөрчлөх санал гаргаснаас харвал уг заалт дахь нөхөх олговор нь шударга байх утгагүй мэт ойлгосон бололтой.²⁵ Гэвч, Үндсэн хуулийн 16-р зүйлийн 3-т буй нөхөх олговор шударга байх нь зайлшгүй юм. Нөхөх олговор гэсэн үг нь өөрөө шударга олговор гэсэн санааг агуулна. Олговор бол заавал тухайн өгч байгаа зүйлдээ дүйцсэн байх албагүй бол нөхөх олговор нь өгч байгаа зүйлээ нөхөхүйц (дүйцэхүйц) байх ёстой гэсэн утгатай. Үндсэн хуулийн 1-р

²² Heun, *The Constitution of Germany: A Contextual Analysis*, 205; Kommers, *The Constitutional Jurisprudence of the Federal Republic of Germany*, 320–335.

²³ Kommers, *The Constitutional Jurisprudence of the Federal Republic of Germany*, 320–323.

²⁴ Wiebke Abel and Burkhard Schafer, “The German Constitutional Court on the Right in Confidentiality and Integrity of Information Technology Systems,” *Hacking* 6, no. 1 (April 2009), <http://www.research.ed.ac.uk/portal/en/publications/the-german-constitutional-court-on-the-right-in-confidentiality-and-integrity-of-information-technology-systems%287f653f17-0842-4ca9-b5ea-aedcc5d080cb%29.html>.

²⁵ Н.Лүндэндорж, Ж.Сайнхшиг, “Хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авах эрх зүйн шударга процесс,” *Нийтийн болон хувийн өмчийн эрх зүйн тулгамдсан асуудал дотор* (УБ: МУИС, Хууль зүйн сургууль, 2012), 48.

зүйлийн 2-т төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим бол шударга ёс гэсэн байхад төрөөс нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авахдаа шударга нөхөх олговор төлөхөөс өөр аргагүй. Үндсэн хуулийн 16-р зүйлийн 3-т заасан нөхөх олговор шударга олговор байх ёстой учраас энэ талаар Үндсэн хуульд өөрчлөлт оруулах шаардлага үгүй.

Хоёрт, нэрлэгдсэн үндсэн эрх, эрх чөлөөг зөвхөн Үндсэн хуулийн 2-р бүлгээр хязгаарлаж болохгүй. Үндсэн хуулийн 2-р бүлэгт төдийгүй бусад бүлэгт олон эрхийг илэрхий дурдаж хамгаалсан. Жишээлбэл, Үндсэн хуулийн 3-р зүйлийн 1, 5-р зүйлийн 2, 6-р зүйлийн 3, 7-р зүйлийн 2, 8-р зүйлийн 2, 9-р зүйлийн 2, 21-р зүйлийн 2, 26-р зүйлийн 2, 31-р зүйлийн 3, 47-р зүйлийн 3, 49-р зүйлийн 2, 52, 53, 54, 55, 62-р зүйлийн 2, 66-р зүйлийн 1 зэрэгт үндсэн эрхүүдийг заасан. Жишээлбэл, Үндсэн хуулийн 21-р зүйлийн 2, 31-р зүйлийн 3-т нийтгээрээ, чөлөөтэй, шууд сонгох, саналаа нууцаар гаргах иргэний эрхийг баталгаажуулсан. Мөн, Үндсэн хуулийн 53-р зүйлийн 2-р зүйлд шүүх хуралдаанд эх хэлээрээ үг хэлэх эрх, 54-р зүйлд хэргээ ил таслан шийдвэрлүүлэх эрх, 51-р зүйлд өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах эрхийг заасан. Үндсэн эрхийн жагсаалтыг гаргахдаа энэ мэт үндсэн эрхийг орхигдуулж болохгүй.

Гуравт, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд нэрлэн заасан эрхүүд үндсэн эрхэд хамаарч хамгаалагдана. “Олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлнэ” гэж Үндсэн хуулийн 10-р зүйлийн 2-т заасны дагуу олон улсын гэрээнд заасан эрхүүд Монгол Улсад шууд үйлчилнэ. Жишээлбэл, Үндсэн хуулийн цэц Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн пактын 8-р зүйлийн 2-т заасан ажил хаях эрхийг хязгаарласан гэсэн үндэслэлээр АИХ-ын Тэргүүлэгчдийн 1990 оны Хамт олны хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх дүрмийн заалтуудыг хүчингүй болгосон бөгөөд Үндсэн хуульд ажил хаях эрхийг шууд нэрлэн заагаагүй.²⁶

Үндсэн хуулиар хамгаалагдсан үндсэн эрхийн хүрээ Үндсэн хуульд нэрлэж заасан

эрхээр үл хязгаарлагдах ёстой. Монгол Улсын Үндсэн хуульд нэрлэсэн үндсэн эрх, эрх чөлөөг тэгш, чөлөөт байдлын агуулгаар утгажуулахын зэрэгцээ тэгш, чөлөөт байдлыг хамгаалахад зайлшгүй шаардлагатай ч нэрлэгдээгүй үндсэн эрхийг хүлээн зөвшөөрч хамгаалах ёстой. Үгүй бол Монгол Улсад хувь хүний тэгш, чөлөөт байдал бүрэн хамгаалагдаж чадахгүй. Тэгш, чөлөөт байдлыг хамгаалахад зайлшгүй боловч нэрлэгдээгүй эрхийг хамгаалах Монгол Улсын Үндсэн хуулийн үндэслэл болсон заалт нь тэгш байдлын болон чөлөөтэй байх эрхийн заалтууд юм.

Үндсэн хуулийн 1-р зүйлийн 2-т тэгш байдлыг төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим гэж, мөн 14-р зүйлийн 1-д хүн бүр хуулийн өмнө тэгш байна гэж тус тус заасан. Энэ бол Монгол Улс дахь хүн бүрийн амьдрал адилхан чухал, хүн бүр хүнийхээ хувьд адилхан үнэ цэнтэй, хүн бүрийг хүн гэж үзэж хүний ёсоор хүндлэх ёстой гэсэн суурь санааг илэрхийлдэг. Мөн, хүнийг дур зоргоор ялгаварлан гадуурхахгүй байх утгатай. Тиймээс, Үндсэн хуулийн 14-р зүйлийн 2-т нэрлэж заасан төдийгүй нэрлэж заагаагүй нөхцөлөөр хүнийг ялгаварлан гадуурхаж болохгүй гэдгийг 14-р зүйлийн 1-д заасан хуулийн өмнө тэгш байх ерөнхий эрх шаардана. Тухайлбал, бэлгийн баримжаа, хөгжлийн бэрхшээл гэж 14-р зүйлийн 2-т бичигдээгүй боловч үүгээр нь хүнийг ялгаварлан гадуурхаж болохгүй.

Тэгш байдлын агуулгаар гэрэл оруулж Үндсэн хуулийг тайлбарлах хэрэгтэй. Жишээлбэл, Үндсэн хуулийн 16-р зүйлийн 11-д “Гэрлэлт нь ...эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ” гэсэн заалт бий. Үүнийг гэрлэлт нь зөвхөн эрэгтэй болон эмэгтэй хоёр хүний хооронд байна гэсэн агуулгаар зарим судлаач тайлбарладаг.²⁷ Гэвч, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хоёр тэгш бус байсан хуучин уламжлал, хандлагын эсрэг энэ заалт чиглэсэн гэж тайлбарлах нь тэгш байдалд илүү нийцтэй. Гэрлэлтийн харилцаанд өмнө

²⁷ Т.Мөнхсүлд, “Монгол Улсын Үндсэн хуулийг тэгш эрхийн зарчмын үүднээс шинжлэх нь,” Үндсэн хууль ба эрх зүйт ёс VII дотор (УБ, 2014), 62.

²⁶ УИХ э. Д.Ламжав, МУУХЦ, Дүгнэлт 2, 1993.04.21

нь эрэгтэй, эмэгтэй хоёр тэгш бус байсан учраас энэ хоёр тэгш байна шүү гэж Үндсэн хуульд онцлон заасан. Түүнээс биш гэрлэлт нь зөвхөн эрэгтэй, эмэгтэй хоёр хүний хооронд байна гэж ойлгож болохгүй. Тиймээс, 2015 онд АНУ-ын Дээд шүүхээс ижил хүйстний гэрлэлтийг хүлээн зөвшөөрсөн шиг Монгол Улсын Үндсэн хуулийн цэц эсхүл УИХ энэ гэрлэлтийг хүлээн зөвшөөрөх нь нээлттэй. Үүнийг хориглосон утга манай Үндсэн хуульд байхгүй.

Тэгш байдлаар Үндсэн хуулийг бүхэлд нь утгажуулж тайлбарлавал Монголд сонгуулийн тэгш эрх үндсэн эрхийн түвшинд хамгаалагдсан. Цэцээс Үндсэн хуулийн 21-р зүйлийн 2-т сонгуулийн тэгш эрхийн зарчмыг хуульчлан заагаагүйн гадна уг хуулийг хэлэлцэн баталсан АИХ-ын хуралдааны удаа дараагийн протоколд энэ зарчмын талаар ямар нэгэн санал гараагүй учраас энэ эрх хамгаалагдаагүй гэж шийдвэрлэсэн.²⁸ Цэцийн энэ шийдвэрийн улмаас тэгш сонгох эрх хамгаалагдаж чадахгүй явж ирсэн. Жишээлбэл, 2008 оны УИХ-ын сонгуулиар тэгш сонгох эрх зөрчигдсөн. УИХ-ын 14-р тойргоос сонгогдсон нэг гишүүн 13000 сонгогчийг төлөөлж байсан бол 22-р тойргоос сонгогдсон нэг гишүүн 39000 сонгогчийг төлөөлж байсан. Өөрөөр хэлбэл, Баянзүрх дүүрэгт амьдарч байсан нэг иргэний сонгуульд өгсөн санал нь Төв аймгийн 14 дүгээр тойргийн иргэнийхээс 3 дахин бага жинтэй байсан гэсэн үг. Энэ нь сонгуулийн тэгш эрхийн зөрчил байв. Цаашид ийм зөрчил гаргахгүйн тулд тэгш байдлын дагуу Үндсэн хуулийг тайлбарлах ёстой. Хэдийгээр Үндсэн хуулийн 21-р зүйлийн 2-т тэгш сонгох эрхтэй гэж илэрхий заагаагүй ч гэсэн 14-р зүйлийн 1-д буй хуулийн өмнө тэгш байх ерөнхий эрхийн хүрээнд тэгш сонгогдох эрх хамгаалагдсан гэж харах хэрэгтэй.²⁹

Үндсэн хуульд нэрлэгдээгүй үндсэн эрхийг хөгжүүлж хамгаалах хоёр дахь

ерөнхий заалт бол Үндсэн хуулийн 14-р зүйлийн 13-т буй “халдашгүй, чөлөөтэй байх эрх” юм. Энэ эрхийг явцуу болон өргөн гэсэн хоёр янзаар ойлгож байна. Үндсэн хуулийн 14-р зүйлийн 13-т нэрлэж заасан эрхээр “халдашгүй, чөлөөтэй байх эрх” хязгаарлагдана гэх нь явцуу ойлголт юм. Өөрөөр хэлбэл, дараах жагсаалтад орсон эрхүүдээр хязгаарлагдана гэсэн үзэл: “Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална.”

Үндсэн хуулийн 14-р зүйлийн 13-ыг зөвхөн дур зоргын нэгжлэг, баривчилгаа, хорио, мөрдлөгөөс ангид байх эрх, эрүү шүүлт, хүнлэг бус, хэрцгий, доромж хандлага, харьцаанаас ангид байх эрхээр хязгаарлаж болохгүй. Илүү өргөн хүрээнд ойлгох хэрэгтэй. Яагаад вэ гэхээр Үндсэн хуулийн 14-р зүйлийн 3-т дээр дурдсан бие махбодын чөлөөт байдлаас гадна “иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг” дурджээ. Тиймээс, Үндсэн хуулийн 14-р зүйлийн 13 нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 9-р зүйлээс өргөн агуулгатай юм. Өөрөөр хэлбэл, халдашгүй, чөлөөтэй байх эрх нь энэ пактын 7-р зүйл дэх эрүү шүүлт, хэрцгий, хүнлэг бус, доромж харьцаа, шийтгэлээс ангид байх эрх, 9-р зүйл дэх чөлөөтэй, халдашгүй байх эрх, 17-р зүйлд буй хувийн амьдрал болон гэр бүл халдашгүй байх эрх зэргийг бүгдийг нь хамруулсан ерөнхий эрх юм. Үндсэн хуулийн 16-р зүйлийн 13-ын текстээс “халдашгүй, чөлөөтэй байх эрх” нь өргөн хүрээтэй орсон бөгөөд чөлөөт байдлыг хамгаалсан ерөнхий заалт гэж харагдаж байна.

Чөлөөтэй (чөлөөт) байдал бол халдашгүй. Б.Чимид багшийн тайлбарласнаар хүн болгон

²⁸ УИХ Ө.Сэргэлэн, Н.Баасанжав, МУУХЦ, Дүгнэлт 4, 1993.12.22

²⁹ Munkhsaikhan O., Towards Better Protection of Fundamental Rights in Mongolia: Constitutional Review and Interpretation, CALE Books 4 (Center for Asian Legal Exchange & Graduate School of Law, Nagoya University, 2014), 186–196.

бусдын эрхийг зөрчөөгүй тэр хязгаарт бие даан чөлөөтэй оршино:

Хязгааргүй эрх чөлөө гэж байх уу? Энэ тухайд “бие хүний эрх чөлөө бусад хүний мөрөөр хязгаарлагдана” гэсэн хариулт байдаг. Энэ л хязгаарын дотор хүн чөлөөт байдалд оршин аж төрнө... Уг нь хүн аль болох чөлөөт байдалд бусдаас хараат бус аж төрж, амьдран суух гэсэн эгэл утгатай. Тэр нь хувь хүний халдашгүй байдлаар баталгаажин илэрдэг...³⁰

Чөлөөт байдлыг баталгаатай хамгаалах зүйл нь халдашгүй байдлаар илэрнэ гэсэн ийм тайлбар нь явцуу тайлбараас илүү үндэслэлтэй юм.

Чөлөөтэй байх эрхийн хүрээнд юу юу хамгаалагдах вэ гэхээр дараах есөн зүйл байна.

1. Бие махбодын эрх чөлөө;
2. Эрүү шүүлт, хүнлэг бус, хэрцгий, доромж хандлага, шийтгэлээс ангид байх эрх;
3. Нэр төр, алдар хүнд халдашгүй байх эрх;
4. Хувийн халдашгүй байдал;
5. Захидал харилцааны нууц байх эрх;
6. Гэр бүл халдашгүй байх эрх;
7. Орон байр халдашгүй байх эрх;
8. Өмч халдашгүй байх эрх;
9. Бусад эрх, эрх чөлөө.

Энэ жагсаалт бол эхний найман эрхээр хязгаарлагдахгүй бөгөөд чөлөөт байдлыг хамгаалахад зайлшгүй чухал үндэслэл байгаа бол бусад эрхийг оруулах боломжтой. Б.Чимид,³¹ Ж.Бямбаа³² багш нар ч халдашгүй, чөлөөтэй байх эрхийг ийнхүү өргөн агуулгаар тодорхойлсон бол доктор Г.Банзрагч,³³ судлаач Б.Буянхишиг³⁴ нар энэ эрхийн хүрээнд эдийн засгийн эрх чөлөө зэрэг Үндсэн хуульд нэрлэн заагаагүй эрх, эрх чөлөөг хамруулан ойлгох талаар санал дэвшүүлжээ. Үе үеийн Монголчууд чөлөөт

байдлыг хамгаалахад шаардлагатай ямар чухал ашиг сонирхолтой байна вэ гэдгийг нухацтай хэлэлцэж, шинэ үндсэн эрхийг хүлээн зөвшөөрөөд явахад халдашгүй, чөлөөтэй байх эрх зориулагдсан.

Эндээс хувийн халдашгүй байдлыг тайлбарлая. Хувийн халдашгүй байдал нь ерөнхийдөө гурван агуулгыг илэрхийлдэг. Нэгд, хувийн орон зай халдашгүй байх эрх. Хувь хүний гэр орон төдийгүй утас, компьютер халдашгүй байх, бас ажлын байранд ч ийм орон зайтай байхыг хүлээн зөвшөөрч, хамгаалдаг. Хоёрт, хувь хүний тусгаар (хараат бус, бие даасан) байдлыг хамгаалдаг. Энэ нь хувийн амьдралтайгаа холбоотой аливаа шийдвэрийг гаргах эрх юм. Жишээ нь, хэнтэй гэрлэх, хэнтэй найзлах, амьдралын ямар хэв маяг сонгох, хэнтэй дотно харилцаанд орох, ямар ном унших, ямар сургуульд явах, ямар мэргэжил эзэмших зэрэг шийдвэрийг зөвхөн тэр хувь хүн гаргах эрхтэй. Гуравт, хувийн нууц халдашгүй байх эрх. Захидал харилцааны нууц байх эрх бол үүний цөм.³⁵

Хувийн халдашгүй байдлыг хүлээн зөвшөөрч, хамгаалах нь Монгол Улсад тулгамдсан асуудал болоод байна. 1992 онд Үндсэн хууль батлагдсан хүмүүсийн төсөөлөөгүй ертөнцөд бид өнөөдөр амьдарч байна. Үүний нэг жишээ бол мэдээллийн технологийн тогтолцоо (МТТ) юм. Монголын Засгийн газар интернетийг хянах, мөрдөх хамгийн хүчтэй, үнэтэй програмыг олон удаа худалдаж авсан тухай мэдээллийн хэрэгслээр мэдээлэх болсон. Энэ програмыг ашиглан тагнуул, цагдаа, бусад хууль сахиулах байгууллага иргэний утас, компьютер зэрэг хэрэгслийг чагнаж, хянаж байгаа эсэхийг мэдэхэд хэцүү байна. Орчин үед хувь хүн МТТ дотор бараг амьдарч, хувь хүнийхээ хувьд оршин байна. Хувь хүний фэйсбүүк, твиттер, гар утас руу нь орж харвал тухайн хүнийг хэн бэ гэдгийг, хамгийн дотоод,

³⁰ Б.Чимид, Үндсэн хуулийн мэдлэг (УБ, 2008), 130.

³¹ Ibid., 126.

³² Ж.Бямбаа, “Арван зургадугаар зүйлийн 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14,” Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар дотор (УБ: Ханнс Зайделийн Сан, 2009), 90–94.

³³ Г.Банзрагч, Эдийн засгийн эрх зүй (УБ, 2013), 60.

³⁴ Б.Буянхишиг, “Эдийн засгийн эрх чөлөөг үндсэн хуулиар хангалттай хамгаалсан уу?,” Үндсэн хууль ба эрх зүйт ёс VII дотор (УБ, 2016), 22.

³⁵ Монгол Улсад захидал харилцааны нууцад прокурорын зөвшөөрлөөр халдах хууль зүйн боломжтой. Гэвч, энэ эрхэд дур зоргоор халдахаас сэргийлэх үр нөлөөтэй арга бол зөвшөөрлийг прокурор бус шүүхээс өгдөг болох явдал. Яллах талын бус хөндлөнгийн этгээд болох шүүгчийн зөвшөөрлөөр тухайн эрхэд халдах зүй ёсны үндэслэл байна уу, зохих журмын дагуу ажилласан уу гэдгийг хянадаг болох хэрэгтэй.

хувийн орчин руу нь өнгийх боломжтой. Дур зоргын ийм халдлагаас иргэний хувийн халдашгүй байдлыг хамгаалахын тулд МТТ болон онлайн орчин дахь хувийн халдашгүй байдлыг хүлээн зөвшөөрч, үндсэн эрхийн түвшинд хамгаалдаг болох шаардлагатай. Үүнийг хүлээн зөвшөөрөх үндэслэл нь Үндсэн хуулийн 16-р зүйлийн 13-т буй халдашгүй, чөлөөтэй байх эрх, үүний зайлшгүй хэсэг болсон хувийн халдашгүй байдал юм. Халдашгүй, чөлөөтэй байх эрхийн хүрээнд хувийн халдашгүй байдал хамгаалагдах ёстой. Германы Холбооны Үндсэн хуулийн шүүх шиг Үндсэн хуулийн цэц эсхүл Улсын Их Хурал Үндсэн хуулийг тайлбарлаж нэрлэгдээгүй энэ эрхийг хамгаалах шаардлагатай. Үндсэн хуульд үүнийг нэрлэж заагаагүй гэдгээр нь үндсэн эрхийн түвшинд хамгаалахгүй орхиж болохгүй.

Дүгнэлт

Энэ өгүүллийн хүрээнд үндсэн эрх, эрх чөлөөний суурь болсон тэгш, чөлөөт байдлыг товч тайлбарласан. АНУ, ХБНГУ гэсэн ардчилсан улсын үндсэн хуульд тэгш, чөлөөт байдлыг хамгаалахад чухал эрхүүдийг шууд нэрлэж хамгаалдаг төдийгүй энэ зорилгод зайлшгүй хамгаалагдах ёстой ч нэрлэгдээгүй эрхийг хөгжүүлэх боломж олгосон ерөнхий заалтуудыг агуулдаг. АНУ-ын Дээд шүүх тэгш хамгаалалт болон чөлөөт байдлын хүрээнд нэрлэгдээгүй эрхүүдийг хүлээн зөвшөөрч хамгаалдаг бол Германы Холбооны Үндсэн

хуулийн шүүх хүний эрхэм чанар, тэгш байдал, хувь чанараа чөлөөтэй хөгжүүлэх эрхийн хүрээнд ийм эрхүүдийг хүлээн зөвшөөрч хамгаалдаг. Монгол Улсын хувьд ч тэгш байдал болон халдашгүй, чөлөөтэй байх гэсэн хоёр ерөнхий эрхийн заалтыг үндэслэлтэй тайлбарлах замаар Үндсэн хууль дахь үндсэн эрхийн хамгаалалтыг тэлэх, шинэ эрхүүдийг хүлээн зөвшөөрөх, Үндсэн хуулийг бүхэлд нь тэгш, чөлөөт байдал гэсэн үнэт зүйлээр утгажуулах хэрэгтэй гэдгийг жишээн дээр тайлбарлав. Тэгш, чөлөөтэй байдалд зайлшгүй чухал ашиг сонирхлуудыг Үндсэн хуулийн төвшинд хүлээн зөвшөөрч хамгаалах эсэхийг үе үеийн Монголчууд шийдвэрлээд явах бүрэн боломжтой.³⁶

Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа

³⁶ Тэгш, чөлөөт байдлын хүрээнд ямар эрхийг үндсэн эрхэд тооцож хамгаалах вэ гэдэг бол хэцүү асуулт. Энэ асуултад хариулахын тулд үндсэн хууль тайлбарлах онолууд, тэдгээрийн харьцуулалтыг ярих шаардлагатай учраас энэ илтгэлийн хүрээнд үүнийг хөндөхөө азнав. Хүний эрхийн Үндэсний Комисс болон Нээлттэй нийгэм форумас зохион байгуулдаг Хүний эрхийн цуврал лекц дээр "Хүний эрхийн заалтыг тайлбарлах нь" гэдэг илтгэлийг миний бие хэлэлцүүлэхдээ энэ онолын маргааныг танилцуулж, өөрийн байр суурийг илэрхийлсэн. Энэ лекцийг онлайн үзэх боломжтой. О.Мөнхсайхан, "Хүний эрхийн заалтыг тайлбарлах нь," 2015.06.19, <http://www.mn-nhrc.org/index.php?newsid=5785> Мөн, энэ талаар бичсэн миний номыг уншиж танилцах боломжтой. Munkhsaikhan O., Towards Better Protection of Fundamental Rights in Mongolia: Constitutional Review and Interpretation, CALE Books 4 (Center for Asian Legal Exchange & Graduate School of Law, Nagoya University, 2014), 186–196.

ОИХ.МН
СУДАЛГААНЫ САН

ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГ ХАНГАХ ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙН БОДЛОГО, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ



Хууль зүйн яамны
Төрийн нарийн бичгийн дарга

Ж.БАЯРЦЭЦЭГ

Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Юуны өмнө Хүний эрхийн Үндэсний Комиссын 15 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан үе үеийн Комиссын ажилтнууд болон дарга гишүүдэд Хууль зүйн яамныхаа хамт олон, Хууль зүйн сайдынхаа нэрийн өмнөөс дахин баяр хүргэе.

Хүний эрхийн Үндэсний Комиссын 15 жилийн ой бол хүний эрхийн хөгжлийн 15 жилийн ой гэсэн үг. Энэ нь зөвхөн нэг байгууллагын хүрээнд яригдах тоо биш Монгол Улсын Үндсэн хуулийн төлөвшлийн ялангуяа Үндсэн хуульд заасан хүний эрхийг хэрэгжүүлэхэд олсон ололт амжилт, сорилтын түүх, мөн зөвхөн Хүний эрхийн Үндэсний Комиссын түүх гэхээсээ илүү төрийн байгууллагын төлөвшлийн түүх юм.

Төрийн байгууллагын үндсэн суурь мөн чанар нь иргэдийнхээ эрхийг баталгаажуулах, хангах, суурь үйлчилгээг үзүүлэх зорилготой байдаг. Энэ утгаараа төрийн байгууллага, ялангуяа хууль зүйн салбарын төлөвшил, хөгжил, хүний эрхийг хамгаалах чиглэлээр хийж буй ажлын түүх гэж би том утгаар нь харж байна. Иймээс энэ ойн өдөр чухал ач холбогдолтой өдөр юм.

Миний өмнө хэлсэнчлэн хууль зүйн салбарын хөгжил төлөвшлийн түүх юм. Бид энэ 15 жилийн хугацаанд хүний эрхийг хамгаалах чиглэлээр алдсан, оносон нь ч их байгаа, суралцсан нь ч их байгаа, суралцаж байгаа, төлөвшиж байгаа энэ үйл явц маань Ж.Бямбадорж даргын танилцуулсан энэ олон чиг үүргийн хүрээнд бий болсон 14 удаагийн Монгол Улс дахь хүний эрх эрх чөлөөний байдлын талаарх илтгэлүүд, мянга мянгаар тоологдох шалгалтууд, иргэдийг чадавхижуулах чиглэлээр хийсэн сургалт, энэ олон ном товхимол, гарын авлагаас харагдаж байна. Энэ нь нэгэн байгууллагын хийдэг ажил гэхээсээ илүү төрийн байгууллагын хүний эрхийн төлөвшилд хувь нэмрээ оруулсан том ажил болсон.

Миний танилцуулах гэж буй эрх зүйн шинэчлэлийн үйл явцтай холбоотой зүйл нь хүний эрхийн төлөвшил, Хүний эрхийн Үндэсний Комиссын хийж байгаа үйл ажиллагаа эрх зүйн шинэчлэлтэйгээ яах аргагүй шууд уялдаа холбоотой явсан билээ. Эрх зүйн шинэчлэлийн үр дүн та нарын хийсэн олон ажлын үр дүн гэдгийг дахин цохон тэмдэглэе.

Та бүхэн мэдэж байгаачлан өнгөрсөн

жил Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн зөвлөлийн гишүүнээр хамгийн их санал аван сонгогдсон билээ. Хүний эрхийн зөвлөлийн гишүүнээр сонгогдоно гэдэг өөрөө нэр төрийн хэрэг.

Бид хэдийгээр дотооддоо хүний эрхийн асуудлаар олон алдаа оноо, цаашид хийх зүйл их байгаа ч гэсэн олон улсын тавцан дээр та бүхний хийсэн ажлын үр дүн үнэлэгдэж Хүний эрхийн зөвлөлийн гишүүнээр сонгогдох болсон нь нэр төрийн асуудал, ийнхүү сонгогдоход та бүхний оролцоо их байгаа гэдгийг цохон хэлье.

Хууль эрх зүйн шинэчлэл нь хүний эрхийг хангахад, мөн хүний эрхийг сахин хамгаалахад эрх зүйн шинэчлэл ямар уялдаа хамааралтай талаар, ялангуяа Засгийн газрын зүгээс, Хууль зүйн яамны зүгээс хийж буй эрх зүйн шинэчлэлийн процессын талаар та бүхэнд танилцуулъя.

Ер нь улс орны хөгжил нь зөвхөн эдийн засгийн хөгжил, дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтөөс хамаардаггүй, хүний хөгжлийн асуудал байдаг. Хүний хөгжил гэдэг нь тухайн иргэн Үндсэн хуулиар болон бусад хүний эрхийн суурь конвенцуудаар олгогдсон хүний эрх, эрх чөлөөгөө хэрхэн эдэлж чадаж байна вэ гэдэг асуудал гол суурь үзүүлэлт. Хүний хөгжлийн индекс, бусад олон индексээр хүний эрхийг хэрхэн хангаж байгааг тусгайлан авч үздэг. Улс орны хөгжил, эдийн засгийн хөгжил ярьж байгаа энэ үед хүний эрхийн талаар ялангуяа эрх зүйн шинэчлэл, төрийн байгууллагын төлөвшилийг үнэлэхэд хүний эрхийг хэрхэн хамгаалж байна вэ гэдэг нь чухал үзүүлэлт байдаг. Тиймээс эрх зүйн шинэчлэл, хуулийн шинэчлэлийн гол суурь цөм нь хүний эрхийг хангадаг, хүний эрхийн суурь хэрэгцээг хүргэдэг энэ тогтолцоонд суурилсан байгаа.

Үндсэн хууль, Үндсэн хуулийн төлөвлөлөөс хойш Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэх, энэ шинэчлэл, процесс хорь гаруй жил үргэлжлээд явж байна. Эрх зүйн шинэчлэл

гэдэг утгаараа хуульчдын дунд, Хууль зүйн яам, хуулийн салбарынхны дунд хоёр давалгаагаар ярьдаг. Эхний давалгаа нь 2000 оноос эхэлсэн, 2003 онд Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр, 1998 онд эрх зүйн шинэчлэлийн хөтөлбөр батлагдсан, энэ хүрээндээ хүний суурь эрхийг хангах төрийн институцүүд жишээлбэл Хүний эрхийн Үндэсний Комисс, Шүүх, Прокурор, Цагдаагийн байгууллагуудыг хөгжүүлэх шинэчлэлийн бодлогууд явж байсан. Гол гол суурь хуулиуд маань шинэчлэгдэн батлагдсан байна. 2003 оноос өнөөг хүртэл эхний давалгаагаар 180 гаруй хууль шинэчлэгдэн Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрхийг хангах чиглэлээр нилээдгүй ажил хийгджээ. Зөвхөн хууль батлагдахаасаа гадна хуулийн үзэл санаа амьдралд хэрэгжих талаасаа төрийн институцүүдийг бэхжүүлэх ажил тодорхой хэмжээгээр хийгджээ.

10 жилийн дараа буюу 2013 оноос эрх зүйн шинэчлэлийн хоёр дахь давалгаа буюу дараагийн үе эхлээд явж байна. Шинэчлэлийн Засгийн газраас алдаа оноон дээрээ суурилад хүний эрхийг хангах чиглэлээр эрх зүйн орчноо улам төгөлдөржүүлэх, боловсронгуй болгох, ялангуяа олон улсын гэрээ конвенцид заасан хүний эрхийн суурь зарчмаа 10 жилийн алдаа оноон дээрээ суурилад, мөн нийгэм, эдийн засгийн шинэ онцлогт тохируулан дахин эргэн харж, засаж сайжруулсан үе байсан.

Энэ хүрээнд Засгийн газраас нилээдгүй цогц бодлогыг хэрэгжүүлж байгааг Хууль зүйн яам толгойлоод ажиллаж байна. Гол нь хууль, эрх зүйн салбарын эрх зүйн орчныг цогцоор нь шинэчлэх ажил эхэлсэн байгаа. Ялангуяа эрүүгийн эрх зүйн цогц шинэчлэлийг эхлүүлээд явж байна. Хуульчдын маань төрийн байгууллагын, хууль сахиулах байгууллагуудын өдөр тутам хэрэглэдэг хуулиудыг цогцоор нь шинэчилсэн. Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа 446 хууль, Хууль зүйн яаманд бүртгэлтэй, нийтээр дагаж мөрдөх, сайдын тушаал, хамтарсан тушаал, засаг даргын захирамж гэх мэт 950 гаруй хууль тогтоомж актуудыг хүний эрхэд

суурилсан байдлаар хүний эрхийг хангаж буй эсэх, хүний эрхийг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагаас тогтоосон хэм хэмжээ нь тодорхой хэмжээгээр хязгаарлаж буй эсэх зэрэгт анализ хийхийг оролдсон болно.

Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийнхээ хүрээнд 10 гаруй хуулийг 3 жилийн хугацаанд шинээр батлуулсан. Эрүүгийн болон зөрчлийн хууль оны өмнө батлагдсан, хэвлэл мэдээлэл, бусад хэрэгслээр нилээд яригдсаныг та бүхэн мэдэж байгаа. Мөн эрүүгийн эрх зүйн цогц шинэчлэлийн хүрээнд эрүүтэй холбоотой ялангуяа эрүүгийн эрх зүйн шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр төрийн байгууллагын хууль, эрх зүйн орчныг шинэчилж байна. Ялангуяа Цагдаагийн албаны тухай, Тахарын албаны тухай хуулийг шинээр батлуулж уг байгууллагыг байгуулаад явж байна. Төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх эрх зүйн туслалцааны төвийг байгууллаа. Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль, мөн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийг батлуулсан. Энэ хүрээндээ Тахарын алба маань гэрч хохирогчийг хамгаалах үйл ажиллагааныхаа хүрээнд 40 гаруй гэрч, хохирогчид хамгаалалт үзүүлээд явж байна. Эрх зүйн шинэчлэлтэй холбоотой суурь 10 гаруй хууль батлагдчихлаа, одоо Улсын Их Хурал дээр мөн 10 гаруй хууль батлагдах гэж байна. Энэ хүрээнд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчлийг хянан шийдвэрлэх тухай зэрэг процессын хуулиуд, ялангуяа Хохирол хамгаалах сангийн тухай хууль, мэдээж гэмт хэрэгт хамгийн их яригддаг зүйл хохирогчийн гол эрх ашиг хөндөгддөг зүйл нь хохирол хамгааллын асуудал байдаг.

Эдгээр хуулиуд батлагдаад явбал эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн хамгийн чухал гол эрх зүйн орчин шинэчлэгдээд явах боломжтой байгаа. Эрх зүйн шинэчлэлийн хүрээнд зөвхөн эрүүгийн шинэчлэлийн асуудлыг яриагүй, цогц шинэчлэл гэдэг утгаараа бусад салбар эрх зүйн шинэчлэлээ давхар авч явж байна. Онцолбол, захиргааны байгууллага, ялангуяа

хүний эрхийг хамгаалах чиг үүрэгтэй төрийн байгууллагын үйл ажиллагаа, чиг үүргийг тодорхой болгох, нарийн стандарттай болгох шинэчлэлийг давхар хийгээд явсан.

Цохон дурдах хууль бол 2015 оны 6 сард батлагдсан Захиргааны ерөнхий хууль. Энэ хууль энэ оны 7 дугаар сараас мөрдөгдөөд явна. Энэ хуулиар төрийн байгууллагуудын үйл ажиллагааг маш нарийн стандарчилж зохион байгуулсан. Ингэснээрээ хүний эрхийг зөрчдөггүй байх, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчсөн тохиолдолд дараагийн шатны арга хэмжээг хэрхэн яаж авах вэ гэдгийг нарийвчлан зохицуулснаараа төрийн байгууллагын хувьд өдөр тутам ашигладаг Үндсэн хууль шахуу хууль болсон. Энэ хуулиар захиргааны байгууллагын акт, шийдвэр яаж гарах вэ гэдгийг нарийн тодорхойлохоос гадна акт шийдвэрийг гаргахдаа заавал иргэдийг оролцуулдаг байх, шийдвэр гаргах асуудлаараа заавал судалгаа, шинжилгээ, анализ хийдэг байх зэрэг маш өндөр шалгууруудыг тавьж өгснөөрөө хүний эрхийг цааш цаашдаа хангах, зөрчихгүй байх зохицуулалтыг хийсэн. Үүний адилаар мөн зайлшгүй цохон хэлэх хууль бол Хууль тогтоомжийн тухай хууль байгаа. Сүүлийн үед хууль маш амархан төрж байна, аливаа судалгаа, шинжилгээгүй, оролцоогүй боловсруулагдсан хууль нь тухайн харилцааг зохицуулахдаа иргэдийн эрх ашгийг их хэмжээгээр зөрчиж хөндөж байна гэсэн шүүмжлэл их өрнөж байдаг. Иймээс Хууль тогтоомжийн тухай хуулиар хууль төрнө гэдэг нилээд амаргүй болж байгаа. Яагаад гэвэл хууль гэдэг нь бүх нийтээрээ дагаж мөрдөх чухал харилцааг зохицуулж байдаг эрхийн акт, энэ утгаараа ч олон шалгуур, олон иргэдийн оролцоо, судалгаа, үнэлгээ, дүн шинжилгээ хийсний дараа л батлагддаг нарийн шалгууртай болсон. Энэ хуулийг батлуулж ирэх оноос мөрдөж эхэлнэ. Мөн Захиргааны процесс гэж хуульчдын дунд яригддаг, цохон дурдахгүй байж болохгүй хууль бол Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль бөгөөд энэ энэ долоо хоногтоо Улсын Их Хурлаар батлагдана гэсэн хүлээлттэй байна. Манай яам процессын

гурван суурь хуулиа шинэчлээд явж байна.

Захиргааны процессын хуульд хүний эрх, эрх чөлөөг хамгаалах үүднээсээ чухал харилцаа орж ирж байгаа нь Захиргааны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг нилээд тодорхой болгосон, хүний эрхийг хангахад бүх шүүх чухал үүрэгтэй, үүн дотроос Захиргааны хэргийн шүүх нь төрийн байгууллагын зүгээс хүний эрхийн зөрчиж байгаа тохиолдолд хүний эрхийг хамгаалах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чухал институт байна. Тэр утгаараа ч Захиргааны хэргийг хянан шийдвэрлэх тухай хуулийг шинэчилж найруулсан болно. Мөн нэг чухал зохицуулалт нь шүүхэд нийтийн эрх ашгийг нэхэмжлэн төлөөлөх асуудал. Энэ асуудал олон жил төрийн бус байгууллага, хүний эрхийн төлөө тэмцэгчдийн дунд ярьсан, тодорхой хэргүүдийг нийтийн эрх ашгийн өмнөөс амжилттай нэхэмжлэн хамгаалж байсан тодорхой жишээнүүд байдаг. Үүнийг хуулиараа эрхийг нь нээж баталгаажуулснаараа онцлог юм.

Мөн Хүний эрхийн Үндэсний Комиссыг цохон дурдмаар байна. Нийтийн эрх ашгийг, хүний эрхийг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах бүрэн эрхтэй байхаар Комиссын тухай хуульд хуульчилсан. Энэ бүрэн эрхээ үнэхээр сайн хэрэгжүүлж, анхны жишиг, анхны түүхийг бий болгож байсан. Олон хэрэг дээр шүүхээр орж төлөөлөн нэхэмжлэл гаргаж байсан, энэ жишиг дээр тулгуурлан энэ эрхийг задалж Захиргааны процессын хуульд тусгаж өгсөн. Хүний эрхийн чиглэлээр, нийтийн эрхийн чиглэлээр ажилладаг эдгээр байгууллагууддаа заавал орон нутагт хохирчихоод байгаа иргэн, шүүхийн процессыг дагаж явалгүйгээр тухайн чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагууд нь эрхийг нь хангаж ажиллах бололцоог нээж өгч байгаагаараа чухал алхам болж байгаа гэж найдаж байна.

Хууль зүйн яамнаас олон төрлийн хуулиуд батлагдаад явж байна. Тухайлбал Бүртгэлийн багц хуулиуд, Хөдлөх эд хөрөнгийн тухай хууль, Хуулийн этгээдийн бүртгэлийн

тухай хууль, Иргэний бүртгэлийн хууль гэх мэт. Эдгээр бүртгэлийн багц хуулиуд нь захиргааны процессын шинжтэй мэт боловч цаанаа хүний суурь эрхийг төрийн зүгээс хангах чухал хуулиуд юм.

Хуулиуд батлагдах нь нэг ажил, хууль батлагдаад батлагдсан концепцийн дагуу хууль бүрэн утгаараа хэрэгжинэ гэдэг төрийн байгууллагуудын хувьд хамгийн чухал зүйл байдаг. Хуулийн хэрэгжилтийг хангана гэдэг бол Засгийн газар үүн дотроо Хууль зүйн яамны үндсэн зорилго, нөгөө талаасаа сорилт болж байгаа. Хууль сахиулагчид маань хуулийг үндсэн концепцийнх нь дагуу хэрэгжүүлнэ гэдэг нь маш чухал, тиймээс салбарынхаа албан хаагчдыг чадавхижуулах, мэргэшүүлэх, хүний эрхийн хандлагатай болгох олон ажлууд бидний өмнө байна.

Хуулийн хэрэгжилттэй холбоотой миний өмнө дурдсан цагдаа, тахар зэрэг институт дээр олон ажлууд хийгдэж байна, жишээ дурдахад гэр бүлийн хүчирхийллийн асуудал олон жил яригдсан тулгамдсан асуудал байсан, хуулийн шинэчилсэн найруулга Улсын Их Хурлаар батлагдах гэж байна. Энэ хүрээнд цагдаагийн байгууллага буцаад хариу үйлдэл үзүүлдэг тогтолцоог бүрдүүлэх гэж нилээд чамгүй ажил хийгдсэн. Түр хамгаалах байр байгуулагдсан. Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүд саяхан очиж үйл ажиллагаатай нь танилцсан байсан. Төрийн анхны хамгаалах байр гэдэг утгаараа нилээд ач холбогдол өгч байна, бидэнд алдах, онох зүйлс их байна. Төр өөрөө анх удаа хохирсон иргэдийнхээ төлөө нөөц, хөрөнгөө гаргаж зохион байгуулалт хийнэ гэдэг тодорхой нэг алхам гэж бодож байна, шууд утас ажиллаж байна, гэр бүлийн хүчирхийллийн тусгай нэгж байгуулагдсан, эмэгтэй мөрдөн байцаагч нарыг бэлтгэж байна, цагдаагийн алба хаагчдын сургалт явуулж байна гэх мэтчилэн дурдаад байвал олон ажлууд байгаа. Цаашдаа ч олон ажлууд хийгдэхээр хүлээгдэж байна. Эдгээр ажлуудыг бүрэн утгаар нь хэрэгжүүлэхэд нилээдгүй жилийн зүтгэл, мэдээж Хууль зүйн яам, Засгийн газрын гэхээсээ илүүтэй

хамтын оролцоо хэрэгтэй. Үүнд Хүний эрхийн Үндэсний Комисс өнөөг хүртэл гүйцэтгэж ирсэн үүрэг, оролцоогоороо бидэнд дэмжлэг үзүүлнэ гэж найдаж байна. Та бүхний хяналт шалгалттай холбоотой шаардлага, зөвлөмж бидэнд юун дээр алдаж байна, юу нь онож байна, цаашид юунд анхаарах вэ гэдэгт байнга дохио, чиглүүлэгч луужин болж явдаг.

Цаашид албан хаагчдаа, иргэдээ сургах ажлыг Хүний эрхийн Үндэсний Комисстой хамтран хийнэ гэж найдаж байна, өнөөдөр ойн арга хэмжээгээ тэмдэглэж буй энэ чухал

өдөр Комиссынхон маань зөвхөн өөрсдөө ярих биш, бусдын хийсэн, судалсныг сонсож, хүний эрхийн талбарт юуг олов, юуг алдав гэдгээ эргэн харж дүгнэх арга хэмжээг зохион байгуулж байгаад хувь хүнийхээ зүгээс талархаж байна.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссынхон Та бүхэнтэй Хууль зүйн яамны зүгээс хамтран ажилласаар ирсэн, цаашид ч хамтран ажиллахад бэлэн байна.

Хүний эрхийн төлөө зүтгэх цаашдын тань ажилд амжилт хүсье.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ХОРИХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ ТОГТОЛЦООНЫ ПАРАДИГМ³⁷



Хууль Сахиулах Их Сургуулийн
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн
сургуулийн захирал, Хууль зүйн ухааны
доктор, дэд профессор, хурандаа

Н.ГАНТУЛГА

Abstract ³⁸

The main goal of the scientific paper is to conduct partial analyze on the issues related to how “Standard Minimum Rules for the Treatment of Prisoners” has been constituted and implemented in domestic laws and legislations, as well as some useful suggestions and solutions have been concluded in order to improve the problem.

Түлхүүр үг

Хорих ял, хоригдол (ялтан, хорих ял эдлэгсэд, хоригдогсад), хорих ял эдлүүлэх (засан хүмүүжүүлэх) байгууллага, Хүний эрхийн билл, олон улсын гэрээ, олон улсын стандарт, хорих ял эдлэх нөхцөл, ялтныг нийгэмшүүлэх ажиллагаа, парадигм зэрэг.

Товчилсон үг

ХЭҮК- Хүний эрхийн Үндэсний Комисс
НҮБ- Нэгдсэн Үндэстний Байгууллага
ЭХ- Эрүүгийн хууль
ШШГТХ- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх
тухай хууль

Оршил

Эрхэм хүндэт Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, ноён Ж.Бямбадорж, гишүүдээ!

Мэргэжил, зорилго нэгт нөхөд,
Эрхэмсэг ноёд, хатагтай нараа!

Юуны өмнө “хүний эрх”-ийг нийгмийн хамгийн үнэ цэнэтэй, бодитой зүйл болгох их үйлсэд мэдэгдэхүйц амжилт, үр дүнд хүрч, үүргээ тууштай хэрэгжүүлж байгаа Монгол Улсын ХЭҮК-ын хамт олон та бүхэнд 15 жилийн ойн баярын чин сэтгэлийн мэндчилгээ хүргэе.

Мөн надад энэ хүндтэй, босго шалгуур өндөр онол, практикийн хуралд илтгэл хэлэлцүүлэх хүсэлт тавьж, оролцуулж байгаа хурал зохион байгуулагчдад талархал илэрхийлж байгааг минь хүлээн авна уу.

Энэ сэдвээр илтгэл хэлэлцүүлэх олон шалтгаан байгаагийн нэг нь хорих ял хүний

³⁷ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын 15 жилийн ойд зориулсан “Хүний эрхийн төлөө хамдаа зүтгэсэн 15 жил” онол, практикийн хуралд хэлэлцүүлсэн илтгэл (Хууль зүйн үндэсний хүрээлэн), 2016 оны 02-р сарын 01-ний өдөр, Улаанбаатар хот.

³⁸ Илтгэлийн хураангуй: Судлаач “Хорих ял эдлүүлэх ажиллагааны буюу хоригдолтой харьцах олон улсын стандарт” манай орны төрийн бодлого, хууль тогтоомжид хэрхэн бэхжин илэрлээ олсон, мөн хэрхэн хэрэгжиж байгаа талаар явуулсан хэсэгчлэн судалгааны үр дүн, түүнтэй холбогдсон дүгнэлт, саналыг тусгав.

үндсэн эрхийг хамгийн ихээр хөнддөг, мөн түүнийг эдлүүлэх явцад багагүй бэрхшээл, цөөнгүй зөрчил дутагдал гардаг байдлыг харгалзан улс орны бодит амьдралыг “нийтийн үйлчилгээний болон хорих газар”-аар шинжиж болно гэсэн олон улсын судлаачдын зөвлөмжийг удирдлага болгосонтой холбон ойлгож болно.

Иймд илүү нарийвчилсан, мэргэжлийн үйл ажиллагааны талаар нурун ярьж та бүхнийг залхаавал намайг уучлан илтгэлийг зогсоох эрх хурал хөтлөгч, бусад оролцогчдоод байгаа гэдгийг хэлье.

Удиртгал

Монгол Улс 1961 онд НҮБ-д бүрэн эрхт гишүүнээр элсэж, 1988 онд Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвенцид нэгдэн орсноор “**pacta sunt servanda**”-г олон улсын болон үндэсний эрх зүйн зохицуулалтын нэг гол зарчим-хэм хэмжээ мөн гэдгийг дахин дэлхий дахинаа албан ёсоор нотолсон хууль зүйн үйл явдал болсон.

Мөн энэ хэм хэмжээг 1992 онд манай улс эрх зүйн хамгийн дээд хүчин чадал бүхий барим бичиг болох Үндсэн хуульдаа³⁹ хуульчлан бататгасан нь гадаадын орон, олон улсын байгууллагаас манай улсад хандах, манай улстай харилцах хамтын ажиллагааг өргөжүүлэх итгэлцлийн гүүр болсон.

Өнөөдөр Монгол Улс НҮБ-ын Ерөнхий Ассамблейн баталсан “Хүний эрхийн билл” гэж нэрлэдэг Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай, Нийгэм, эдийн засаг, соёлын эрхийн тухай олон улсын пактууд зэрэг шүүх эрх мэдлийн салбарын 30 гаруй олон улсын олон талт гэрээнд нэгдэн орж⁴⁰ дэлхийн хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлж байна.

XX-XXI зуун өмнөх зуунуудаас цөөнгүй онцлох үйл явдлаар ялгардаг ба эдгээрт хүний

эрхийн үзэл санаа, эрх зүйн зохицуулалт, шүүх, хууль зүйн практикийн хөгжил дэвшил, хүний эрхийн салбарын хамтын ажиллагааны үр дүн онцгой байрыг эзэлдэг.

Мөн энэ цаг үед глобалчлал, объектив, субъектив бусад хүчин зүйлсийн улмаас гэмт хэргийн⁴¹ аюул занал, хор уршиг нь хувь хүн, өрх гэр, улс орон төдийгүй дэлхий дахинаа нөлөөлж буйг тодотгохын зэрэгцээ шударга ёсыг тогтоох хүрээнд нэг талаас нийгэм, хохирогчийн, нөгөө талаас гэмт хэрэгтэн, ял эдлэгсдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангах эрх зүйн механизмыг төгөлдөршүүлэх, тэнцвэртэй, зохистой орчинг бүрдүүлэх явдал улс орон, олон улсын байгууллагын анхаарлыг улам бүр татаж, энэ нь хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэл, өргөн талбар болсоор байна.

Иймээс миний бие “Хорих ял эдлүүлэх ажиллагаа” буюу “Хоригдолтой харьцах олон улсын стандарт”⁴² манай орны төрийн бодлого, хууль тогтоомж, цаашдын төсөөлөлд хэрхэн бэхжин илэрхийллээ олсон талаарх өөрийн хийсэн судалгааны⁴³ үр дүн, дүгнэлтийг танилцуулан цаашид үндэсний эрх зүйн механизмыг төгөлдөршүүлж зохистой орчин бүрдүүлэхэд нэн түрүүнд хууль тогтоомж, хууль зүйн практикт юу хийх шаардлагатай вэ гэсэн өнцгөөс зорилгоо харж илтгэлээ бэлтгэн байр сууриа илэрхийллээ.

Үндсэн хэсэг

Манай Улсын хууль тогтоомж, шүүхийн болон хууль зүйн практик, судалгааны бусад эх сурвалж-материалуудад тулгуурлан шинэ цаг үеийн эрх зүйн хөгжлийн 1920-1980-аад оны гэмт хэрэгтэй тэмцэх эрүүгийн ялын ба ял эдлүүлэх ажиллагааны төрийн бодлого дараах үзэл санаа, практикт тулгуурлан хэрэгжиж байсныг тодотгож байна. Энэ нь:

³⁹ 10-р зүйлийн 2 хэсэг “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ”, 10-р зүйлийн 3 хэсэг “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” ((Төрийн мэдээлэл. УБ 1992 №01

⁴⁰ www.Legalinfo.mn; www.parlament.mn; www.mfa.gov.mn

⁴¹ Ялангуяа хил дамнансан зохион байгуулалттай гэмт явдал

⁴² Олон улсын хэмжээнд хорих ял эдлүүлэх ажиллагаа, хоригдолтой харьцах стандартыг нэг ойлголт гэж үздэг.

⁴³ Энэхүү судалгаанд эрх зүйн баримт бичиг, хууль зүйн практик, мэдээ мэдээлэлд дүн шинжилгээ хийх, харьцуулах, биечлэн сурвалжлах, фокус ярилцлага, ажиглалт хийх зэрэг аргыг голлон ашигласан.

Гэмт хэрэг бол буурай хөгжилтэй болон капиталист орнуудын нийгмийн үзэгдэл тул түүнийг бүрэн арилгах зорилт;

Эрүүгийн хариуцлага, ял нь “цээрлэлд тулгуурласан ял эдлүүлэх хугацааны болон түүнийг эдэлсний дараах эрхийн хязгаарлалтаар хэрэгжих үзэл санаа”;

Гэмт хэрэгтэй хийх тэмцэл улс орны дотоодын асуудал тул салбарын хууль тогтоомжийг эхний ээлжинд хууль хэрэглэгчдэд хүргэх⁴⁴, холбогдох харилцааг эрх зүйн дэд актуудын түвшинд⁴⁵ хэм хэмжээ тогтоон⁴⁶ нарийвчлан журамлан зохицуулах хууль зүйн практик;

Ялтныг хүмүүжүүлэх (засан хүмүүжүүлэх, дахин хүмүүжүүлэх);

Ялтны хөдөлмөрийг улс ардын аж ахуй, үйлдвэрлэлийн төлөвлөгөөг биелүүлж “эдийн засгийн ашиг олох” арга хэрэгсэл болгон ашиглах практик мөн хэмээн үзэж байлаа.

Тэгвэл 1980-аад оны сүүлчээс манай оронд өрнөсөн ардчилсан хөдөлгөөний үр дүнд батласан 1992 оны Үндсэн хуульд “... эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлоон хөгжүүлэх нь манай ард түмний эрхэм зорилго” гэж хуульчлан тунхагласантай уялдан энэ үеэс салбарын бодлогыг “үзэл баримтлал”-ын хувьд үндсээр нь өөрчлөн, хууль тогтоомжийг шинэчлэх ажил эхэлж өнөөг хүртэл үргэлжилсээр байна.

Хорих ял эдлүүлэх ажиллагаанд хамаарах төрийн өнөөгийн бодлогоос онцлон авч үзвэл:

Хорих ангийн төрөл, дэглэмийг нээлттэй, хаалттай тогтолцоонд шилжүүлэх⁴⁷;

Хоригдогсдыг хуульд заасан шаардлага, олон улсын стандарт, жишигт нийцсэн нөхцөлд ял эдлүүлэх⁴⁸;

Ялтныг нийгэмшүүлэх⁴⁹ зорилтууд тус тус болно.

Олон улсын эрх зүйн эх сурвалжийн тогтолцоонд тулгуурлан хорих ял эдлүүлэх ажиллагаанд хамаарах “төрөлжсөн” дараах олон талт гэрээний актууд өнөөдөр үйлчилж байгааг тодотгож байна. Энэ нь:

Хоригдолтой харьцах наад захын жишиг дүрмүүд⁵⁰;

Хоригдлуудтай харьцах үндсэн зарчмууд⁵¹;

Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц⁵²;

НҮБ-ын Хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүмүүсийг хамгаалах дүрэм (журам)⁵³;

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхийн

⁴⁸ Дурдсан УИХ, Засгийн газрын тогтоолууд болон ХЗДХ-ийн сайдын 2009 оны “Хөгжлийн стратеги, хөтөлбөр батлах тухай” 156-р тушаалын нэгдүгээр хавсралтын 3.5 хэсэг

⁴⁹ ХЗДХ-ийн сайдын 2009 оны “Ялтныг нийгэмшүүлэх хөтөлбөр батлах тухай” 198-р тушаал, ШШГЕГ-ын даргын 2009 оны “Ялтныг нийгэмшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай” А(91-р тушаал

⁵⁰ Энэ баримт бичгийг 1955 онд Женев хотноо хуралдсан НҮБ-ын “Гэмт хэргээс урьчилан сэргийлэх ба эрх зүйн зөрчил үйлдэгдсэд хандах асуудлаарх 1-р их хурлаар баталж, НҮБ-ын Эдийн засаг, Нийгмийн зөвлөлийн 1957 оны 663 С(XXIV), 1977 оны 2076 (LXII) тогтоолоор сайшаасан. Манай орны хувд энэ баримт бичгийг НҮБ-ын Хүний эрхийн төвөөс Монгол Улсад хүний эрхийн асуудлаар хэрэгжүүлж буй төслийн хүрээнд монгол хэлнээ “Хүний эрх. Шүүх эрх мэдлийн салбар дах хүний эрх” УБ.1996 он эмхэтгэлд хөрвүүлэн нийтлэсэн. Тайлбар эмхэтгэлд дурдсанаар түүнийг Монгол Улсын Дээд шүүхийн шүүгчид орчуулж П.Эрдэнэбаяр хянан тохиолдуулжээ. Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд нь англи хэлнээ “Standard Minimum Rules for the Treatment of Prisoners”, орос хэлнээ “Минимальные стандартные правила обращения с заключенными” гэж бичигддэг. ((www.un.org/ru

⁵¹ НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1990 оны 44(111-р тогтоолоор баталсан. ((дурдсан эмхэтгэл

⁵² НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1988 оны 43(173-р тогтоолоор баталсан. ((дурдсан эмхэтгэл

⁵³ НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1990 оны 45(113-р тогтоолоор баталсан. ((дурдсан эмхэтгэл

⁴⁴ Тухайлбал: БНМАУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн 1966 оны хуулийг Ардын их хурлын тэргүүлэгчид нууцын зэрэглэлээр баталсан. ((А. Лхагва “Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын эх сурвалж (уламжлал шинэчлэл)” УБ. 2013, 61-р тал

⁴⁵ ДЯЯ-ны, НАХЯ-ны сайд, УЦСЕГ-ын, Засан хүмүүжүүлэх байгууллага, Хорих ангиудыг удирдах газрын дарга нарын дангаар болон хамтран баталсан тушаалаар голлон журамлаж байсан.

⁴⁶ Хуулийн агуулгыг эрх зүйн дэд актын түвшинд өргөжүүлэн “хэм хэмжээ” тогтоох практик өргөн дэлгэр байсан.

⁴⁷ УИХ-ын 2008 оны 35-р тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.2.11, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 193-р тогтоолоор баталсан “Хорих ангийн төрөл, дэглэмийг нээлттэй болон хаалттай тогтолцоонд шилжүүлэх хөтөлбөр”

эсрэг конвенц⁵⁴;

Насанд хүрээгүй хүмүүсийн талаарх байцаан шийтгэх ажиллагаа явуулах наад захын жишиг дүрэм (Бээжингийн дүрэм)⁵⁵ болон гэрээний бусад актууд болно.

Хэдийгээр олон улсын гэрээний⁵⁶ заалт нь “хэм хэмжээ”, “зарчим”, “зөвлөмж”-ийн хэлбэрээр батлагдаж “онол”-ын хувьд хууль зүйн янз бүрийн үр дагаврыг илэрхийлэх боломжтой боловч нэрлэсэн гэрээнүүдийн заалтуудыг “салбарын олон улсын стандарт” гэж дагаж мөрдөхөөр зөвшөөрөн, хэрэгжүүлэх практик баттай тогтсоор байна⁵⁷.

Иймд олон улсын стандартуудыг олон улсын эрх зүйн субъектуудын хамтын ажиллагаа, харилцан итгэлцэл, түүхэн хөгжлийн ололт амжилт, нийтээр хүлээн зөвшөөрсөн, тэргүүлэх үзэл санааны үр дүн, илэрхийлэл, зайлшгүй биелүүлэх шаардлага гэж тодорхойлж болох бөгөөд ял оногдуулах, ял эдлүүлэх ажиллагаанд хамаарах стандартын онцлог нь ялын бодлогыг либеральчлах, хүмүүнлэг болгох, хүн төрөлхтөний үнэт зүйлсийг эрхэмлэх, хүний эрхийг дээдлэх, ял, ял эдлүүлэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхэд улс гүрнүүдийн бодлого, эрх зүйн журам, арга хэрэгсэл, үйл ажиллагааг нийцүүлэн хэрэгжүүлэх нэгдмэл үзэл санаа, хүсэл тэмүүлэлд захирагдаж байна хэмээн хэлж болно.

Хорих ял эдлүүлэх ажиллагааны стандартыг олон улсын гэрээний актуудын хууль зүйн техник, энэ харилцааны үе

шат, зохион байгуулалт, төрөл, хэлбэр зэрэг онцлогт нь тулгуурлан тодорхой “институци”-ээр зааглан үздэг ба “зарим стандарт”-тай холбогдсон асуудлыг авч үзье.

А. Хорих ялын зорилго

Манай улсын Эрүүгийн хуулийн 45-р зүйлийн 45.3 хэсэгт “Эрүүгийн хариуцлагын зорилго нь иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргийн улмаас зөрчсөн эрхийг сэргээх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, хүмүүжүүлэх, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд оршино”;

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 5.1-р зүйлийн 1-р хэсэгт “Ялын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас хөндөгдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг дахин нийгэмшүүлэхэд оршино”;

ШШГТХ-ийн 8-р зүйл, ШШГТХ-ийн шинэчилсэн найруулгын төслийн 8-р зүйлийн 8.2 хэсэгт “Хорих ял эдлүүлэх талаар хорих байгууллагын хэрэгжүүлэх чиг үүрэгт ... ялтанд хүмүүжлийн нөлөө үзүүлэх” үүрэг тус тус тусгагджээ.

Эндээс үзвэл манай орны эрүүгийн хариуцлагын тогтолцоонд “цээрлүүлэх” чиг үүрэг ялын зорилгын жагсаалтын 3-рт, “хүмүүжүүлэх” 4-рт, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүрэг 5-рт эрэмблэгдсэн бол, ЭХ-ийн шинэчилсэн найруулгад ялын зорилгын 1-рт “цээрлүүлэх”, 5-рт “гэмт хэрэг үйлдсэн хүнийг дахин нийгэмшүүлэх” хэмээн заажээ.

Тэгвэл “Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”-ийн II хэсгийн -57-р зүйлд “Хууль зөрчигчийг нийгэм, орчны хүрээндээ тусгаарлаж байгаа хорих болон бусад арга хэмжээнүүд нь хүний өөрийн амьдралын хэм хэмжээг тогтоох эрхийг⁵⁸ хасч, эрх чөлөөгүй болгодог ороо

⁵⁴ НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1984 оны 39(46)-р тогтоолоор гарын үсэг зурах, батламжлах, нэгдэн ороход нээлттэйгээр баталсан ба 1987 оны 06-р сарын 26-аас хүчин төгөлдөр болсон. Монгол Улс энэ конвенцид 2000 оны 11-р сарын 02-ны өдөр нэгдэн орсон. ((Төрийн мэдээлэл тусгай дугаар 1-р боть, 2004 он

⁵⁵ НҮБ-ын “Гэмт хэргээс урьчилан сэргийлэх ба эрх зүйн зөрчил үйлдэгдсэд хандах асуудлаарх 7-р их хурлаас өргөн барьж, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1985 оны 40(33) тогтоолоор баталсан.

⁵⁶ Хэлэлцээр, протокол, пакт, конвенц, гэрээ, тунхаглал, журам, дүрэм зэрэг.

⁵⁷ II Международный пенитенциарный форум “Преступление, наказание, исправление” (к 60-летию принятия Минимальных стандартных правил обращения с заключенными и 30-летию принятия Минимальных стандартных правил, касающихся отправления правосудия в отношении несовершеннолетних). Сборник тезисов выступлений и докладов участников. Том.1, 2. Материалы пленарного заседания. Рязань.2015

⁵⁸ Илтгэгч англи хэлний “right of self-determination”, орос хэлний “право человека на самоопределение” гэснийг “Хүний эрх. Шүүх эрх мэдлийн салбар дах хүний эрх” УБ.1996 он эмхэтгэлд “хүний өөрийгөө мэдэх эрх” гэж орчуулсныг ийнхүү өөрчлөн томьёолж ашиглах саналыг дэвшүүлж байгаа.

зохих цээрлэлийг үзүүлдэг. Иймээс хорих тогтолцоо нь энд журамласнаас бусад байдлаар хүндрүүлэн зовоох үйл ажиллагаа явуулах ёсгүй” -58-р зүйлд “... шоронд хорих буюу эрх чөлөөг хасах ялын эцсийн зорилго нь нийгмийг хамгаалах, нийгэмд аюултай гэмт хэргүүдийг арилгах, урьдчилан сэргийлэх явдал бөгөөд түүнд хүрэх нөхцөл нь гэмт хэрэгтэн хорих ялыг эдэлж нийгмийн жирийн амьдралд шилжихэд эрх зүйн журамд захирагдаж, өөрийн амьдралыг авч явах чадвар, дадал хэвшилтэй болсон байх явдал мөн” гэжээ.

Өөрөөр хэлбэл олон улсын стандартын шаардлагын үүднээс авч үзвэл эрүүгийн хариуцлага, ялын тогтолцоонд “цээрлүүлэх” тусгай чиг үүргийн тухай бус, харин нийгмийг хамгаалах, гэмт явдлыг урьдчилан сэргийлэх нь түүний эрхэм зорилго ба үүнд хүрэх үндсэн нөхцөлийг “ялтныг өөрчлөн нийгэмшүүлэх” гэснийг бид онцгойлон анхаарах ёстой.

Б. Хорих ял эдлэгсдийн ангилал, хорих байгууллагын төрөл

Манай орны хувьд ЭХ, ШШГТХ-ийн хэм хэмжээг хэрэглэн хорих ялаар шийтгүүлэгчдийг:

-тэдний үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, өмнө нь хорих ял эдэлж байсан эсэхэд тулгуурласан гэмт хэргийн ангилал⁵⁹,

-мөн ял эдлэгсдийн нас, хүйс⁶⁰; эрүүл мэндийн байдал⁶¹; зан төлөв, үйлдсэн гэмт хэргийн зарим шинжийг⁶² харгалзан хорих нөхцөлөөр ялгарах жирийн, чанга, онцгой дэглэмтэй хорих анги, гянданд, эсхүл ижил

дэглэмийн хорих ангид тусгаарлан⁶³ ял эдлүүлж байна.

Харин салбарын хуулийн⁶⁴ шинэчилсэн найруулгын төсөлд:

-хорих байгууллага нь сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага, насанд хүрэгсдийн нээлттэй, хаалттай хорих анги (болон цагдан хорих төв, орон нутгийн цагдан хорих байр, мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төв)-аас бүрдэх⁶⁵;

-харуул хамгаалалтын түвшингээр нээлттэй хорих анги “Б”, “В”, хаалттай хорих анги “А”, “Б”, “В” зэрэглэлээр төрөлжихөөр тусгагджээ⁶⁶.

Тэгвэл энэ харилцаанд баримталдаг олон улсын стандартаас дурдвал:

Хоригдлыг ангилан тусгаарлахын зорилго нь: а) бие биедээ сөрөг муу нөлөө үзүүлэхээс сэргийлэх, б) тэднийг нийгмийн амьдралд буцаан оруулах хоригдолтой ажиллах ажлыг хөнгөвчлөх явдал мөн⁶⁷.

Насанд хүрээгүй хорих ял эдлэгсдийг төрөл бүлэгт хуваах үндсэн шалгуур нь тэдэнд үзүүлэх асрамж, онцлог хэрэгцээнд хамгийн ихээр нийцэж бие бялдрын, сэтгэл зүйн, ёс суртахууны төлөвшил, сайн сайхныг хамгаалах явдал байх ёстой⁶⁸.

Насанд хүрээгүй хүмүүсийн хувьд нээлттэй засан хүмүүжүүлэх газар байгуулвал зохино. Аюулгүй байдлын арга хэмжээ байхгүй юм уу, тодорхой хэмжээгээр хязгаарлагдсан байгууллагыг нээлттэй засан хүмүүжүүлэх газар гэнэ⁶⁹. Насанд хүрээгүй хүмүүсийн засан хүмүүжүүлэх байгууллага нь төвлөрсөн бус, насанд хүрээгүй хүмүүс ба тэдний гэр бүлийн хоорондын холбоо хэлхээг тасалдуулахгүй байх хэмжээнд байна⁷⁰.

⁵⁹ ЭХ-ийн 52-р зүйлийн 52.4, 52.5, 52.6, 52.7, 52.8, 52.9, 52.10, 52.11 хэсэг.

⁶⁰ ШШГТХ-ийн 118-р зүйлийн 118.1 хэсэг. Насанд хүрээгүй болон эмэгтэй, эрэгтэй ялтныг тус тусад нь ял эдлүүлнэ.

⁶¹ Мөн хуулийн 118-р зүйлийн 118.2 хэсэг. Ил хэлбэрийн сүрьеэ өвчтэй, дархлалын олдмол хомсдол өвчнөөр халдварласан, өвчилсөн ялтныг бусад ялтнаас тусгаарлан ял эдлүүлнэ. 111-р зүйлийн 111.2 хэсэг. Жирэмсэн ... эмэгтэй ялтныг тусад нь байрлуулна.

⁶² Мөн хуулийн 118-р зүйлийн 118.3 хэсэг. “Ижил дэглэмтэй хорих ангид анх удаа ял эдэлж байгаа ялтныг давтан гэмт хэрэг үйлдсэн ялтнаас, засарч хүмүүжиж байгаа ялтныг засрал олохгүй байгаа ялтнаас, түүнчлэн эдийн засгийн гэмт хэрэг үйлдсэн ялтныг тус тусад нь ял эдлүүлнэ”

⁶³ Мөн зүйл хэсэг.

⁶⁴ Цаашид зарим газар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг ийнхүү нэрлэн бичнэ.

⁶⁵ Төслийн 104-р зүйлийн 104.1 хэсэг

⁶⁶ Төслийн 106-р зүйлийн 106.1 хэсэг, 107-р зүйлийн 107.1 хэсэг

⁶⁷ Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмийн 67-р зүйл

⁶⁸ НҮБ-ын Хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүмүүсийг хамгаалах дүрмийн 28-р зүйл ((Хүний эрх. Шүүх эрх мэдлийн салбар дах хүний эрх. УБ, 1996 он, 45-46-р тал.

⁶⁹ Мөн дүрмийн 30-р зүйл

⁷⁰ Мөн дүрмийн 30-р зүйл

В. Хорих ял эдлэх нөхцөл, ялтны бусадтай уулзах, харилцах, хорих байгууллагаас гадна зорчих журам

Манай салбарын хуульд ялтны хорих ял эдлэх нөхцөл, бусадтай хийх түр, удаан хугацааны уулзалт, илгээмж авах, утсаар ярих, захидал илгээх тоо, хугацаа, чөлөөгөөр гарах, харуул хамгаалалтгүй ажиллах эрх нь хорих ангийн дэглэм, төрөл⁷¹”, хорих ял эдэлсэн хугацаанаас⁷², хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд⁷³ хорих ангийн харуул хамгаалалтын зэрэглэл, төрлөөс хамаарч ялгамжтай байдлаар туссан.

Тэгвэл судлаач олон улсын дараах стандартыг онцолж байна.

Хоригдлыг ял эдэлж эхлэх үеэс түүний ирээдүйн талаар бодох ёстой. Иймээс хоригдлыг ял эдэлж дуусаад суллагдсаны дараа түүнийг нийгмийн амьдралд татан оролцуулах, гэр бүлийн ашиг сонирхлыг хамгаалах хувь хүмүүс, албан газар, нэгжтэй харилцаа холбоо тогтоон бэхжүүлэхэд туслалцаа үзүүлнэ⁷⁴.

Хоригдлуудтай харьцахдаа нийгмээс тусгаарлагдсан байдлыг бус харин нийгмийн гишүүн хэвээр байгаа гэдгийг тодотгож харьцах хэрэгтэй. Үүний тулд тэднийг нийгмийн амьдралд буцаан оруулах зорилгоор олон нийтийн байгууллагуудын бүх боломжийг ашиглах, тус хорих газрын ажилтай холбож, хамтын ажиллагааг тогтоох хэрэгтэй⁷⁵.

Хоригдол, түүний гэр бүлийн хоорондын харьцааг бэхжүүлэхэд онцгой анхаарал тавина⁷⁶.

Эрх бүхий байгууллагууд хоригдож

байгаа насанд хүрээгүй хүмүүс орон нутгийн оршин суугчидтай чөлөөтэй харьцах явдлыг урамшуулах талаар идэвхитэй арга хэмжээг авч хэрэгжүүлвэл зохино⁷⁷.

Насанд хүрээгүй хүнийг гадна орчинтой холбох бүх арга хэрэгслийг аль болох бүрэн ашиглах нь түүнтэй шударга, хүнлэг ёсоор харьцах эрхийг нь хэрэгжүүлж, түүнийг нийгэмд эргүүлэн оруулах бэлтгэлийг хангахад чухал ач холбогдолтой. Насанд хүрээгүй хүмүүсийг гэр бүл, найз нөхөд, сайн нөлөө үзүүлж болох байгууллагын төлөөлөгчид, бусад хүмүүстэй уулзуулах, гэрт нь чөлөөгөөр явуулах, ерөнхий болон мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх, бусад чухал зорилгоор засан хүмүүжүүлэх байгууллагаас гадагш гарахыг зөвшөөрч байвал зохино⁷⁸.

Г. Ялтнуудад мэдээлэл өгөх, тэдний гомдол гаргах эрх

ШШГТХ, Хорих ангийн дотоод журам⁷⁹, салбарын хуулийн шинэчилэн найруулгын төсөлд: “... ялтан шүүхээс оногдуулсан ял эдлэх нөхцөл, журам болон өөрийнхөө эрх, үүрэг, хязгаарлалтын талаар мэдээлэл авах, өөрт холбогдох⁸⁰ болон хорих ангийн үйл ажиллагаа, албан хаагчдын харилцааны талаар⁸¹ байгууллагын захиргаа, аль ч байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол, хүсэлт гаргах эрхтэй”, “хорих байгууллагын ажилтан хоригдогсдод ангийн хориотой бүс, ялтны эрх, үүргийн талаар танилцуулах ажлыг зохион байгуулах⁸² үүрэг хүлээх”-ээр туссан.

Иймд судлаач энэ харилцаанд хамаарах олон улсын дараах стандартуудыг онцолж байна.

Хоригдол бүрийг хорих газар хүлээн авахдаа тухайн төрлийн хоригдлуудтай харилцах журам, сахилгын шаардлага,

⁷¹ Тус хуулийн 107-р зүйл. Баривчлах байр, жирийн дэглэмтэй хорих анги; 108-р зүйл. Чанга, онцгой дэглэмтэй хорих анги; 109-р зүйл. Гяндан; 110-р зүйл. Насанд хүрээгүй ялтныг ял эдлүүлэх; 111-р зүйл. Эмэгтэй ялтныг ял эдлүүлэх; 119-р зүйл. Ялтан бусадтай уулзах, харилцах.

⁷² Тус хуулийн 122-р зүйл. Ялтныг харуул хамгаалалтгүй ажиллуулах.

⁷³ Төслийн 106-р зүйл. Нээлттэй хорих анги; 107-р зүйл. Хаалттай хорих анги; 108-р зүйл. Харуул хамгаалалтын “А” зэрэглэлд ял эдлүүлэх; 109-р зүйл. Өсвөр насны ялтныг ял эдлүүлэх; 110-р зүйл. Эмэгтэй ялтныг ял эдлүүлэх;

⁷⁴ Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмийн 80-р зүйл

⁷⁵ Дурдсан жишиг дүрмийн 61-р зүйл

⁷⁶ Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмийн 79-р зүйл

⁷⁷ НҮБ-ын Хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүмүүсийг хамгаалах дүрмийн 8-р зүйл

⁷⁸ Дурдсан жишиг дүрмийн 59-р зүйл

⁷⁹ Хууль зүйн сайдын 2014 оны “Журам шинэчилэн батлах тухай” А(230-р тушаал (Хорих ангийн дотоод журам)

⁸⁰ Дурдсан хуулийн 115-р зүйлийн 115.1.2

⁸¹ Хорих ангийн дотоод журмын 14.1 хэсэг (Энэ хэм

⁸² хэмжээ ШШГТХ-д тусгагдаагүй болно) Мөн журмын 2.8.1

мэдээлэл авах зөвшөөрсөн хэрэгсэл, гомдол гаргах журам болон өөрийн эрх, үүргээ мэдэх, амьдралын нөхцөлд дасахтай холбогдсон бусад асуудлаарх мэдээллийг бичгээр өгнө⁸³; бичиг үсэг мэддэггүй хоригдолд амаар танилцуулна.

Хоригдол бүр шоронгийн төв захиргаа, шүүх болон бусад эрх бүхий байгууллагад хүсэлт, өргөдлөө гаргах боломжтой байх ёстой бөгөөд тэдгээрийг агуулгын талаас хянахгүйгээр зохих хэлбэрийн дагуу бүрдүүлж тогтоосон журмаар шоронгийн төв захиргаа, шүүх болон бусад эрх бүхий байгууллагад хүргэж байвал зохино.

Засан хүмүүжүүлэх байгууллагад байрласны дараа насанд хүрээгүй хүн бүрт тус байгууллагад байх журам, эрх, үүргийн бичмэл танилцуулга, гомдол гаргах бүрэн эрх бүхий байгууллага, мөн хууль зүйн туслалцаа үзүүлэх төрийн, хувийн байгууллагын хаягийг өгөх ёстой. Бичиг үсэг үл мэдэх буюу зохих хэлээр уншиж чадахгүй насанд хүрээгүй хүмүүст мэдээллийг бүрэн ойлгох боломжийг хангасан хэлбэрээр өгнө⁸⁴.

Хоригдлуудад хамгийн чухал мэдээг сонин, сэтгүүл, шоронгийн тусгай хэвлэлийг унших, радио сонсох, лекцэнд суух болон захиргаанаас зөвшөөрч хянагддаг аливаа хэрэгслийг ашиглах замаар хүргэж байвал зохино⁸⁵.

Д. Ялтны хөдөлмөр

ШШГТХ, салбарын хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд ялтны энэ харилцаатай холбоотой дараах зохицуулалт бий.

Хорих байгууллага ялтныг албадан хөдөлмөрлүүлж, эрхэлсэн үйлдвэрлэлийн чиглэлээр түүнд дадлага олгоно⁸⁶. Хуулийн төслийн 8-р зүйлийн 8.2.4-д “албадан” гэсэн үгийг энэ хэм хэмжээнээс хассан.

Ялтан эрх бүхий албан тушаалтнаас

даалгасан ажлыг заавал гүйцэтгэх үүрэг хүлээнэ⁸⁷.

Чанга, онцгой дэглэмтэй хорих ангийн ялтны ажил, амралтын цагийг хөдөлмөрийн хууль тогтоомжид зааснаас өөрөөр тогтоож болно⁸⁸. (Хуулийн төслийн 119-р зүйлийн 119.7-д энэ зохицуулалтыг хаалттай хорих ангид ял эдлэгсэд хамруулсан)

Насанд хүрээгүй болон жирийн дэглэмтэй хорих ангийн ялтны ажил, амралтын цаг нь хөдөлмөрийн хуультай нийцсэн байна⁸⁹. (Хуулийн төслийн 119-р зүйлийн 119.2-т нээлттэй хорих ангийн ялтанд энэ хэм хэмжээг хамруулсан)

Ялтнаар ажил хийлгэхдээ түүний мэргэжил, хөдөлмөрийн чадварыг харгалзах боловч мэргэжлийн ажил байхгүй нь түүнийг хөдөлмөрөөс чөлөөлөх үндэслэл болохгүй⁹⁰.

Тэгвэл ялтны хөдөлмөр эрхлэлттэй холбогдсон олон улсын стандартын дараах шаардлагыг дурдья.

Хоригдлыг ажлаар хангах нь юуны өмнө тэднийг хорих газраас суллагдсаны дараа шударга хөдөлмөр эрхлэхэд тулах, ур чадварыг бий болгох, дээшлүүлэхэд оршино⁹¹.

Шоронгийн нөхцөлд үйлдвэрлэл явуулж ашиг олох явдалд хоригдлын сонирхол, мэргэжлийн сургалтыг захируулж болохгүй⁹².

Ажлын цагийг долоо хоногт нэг удаа амралтын өдөртэй байхаар зохион байгуулах ба энэ нь хоригдлыг дахин хүмүүжүүлэх, сурах болон бусад ажиллагаа эрхлүүлэхэд зориулагдана⁹³.

Хэрэв боломжтой бол насанд хүрээгүй хүмүүсийг мэргэжлийн сургалттай нь холбоотой тухайн орон нутагт цалин хөлстэй ажил хийлгэх бололцоо олгож суллагдсаны дараах нийгмийн амьдралд хөдөлмөр эрхлэх боломж нөхцлийг нь нэмэгдүүлэх ёстой⁹⁴.

⁸³ Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмийн 35.1-р зүйл

⁸⁴ НҮБ-ын Хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүмүүсийг хамгаалах дүрмийн 24-р зүйл

⁸⁵ Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмийн 39-р зүйл

⁸⁶ Хуулийн 8-р зүйлийн 8.2.4; 125-р зүйлийн 125.3; Хуулийн төслийн 124-р зүйлийн 124.4-т өнөөгийн хуулийн 125-р зүйлийн 125.3 хэсэгтэй адил зохицуулалт туссан.

⁸⁷ Хуулийн 115-р зүйлийн 115.2.2; Хуулийн төслийн 114-р зүйлийн 114.2.2

⁸⁸ Хуулийн төслийн 119-р зүйлийн 119.7

⁸⁹ Хуулийн 120-р зүйлийн 120.2

⁹⁰ Хуулийн 120-р зүйлийн 120.3; Хуулийн төслийн 119-р зүйлийн 119.3

⁹¹ Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмийн 71.4

⁹² Дурдсан жишиг дүрмийн 72.2

⁹³ Дурдсан жишиг дүрмийн 75.2

⁹⁴ НҮБ-ын Хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүмүүсийг хамгаалах дүрмийн 45-р зүйл

Е. Боловсрол ба сургалт

ШШГТХ, хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд ялтны сургалт, түүний зохион байгуулалт, боловсрол эзэмшихтэй холбогдсон дараах зохицуулалт бий.

Насанд хүрээгүй ялтныг ерөнхий боловсролын сургалтад бүрэн хамруулж, бусад ялтан бие дааж мэдлэгээ дээшлүүлэхэд хорих анги туслалцаа үзүүлнэ⁹⁵.

Боловсролын сургалтыг зөвхөн хорих ангийн байранд зохион байгуулна⁹⁶.

Хөдөлмөрийн дадлага олгох сургалтад ялтныг сайн дурын үндсэн дээр хамруулна⁹⁷.

Тэгвэл олон улсын зарим стандартыг онцолбол:

Бичиг үсэггүй буюу залуу хоригдлуудыг сургалтад заавал хамруулах ба үүнд хорих газар онцгой анхаарал тавих ёстой⁹⁸.

Заавал сурах сургалтын насны хүүхэд бүр өөрийнхөө хэрэгцээ, чадварт тохирсон, нийгэмд эргэж орох бэлтгэл хангах боловсрол эзэмших эрхтэй. Ийм боловсролыг аль болохоор засан хүмүүжүүлэх газраас гадуур ердийн сургуулиар олгох⁹⁹.

Заавал сургах сургалтын нас хэтэрсэн боловч боловсрол олох ажлаа үргэлжлүүлэх хүсэлтэй насанд хүрээгүй хүмүүст ийм боломж олгон хөхүүлэн дэмжиж, сургалтын зохих хөтөлбөрөөр хангах боломж бүхнийг ашиглавал зохино¹⁰⁰.

Ё. Урамшуулал, сахилгын шийтгэл

Хорих ял эдлэгсэд үзүүлэх урамшуулал, сахилгын шийтгэлийн үндэсний тогтолцоо, механизмд социализмын үеийн үзэл санаа, хандлага бусад институцитай харьцуулахад илүү бат бөх өнөөг хүртэл хадгалагдаж байгаагийн зэрэгцээ салбарын хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд сахилгын шийтгэлийн журмаар ялтны сар, улирал, жилд авах түр болон удаан хугацааны

уулзалтын тоог бууруулах¹⁰¹ зохицуулалт тусжээ.

Тэгвэл энэ харилцааны олон улсын зарим стандартыг дурдвал:

Хоригдлыг тухайн хорих газрын үйлчилгээнд сахилгын арга хэмжээ болгон ажиллуулж болохгүй¹⁰².

Ямар ч тохиолдолд хоол ундыг хасах, гэр бүлийн гишүүдтэйгээ уулзахыг хязгаарлах буюу хориглох явдал байж болохгүй. Хөдөлмөр эрхлэх нь насанд хүрээгүй хүмүүсийг нийгмийн амьдралд буцаан ороход бэлтгэх, өөрийгөө хүндэтгэж сурах арга хэрэгсэл, хүмүүжлийн арга байх ёстой бөгөөд сахилгын арга хэмжээ болгон хэрэглэж болохгүй. Хамт олноор нь шийтгэхийг хориглоно¹⁰³.

Ж. Ялтныг суллахад бэлтгэх, суллагдсан хүнд үзүүлэх тусгай институци

Манай орны салбарын хуульд энэ талаарх тусгайлсан зохицуулалт байхгүй. Харин энэ харилцаанд хамаарах олон улсын дараах стандартыг дурдаж болно.

Хорих ялын хугацаа дуусахаас өмнө хоригдлыг нийгмийн ердийн амьдралд аажмаар дасгаж хэвшүүлэх арга хэмжээг идэвхитэй авч хэрэгжүүлэх шаардлагатай. Энэ зорилгоор суллагдаж байгаа хоригдлуудын онцлогийг харгалзан хорих газарт эсвэл ямар нэгэн өөр байгууллагад өвөрмөц дэглэм тогтоон итгэл өгч ажиллуулж болно эсвэл цагдаагийн биш иргэний нийгмийн хяналтад зохих болзолтойгоор сорилын хугацаагаар суллаж байна¹⁰⁴.

Суллагдсан хоригдолд туслах засгийн газрын болон бусад байгууллага нийгэмд байх ёстой. Эдгээр байгууллага нь тухайн хүмүүст орон сууц авах, ажилд орох зэрэгт нь зайлшгүй шаардлагатай бичиг баримтыг олж авах, улирлын хувцсаар хангах, очих газрын тээврийн хөлс болон тодорхой хугацаанд хүрэлцэхүйц мөнгө олгоно. Эдгээр байгууллагын эрх бүхий төлөөлөгчид хорих

⁹⁵ Хуулийн 125-р зүйлийн 125.1; Хуулийн төслийн 124-р зүйлийн 124.1

⁹⁶ Хуулийн 125-р зүйлийн 125.2; Хуулийн төслийн 124-р зүйлийн 124.2

⁹⁷ Хуулийн 125-р зүйлийн 125.4; Хуулийн төслийн 124-р зүйлийн 124.4

⁹⁸ Хоригдолтой харьцах наад захын жишиг дүрмийн 77.1

⁹⁹ НҮБ-ын Хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүмүүсийг хамгаалах дүрмийн 38-р зүйл

¹⁰⁰ Дурдсан дүрмийн 39-р зүйл

¹⁰¹ Төслийн 127-р зүйлийн 127.1.1

¹⁰² Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмийн 28.1

¹⁰³ НҮБ-ын Хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүмүүсийг хамгаалах дүрмийн 67-р зүйл

¹⁰⁴ Дурдсан жишиг дүрмийн 60-р зүйлийн 2 хэсэг

ангид ирж хоригдолтой уулзаж, түүний ирээдүйн амьдралын талаар зөвлөж байвал зохино¹⁰⁵.

3. Бусад

Эдгээрээс гадна:

- Хоригдлын өрөө тасалгаа; Хувийн ариун цэвэр;
- Хувцас, унтлагын хэрэгсэл; Хоол унд;
- Эмнэлгийн үйлчилгээ; Хоригдлын эд зүйлийг хадгалах;
- Номхруулах хэрэгсэл;
- Шашин шүтлэг;
- Хоригдлыг шилжүүлэх, Нас барсан, өвчилсөн, өөр газарт шилжсэн талаар мэдэгдэх;
- Хорих ангийн албан хаагч;
- Хяналт шалгалт зэрэг “институци”-ээр төрөлжсөн бусад стандартууд байдгийг бас дурдах ёстой.

Дүгнэлт

Гэмт хэрэгтэй тэмцэх салбарын манай орны хууль тогтоомжийн энэ цаг үеийн өөрчлөлт дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага, өөрийн орны онцлогийг харгалзан хийгдэж байгааг сайшаан тодотгохын зэрэгцээ зарим тохиолдолд бид өмнөх нийгмийн¹⁰⁶ үзэл суртал, хандлагаасаа салаагүй зууралдсаар байгааг бас анхааруулах ёстой. Тухайлбал: үүнд эрүүгийн хариуцлага, ялын “цээрлүүлэх тусгайлсан зорилго”, мөн хорих ял эдлүүлэх салбарын шинэчлэл хамаарна.

Мөн салбарын хууль тогтоомжийн зарим хэм хэмжээ¹⁰⁷ “олон улсын стандарт”-ын шаардлагыг харгалзаагүй, түүнчлэн бидний олон жил чиг баримжаагаа болгон нэг тогтолцоонд хамтран ирсэн хөрш орныхоо¹⁰⁸ хууль тогтоомж, хууль зүйн дэвшилтэт практикийг судлаагүй, түүнд хайхрамжгүй хандаж буй байдлыг нэрлэж болно.

Иймд илтгэлийн үндсэн хэсэгт тусгаагүй зарим баримтыг тодотгон дурдвал ялтныг

нийгэмшүүлэх гол нөхцөл болсон “хорих ял эдлүүлэх дэвшилтэт тогтолцоо¹⁰⁹”, “хорих ял эдлэх харьцангуй ялгамжтай орчин нөхцөл”, “ялтны хорих байгууллагаас гадагш зорчих”, “чөлөө авах”, “ялтны хөдөлмөрийн амралт, цалин хөлс”, “ялтны түр, удаан хугацааны уулзалт”, “ялтны захидал харилцаа”, “ялтанд үзүүлэх урамшуулал, сахилгын шийтгэл”, түүнчлэн ял эдлүүлэх тогтолцоог либериальчлах, нийгэм, олон нийтийн хяналтад оруулах асуудалд бид зарчмын өөрчлөлт хийж чадаагүй, одоог хүртэл тодорхой шийдэл төлөвлөөгүй байна.

Олон улсын болон гадаад орнуудын эрүүгийн ял эдлүүлэх эрх зүйн шинжлэх ухаан, салбарын онолууд, хууль зүйн практикаас үзвэл өнөө үед хорих ял, хорих нөхцөлийн тухай “эргэлт, уулзалт, захидал, илгээмжийн тоон хязгаарлалтад тулгуурласан” үзэл баримтлал хоцорч, “нийгэмшүүлэх үйл ажиллагаанд захирагдсан, олон нийтийн оролцоо, дэмжлэг, хяналтад түшиглэсэн” үзэл баримтлал салбарын хөгжлийн “парадигм” болсныг судлаач онцлон тодотгож байна.

Санал

Иймд олон улсын стандартууд болон дараах судлаачийн саналыг ШШГТХ-ийн шинэчилсэн найруулгын төсөлд харгалзан үзэхийг санал болгож байна. Энэ нь:

Салбарын хуульд эрүүгийн ял эдлүүлэх эрх зүйн дараах зарчмуудыг нэмж хуульчлан, практикт тууштай хэрэгжүүлэх:

- “ял эдлүүлэх харилцааг ялтны нийгэмшүүлэх үйл ажиллагаанд захируулах¹¹⁰”;
- “ялыг ялгамжтай эдлүүлэх¹¹¹”;
- “ялын гүйцэтгэлийг хувь хүний онцлогтой уялдуулан бодьгалчлах¹¹²”;

¹⁰⁵ Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмийн 81-р зүйл

¹⁰⁶ “Социалист”

¹⁰⁷ ЭХ, ШШГТХ, Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга, УИХ-аар хэлэлцэхээр төлөвлөж буй ШШГТХ-ийн шинэчилсэн найруулгын төслийн

¹⁰⁸ Энэ тохиолдолд хөрш ОХУ-ыг дурдсан болно.

¹⁰⁹ Оросоор “прогрессивная система отбывания лишения свободы” гэж нэрлэдэг.

¹¹⁰ Энэ зарчмыг “ял шийтгэлийг засан сайжруулах (засан төлөвшүүлэх) үйл ажиллагаатай холбох” буюу оросоор “принцип соединения наказания с исправительным воздействием” гэж нэрлэдэг бөгөөд судлаач үүнийг ийнхүү өөрчлөн нэрлэхээр санал болгож байна.

¹¹¹ Принцип дифференциации исполнения наказания

¹¹² Принцип индивидуализации исполнения наказания

- “албадлагын арга хэмжээний үр нөлөөг эрхэмлэх¹¹³”;
- “ялтны эерэг зан төлөвийг бүх талаар дэмжин урамшуулах¹¹⁴”;
- “ял эдлүүлэх ажиллагааг нийгэм, олон нийтийн оролцоо, дэмжлэг, хяналтад түшиглэн явуулах¹¹⁵” тус тус болно.

Салбар эрх зүйн нэрлэсэн зарчмууд, хорих ялыг ялтны харьяалах орон нутагт эдлүүлэх үзэл санааг харгалзсан хорих ялыг ялтан “ялгамжтай нөхцөл бүхий салбар-хэсгүүдтэй¹¹⁶ Засан төлөвшүүлэх¹¹⁷ нэг байгууллагад¹¹⁸ (үүнийг гадаадын орнуудад “мульти” буюу “гибрид” зохион

байгуулалттай) хорих ялыг эдлүүлэх эрх зүйн зохицуулалт, хууль зүйн практикийг нарийвчлан судалж манай оронд нэвтрүүлэн “нутагшуулах” асуудалд судлаачид төдийгүй салбарын байгууллага, хууль тогтоогч, “хууль хэрэглэгчдийн анхаарлыг нэн даруй хандуулж шийдлийг олох.

Өөрөөр хэлбэл ялтан хорих ялыг нэг байгууллага, түүний харьцангуй ялгаа бүхий нөхцөлтэй салбар-хэсэгт зан төлөвтэйгээ уялдан “шилжин эдлэх¹¹⁹” зохицуулалт болно.

Цаг зарцуулж, анхаарлаа хандуулж сонссон та бүхэнд чин сэтгэлээсээ талархал илэрхийлье.

¹¹³ Принцип рационального применения мер принуждения

¹¹⁴ Принцип стимулирования правопослушного поведения осужденных

¹¹⁵ Энэ үзэл санааг судлаач зарчмын хэмжээнд үнэлэх саналыг дэвшүүлж байна.

¹¹⁶ Өнөөгийн ойлголтоор “ялгаа бүхий дэглэмтэй”

¹¹⁷ Боловсролын тухай хуулийн 3.1.11-д “төлөвшил гэж суралцагчийн хүмүүжил, итгэл үнэмшлийн цогцыг ойлгоно” (www.meds.gov.mn) гэснийг харгалзан илтгэгч хорих ял эдлүүлэх байгууллагыг “Засан төлөвшүүлэх (сайжруулах) газар” гэж нэрлэхийг санал болгож байна.

¹¹⁸ Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмийн 8-р зүйл “Янз бүрийн бүлгийн хоригдлуудад хүйс, нас, урьд ял шийтгэгдэж байсан эсэх, хоригдох болсон хууль зүйн шалтгаан болон тэдэнтэй харилцах зааврыг харгалзан тусдаа хорих газруудад эсхүл 1 хорих газрын өөр өөр хэсэгт байлгана”; ОХУ-ын Эрүүгийн ял эдлүүлэх хуулийн 73-р зүйл “Хорих ял эдлүүлэх байгууллага”, 74-р зүйл “Засан хүмүүжүүлэх байгууллагын төрөл”.

¹¹⁹ ОХУ-ын хорих ял эдлүүлэх практикт үүнийг “социальный лифт” гэж нэрлэдэг.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГА БА ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ҮР НӨЛӨӨ, ТҮҮНИЙГ САЙЖРУУЛАХ НЬ: ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА



Хүний эрх, хөгжлийн төлөөх Азийн форум (Форум-Ази) болон Хүний эрх хөгжил төвийн тэргүүн

Г.УРАНЦООЖ

Илтгэлийн өмнө Форум-Ази болон Хүний Эрх хөгжил төвийн өмнөөс Монгол Улсын үндэсний хүний эрхийн байгууллага болох Хүний Эрхийн Үндэсний Комиссын хамт олонд 15 жилийн ойн мэндийг дэвшүүлж, энэ хугацаанд хүний эрхийн төлөө хийсэн бүх ажилд нь Монголын Иргэний Нийгмийн байгууллагыг төлөөлөн талархал илэрхийлье.

Агуулга

Хүний эрх хөгжил төвийн танилцуулга, холбогдох үйл ажиллагаа

Хүний эрхийн үндэсний байгууллагын үйл ажиллагааны зарчим

Иргэний нийгмийн байгууллага ба хүний эрхийн үндэсний байгууллагын хамтын ажиллагааны олон улсын туршлага

Хамтын ажиллагааны үр нөлөө, түүнийг сайжруулах арга зам

Хүний эрх хөгжил төв нь 1998 онд байгуулагдан хүний эрх, нийгмийн шударга ёс, хөгжлийн төлөө 18 жил тасралтгүй үйл ажиллагаа явуулж буй нам бус, ашгийн бус, төрийн бус байгууллага юм. Төв нь төрийн үйл ажиллагааг хянах, үнэлэх, хариуцлага тооцох иргэдийн чадавхийг хөгжүүлэх, жишиг гаргахад хувь нэмэр оруулах зорилготой,

Хүний эрхийн хамгаалал, Хүний эрхийн нөлөөлөл, Хамт олонд суурилсан хөгжлийн хөтөлбөр гэсэн үндсэн 3 хөтөлбөртэй. Хөтөлбөрүүд нь хүний эрх, хууль эрх зүйн нөлөөлөл, өмгөөлөл, мониторинг хийх, судалгаа явуулах, зөвлөмж боловсруулах, мэдээлэл түгээх, сургалт, уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулах, ном, гарын авлага хэвлэн түгээх, дотоод гадаадын байгууллагуудтай сүлжээ холбоонд нэгдэх, олон нийтийн кампанит ажил зохион байгуулах, орон нутгийн иргэдийг идэвхижүүлэх, чадавхижуулах ажлуудыг хийдэг.

Манай төв нь байгуулагдсан цагаас эхлэн хүний эрхийн үндэсний тогтолцоо, бүтэц, механизмыг бэхжүүлэхэд анхаарч ирсэн ба 2015-2018 оны стратеги зорилтдоо ХЭХХөтөлбөрөөрөө хүний эрхийн үндэсний бүтэц, механизмыг бэхжүүлэх, олон улсын гэрээ конвенцийг үр дүнтэй хэрэглэх, хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулахаар тусган ажиллаж байна.

Хүний эрхийн үндэсний байгууллагын үйл ажиллагааны чиг шугам болох баримт бичиг нь Парисын зарчмууд буюу Хүний эрхийн үндэсний байгууллагын эрх зүйн

зарчим юм. Энэ зарчмыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний Эрхийн Комиссоос 1991 онд Парис хотноо зохион байгуулсан уулзалтаас боловсруулж, хожим 1993 онд НҮБ-ын ХЭК-ын 1993/54 болон Ерөнхий Ассемблейн 1993/48/134 тоот тогтоолоор тус тус баталсан. Үүгээрээ НҮБ-ын гишүүн орнууд дагаж мөрдөх учиртай болно. Энэхүү зарчмын баримт бичигт хүний эрхийг хангах, түүнийг сахин хамгаалах үндэсний байгууллагуудын эрх мэдэл, үйл ажиллагаа, эрх зүйн байдлын талаар улс орнууд дагаж мөрдвөл зохих наад захын хэм хэмжээний цэгцтэй мэдээлэл байдаг.

Баримт бичиг дэх гол зарчим бол “Үндэсний хүний эрхийн үндэсний байгууллага нь бие даасан, тодорхой эрх мэдэлтэй, байнгын ажиллагаатай, олон ургальч төлөөллийг хангах зарчмаар бий болсон бүрэлдэхүүнтэй, олон нийтэд ойр, өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулах санхүүгийн чадвартай байх ёстой”. Эдгээр үзүүлэлтүүд бол аливаа үндэсний байгууллагын үр ашигтай ажиллах шалгуур болдог.

Иргэний нийгмийн байгууллага ба хүний эрхийн үндэсний байгууллагын хамтын ажиллагаа нь мөн Парисын зарчимд үндэслэгдэх бөгөөд зарчмын хэрэгжилтийн үр нөлөөг сайжруулахад Ази Номхон Далайн Бүсийн Чуулган, Хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих Олон улсын хороо (ИСС), Хүний эрх, хөгжлийн төлөөх Азийн форум (Форум-Ази) зэрэг бүтцүүд хамтран ажиллаж байна. Үүнээс иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог хангах чухал механизм бол Форум Азийн үйл ажиллагааны нэг гол үндсэн чиглэл болох Хүний эрхийн үндэсний байгууллагуудтай ажиллах Азийн төрийн бус байгууллагуудын сүлжээ (АННИ) юм. Энэ сүлжээ нь Форум Азиас Тайланд улсын Бангкок хотноо 2006 оны 12 дугаар сард Ази дахь Төрийн бус байгууллагууд болон Хүний эрхийн үндэсний байгууллагуудын анхдугаар бүсийн зөвлөгөөний үеэр үүсгэн байгуулагдсан ба сүлжээ нь Ази дахь Хүний

эрхийн үндэсний байгууллагуудыг ил тод, үр дүнтэй, бие даасан, хариуцлагатай хөгжүүлэх, бий болгоход дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах гол зорилготой юм.

АННИ сүлжээ нь, сүлжээний гишүүн орнууд өөрийн орны ХЭҮБ-ын үйл ажиллагааг Парисын зарчмын хүрээнд, үндэсний болон орон нутгийн хэмжээнд ажилладаг хүний эрхийн төрийн бус байгууллагын байр сууринаас үнэлгээ хийж, жил бүр тайлан бэлтгэж, үүнийг нэгтгэн хэвлэдэг. Энэхүү тайланг жил бүр хэлэлцэж, тухайн жилийн онцлох асуудал, түүнд өгөх зөвлөмжийг 2 жилд 1 удаа зохион байгуулагддаг Ази номхон далайн бүсийн чуулганд танилцуулдаг болно.

Манай төв нь Форум-Азийн гишүүн байгууллагын хувьд АННИ сүлжээнд хамтран ажиллаж ИНБ болон ХЭҮБ хамтын ажиллагааны олон улсын туршлагад хувь нэмрээ оруулж байна. Одоогоор 2006-2015 онд нийт хөндлөнгийн тайланг 9 удаа бэлтгэж АННИ сүлжээний нэгтгэл тайланд хэвлүүлсэн. Эдгээр тайланг манай төв хариуцан бэлтгэж, зарим сонирхогч ТББ-ын саналыг тусгадаг.

Эдгээр тайлангууд нь 2006 онд Хүний эрхийг хамгаалах тууштай алхмын төлөө; 2007 онд Хүний эрхийг хамгаалах явдлыг тэргүүн зорилтоо болго; 2008 онд Санаачлагатай бөгөөд хараат бус бай; 2009 онд Бие даасан хараат бус бай; 2010 онд ХЭҮК-ын тухай; 2011 онд ХЭҮК: 10 жилд; 2013 онд ХЭҮК: Илүү их үр дүн рүү!; 2014 онд Сонгуулийн процест өөрчлөлт хэрэгтэй; 2015 онд Хуулийн өөрчлөлт шаардлагатай байна гэсэн сэдвүүдээр бичигдэж ХЭҮК-ын үйл ажиллагааны үр нөлөөг сайжруулахад чиглэсэн 39 зөвлөмжийг өгсөн байна.

Зөвлөмжүүдийн гол агуулга, чиглэл нь:

ХЭҮК-ын бүтэц: Олон талын төлөөллийг хангах зарчимд нийцүүлэх;

ХЭҮК-ын гишүүний томилгоо, гишүүнд тавигдах шаардлага, ил тод байдал;

Чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэхэд чиглэсэн хангалттай санхүүжилт авахад анхаарах;

ХЭҮК, ТББ-уудын хамтын ажиллагааг сайжруулах, өргөжүүлэх;

Гаргасан шийдвэрээ хэрэгжүүлэхэд анхаарах, хэрэгжилтэнд мониторинг хийх;

Зарим бүлгүүдийн хүний эрхийн хэрэгжилтэнд анхаарах: Эвлэлдэн нэгдсэн бүлгүүд, Малчдын эрх, Хүний эрхийн хамгаалагчид г.м;

Шинэ тутам гарч буй хүний эрхийн ноцтой зөрчлийн талаарх байр суурь, түүний мөрөөр авах арга хэмжээнд оролцох;

Комиссын тухай хуулийн өөрчлөлт: Парисын зарчимд нийцүүлэх;

Төрийн хүний эрхийн бүтцүүдтэй хамтын ажиллагааг үр дүнтэй болгох: Хүний эрхийн дэд хороо, УИХ-д тайлангаа танилцуулж, хэлэлцүүлдэг болох;

ХЭҮК-ын дэргэдэх орон тооны бус зөвлөл: Хүчийг дайчлах;

Монгол Улсын улс төр, эдийн засаг, нийгмийн нөхцөл байдалд хүний эрхийн хяналт, шинжилгээ хийж, энэ анализыг жил бүрийн илтгэлд оруулах;

Монгол Улсын хууль тогтоомжийн төслүүдэд хүний эрхийн анализ хийдэг болох;

Үүнээс гадна ХЭҮК-ыг Хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих олон улсын хорооноос ХЭҮК-ыг магадлан итгэмжлэхэд үндэсний Хүний эрхийн ТББ-ууд нь илтгэл, мэдээлэл, санал хүргүүлэн ажиллаж байна. Мөн олон улсын гэрээ конвенцийн хэрэгжүүлэх Төрийн үүргийг хэрэгжүүлэх,

шаардахад хамтран ажиллаж байна.

ИНБ болон ХЭҮБ-ын хамтын ажиллагааны үр нөлөөг сайжруулах талаар саналууд:

ХЭҮК нь хүний эрхийн үндэсний механизмын гол цөм болох учиртай тул бие даасан хараат бус байдлаа хангах хууль тогтоомжийг яаралтай батлуулах. Ингэхдээ ИНБ-тай өргөн хүрээний хэлэлцүүлэг зохион байгуулах;

АННИ сүлжээний хүрээнд бичигдсэн илтгэлээр өгөгдсөн зарим зөвлөмжийн хэрэгжилт хангагдсан ч, зарим зөвлөмж удаа дараа өгөгдөж байгааг анхаарах. Үүнийг хэрэгжүүлэх талаар хэлэлцэж, арга замыг тодорхойлох;

Олон улсын гэрээ, конвенцуудын хэрэгжилтийг хангах үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллага, хүний эрхийн ТББ-уудын саналыг авах, оролцоог нэмэгдүүлэх;

Жил бүр бэлтгэдэг “МУ дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл”-ийг бэлтгэхэд ТББ-уудтай хамтран ажиллах, саналыг авах;

Чиг үүргээ хэрэгжүүлэх хангалттай санхүүжилттай болох талаар санал, санаачлага гаргаж, идэвхи гаргаж ажиллах;

Илтгэлийн төгсгөлд Хүний Эрхийн Үндэсний Комиссын цаашдын үйл ажиллагаанд улам илүү амжилт хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа!

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

ӨГҮҮЛЭЛ, НИЙТЛЭЛ

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГА: ТАВИГДАХ
ШААРДЛАГА, ЧИГ ҮҮРЭГ

Хууль зүйн ухааны доктор (Ph.D)

С.ЦЭРЭНДОРЖ

Хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн Х дэмжих үүрэг бүхий үндэсний байгууллагуудын эрх зүйн Зарчмууд (Парисын Зарчмууд)-ыг НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1993 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 48(134) дүгээр тогтоолоор баталсан.

Парисын Зарчмууд нь Хүний эрхийн үндэсний байгууллага (ХЭҮБ)-уудад¹²⁰ зориулсан олон улсын наад захын шаардлага, стандартууд юм. Эдгээр нь тунхаглал, хүсэл төдий зүйл биш, харин заавал биелүүлэх шинжтэй стандартууд бөгөөд хэрэв нийгэм болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, нэр хүндтэй ХЭҮБ байа гэвэл Парисын Зарчмуудад заасан стандартын дагуу байгуулагдсан байх ёстой.

¹²⁰ Хүний эрхийн үндэсний байгууллага Хуульд үндэсний байгууллагын бүрэн эрх үйл ажиллагааны тодорхой чиглэл, хараат бус байдлыг хангахуйц нарийвчилсан заалтыг тусгах ёстой. Хуульд ялангуяа үндэсний байгууллагын чиг үүрэг, бүрэн эрх хэмжээ, гишүүдийн томилгооны механизм, томилогдох хугацаа, ажлаас чөлөөлөгдөх үндэслэл, үйл ажиллагааны санхүүжилт зэргийг тодорхой заахыг шаарддаг.

А. ХЭҮБ-уудад тавигддаг шаардлага, стандартууд

Хараат бус бие даасан байдал
Олон ургальч байдал
Хүртгэмжтэй байдал
Хариуцлага хүлээх чадвар
Хамтын ажиллагаа
Дэд бүтэц

Нэг. Хараат бус бие даасан байдал

Парисын Зарчмаар хүний эрхийн үндэсний байгууллагад тавигддаг эхний бөгөөд хамгийн чухал шаардлага бол хараат бус байдал юм.

Хэдийгээр ХЭҮБ нь төрийн байгууллага боловч бусад төрийн болон төрийн бус байгууллагаас хараат бусаар ажиллах ёстой.

Хараат бус байдлын баталгааны дараах хэмжигдэхүүнийг нэрлэж болно.

1.1 Хуулийн хараат бус байдал

ХЭҮБ-ыг Үндсэн хууль эсхүл тусгайлсан хуулиар байгуулж, Парламентаас комиссын гишүүдийг батална. Гүйцэтгэх засаглалын тогтоол шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, захирамжаар Үндэсний байгууллагын ажиллах журмыг тогтоох, эсхүл

бүрэлдэхүүнийг нь томилохыг зохисгүй, хүлээн авах боломжгүйг Парисын зарчмуудад тусгасан. Филиппин, Тайланд Мальдив улсын ХЭҮБ-ыг Үндсэн хуулиар байгуулсан байдаг.

1.2. Үйл ажиллагааны хараат бус байдал

ХЭҮБ нь хууль болон байгаа нөөц бололцоондоо тулгуурлан хуульд заасан өөрийн үйл ажиллагаа, хяналт шалгалтын ажлын тэргүүлэх чиглэл, төсөл хөтөлбөрүүд, хэтийн болон ойрын зорилтууддаа (стратегитөлөвлөгөө) бие дааж, чөлөөтэйгээр тодорхойлж, хэрэгжүүлдэг байхыг үйл ажиллагааны хараат бус байдал гэнэ.

Хэрэв Парламент, Засгийн газар, Ерөнхийлөгчийн зүгээс юуг шалгах, эсхүл шалгахгүй байх, үйл ажиллагааны тухайн үеийн тэргүүлэх чиглэл хяналт шалгалтын ажлын талаар хэн нэгэн хөндлөнгөөс оролцох боломжтой бол ХЭҮБ-ын бие даасан хараат байдлын тухай ярих нь утгагүй болдог.

1.1. Бодлогын хараат бус байдал

Бодлогын хараат бус байдал гэдэг нь ХЭҮБ-аас урт болон богино хугацааны туршид ямар үйл ажиллагаа явуулах, хүний эрхийн ямар асуудлыг онцгойлон авч үзэх, хаана хяналт шалгалт хийх, ямар сэдвээр илтгэл тайлан гаргах зэргээ бие дааж төлөвлөх ба хэрэгжүүлэхтэй холбоотой болно.

Мөн түүнчлэн Парламент, Засгийн газар, болон бусад этгээдүүдэд хүний эрхийн асуудлаар зөвлөгөө өгөх, хүний эрхийн талаарх өргөдөл гомдлыг шалгаж шийдвэрлэх, сургалт, сурталчилгаа явуулахад ХЭҮБ өөрөө бие дааж тухайн асуудлаар шийдвэрээ гаргах нь бодлогын хараат бус байдлын салшгүй хэсэг юм.

1.2. Санхүүгийн хараат бус байдал

ХЭҮБ нь төрийн байгууллага учраас улсын

төсвөөс тодорхой хэмжээний санхүүжилт авах ба энэхүү санхүүжилт нь хуульд заасан чиг үүрэг, бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь хүрэлцэхүйц байхтай санхүүгийн хараат бус байдал холбогддог.

Түүнчлэн нэгэнт батлагдсан төсвөө ХЭҮБ өөрөө бие дааж, үйл ажиллагаандаа зарцуулах эрх боломж нь санхүүгийн хараат бус байдлын нэг чухал хэсэг болно.

1.3. Бие даасан хараат бус гишүүд

Хуульд заасан тодорхой болзол хангасан хүнийг ХЭҮБ-ын гишүүнээр тодорхой хугацаагаар сонгох буюу томилох ба тэднийг зөвхөн хуульд заасан үндэслэлээр үүрэгт ажлаас нь чөлөөлөх нь ХЭҮБ-ын хараат бус байдлын баталгааны амин чухал хэсэг байдаг.

Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухайд:

- Комиссын гишүүнд нэр дэвшигч нь хууль зүй, улс төрийн өндөр мэргэжилтэй, хүний эрхийн асуудлаар зохих мэдлэг, туршлагатай, ял шийтгэлгүй, Монгол Улсын гучин таван насанд хүрсэн иргэн байна гэж заасан (4 дүгээр зүйлийн 4.1).

Комиссын гишүүнийг дараах тохиолдолд УИХ албан тушаалаас нь чөлөөлнө.

- МУ-ын Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүнд нэрээ дэвшүүлсэн
- Бусад албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон
- Биеийн эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсоноос өөрөө хүсэлт гаргасан (8 дугаар зүйлийн 8.1).

Үүнээс өөр үндэслэлээр чөлөөлөхгүй.

Комиссын гишүүдийн бие даасан, хараат бус байдлын чухал бүрэлдэхүүн хэмжигдэхүүн бол бие даасан үзэл бодол юм. Хэдийгээр Парисын Зарчимуудад энэ талаар дурдаагүй боловч ХЭҮБ-ын гишүүд болон ажилтнуудын хэнээс ч хараат бус үзэл бодол, байр суурь нь тэдний хүний эрхийг хамгаалах

ажлаа хэрхэн үр өгөөжтэй, шударга явуулж байгааг цаг ямагт тодорхойлдог.

ХЭҮБ нь хүний эрхийн онолын үүднээс төр засаг ба иргэдийн хооронд байршиж, төрийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж, хүний эрхийн үүднээс иргэдийг хөхиүлэн дэмждэг “иргэнлэг” байгууллага юм. Засгийн газар, эрх баригч хүчний байр суурь, төрийн албан хаагчдын үзэл бодлоос үл хамааран, хүний эрхийн асуудлаар хяналт шалгалт явуулж чаддаг, тухайн асуудалд хүний эрхийн зарчим, байр сууринаас үнэлэлт дүгнэлт өгдөг, илтгэл, зөвлөмж, саналаа гаргадаг ХЭҮБ-ыг хараат бус, бие даасан үзэл бодолтой гэж үздэг ба энэ нь тухайн ХЭҮБ-ыг үйл ажиллагааны хамгийн үнэ цэнэтэй шалгуур үзүүлэлт болдог байна.

Хоёр: Олон ургальч байдал
Парисын зарчмууд: ХЭҮБ-ын бүрэлдэхүүнд:

“...хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжихэд нийгмийн бүхий л хүчийг оролцуулсан олон ургальч төлөөллийг хангах”-ыг шаарддаг.

“Нийгмийн хүч” гэдэгт:

Хүний эрхийн төрийн бус байгууллагууд
Үйлдвэрчний эвлэл
Хэвлэл мэдээллийн байгууллагууд
Эрдэмтэд, эмч, хуульчдын холбоод зэрэг мэргэжлийн байгууллагууд
Их, дээд сургуулиуд
Шашин болон хүмүүнлэгийн байгууллагууд
Засгийн газрын байгууллагууд
Хууль хүчний байгууллагууд гэх мэтийг ойлгоно.

Олон ургальч байдал нь улс үндэсний нийгмийн өргөн төлөөлөл, тухайлбал үндэсний цөөнх, жендерийн тэгш оролцоог мөн шаардана.

ХЭҮБ-ыг жендерийн тэгш оролцоог хангасан бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, ажиллуулахыг чухалчилдаг.

Тухайлбал, Непал, Өмнөд Солонгос, Малайзын хуулиудад комиссын гишүүдийн

жендерийн тэгш байдлыг тодорхой зохицуулсан.

ХЭҮБ-ын гишүүдийн бүрэлдэхүүнд мэдээж нийгмийн бүхий л төлөөллийг багтаах боломжгүй учраас ХЭҮБ нь өөрөө тэдний дуу хоолой, эрх ашгийг илэрхийлэгч байхын тулд дэргэдээ орон тооны бус зөвлөл, ажлын хэсэг, экспертүүд, сайн дурынхан, хороо зөвлөл зэргийг ажиллуулж, тэдгээрээр дамжуулан олон ургальч байдал, үзлийг хангах болдог.

Гурав. Хүртээмжтэй байдал

Хэдийгээр Парисын зарчмуудад хүртээмжтэй байдлын талаар тусгайлсан заалт байдаггүй боловч хожмын гэрээ, конвенц, хурал зөвлөлгөөн, Засгийн газрын илтгэл тайланг хэлэлцээд НҮБ-ын гэрээний хороодоос гаргасан зөвлөмжүүдэд хүртээмжтэй байдлын талаар анхаарал их хандуулж байна.

Хүртээмжтэй байдал:

- Хүний эрхийн зөрчилд өртөж буй бүх хохирогчийн хувьд хүртээмжтэй байх
- Хүний эрхийн бүх төрөл салбарт хүртээмжтэй байх (нийгэм, соёлын эрх, эрүүл мэндээ хамгаалуулах эрх гэх мэт)
- Нийгмийн ядуучууд, төлбөрийн чадваргүй иргэд, нийгмийн эмзэг бүлгийнхэн ялангуяа хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, аливаа цөөнхүүд, дүрвэгсэд, цагаач ажилчидад хүрч, тэдний эрх асуудлыг судалж, хамгаалах нь хүртээмжтэй байдлын чухал шалгуур болно.
- Нутаг дэвсгэрийн хүртээмжтэй байдал. (Бүх аймаг, сум, дүүргүүдэд хүрч ажиллах)

ХЭҮБ-ууд нь хүртээмжтэй байдлыг хангахын тулд дараах эерэг арга хэмжээг авч хэрэгжүүлэн үйл ажиллагаандаа хэвшүүлэх шаардлагатай болдог.

- гомдол, өргөдөл гаргаж буй хүмүүст чанартай, мэргэжлийн зөвлөгөө өгөх,
- эмзэг бүлгийнхэн, ялангуяа хөгжлийн

бэрхшээлтэй хүмүүс ХЭҮБ-ын байранд саадгүй нэвтрэн орох боломжийг хангах,

- мэдээллийг амаар болон бичгээр, энгийн үг хэллэгтэйгээр хүргэх,
- өөрийн салбар, төлөөлөгчийн газраа хөдөө орон нутаг, дүүргүүдэд нээж ажиллуулах,
- алслагдсан газар, хүмүүст хүрч ажиллах хөдөлгөөнт зөвлөгөө үйлчилгээг бий болгох,
- харилцаа холбоо, орчны хүртээмжтэй байдлыг хялбаршуулах тохиромжтой технологи ашиглах,

Дөрөв. Хариуцлага хүлээх чадвар

Хэдийгээр Парисын Зарчмуудад ХЭҮБ-ын хариуцлагын талаар тусгайлан заагаагүй ч аливаа байгууллага, хувь хүн бүр өөрсдийн хийж буй үйлдэлд хариуцлага хүлээдэг.

ХЭҮБ нь хуулиар байгуулагддаг төрийн байгууллага гэдгээс урган гарах хуулийн хариуцлага, мөн хүний эрхийн байгууллага болохын хувьд урган гарах ёс суртахууны хариуцлага хүлээнэ.

Зарим ХЭҮБ-ууд тухайн улсын Парламентын өмнө тайлагнадаг, зарим нь өөрийн илтгэл мэдээллээ Парламентдаа тавьдаг. Парламентын өмнө тайлагнах, илтгэх гэдэг нь хуулийн хариуцлагын илрэл болно.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссын тухай хуульд зааснаар:

Комисс нь Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар жил бүрийн эхний улиралд багтаан Улсын Их хуралд илтгэнэ (20 дугаар зүйлийн 20.1). гэж заасан. Одоо 14 дэх илтгэлээ бэлтгэж байна.

Парламент дахь хариуцлагын асуудал янз бүр байж болно. ХЭҮБ-ууд нь олон нийтийн тэр дундаа хүний эрхийн хохирогчид болон хүний эрхийн зөрчлийн эрсдэлд буй хүмүүсийн өмнө ёс суртахууны хариуцлага хүлээнэ.

ХЭҮБ-ууд нь өөрсдийн үйл ажиллагаа, хүний эрхийн төлөв байдал, болзошгүй эрсдэлийн талаар олон нийтэд мэдээлж байх үүрэгтэй.

Тав. Хамтын ажиллагаа

Хүний эрхийн үйл ажиллагааг үр дүнтэй явуулахад холбогдох бүх талуудтай нягт хамтарч ажиллах шаардлагатайг Парисын Зарчмуудад хүлээн зөвшөөрдөг.

ХЭҮБ нь дотооддоо төрийн бусад байгууллагууд, ТББ-ууд, шүүх, хэвлэл мэдээлэл, эмэгтэйчүүд, хүүхэд, залуучууд, байгууллагуудтай хамтарч ажиллахын зэрэгцээ гадаад талбарт өргөн хүрээтэй хамтын ажиллагаанд оролцох шаардлагатай болдог.

- НҮБ-ын байгууллага болон механизмууд
- ХЭДК газар
- Бүс нутгийн хүний эрхийн байгууллага (чуулга, форум)
- Бүс нутгийн хүний эрхийн ТББ-ын сүлжээ, форум
- Бусад улсын ХЭҮБ

Зургаа. Дэд бүтэц

ХЭҮБ нь хангалттай нөөц, дэд бүтэцтэй байх ёстой. Нөөц, дэд бүтэц нь зөвхөн санхүүжилтээр хязгаарлагдахгүй. ХЭҮБ нь хуульд заасан өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх л зүйлийг нөөц, дэд бүтэцэд хамааруулдаг.

Тухайлбал, ажлын байр, техник хангамж, харилцаа холбоо, машин, зам тээвэр, сургалт мэдээллийн сүлжээ, иж бүрдэл зэрэг байгууллагын чадавхид нөлөөлөх бүхий л зүйлс багтана.

Б. ХЭҮБ-уудын хэрэгжүүлэх чиг үүргүүд

Эрх хамгаалах чиг үүрэг

Хүний эрхийг хөхиүлэн дэмжих үйл ажиллагаа

Нэг. Эрх хамгаалах чиг үүрэг

Хүний эрхийн зөрчлөөс хувь хүн хэсэг бүлэг хүмүүсийг хамгаалах нь ХЭҮБ-уудын хэнтэй ч хуваалцахгүй өдөр тутмын гол үүрэг байдаг. Хүний эрхийг хамгаалах чиг үүргийн хүрээнд олон төрлийн үйл ажиллагаа хамрагдана.

Тухайлбал:

- Хүний эрхийн нийтлэг болон ноцтой зөрчлийн талаар судалгаа, хяналт шалгалтын ажил зохиох байгуулах
- Улс орон дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын тухай болон тодорхой асуудлуудтай холбоотой илтгэлүүдийг гаргах
- Хүний эрхийн зөрчлүүдэд Засгийн газрын анхаарлыг хандуулж, ийм зөрчлийг таслан зогсооход чиглэгдсэн арга хэмжээнүүдийг санал болгох, шаардлагатай тохиолдолд Засгийн газрын байр суурь, арга хэмжээний талаар өөрийн үзэл бодлыг илэрхийлэх
- Хүний эрхийн зөрчлийн тухай өргөдөл гомдол хүлээн авч шалгах
- Хууль тогтоомжийг судлаж, хүний эрхийн үндсэн зарчмуудад нийцүүлэхэд чиглэгдсэн санал, зөвлөмж гаргах
- Хүний эрхийн олон улсын гэрээ, баримт бичгүүдтэй үндэсний хууль тогтоомжийг нийцүүлэх, олон улсын гэрээнүүдэд нэгдэн орох, соёрхон батлах талаар санал, зөвлөмж гаргах,
- НҮБ-ын холбогдох хороо, байгууллагуудад гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийнхээ талаар Засгийн газраас гаргадаг илтгэлүүдэд санал өгч, шаардлагатай бол өөрийн байр суурийг тусгайлан илэрхийлэх
- Аливаа ялгаварлан гадуурхалтын эсрэг идэвхтэй тэмцэх

1.1 Гомдол хүлээн авч шийдвэрлэх

Ихэнх ХЭҮБ-ууд гомдол хүлээн авч, шалгаж шийдвэрлэдэг. Гомдол хүлээн авч шийдвэрлэх нь ХЭҮБ болон иргэн хоёрын

харилцааны уулзах цэг болоод зогсохгүй ХЭҮБ-т итгэх итгэл, түүний албан ёсны байр суурь, нэр хүндийг улам баталгаажуулж байдаг.

Монгол Улсын Хүний Эрхийн Комиссын тухай хуулиар тус комисст ирүүлэх гомдолд ямар нэг хязгаарлалт тавиагүй, иргэд дангаар буюу хамтарч гомдол гаргах ба ТББ, үйлдвэрчний эвлэлийн байгууллага төлөөлөгчөөрөө дамжуулан гомдол гаргах боломжтой (9 дүгээр зүйлийн 9.1, 9.4).

Гомдлыг бичгээр эсхүл амаар, гаргаж болох бөгөөд монгол хэл мэдэхгүй хүн эх хэлээрээ гомдол гаргаж болно.

Харин комисс нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн шатанд байгаа болон хянан шийдвэрлэгдсэн эрүү, иргэний хэрэг маргааны талаарх гомдлыг хүлээн авахгүй.

Комисст гаргах гомдолд дараах шаардлагыг тавина.

- Гомдол гаргагч гомдлоо захиргааны журмаар шийдвэрлүүлсэн байх
- Монгол Улсын ямар хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан ямар эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн болохыг заах,
- Гомдолд холбогдож байгаа аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүний нэр, хаяг, утасны дугаар, холбогдох бусад баримтыг хавсаргасан байх
- Гомдол гаргагч эрх, эрх чөлөө нь зөрчигдсэн өдрөөс, эсхүл тийнхүү зөрчигдсэн гэдгийг мэдсэн өдрөөс хойш нэг жилийн дотор гомдол гаргана.

Гомдлыг шалгаад дараах арга хэмжээг авдаг.

- Хүний эрхийг зөрчсөн, зөрчих нөхцөлийг бүрдүүлсэн үйл ажиллагаагаа зогсоохыг байгууллага албан тушаалтнаас шаардах
- Хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн албан тушаалтанд захиргааны шийтгэл ноогдуулах тухай хүсэлтээ эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавих
- Хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн тухай асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах

- Талуудыг эвлэрүүлэх замаар асуудлыг шийдвэрлэх

Гомдлыг үндэслэлгүй гэж үзвэл гомдол гаргагчид хариу өгөх

Гомдол шийдвэрлэлтийн ажиллагаанд ул суурьтай дүн шинжилгээ хийх нь хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой юм.

Дүн шинжилгээний үр дүнд

- Хүний эрхийн зөрчлийн үндэс суурь болж буй нөхцөл, тогтолцоог зөв тодорхойлно.
- Хүний эрхийн төлөв байдалд бүхэлд нь үнэлэлт өгөх амьд нотолгоо баримтуудтай болно.
- Комиссын гишүүд, ажилтануудын гомдлыг шийдвэрлэх ажиллагаа, процессын ил тод байдал, шударга хандлага нь хүний эрхийн зөрчлийг нөхцөлдүүлэгч эрсдэлтэй байгууллага, албан тушаалтнуудад төдийгүй өргөн олон нийтэд сургамжтай, урьдчилан сэргийлэх үр дагавартай болохыг олж харна.
- Цаашид гомдол шалгах арга ажиллагаагаа сайжруулах, үр дүнтэй болгох улмаар стратеги төлөвлөгөөндөө гомдлын шалгалттай холбоотой шинэ зорилт дэвшүүлэн оруулж болно.

1.2. Хяналт шалгалт

ХЭҮБ нь хүний эрхийн зөрчлүүдийн талаар хяналт шалгалтын ажил зохион байгуулах нь хүний эрхийн нөхцөл байдлыг сайжруулан өөрчлөхөд онцгой ач холбогдолтой. Ийм хяналт шалгалтын ажлын явцад ХЭҮБ олон чиг үүргээ хамтад нь хэрэгжүүлэхийн зэрэгцээ өөрийн бүрэн эрхээ эдэлдэг онцлогтой.

Хүний эрхийн хяналт шалгалтыг хийснээр ХЭҮБ нь:

- Хүний эрхийн ноцтой асуудлыг мөрдөн шалгаж, зөрчил дутагдлыг дэлгэж харуулна.

- Хяналт шалгалтын ажлын явцад цугларсан мэдээллээ боловсруулж, тайлан илтгэл бичиж, шаардлага зөвлөмж, саналыг холбогдох газруудад хүргүүлнэ
- Буруутай албан тушаалтнуудад хариуцлага хүлээлгэнэ.
- Хохирогчийн эрхийг сэргээх, ирээдүйд эрхээ улам таатай нөхцөлд эдлэх явдлыг баталгаажуулахын тулд тухайн байгууллагын зүгээс болон бусад байгууллагаас цаашид авах арга хэмжээг тодорхойлно.

Үндэсний хэмжээний нээлттэй хяналт шалгалт

ХЭҮБ-уудын хяналт шалгалтын ажлын дотор үндэсний хэмжээний нээлттэй хяналт шалгалт онцгой анхаарал татдаг. Хяналт шалгалтын энэ аргыг Ази Номхон далайн бүс нутгийн ХЭҮБ-уудад түлхүү хэрэглэдэг ба анх Австралийн ХЭҮК-оос зохион байгуулсан байдаг.

ХЭҮБ нь ердийн хяналт шалгалтыг ихэвчлэн иргэдийн гомдлыг үндэслэн тухайн хувь хүний эрхийн зөрчлийн асуудлаар, эсхүл тодорхой эрхийн асуудлаар өөрийн гишүүд, ажилтнуудын оролцоотойгоор, хуульд заасан хугацаанд хийж шийдвэрлэхтэй холбоотой байдаг.

Үндэсний хэмжээний нээлттэй хяналт шалгалт нь дараах онцлогтой байна.

- Тогтолцооны шинжтэй, хүний эрхийн ужгирсан ноцтой зөрчлийг шалгана.
- Хяналт шалгалтыг үндэсний хэмжээнд зохион явуулна.
- Уг хяналт шалгалтын ажил нь урьдаас олон нийтэд зарлагдаж, хүний эрхийн ямар асуудлаар, хаана хийх, ямар зорилготой болон шалгалтын удирдамж хөтөлбөр нь ил тод байна.
- Хяналт шалгалтанд ХЭҮБ-ын гишүүд ажилтануудаас гадна тухайн эрхийн талаар мэргэшсэн судлаачид, багш, шинжээчид, ТББ-ыг урьж оролцуулна.
- Шалгалтын удирдамжийг боловсруулахдаа мэргэжилтнүүд

болон хохирогчидын төлөөллийг оролцуулж, тэдний санал зөвлөмжийг авна.

- Нээлттэй хяналт шалгалтын талаар хэвлэл, мэдээллийн байгуулагатай хамтарч, тухайн эрхийн зөрчлийн талаарх олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлж, мөн тусгайлан хариуцлага хүлээж буй байгууллага, албан тушаалтануудыг мэдээллээр хангана.
- Тухайн эрхийн хэрэгжилт, зөрчлийн талаар үндэсний хэмжээний мэдээлэл, баримт нотолгоо цуглуулна.
- Нээлттэй хяналт шалгалтын цар хүрээ, нөлөө нь зөвхөн тухайн эрхээр хязгаарлагдахгүйгээр хүний эрхийн бусад асуудлыг үндэсний хэмжээнд олон нийтийн анхаарлын төвд байлгаж, хүний эрх нь хуваагдашгүй, харилцан хамааралтай болохыг харуулж чадна.
- Олон улсын хүний эрхийн гэрээ, баримт бичгээр хүлээсэн үүргийн биелэлт, хэрэгжилтийг харуулдаг үр нөлөөтэй арга болно.
- Олон нийтийн мэдлэг нэмэгдэж, эрх баригчдад улс төрийн шахалт үүсч, Засгийн газар болон байгуулагуудад өгсөн санал, зөвлөмж, шаардлагууд бодит үр дүнд хүрнэ.

Хоёр. Хүний эрхийг хөхиүлэн дэмжих үйл ажиллагаа

ХЭҮБ нь үндэсний хэмжээнд хүний эрхийн соёлыг бий болгох, түгээн дэлгэрүүлэх, хүний эрхийг хөхиүлэн дэмжихэд онцгой үүрэг хүлээнэ. Мэдээж, хүний эрхийг хөхиүлэн дэмжих үйл ажиллагаа нь өөртөө хүний эрхийг хамгаалахад чиглэгдсэн үйл ажиллагааг нэгэн зэрэг агуулж байдаг.

Парисын Зарчмуудад зааснаар ХЭҮБ нь хүний эрхийг хөхиүлэн дэмжих бүрэн эрх хэмжээтэй байх шаардлагатай.

Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд:

Комисс нь хүний эрхийг сахин

хамгаалах, хөхиүлэн дэмжих байгууллага нь мөн (3 дугаар зүйлийн 3.1) хэмээн заасан байдаг.

Хөхиүлэн дэмжих үйл ажиллагаа нь нийгэмд хүний эрхийн талаар мэдээлэл өгөх, хэлэлцүүлэг өрнүүлэх, шүүмжлэн хэлэлцэх нөхцөлийг бий болгох, улмаар хүний эрхтэй холбоотой аливаа эерэг санал санаачилга, оролдлогыг бүх талаар сайшаан дэмжиж, хамтран ажиллах өргөн хүрээний ойлголт болно. Мөн хүний эрхийн талаарх алдаатай, хоцрогдсон ойлголтыг залруулахад түлхэц болно.

Хөхиүлэн дэмжих үйл ажиллагааны дараах төрөл, арга барилыг ХЭҮБ-ууд хэрэгжүүлж байна.

- Хүний эрхийн боловсрол,
- Соён гэгээрүүлэх үйл ажиллагаа,
- Хүний эрхийн судалгаа,
- Хүний эрхийн талаар мэдээлэл түгээх, хэвлэн нийтэлж олон нийтийн хүртээл болгох,
- Хүний эрхийн сургалт явуулж, хувь хүн, бүлгийн чадавхийг хөгжүүлэх,
- Хүн амын зорилтот бүлгүүд ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд залуучууд, оюутнуудын дунд хүний эрхийн асуудлаар маргаан мэтгэлцээн, уралдаан зохион байгуулах гэх мэт.

2.1. Боловсрол, сургалт мэдээлэл, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа

ХЭҮБ-ууд хүний эрхийн боловсрол, мэдээлэлд онцгойлон анхаарч, өөрсдийн хязгаарлагдмал нөөц боломжийн хүрээнд идэвхтэй ажилладаг. Энэ ажлыг хийхдээ төрийн байгууллага, ТББ-ууд, эрдэмтэн судлаачид, шашны зүтгэлтэнүүд, гадаад болон дотоодын донор байгууллагуудтай өргөн хүрээнд хамтран ажиллах шаардлагатай болдог.

Хүний эрхийн боловсрол, сургалт нь хүний эрх, үндсэн эрх чөлөөг хүндэтгэхийг хөхиүлэн дэмжих, олон нийтэд мэдлэг, чадвар эзэмшүүлэх замаар хүний эрхийн

зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүний эрхийн хэм хэмжээ, үнэт зүйлс, түүнийг хамгаалах механизмын талаарх мэдлэг олгох ойлгуулах, олон нийтийн хандлага, зан үйлийг төлөвшүүлэх, хүний эрхийн түгээмэл соёлыг бий болгож, дэмжихэд хувь нэмрээ оруулах үйл ажиллагаа болно.

ХЭҮБ-ууд ихэвчлэн хууль сахиулах байгууллагын ажилтанууд, төрийн албан тушаалтнууд, хэвлэл мэдээллийн байгууллагын идэвхтэнүүдэд зориулан хүний эрхийн сургалтуудыг зохион байгуулдаг.

Олон нийтэд хүний эрхийн талаар мэдээлэл хүргэж, зөрчигдсөн эрхээ хэрхэн яаж, хэнд хандаж хамгаалуулах, эрхийн эрсдлээс өөрсдийгөө урьдчилан сэргийлэх чадвартай болгох нь хүний эрхийн төлөөх тэмцэл, үйл ажиллагааны гол зорилго байдаг.

Эрхээ мэддэггүй, зөрчигдсөн тохиолдолд хэрхэн яаж эрхээ сэргээлэх талаар төсөөлөлгүй хүмүүс бол хүний эрхийн зөрчлийн байнгын хохирогчид болдог.

Үүнийг ч бас хүний эрхийг зөрчигчид албан тушаалтанууд сайн мэддэг. “Номхон

тэмээ ноолоход амар” гэж монголчууд ярьдаг.

Мэдээлэл түгээх, соёх гэрээрүүлэх ажилд ХЭҮБ-ууд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хэрхэн хамтарч ажиллаж буй нь онцгой ая холбогдолтой. Цахим хуудас болон үндэсний олон нийтийн радио, телевизийн сувгийг ашигладаг.

ХЭҮБ-ын цахим хаяг, түүнд тавигдаж буй материалууд байнга олон нийтийн анхааралд өртөж байх ёстой.

2.2 Судалгаа, илтгэл

Тухайн цаг үед хүний эрхийн талаасаа анхаарал татаж буй сэдвээр ХЭҮБ-ууд судалгаа хийж, илтгэл тайлан гаргадаг.

Судалгааг:

- ХЭҮБ-ын гишүүд, ажилтнуудын оролцоотойгоор хийх
- Бусад байгууллага, судлаачидтай хамтран хийх
- Захиалгаар бусад судалгааны байгууллага, багаар хийлгэх,

Ихэнх ХЭҮБ-ууд жил тутмын хүний эрхийн тухай илтгэл гаргадаг.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

АЛБАДАН АЖИЛ ХИЙЛГЭХ ЯЛ БА НИЙТЭД ТУСТАЙ АЖИЛ ХИЙЛГЭХ ЯЛЫГ ХАРЬЦУУЛАН СУДЛАХ НЬ



Улсын Ерөнхий Прокурорын туслах,
Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих
хэлтсийн дарга, Монголын хуульчдын холбооны
Хууль зүйн шинжлэх ухаан, боловсролын
хөгжлийг дэмжих хорооны дарга

Ц.МӨНХБАТ

2002 онд батлагдсан Эрүүгийн хуульд ялын шинэ төрөл болж хуульчлагдсан “Албадан ажил хийлгэх ял”-ыг хэрэгжүүлэх нөхцөл боломжийг судлах зорилгоор “Нээлттэй нийгэм форум”-ын санхүүжилтээр Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанаас “Албадан ажил хийлгэх, ял эдлүүлэх ажиллагааг хэвшүүлэх нь” төслийг улсын хэмжээнд хэрэгжүүлсэн ба хөдөлмөрийн эрх зүйн талаас нь доктор, профессор Б.Уранцэцэг тусгайлан судалж дүгнэлт гаргасан, түүнчлэн ялын хэрэгжилт, үр нөлөөг Монгол Улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийн Эрүүгийн эрх зүйн тэнхимийн эрдэмтэн, багш нарын баг тухайн үед судалгаа хийсэн байна.

2004 онд Б.Билэгсайханы “Албадан ажил хийлгэх ял бол ял шийтгэлийн өвөрмөц төрөл мөн” гэсэн гарын авлага хэвлэгдсэн, академич, хууль зүйн шинжлэх ухааны доктор профессор С.Нарангэрэл, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Ж.Авхиа, Г.Совд, С.Жанцан, Д.Баярсайхан нарын эрх зүйн ном, сурах бичиг, бусад судлаачдын бичсэн илтгэл, өгүүлэлд дээрх ялын тухай тусгагдсан боловч энэ талаар дагнасан судалгааг нэг сэдэвт докторын ажил болгосон зүйл одоог хүртэл хараахан гараагүй байна.

Иймд энэхүү сэдвийн хүрээнд албадан

ажил хийлгэх ял болон нийтэд тустай ажил хийлгэх ялын хоорондын харилцан холбоо, уялдааг төсөөтэй болон ялгаатай талаас нь харуулан судлахыг оролдов.

Нэг: Ялын нэршлийн тухай

“Жинхэнэ дагаж явах хууль дүрэм”-д архи ууж, мөрийтэй тоглохыг хориглоод хагас жилийн хугацаагаар үйлдвэр хийлгэж, цээрлэл үзүүлэн уг хугацаа дуусмагц тус тус зуун ташуур шийтгэхийг заажээ. “Үйлдвэр хийлгэнэ” гэдэг ойлголт нь хүнд хүчир ажил албадан хийлгэхтэй дүйцнэ гэж зарим судлаачид тэмдэглэсэн байна. Мөн энэ дүрэмд заасан ёсоор хулгайлах гэмт хэрэгт “үйлтгэх ял” буюу албадан ажил хийлгэх ял оногдуулдаг байв¹²¹.

Зарлигаар тогтоосон хууль зүйлийн бичигт албадан хөдөлмөрлүүлж, хүнд (зовоох) ажилд зүтгүүлэх ялыг хязгаарт цөлөх ялтай хамт хэрэглэж байсан.

1921 оны 8 дугаар сард Шүүх явдлын яамнаас тусгасан “Эрүү шүүлтийг хувьсган тогтоох явдлын тухай” Ардын засгийн гаргасан бичигт гянданд хорьж, өдөр бүр зүдгүүртэй ажил хийхийг тогтоосон.

1926 оны Шүүх цаазын бичгийн 5 дугаар зүйлд гянданд хорьж, албадан

¹²¹ Б.Баярсайхан. Эх бичгийн судалгаа. Тэргүүн дэвтэр УБ 2004 он 2016 дахь тал

ажил хийлгэх¹²², 1929, 1934 оны Шүүх цаазын бичгийн 8 дугаар зүйлд хорихгүйгээр албадан ажил хийлгэх¹²³, 1942 оны Эрүүгийн хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт хорихгүйгээр засан хүмүүжүүлэх хөдөлмөр гэж¹²⁴ гэж өөрчлөн найруулжээ.

1961 оны Эрүүгийн хуулийн 17 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “засан хүмүүжүүлэх ажил хийлгэх” гэж нэрлэж хуульчлагдсанаас хойш 2002 он хүртэл энэ нэрээр ялын төрөлд хамаарч байгаад 2002 оны Эрүүгийн хуульд албадан ажил хийлгэх ял болгон өөрчилсөн¹²⁵ байна.

Дээрх хууль тогтоомж үйлчилж байсан тухайн нийгмийн нөхцөл байдлыг харьцуулан үзэхэд “Албадан ажил хийлгэх ял” нь 1942 он хүртэл бодитой оршиж байсан гэж үзэж болох талтай.

2002 оны Эрүүгийн хуулийг боловсруулах ажлын хэсгийн хэлэлцүүлгийн явцад “Ажил албадаж хийлгэх” гэдэг болохоос биш “албадан ажил” гэж байдаггүй, энэ бол 1937 оны хэллэг хэмээн шүүмжилсэн байдаг¹²⁶.

Албадан ажил хийлгэх гэдэг нь хүнд хүчир ажлыг хүнлэг бус байдлаар хатуу чанд нөхцөлийн дор хүч хэрэглэж албадан тулгаж хийлгэхэд чиглэгдсэн ял юм¹²⁷.

1990 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгээс “Хорихоос өөр төрлийн ял хэрэглэхэд баримтлах НҮБ-ийн наад захын стандарт журам” (Токиогийн дүрэм)-ыг баталсан ба түүний 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Нийгмийн тустай ажлыг заавал хийлгэх ял”¹²⁸ буюу “Нийгэмд үйлчлэх ял” хэмээн нэрийдэж ялын төрлийг сонгох

үндэслэл зарчмыг тодорхой заасан. Өөрөөр хэлбэл гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн этгээдийг хуулиар зөвшөөрсөн ажлыг хуульд заасан хугацаа, нөхцөлийн дагуу хүнлэг ёсны зарчимд нийцүүлэн, цалин хөлсгүй хийлгэж, түүнийг хорих ангид байлгах бус нийгэмд учруулсан хор уршгаа нийтэд тустай ажил хийж, засарч хүмүүжих боломжийг олгодог ял юм.

Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор С.Жанцан гадаад орнуудын эрүүгийн ялын тогтолцоонд “Нийгэмд үйлчлэх ял” гэсэн нийтлэг нэр томъёогоор хэрэглэгдэж байгаа боловч ялын зорилго, мөн чанарын хувьд манай улсад хэрэглэж буй албадан ажил хийлгэх ялтай төсөөтэй юм¹²⁹ гэсэнтэй судлаачийн хувьд санал нийлэхгүй байна. Учир нь манай Эрүүгийн хууль дахь албадан ажил хийлгэх ял нь эсрэгээрээ гадаад орнууд дахь “Нийгэмд үйлчлэх ялтай” төстэй байна.

2002 оны Эрүүгийн хуульд тусгалаа олсон “Албадан ажил хийлгэх ял” нь мөн чанар, агуулгын хувьд “Нийгэмд үйлчлэх ял”-тай адилхан тул нэршлийн тухайд буруу томъёологдсон байна. Бусад оронд Эрүүгийн хуулиндаа “Нийгэмд үйлчлэх ял”-ыг дараах байдлаар нэрлэжээ. Тухайлбал:

Казахстан- Нийгмийн ажилд татан оролцуулах

Молдав- Нийгмийн тусын тулд үнэ хөлсгүй үйлчлэх

Гүрж- Нийгэмд ашигтай хөдөлмөр эрхлэх

Литва- Нийгэмд тустай хөдөлмөр хийх

Франц- Нийтийн ашиг сонирхлын төлөө ажиллах

Канад- Болзолт ял

Орос, Голланд, Украин- Заавал хийлгэх ажил

Латви- Албадан хөдөлмөр хийх

Испани- Нийгмийн тусын тулд ажиллах гэх мэт.

Тэгэхээр 2002 оны Эрүүгийн хуулинд “Албадан ажил хийлгэх ял” гэхийн оронд “Нийгэмд үйлчлэх ял буюу Нийтэд тустай ажил хийлгэх ял” гэсэн бол нэршлийн хувьд илүү оновчтой болох байжээ.

¹²² Д.Адъяабазар. МУ-ын 1921 оноос хойшхи Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт I дэвтэрУБ. 1998 он 9 дэх тал

¹²³ Б.Ганболд. Эрүүгийн эрх зүйд хэвтрэхүй. УБ. 2012 он. 172 дахь тал

¹²⁴ Д.Адъяабазар. МУ-ын 1921 оноос хойшхи Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт I дэвтэрУБ. 1998 он 108-109 дэх тал

¹²⁵ С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол УБ 2014 он 179 дэх тал

¹²⁶ МУ-ын Эрүүгийн хуулийн үндсэн үзэл баримтлал. УБ 2002 он. 3-р ботиос дэлгэрүүлж үзнэ үү.

¹²⁷ Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ. 1966 он 29 дэх тал

¹²⁸ Д.Баярсайхан. Харьцуулсан Эрүүгийн эрх зүй. УБ 150 дахь тал

¹²⁹ С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол УБ. 2014 он. 181 дэх тал

Хоёр: Ялын төсөөтэй ба ялгаатай тал

2002 оны Эрүүгийн хууль дахь “Албадан ажил хийлгэх ял” болон 2015 оны Эрүүгийн хууль дахь “Нийтэд тустай ажил хийлгэх ял” хоорондын нийтлэг төсөөтөй байдлыг судлахад

- а) Ялтанд цалин хөлс олгодоггүй
б) Ялын хугацааг цагаар тооцдог

в) Жирэмсэн хүн, 55-аас дээш насны эмэгтэй, 60-аас дээш насны эрэгтэй хүнд энэ ялыг оногдуулахгүй

г) Ял эдлүүлэх ажиллагаанд прокурор хяналт тавьдаг гэх мэт.

Дээрх ял хоорондын ялгаатай талыг үзэхэд дараах онцлогууд байна. Үүнд:

ЯЛЫН ЯЛГААТАЙ ТАЛ			
АЛБАДАН АЖИЛ ХИЙЛГЭХ ЯЛ (2002 оны Эрүүгийн хууль)		НИЙТЭД ТУСТАЙ АЖИЛ ХИЙЛГЭХ ЯЛ (2015 оны Эрүүгийн хууль)	
1	Үндсэн ял (Эрүүгийн хуулийн 46.2)	1	Үндсэн ба нэмэгдэл ял (торгох+нийтэд тустай ажил хийлгэх) (нийтэд тустай ажил хийлгэх + хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ) (Эрүүгийн хуулийн 5.2-2, 8.3-3)
2	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлсон газарт нийгэмд ашигтай ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийлгэхийг албадан ажил хийлгэх ял гэнэ (Эрүүгийн хуулийн 50.1)	2	Шүүхээс тогтоосон нийтэд тустай ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийлгэхийг нийтэд тустай ажил хийлгэх ял гэнэ. (Эрүүгийн хуулийн 5.4-1)
3	Ялын хугацаа нь 100-500 цаг байна. (Эрүүгийн хуулийн 50.2)	3	Ялын хугацаа нь 120-480 цаг байна. (өсвөр насны хүнд 60-240 цаг) (Эрүүгийн хуулийн 5.4-3)
4	Ялын үргэлжлэх хугацаа 1 өдөрт 3 цагаас доошгүй байна. (Эрүүгийн хуулийн 50.2)	4	Ялын үргэлжлэх хугацаа өдөрт 4-өөс дээшгүй цаг байна. (Эрүүгийн хуулийн 5.4-3)
5	Ял эдлэхээс санаатайгаар зайлсхийвэл ялын 8 цагийн ажлыг 1 хоног баривчлах ялаар солино. (Эрүүгийн хуулийн 50.3)	5	Ялыг биелүүлээгүй бол ялын 8 цагийн ажлыг 1 хоногоор тооцож хорих ялаар солино. (Эрүүгийн хуулийн 5.4-4)
6	-Хөдөлмөрийн чадваргүй этгээд -3 хүртэлх насны хүүхэдтэй эх буюу ганц бие эцэг -Цэргийн жинхэнэ алба хааж байгаа этгээдэд ял оногдуулахгүй (Эрүүгийн хуулийн 50.4)	6	-Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан (Эрүүгийн хуулийн 5.4-5)
7	Хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэгт ял оногдуулах (Эрүүгийн хуулийн 17.2-3)		

2015 оны Эрүүгийн хуульд “шүүхээс тогтоосон нийтийн ашиг сонирхол тустай ажил” гэж заасан нь үндэслэл муутай. Зүй нь төрийн захиргаа, орон нутгийн өөрөө удирдах байгууллага жагсаалт гаргаж тогтоож байх нь зохистой.

Ялын үргэлжлэх хугацаа нэг өдөрт 3 цагаас доошгүй байна¹³⁰ гэсэн хуулийн заалтын дагуу ялтан ажлын өдөр тутам 3-8

цаг албадан ажил хийж оногдуулсан ялыг эдэлж¹³¹ байгаа өнөөгийн практикийг халж ялын үргэлжлэх хугацаа өдөрт 4-өөс дээшгүй цаг байхаар шинэчилсэн нь олон талын ач холбогдолтой. Ялтан өдөрт 4 цаг хүртэл ажиллаад бусад үед нь сурч боловсрох, ажил хөдөлмөр эрхлэх боломжтой болсон нь хүний эрхийг хангах чухал алхам болсон.

Түүнчлэн 2002 оны Эрүүгийн хуулийн

¹³⁰ 2002 оны Эрүүгийн хуулийн 50 дугаар зүйлийн 50.2 дахь хэсэг

¹³¹ Албадан ажил хийлгэх ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэхэд хяналт тавих журмын 6.4 дэх хэсэг

50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэгт заасан албадан ажил хийлгэх ял оногдуулж болохгүй этгээдэд 16 насанд хүрээгүй хүнийг хамааруулаагүй. Энэ нь 16 насанд хүрээгүй этгээдэд албадан ажил хийлгэх ял оногдуулах боломжийг нээж өгсөн нь Хөдөлмөрийн хуулийн 109 дүгээр зүйлд заасан “Насанд хүрээгүй хүний хөдөлмөр”-ийн ... 16 насанд хүрсэн хүн хөдөлмөрийн гэрээ байгуулах эрхтэй ... мэргэжлийн баримжаа, ажлын дадлага олгох зорилгоор 15 насанд хүрсэн хүнтэй эцэг эх, асран хамгаалагч болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлтэйгээр хөдөлмөрийн гэрээ байгуулж болно ... насанд хүрээгүй хүнийг оюун ухааны хөгжил, эрүүл мэндэд нь харшлах хөдөлмөр эрхлүүлэхийг хориглоно ... бусад тохиолдолд насанд хүрээгүй хүнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулахыг хориглоно¹³²

Эрүүгийн хуулийн 121 дүгээр зүйлийн ... хүүхдийг албадан болон хүчээр хөдөлмөрлүүлэх¹³³ болон Хүүхдийн эрхийн конвенцийн заалттай зөрчилдөж байсныг өөрчилж шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд түүний нас биед тохирсон, эрүүл мэнд, ёс суртахуун, хүүхдийн сэтгэцийн хөгжилд

харшлахгүй нийтэд тустай ажил хийлгэх ял оногдуулах¹³⁴ гэсэн нь эерэг дэвшил гарсан.

Анхаарал татсан асуудлын тухайд нийгэмд ашигтай буюу нийгмийн ашиг сонирхолд тустай ажлыг ялтанд цалин хөлс олгохгүйгээр хийлгэх гэснийг нарийвчлах шаардлагатай. Хуулиар ялтанд цалин хөлс олгохгүй ч түүний хөдөлмөрийн үнэ цэнэ мөнгөөр хэмжигдэж тэр нь улсын төсөвт орж хохирол нөхөн төлөх, улмаар эх орны бүтээн байгуулалтад нэмэр болох учиртай. Гэтэл практик дээр албадан ажил хийлгэх ял шийтгүүлсэн этгээдийн хөдөлмөрийн хөлсийг тооцдоггүй ба хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр сүүлийн 3 жилийн байдлаар судлахад 2013 онд улсын хэмжээнд 437 ялтны 145805.652 төгрөг, 2014 онд 367 ялтны 125246.511 төгрөг, 2015 онд 376 ялтны 124653.294 төгрөг нийт 1180 ялтны 395705.457 төгрөгийн ажлыг ял эдлүүлсэн газрууд бодож тооцоогүй байгааг цаашид эрх зүйн хүрээнд шийдвэрлэх нь тулгамдсан асуудлын нэг болж байна.

Эцэст нь нийтэд тустай ажил хийлгэх ялыг биелүүлэхтэй холбоотой процессийн хуулиудыг зохицуулалт сайтай батлан гаргаж хэрэгжүүлэх нь үр нөлөөгөө өгөх болно.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

¹³² Эрх зүйн мэдээллийн систем, Хөдөлмөрийн хууль 109.1, 109.3, 109.4, 109.6 дугаар зүйл

¹³³ Эрүүгийн хууль, Монгол Улсын хууль эмхтгэл 2015 он. УБ 48 дахь тал

¹³⁴ Эрүүгийн хууль. УБ 2016 он 24 дэх тал

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГЫН ЦААШДЫН ТӨЛӨВ



Монгол Улсын Их Сургуулийн
Хууль зүйн сургуулийн докторант

Б.БОЛОРСАЙХАН

Олон улсын тавцан дээр хүний эрхийн төлөө зүтгэх нэгэн байгууллага сүүлийн хорин жилийн хугацаанд тодрон гарч ирсэн нь Парисын зарчим хэмээх дэлхий дахинд хүлээн зөвшөөрсөн жишгийн дагуу байгуулсан хүний эрхийн үндэсний байгууллагууд билээ¹³⁵. Парисын зарчим бол хүний эрхийг сахин хамгаалагч, заан зөвлөгч, сурган хүмүүжүүлэгчийн үүргээр ажиллах боломжтой үндэсний хэмжээнд ажиллах тусгай төрлийн байгууллагыг хэрхэн байгуулах тухай заасан баримт бичиг юм. Энэхүү баримт бичгийн дагуу тухайн улсын төр нь хүний эрхийн үндэсний байгууллагын бүтцийг тодорхойлох, бүрэлдэхүүнийг томилох, санхүүжүүлэх, ямар нэгэн хөндлөнгийн хяналтгүйгээр шударга ажиллах, үндэсний болон олон улсын түвшинд хүний эрхийн төлөө ажилладаг бусад этгээдтэй ойр нягт ажиллах нөхцөл бүрдүүлэх ёстой. Хорь хүрэхгүй жилийн өмнө маш цөөн тооны хүний эрхийн үндэсний байгууллага ажиллаж

байсан бол өнөөдөр зуугаар тоолохуйц их болж, төрөл бүрийн олон улсын байгууллагын зүгээс тус бүтцийг байгуулах, бэхжүүлэхэд анхаарч дэмжиж байна.

Хүний эрхийн үүрэг амлалтаа биелүүлэх нь нэн тэргүүнд дотооддоо хүлээх үүрэг хариуцлага болохыг олон улсын тогтолцоо буюу Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ), түүний бүтэц хүлээн зөвшөөрсөн нь 70 орчим жилийн өмнөөс тусгайлсан дотоодын механизм байгуулж, хөгжүүлэхийг уриалан дэмжсэнээр илэрдэг.

НҮБ-ын санаачилга

Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг батлахаас хоёр жилийн өмнө буюу 1946 онд НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн Зөвлөл (ЭЗНЗ) НҮБ-ын гишүүн улсуудыг “[НҮБ]-ын Хүний эрхийн Комиссын ажилд түлхэц үзүүлэх зорилгоор тэдэнтэй хамтарч ажиллах мэдээллийн бүлэг эсхүл орон нутгийн хүний эрхийн хороодыг тус тусын улсдаа байгуулах хүсэл сонирхол”-ыг харгалзан үзэхийг хүссэн.¹³⁶ Эдгээр “орон нутгийн хүний

¹³⁵ United Nations, National Human Rights Institutions: A Handbook on the Establishment and Strengthening of National Institutions for the Promotion and Protection of Human Rights (New York, 1995), 6 дахь нүүр; A. Schedler, L. Diamond, and M. F. Plattner (eds.) The Self-Restraining State: Power and Accountability in New Democracies (Boulder: Lynne Rienner, 1999).

¹³⁶ 1946 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн ЭЗНЗ-ын тогтоол 9 (II), 5 дахь догол мөр.

эрхийн хороод” нь ХЭҮБ-ууд шиг хяналт тавих, мөрдөн шалгалт хийх хараат бус байгууллага байхаар төлөвлөөгүй байжээ. Гэхдээ ЭЗНЗ-ийн тогтоолоор үндэсний хүний эрхийн бүлгийн хэрэгцээг хүлээн зөвшөөрч, ХЭҮБ-уудын дараагийн хөгжлийг урьдчилан харжээ. Гэсэн ч энэхүү хүсэлтэд яаран хариу өгсөн улс орнууд тун цөөн байлаа.

Арван дөрвөн жилийн дараа буюу 1960 онд ЭЗНЗ цааш ахиж, илүү тодорхой алхам хийлээ. ЭЗНЗ нь үндэсний байгууллагууд хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалахад онцгой үүрэг гүйцэтгэж чадах болохыг хүлээн зөвшөөрч, гишүүн улсуудыг ХЭҮБ-уудыг байгуулж, бэхжүүлэхийг хүсчээ.¹³⁷ Удаах 18 жилд буюу 1978 онд НҮБ-ын Хүний эрхийн комисс тусгайлсан дотоодын байгууллагуудаар дотоодын мониторинг хийлгүүлэхийг хөхиүлэн дэмжих явдлыг уриалжээ.

Хүний эрхийн салбарт жишиг тогтоохын тулд 1960 болон 1970-аад онд санаачилга өрнөсөн ба үндэсний байгууллагуудын талаарх хэлэлцүүлэг нь эдгээр олон улсын стандартыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд тустай гэж төсөөлж байлаа. НҮБ-ын Хүний эрхийн комисс 1978 онд үндэсний байгууллагуудын бүтэц, үйл ажиллагааны талаарх удирдамж боловсруулах зорилгоор үндэсний болон орон нутгийн байгууллагуудын асуудлаар семинар зохион байгуулахаар шийдвэрлэж, улмаар Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах үндэсний болон орон нутгийн байгууллагуудын семинар 1978 оны 9 дүгээр сарын 18-29-ний өдөр Женев хотноо болсон байна. Уг семинарын үеэр алхамчилсан заавар бүхий удирдамж баталж, үндэсний байгууллагууд дараах үүрэг чиг үүрэгтэй байх ёстой гэж санал болгожээ:

- (a) Засгийн газартаа болон тухайн улсын ард иргэддээ хүний эрхийн мэдээллийн эх сурвалжийн үүрэг гүйцэтгэх;
- (b) Хүний эрхийн талаарх олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх,

¹³⁷ 1960 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн ЭЗНЗ-ын тогтоол 772 (XXX), Б хэсэг.

хүндэтгэх явдлыг хөхиүлэн дэмжихэд туслалцаа үзүүлэх;

- (c) Үндэсний хэмжээнд оршиж буй ямар нэг онцгой нөхцөл байдлыг харгалзан авч үзэж, энэ талаар зөвлөмж гаргах бөгөөд уг асуудлаар Засгийн газар үндэсний байгуулагад мөн хандахыг хүсч болох;
- (d) Засгийн газрын зүгээс тэдэнд хандсан хүний эрхийн аливаа асуудалд зөвлөгөө өгөх;
- (e) Хүний эрхийг хөхиүлэн дэмжих хууль тогтоомжийн статус, шүүхийн шийдвэрүүд болон захиргааны арга хэмжээнүүдийг судалж, тогтмол хяналт тавьж, холбогдох эрх баригчдад эдгээр асуудлаар илтгэл бэлдэж, хүргүүлэх;
- (f) Тухайн улсын нэгдэж орсон хүний эрхийн салбар дахь олон улсын гэрээ хэлэлцээрийн дагуу хүлээсэн үүрэгтэй холбогдуулан Засгийн газар үндэсний байгууллагуудад даалгахыг хүсч буй аливаа үүргийг гүйцэтгэх.

Ийм төрлийн байгууллагуудын бүтэц зохион байгуулалттай холбогдуулан удирдамжид дараах зөвлөмжийг санал болгожээ:

- (a) Бүтэц болон үндэсний өргөн хүрээний төлөөллийг тусгах зориулалттай байх ёстой ба иймд хүний эрхийн асуудлаар шийдвэр гаргах үйл явцад хүн амын бүх хэсгийг оролцуулах;
- (b) Тогтмол ажиллах ба ард иргэд болон аливаа төрийн албанаас тухайн байгууллагад шуурхай хандах боломжтой, хүртээмжтэй байх;
- (c) Зохих тохиолдолд, орон нутгийн эсхүл бүсийн зөвлөх байгууллагуудыг ХЭҮБ-ын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд туслуулж болно.

Удалгүй дээрх удирдамийг НҮБ-ын Хүний эрхийн комисс болон Ерөнхий Ассамблей батлав. НҮБ-ын Хүний эрхийн комисс хүний эрхийн үндэсний байгууллагагүй НҮБ-ын гишүүн бүх улсуудыг хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих үндэсний

байгууллагуудыг байгуулах тал дээр зохих арга хэмжээг авахыг уриалж, харин байгуулагдсан үндэсний байгууллагуудын талаарх дэлгэрэнгүй тайланг Комисст хүргүүлэхийг НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргаас хүсчээ.¹³⁸

Энэхүү олон улсын түлхэц дэмжлэгтэйгээр улс орнууд хүний эрхийн үндэсний байгууллагуудыг байгуулж эхэлсэн ч ахиц дэвшил удаан байв. Тодруулбал, 1999 онд 20 хүрэхгүй орчим хүний эрхийн үндэсний байгууллагууд байсан бол¹³⁹ дээрх хоёр үйл ажиллагааны дүнд өнгөрсөн 20 жилийн хугацаанд хүний эрхийн үндэсний байгууллагуудын тоог эрчимтэйгээр нэмэгдүүлэхэд нөлөөлжээ.

Парисын зарчим

Анхны чухал ач холбогдол бүхий үйл

¹³⁸ НҮБ-ын Хүний эрхийн Төв, Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах үндэсний байгууллагууд: Баримт Мэдээлэл 19, 1993 оны 4 дүгээр сар.

¹³⁹ Парис дахь семинарын албан ёсны тайланд: “Дараах үндэсний байгууллагуудын төлөөлөгчид семинарт оролцов: Австрали Улсын хүний эрх болон тэгш боломж хариуцсан комисс; Бенины хүний эрхийн комисс; Бразил Улсын Хүний эрхийг хамгаалах зөвлөл; Канад Улсын Хүний эрхийн Комисс; Чили Улсын хүний эрхийн комисс; АНУ-ын Иргэний эрхийн комисс; Франц Улсын Хүний эрхийн үндэсний зөвлөлдөх комисс; Итали Улсын Хүний эрхийн комисс; Марокко Улсын Хүний эрхийн зөвлөлдөх зөвлөл; Мексик Улсын Хүний эрхийн үндэсний комисс; Шинэ Зеланд Улсын Хүний эрхийн комисс; Норвеги Улсын Хүний эрхийн зөвлөлдөх комисс; Уганда Улсын Хүний эрхийн зөрчилд хяналт шалгалт хийх комисс; Нидерланд Улсын Хүний эрх болон гадаад бодлогын зөвлөх комисс; Перу Улсын Хүний эрхийн үндэсний зөвлөл; Филиппин Улсын Хүний эрхийн Комисс; Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Арьс өнгөний тэгш эрхийн комисс; Сенегал Улсын Хүний эрхийн комисс; Того Улсын Хүний эрхийн үндэсний комисс; Тунис Улсын Хүний эрх ба үндсэн эрх чөлөөний дээд хороо; Турк Улсын Хүний эрхийн Комисс; Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын Олон улсын хамтын ажиллагаа, хүмүүнлэгийн болон хүний эрхийн асуудал хариуцсан улс төрийн комисс; Венесуэлийн Бүгд Найрамдах улсын Ерөнхий шүүгч; Югослав Улсын Эрх чөлөө болон хүний эрхийг хамгаалах хороо” (E/CN.4(1992/43, 1991оны 12 дугаар сарын 16). Гэсэн ч эдгээр хүний эрхийн үндэсний байгууллагууд бүгд хараат бус шинж агуулаагүй болно. хүний эрхийн үндэсний байгууллагуудын олон улсын зохицуулах хороог 1993 онд байгуулахад дараах улсын хүний эрхийн үндэсний байгууллагыг тус хорооны гишүүнээр хүлээн зөвшөөрчээ. Үүнд: Австрали, Камерун, Канад, Дани, Франц, Мексик, Марокко, Шинэ Зеланд, Филиппин, Сенегал, Того, Тунис Улсын хүний эрхийн үндэсний байгууллагууд орно.

явдал нь Франц Улсын Парис хотноо 1991 оны 10 дугаар сарын 7-9-ний өдөр НҮБ-ын Хүний эрхийн комиссын зохион байгуулсан хүний эрхийн үндэсний байгууллагуудын тухай семинар байжээ. Тус семинарт хүний эрхийн үндэсний байгууллагуудын болон гишүүн улсуудын төлөөлөгчид, НҮБ болон түүний агентлагууд, засгийн газрын хоорондын байгууллагууд, төрийн бус байгууллагууд оролцсон ба гол оролцогчид нь анх удаа оролцсон хүний эрхийн үндэсний байгууллагууд өөрсдөө байжээ. Семинарын гол зорилго нь одоо ажиллаж байгаа хүний эрхийн үндэсний байгууллагуудын талаарх мэдээллийг хянаж, шинэчлэх, олон улсын байгууллагуудтай ажиллах хүний эрхийн үндэсний байгууллагуудын хамтын ажиллагааны хэв маягийг авч үзэх, хүний эрхийн үндэсний байгууллагуудын үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх арга замуудыг эрж хайхад оршиж байв.¹⁴⁰

Семинараар зорьсон зорилгодоо хүрсэн төдийгүй хамгийн чухал зүйл болох Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах үндэсний байгууллагуудын статусын талаарх зарчмыг (Парисын зарчим) боловсруулжээ. Парисын Зарчмыг НҮБ-ын Хүний эрхийн Комисс 1992 онд баталж, улмаар Ерөнхий Ассамблей 1993 онд батлав.¹⁴¹ Энэхүү баримт бичиг нь олон улсын хүний эрхийн тогтолцоо хүний эрхийн үндэсний байгууллагуудыг хүлээн зөвшөөрч, оролцоог нь үнэлэх стандарт бөгөөд “байгууллагын хуульт ёс болон хариуцлагын шалгуур” юм.¹⁴²

Парисын Зарчим нь урт биш ба ердөө 1,200 үгтэй. Бүхэлд нь авч үзвэл нилээн ерөнхий талдаа ч зарим хэсгүүд нь нилээн нарийвчилсан дэлгэрэнгүй байдаг. “Эдгээр зарчим нь дотоодын үндсэн хүний эрхийн механизмын статус, бүтэц зохион байгуулалт, эрх хэмжээ, бүрэлдэхүүн, бүрэн эрх болон

¹⁴⁰ Хүний эрхийн комиссын тогтоол 1990(73).

¹⁴¹ Хүний эрхийн комиссын тогтоол 1992(54); Ерөнхий Ассамблейн тогтоол 48(134).

¹⁴² НҮБ-ын ХЭДКГ, Хүний эрхийн Үндэсний Байгууллагууд: Түүх, зарчим, үүрэг, хариуцлага, Мэргэжлийн сургалтын цуврал No. 4 (Rev. 1), 2010, p. 7.

үйл ажиллагааны арга барилд зориулсан өргөн норматив хүрээг гаргаж өгдөг”.¹⁴³

Венийн тунхаглал ба Үйл ажиллагааны хөтөлбөр

Хоёр дахь чухал ач холбогдол бүхий үйл явдал нь 1993 онд Австри Улсын Вена хотод болсон Хүний эрхийн дэлхийн хоёрдугаар бага хурал байв. Венийн Дэлхийн бага хуралд хүний эрхийн үндэсний байгууллагууд оролцсон нь тэдний хувьд анх удаа дээд түвшний олон улсын чуулганд ирсэн явдал байлаа. Хүний эрхийн үндэсний байгууллагууд өөрсдийн эрхийн зүгээс оролцсоноос биш өөрсдийн засгийн газрын төлөөлөгч гишүүн гэдэг үүднээс оролцоогүй. Өнөөг хүртэл НҮБ-ын Хүний эрхийн комиссын уулзалт хуралд оролцдог байсны адилаар оролцож байна. Тэд бага хурлын нэгдсэн чуулганд тусгай суудалтай, хуралд бие дааж ярих эрхтэй байлаа. Тэд Бага хурлын мэдэгдэл болох Венийн тунхаглал ба Үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулах болон хэлэлцээр хийхэд гол үүрэг гүйцэтгэв.¹⁴⁴

Хүний эрхийн үндэсний байгууллагуудын хувьд хамгийн чухал үйл явдал бол Венийн тунхаглал ба Үйл ажиллагааны хөтөлбөр Парисын зарчимтай нийцүүлэн хүний эрхийн үндэсний байгууллагуудыг байгуулах, бэхжүүлэх тал дээр хүчтэй дэмжлэг үзүүлж, хүний эрхийн үндэсний байгууллагагүй улс орнуудад байгуулахыг уриалан дэмжив. Венийн тунхаглал ба Үйл ажиллагааны хөтөлбөрт:

Дэлхийн хүний эрхийн бага хурал нь “хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалахад үндэсний байгууллагууд чухал, үр дүнтэй үүрэг гүйцэтгэж байгааг, нэн ялангуяа эрх бүхий байгууллагуудад зөвлөх эрхтэйгээр, хүний эрхийн зөрчлийг арилгахад оролцох үүрэг, хүний эрхийн мэдээллийг түгээхэд болон хүний эрх дэх боловсролд чухал үүрэг гүйцэтгэдгийг” дахин батлав.

Дэлхийн Хүний эрхийн бага хурал дээр “Үндэсний байгууллагуудын статустай холбоотой зарчим”-ыг харгалзан үзэж, улс

¹⁴³ 2013 оны 5 дугаар сард Женевт батлагдсан ОУЗХ-ны Магадлан Итгэмжлэлийн Дэд Хорооны Ерөнхий Зөвлөмж, хуудасны тал 1.

¹⁴⁴ A(CONF.157)(23).

болгон үндэсний түвшинд өөрсдийн тусгай хэрэгцээ шаардлагад хамгийн сайн нийцсэн хууль тогтоомжийг сонгох эрхтэйг хүлээн зөвшөөрч, үндэсний байгууллагуудыг байгуулж, бэхжүүлэхийг уриалан дууджээ.¹⁴⁵

Өнгөрсөн 20 жилийн хугацаанд хүний эрхийн асуудал хариуцсан НҮБ-ын хамгийн чухал байгууллагууд хүний эрхийн үндэсний байгууллагуудын тухай байнга тогтоол гаргасаар ирсэн. Эдгээр тогтоол нь хүний эрхийн үндэсний байгууллагуудыг байгуулах болон байгуулсан тохиолдолд бэхжүүлэхийг гишүүн улсуудад зөвлөсөн Венийн тунхаглал ба Үйл ажиллагааны хөтөлбөрийн зөвлөмжийг үргэлжлүүлж, мөн хөгжлийн талаар анхаарч үздэг. Ялангуяа, эдгээр тогтоолоор олон улсын хүний эрхийн тогтолцоонд хүний эрхийн үндэсний байгууллагуудын үүргийг өргөжүүлж чадсан юм. Тухайлбал, НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн нэгдсэн хуралдаанд оролцох эрхийг нь нэмэгдүүлсэн. ХЭҮБ-ууд нь хүлээн зөвшөөрөгдсөн, өөрийн гэсэн статустай бөгөөд Ерөнхий Ассамблейн хуралд оролцох эрхтэй гэдэг талаар санал гарсан байна.

Өмнөх Хүний эрхийн комисс нь 2006 онд татан буугдахаасаа өмнө хүний эрхийн үндэсний байгууллагуудын тухай жил тутам тогтоол олон жил баталж ирсэн. НҮБ-ын тус комиссын оронд Хүний эрхийн зөвлөл байгуулахад хүний эрхийн үндэсний байгууллагын оролцооны талаарх Комиссын шийдвэрүүдийг Хүний эрхийн Зөвлөл биелүүлсэн ч жил тутам тогтоол батлах туршлагыг нь эхэндээ үргэлжлүүлээгүй. Энэхүү туршлагыг дахин сэргээж, Парисын зарчимтай нийцэж байгуулсан хүний эрхийн үндэсний байгууллагуудын гүйцэтгэх үүрэг, чиг үүргийн талаар Хүний эрхийн зөвлөл маш хүчтэй дэмжлэг баталгаа үзүүлээд байна.

Венийн Дэлхийн бага хурлаас хойш хүний эрхийн үндэсний байгууллагуудын тоо тав дахин нэмэгдсэн ба 20 хүрэхгүй байсан бол одоо 100 гаруй болсон байна. Үүний 70 орчим хувь нь Парисын зарчимтай бүрэн нийцэж байгаа гэж хүлээн зөвшөөрөгдсөн ажээ. Ийнхүү хурдацтай

¹⁴⁵ A(CONF.157)(23, Part I, para. 36).

өсөхөд буюу ихэнх хүний эрхийн үндэсний байгууллага шинээр бий болоход хүний эрхийн асуудал хариуцсан, НҮБ-ын дээд түвшний шинэ албан тушаалтан – Хүний эрхийн дээд комиссарын үйл ажиллагаатай холбоотой.¹⁴⁶ Хүний эрхийн дээд комиссар болон Хүний эрхийн дээд комиссарын газар (ХЭДКГ) хүний эрхийн үндэсний байгууллагуудыг бүх бүс нутагт байгуулж, бэхжүүлэхийг дэмжиж, хүний эрхийн үндэсний байгууллагуудын талаарх Венийн тунхаглал ба Үйл ажиллагааны хөтөлбөрийн зөвлөмж болон хүний эрхийн үндэсний

байгууллагуудын талаарх Ерөнхий Ассамблей болон Хүний эрхийн комиссын тогтоолуудыг хэрэгжүүлэхийг нэн тэргүүнд тавьсан. Мөн 1995-2003 оны хооронд энэхүү дэмжлэгийг Дээд Комиссарын Тусгай Зөвлөх үзүүлж байсан.¹⁴⁷ Хожим ХЭДКГ-ын тусгай нэгж болох Үндэсний байгууллагууд болон бүсийн механизмын газар үзүүлж байсан юм. Дээд комиссар болон ХЭДКГ-ын хүчин чармайлтаар хүний эрхийн үндэсний байгууллагууд тоог нэмэгдэхэд ихээхэн хувь нэмэр оруулжээ. Дээрх ахиц дэвшлийг үечлэн харвал:

Хугацаа	Үндэсний байгууллагыг тодорхойлсон ойлголт	Засгийн газрын хандлага	НҮБ-ын гүйцэтгэх үүрэг
Санаагаа танилцуулах, боловсруулах (1946-1978)	Хүний эрхийн талаар судлах, тухайн улсын нөхцөл байдлыг нягтлан шалгах, олон нийтийг соён гэгээрүүлэх, Засгийн газарт зөвлөгөө өгөх эрх бүхий байгууллага (НҮБ-ын Хүний эрхийн комиссын 1962 оны тогтоол)	Үндэсний байгууллага нь тухайн улсын дотоодын хууль тогтоомжид сайтар зохицуулаагүй; хариуцах ажил нь үйлчилж байгаа хуулийн зохицуулалттай давхацсан; байгуулахдаа удирдлага болгох нэгдсэн нэг загвар байгаагүй; Засгийн газар нь үндэсний байгууллагын чиг үүргийг тодорхойлж байсан.	Мэдээлэл, туршлагаа солилцох, ярилцах “форум”
Ойлголтоо олон нийтэд таниулах (1978-1990)	Засгийн газрын хүсэлтээр дэмжлэг үзүүлдэг, хүний эрхийг эдлүүлж байгаа талаар мэдээлэл цуглуулан, судалж, хянадаг, олон талын төлөөлөл бүхий, бие даасан, шударга байгууллага (1978 оны зөвлөмж)	Адил эрх хэмжээтэй байгууллага байхгүй тохиолдолд одоогийн бүтэцдээ нэмж байгуулах шаардлагатай гэж үндэсний байгууллагыг тодорхойлсон; үндэсний нөхцөл байдалдаа нийцүүлэн харилцан адилгүй хэлбэрээр байгуулж байсан.	Төрөл бүрийн үндэсний байгууллагын талаарх мэдээлэл солилцох “форум”; үндэсний байгууллагын үйл ажиллагаанд техникийн туслалцаа үзүүлдэг “этгээд”


¹⁴⁶ А(CONF.157(23); Хэсэн II, догол мөр. 18. Ерөнхий Ассамблейн тогтоол 48(141-р уг албан тушаалыг бий болгов.

¹⁴⁷ А(CONF.157(23); Хэсэн II, догол мөр. 18. Ерөнхий Ассамблейн тогтоол 48(141-р уг албан тушаалыг бий болгов.

<p>Үндэсний байгууллагууд түгэн дэлгэрсэний</p> <p>(1990-2002)</p>	<p>Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалахын тулд зөвлөх, соён гэгээрүүлэх, хувь хүний гомдлыг шийдвэрлэх, хүний эрхийн бусад үндэсний болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах хуулиар тогтоосон эрх мэдлийн хүрээнд хүний эрхийн үндэсний гол байгууллага</p> <p>(Парисын зарчим)</p>	<p>Хүний эрхийг хамгаалах дотоодын бүтэцдээ, ялангуяа шинээр байгуулсан эсхүл шилжиж байгаа ардчилсан орнуудад маш чухал үндэсний байгууллага; хэлбэрийн хувьд хоорондоо маш цөөн шалгуураар ялгаатай</p>	<p>Мэдээлэл солилцох “форум”; үндэсний байгууллагын олон улсын түвшинд гүйцэтгэх үүргийг хөхиүлэн дэмжих, үндэсний байгууллагын гүйцэтгэж байгаа үйл ажиллагаанд тусалцаа үзүүлдэг</p> <p>“этгээд”</p>
<p>Үндэсний байгууллагын эрх хэмжээг өргөтгөсөний</p> <p>(2003 хойш)</p>	<p>Парисын зарчмын удирдлага болгон ажиллах байгууллагын хамт эмэгтэйчүүд, хүүхэд, тэгш эрх, жендэр, эрүү шүүлт зэрэг асуудлаар дагнан ажиллах тусгай бүрэн эрх бүхий хүний эрхийн үндэсний байгууллага</p>	<p>Хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжихийн тулд үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг хүний эрхийн комисс, эсвэл хүний эрхийн омбудсман</p>	<p>Мэдээлэл солилцох, шийдвэр гаргахдаа үндэсний байгууллагын байр суурийг хүндэтгэдэг “форум”; хүний эрхийн зэрэгцээ сэдэвчилсэн буюу тодорхой асуудлаар ажиллахад тусалцаа үзүүлдэг “этгээд”</p>

Үндэсний түвшинд нийгэмд нөлөөлдөг гурван том бүрэлдэхүүнийг уламжлалт байдлаар төр, иргэний нийгэм, хувийн хэвшил хэмээн тодорхойлж, тус тусдаа гол төлөв өөрийн хүрээндээ ажилладаг.

Хоорондоо харилцах ч маш хязгаарлагдмал хүрээг хамарч, салбар бүр бусдын нөлөөнөөс ангид, хараат бусаар ажиллаж байсан бөгөөд салбар бүр хараат бусаар ажиллахын тулд чиг үүргээ сайтар тодорхойлсон байлаа.



Эх сурвалж: Иргэний нийгмийн ирээдүйд гүйцэтгэх үүрэг, Дэлхийн эдийн засгийн форум, 2013

Орчин үед дээрх ойлголт маш хурдтай өөрчлөгдөж байна. Салбар бүрийн дотоодын нийгэмд чиглэсэн чиг үүрэг, тулгарах бэрхшээлээ даван туулахын тулд орон зайгаа хуваалцаж эхэлсэн ба хамтын ажиллагаа, түншлэл, инновацийн хүрээнд нэг нэгэнтэйгээ ойртож нийлэх явдал улам ихэссэн байна. Үүнтэй уялдан уламжлалт загварын өмнөх чиг үүрэг улам тодорхойгүй болохын хамт гибрид буюу нийлмэл шинжтэй байгууллага ихээр бий болжээ. Тодруулбал, нийгэмд тустай байдлаар ажилладаг хувийн хэвшлийн компани, үйл ажиллагааны хөрөнгө худалдаа эрхлэх байдлаар олдог төрийн бус байгууллага гэх мэт.

Дээрхээс үл хамааран НҮБ-ын гишүүн болсон оролцогч улсын төр нь хүлээсэн үүрэг амлалтынхаа биелэлтэд олон улсын өмнө хариуцлага хүлээдэг. Хүний эрхийг хангах, хамгаалах, хөхиүлэн дэмжих нь Төрийн эн тэргүүнд хувийн хэвшил, бизнесээс ч хамааралгүйгээр өөрөө бие даан гүйцэтгэх ёстой. НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлын ээлжит нэгдсэн хэлэлцүүлгээр (ХЭТБЭНХ), гишүүн улс болгон 4.5 жил тутам өөрсдийн хүний эрхийн хэрэгжилтийн талаар мэдээлэх үүрэгтэй бөгөөд өөрсдийн тайлан, хариултын талаар бусад улс орнуудын асуух асуулт болон хариу мэдэгдэлд бэлэн байж, хүний эрхийн хэрэгжилтээ сайжруулахын тулд ямар арга хэмжээ авах тухай бусад улсаас өгөх зөвлөмжийг хүлээн авдаг.¹⁴⁸ Хүний эрхийн үндсэн гэрээ конвенцийн нэг бүрийн дагуу байгуулсан, гэрээнд хяналт тавих байгууллага бүрт гишүүн улс бүр хамаарах гэрээний байгууллагуудад тогтмол тайлан илгээж, хуралд нь оролцож, хараат бус шинжээчдийн тавих асуултанд хариулж, тэдний олсон баримт мэдээлэл болон зөвлөмжүүдийг хүлээн авах ёстой.¹⁴⁹

¹⁴⁸ НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлын ээлжит нэгдсэн хэлэлцүүлэг www.ohchr.org/EN/HRBodies/UPR/Pages/UPRMain.aspx. –аас үзнэ үү.

¹⁴⁹ Хүний эрхийн есөн гол гэрээ конвенц байдаг ба тус бүр хараат бус шинжээчдээс бүрдэх тусгай хороотой бөгөөд эдгээр хороод нь Оролцогч улсуудын гэрээний өмнө хүлээсэн үүрэг хариуцлагын хэрэгжилтийг хянадаг ба тухайн гэрээ болон түүний тайлбар, хэрэгжилтийг хөхиүлэн дэмждэг. Дэлгэрэнгүйг дараах холбоосоос үзнэ үү www.ohchr.org/EN/HRBodies/Pages/TreatyBodies.aspx ба [http://\(www2.ohchr.org/english/bodies/docs/OHCHR-FactSheet30.pdf](http://(www2.ohchr.org/english/bodies/docs/OHCHR-FactSheet30.pdf).

Олон улсын хүний эрхийн тогтолцоо нь хүний эрхийн үүрэг хариуцлагын хэрэгжилтийг дэмжиж, хяналт тавих зорилгоор ХЭТБЭНХ болон гэрээний байгууллагууд зэрэг янз бүрийн механизмуудыг боловсруулжээ. Гэсэн ч үндэсний түвшинд хүний эрхийг хэрэгжүүлэх болон хэрэгжилтэд хяналт тавих нь хамгийн оновчтой гэж олон улсын систем хүлээн зөвшөөрдөг. Олон улсын систем нь удааширсан системд оновчтой ба нэгдүгээрт дотоодын арга хэмжээ, хяналтыг хөхиүлэн дэмжиж, хоёрдугаарт дотоодын систем нь үр дүнгүй эсхүл шаардлага хангахгүй тохиолдолд олон улсын зарим хязгаарлагдмал арга хэмжээ авдаг.

Төр олон улсын хүний эрхийн талаарх өөрсдийн үүрэг хариуцлагыг хэрэгжүүлэх, хяналт тавихад ашиглаж болох янз бүрийн өргөн хүрээтэй дотоодын механизм болон арга хэмжээнүүд байдаг. Ардчилсан, олон ургалч төртэй бүх байгууллагууд үүнд хувь нэмрээ оруулж чадах бөгөөд хувь нэмрээ оруулах ёстой.

Парламент нь хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах хууль тогтоомжуудыг батлах боломжтой. Эдгээр хууль тогтоомж нь засгийн газрыг өөрсдийн бодлого, хүний эрхэд нөлөөлөх үйл ажиллагаанд нь хариуцлага тооцож чадна.

Засгийн газар болон түүний төрийн албан тушаалтнууд хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах бодлого, хөтөлбөрүүдийг боловсруулж, баталж, хэрэгжүүлэх боломжтой. Эдгээр бодлого, хөтөлбөрүүд нь зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчил гарсан тохиолдолд гэм буруутанд хариуцлага тооцох, хохирогчдын хохирлыг барагдуулах явдлыг хангах арга хэмжээ авч чадна.

Шүүх нь хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах хууль тогтоомжийг хэрэгжүүлж чадна. Мөн хүний эрхийг зөрчсөн гэм буруутнуудыг шийтгэж, хохирогчдод хамгаалалт үзүүлж, нөхөн төлбөр олгох боломжтой. Ялангуяа хууль дээдлэх ёсыг тогтоох, хуулийн өмнө эрх тэгш байх, өөрсдийн эрх мэдлийн хүрээнд бүх хүмүүст зохих ёсны үйл ажиллагааг хангаж чадна.

Хууль ёсны засгийн газрын байгууллагууд, тухайлбал авлигатай тэмцэх комисс, захиргааны омбудсмений газар, захиргааны хянан шийдвэрлэх шүүх нь засгийн газрын бүтэц дэх өөрсдийн тодорхой бүрэн эрхийн хүрээнд хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах үүрэгтэй.

Улс төрийн намууд нь эерэг болон сөрөг тодорхой үүрэг хариуцлагатай. Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, сайтар нягталсан бодлого боловсруулах, олон нийтийн хүний эрхийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд хувь нэмэртэй. Нөгөө талаас, нийтийн дунд ухвар мөчид төсөөлөл түгээх, арьс үндэс, хүйс зэргээр ялгаварласан аян өрнүүлэх, хүний эрхийг зөрчсөн бодлого гаргаж болзошгүй.

Хэвлэл мэдээлэл нь хүний эрхийн үнэ цэнэ болон зарчмыг эерэгээр хөхиүлэн дэмжих болон хүний эрхийг зөрчих үйл ажиллагаа, үзэл бодлыг зөвшөөрөх эсхүл дэмжих болон тийм зүйл үйлдэхээс зайлсхийх ижил төстэй үүрэг хариуцлагатай. Мөн тэд албан ёсны


мэдэж, сонгогчид тэдэнд хариуцлага тооцох боломжтой.

Иргэний нийгэм, үүнд төрийн бус байгууллагууд, үйлдвэрчний эвлэлүүд, бизнесийн холбоод, их дээд сургуулиуд болон ердийн сургуулиуд, шашны бүлэг нь хүний эрхийн үнэ цэнэ болон зарчмыг эерэгээр хөхиүлэн дэмжих болон хүний эрхийг зөрчих үйл ажиллагаа, үзэл бодлыг зөвшөөрөх эсхүл дэмжих болон тийм зүйл үйлдэхээс зайлсхийх зэрэг хэвлэл мэдээлэлтэй адил төстэй үүрэг хариуцлага хүлээнэ. Тэд мөн хүний эрхийн үүрэг хариуцлагаа биелүүлэхийг дэмжиж, төрөөс авч буй арга хэмжээнд хяналт тавьж, алдаа дутагдлыг гаргаж ирж болно.

Парисын зарчим буюу хүний эрхийн үндэсний байгууллагуудад зориулсан олон улсын наад захын жишиг стандартад нийцэж байгуулагдсан Хүний эрхийн үндэсний байгууллагууд нь төр хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах олон улсын үүрэг амлалтандаа хүрэхэд туслалцаа үзүүлэх

ХЭҮБ: Үндэсний хамгаалах тогтолцооны гол бүрэлдэхүүн

Үр нөлөөтэй ХЭҮБ нь “үндэсний түвшинд хүний эрхийг хамгаалж ажиллах тогтолцооны тулгын чулуу бөгөөд...”



улсынхаа дотор хүний эрхийн олон улсын хэм хэмжээг ашиглах явдлыг баталгаажуулах найдвартай механизм”

төрийн байгууллагууд болох парламент, засгийн газрын байгууллагууд болон шүүхүүдийн үйл ажиллагаа болон алдаа мэддэг мөрдөн шалгаж, хэвлэн нийтэлж болох буюу шалгаж, хэвлэн нийтлэх ёстой. Ингэснээр ард иргэд юу болж байгааг

бүхий дотоодын өөр нэг механизм билээ. Хүний эрхийн үндэсний байгууллагууд нь шүүх гэх мэт дотоодын бусад байгууллага, механизмтай өрсөлдөхгүй буюу тэднийг төлөөлөхгүй. Харин өөрсдийн үйл ажиллагаанд бусад байгууллага, механизмаа

хөхиүлэн дэмжих байдлаар хамтарч ажилладаг.

Үндэсний түвшинд хүний эрхийг сайжруулах, хамгаалах тодорхой зорилготой төрөөс байгуулсан үндэсний байгууллагыг төр өөрийн олон улсын хүний эрхийн талаарх үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэх болон бодит байдал дээр хүний эрхийг биелүүлж байгаагийн хооронд үүсэх зөрүүг арилгах, заагийг холбох хамгийн чухал арга замуудын нэг гэж хүлээн зөвшөөрсөн юм.¹⁵⁰

Хүний эрхийн үндэсний байгууллага нь Засгийн газрын буруу үйл ажиллагаа, хүний эрхийн зөрчлийг байнга шүүмжилдэг байснаар Төртэй зөрчилдөх тохиолдол гарч болзошгүй. Хүний эрхийн үндэсний байгууллага болон төрийн хооронд

зөрчилдөөн үүсэхгүй бол өөрийгөө хүний эрхийн үндэсний байгууллага гэж тодорхойлох шаардлагагүй гэж харж болно. Манай улсад өрнөсөн иргэний нийгмийн хөдөлгөөний дүнд ардчилалжих үйл явцын нэг том ололт нь Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс байгуулсан явдал юм. Хэдийгээр олон асуудалтай тулгарч байгаа ч төрийн зүгээс хүний эрхийг талаарх бодлогоо дээрээс доош чиглэсэн байдлаар бус, илүү хөндлөн хэлбэртэй, хамтын ажиллагаанд тулгуурласан байдлаар зохион байгуулах нь зүйтэй. Ийнхүү ажилласан тохиолдолд хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоог тал бүрийн оролцоотой улам бэхжүүлэхийн зэрэгцээ Монгол Улсад хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжихэд эерэг нөлөөтэй.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

¹⁵⁰ 2013 оны 5 дугаар сард Женевт батлагдсан ОУЗХ-ны Магадлан Итгэмжлэлийн Дэд Хорооны Ерөнхий Зөвлөмж, хуудасны тал 2.

Тайлбар: *Amicus curiae* - Ямарваа нэгэн хэрэг, маргааныг шийдвэрлэхэд хэргийн оролцогч, маргааны тал болохгүйгээр тухайн хэрэгтэй холбоотой мэдээлэл өгч байгаа этгээдийг ойлгоно. Гэхдээ шүүхэд туслах зорилгоор аль нэг талтай зөвшилцөхгүй оролцдог онцлогтой.

ХӨДӨЛМӨРИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛБЭРҮҮДИЙГ ЗӨВ ХЭРЭГЛЭХ НЬ



Удирдлагын Академийн
Эрх зүйн тэнхмийн багш

С.ГАНЦЭЦЭГ

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван Мзургадугаар зүйлийн 4-т: ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй гэж заасан. Энэхүү эрхийг хүний хувийн эрхийн чухал хэсэг билээ. Учир нь хүний амьдрах эрхийн эх сурвалж байдаг.¹⁵¹ Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 23 дугаар зүйлд: хүн бүр хөдөлмөрлөх, ажлаа чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн шударга, таатай нөхцөлөөр хангуулах, ажилгүйдлээс сэргийлэн хамгаалуулах эрхтэй гэж тодорхойлсон билээ.

Ажил мэргэжил эрхлэх эрхийн хэрэгжилт нь хүний хөдөлмөрөөр биелэлээ олдог. НҮБ-ын Ерөнхий асамблейгаас баталсан Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай Олон улсын пактын 7 дугаар зүйлд: Энэхүү пактад оролцогч улсууд хүн бүр шударга, аятай тавтай хөдөлмөрийн нөхцөлөөр хангагдах эрхийг хүлээн зөвшөөрнө гэж заасан бөгөөд Монгол Улс уг конвенцид нэгдэн орсон тул бусад хуулийн адил үйлчлэх хүчин чадалтай.

Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн Арван долдугаар зүйлийн 2-т: хөдөлмөрлөх

нь иргэний журамт үүрэг мөн хэмээн заасан.

Хувийн өмчийн харилцаанд суурилсан нийгмийн тогтолцоонд хөдөлмөрлөж ахуй амьдралаа авч явах нь хүн бүрийн үүрэг билээ.

Хөдөлмөрийн эрх зүйн харилцаанд оролцогч үндсэн талууд болох ажил олгогч, ажилтны хоорондын дээрх эрх, үүргийн харилцааг зохицуулах гол эх сурвалж нь Хөдөлмөрийн тухай хууль (1999 он), мөн тэдний хооронд байгуулсан хөдөлмөрийн гэрээ болно.

Хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр үүсэх ажилтан, ажил олгогч хоорондын хөдөлмөрийн харилцаанд хэд хэдэн хэлбэрүүд үүсэж болдог. Үүнд:

Ажилтныг өөр ажилд шилжүүлэх

Ажил, албан тушаалыг хэвээр хадгалах

Ажил албан тушаалд эгүүлэн тогтоох

Ажилтныг ажил, албан тушаалаас түр түдгэлзүүлэх зэрэг багтана.

Хөдөлмөрийн эрх зүйн зохицуулалтын дээрх хэлбэрүүдийг оновчтой, зөв хэрэглээгүйгээс талуудын хооронд маргаан үүсэх нь цөөнгүй. Тиймээс эдгээрийн хоорондын ялгааг зөв гаргаж, хууль зүйн үндэслэлийг зөв тогтоон хэрэглэх нь нэг талаас маргаан гарахаас сэргийлэх, нөгөө

¹⁵¹ Г.Совд. "Монгол Улсын Үндсэн хууль: Хүний эрх". (Харьцуулсан эрх зүй). УБ., 1999. 105 дахь тал.

талаас талуудын хууль ёсны эрх ашиг хөндөгдөхгүй байх нөхцөл бүрдэх талтай.

Хөдөлмөрийн тухай хуулийн 32-34 дүгээр зүйлд зааснаар ажилтныг өөр ажилд шилжүүлэх үндэслэл нь ажлын зайлшгүй шаардлага, сул зогсолт, эрүүл мэндэд нь харшлахгүй өөр ажилд шилжүүлэх зэрэг болно.¹⁵²

Хөдөлмөрийн тухай хуулийн 32-34 дүгээр зүйлд тусгагдсан өөр ажилд шилжүүлэх зохицуулалт нь түр хугацаагаар хэрэглэгддэг, тодорхой хугацаа өнгөрмөгц ажил олгогч ажилтнаар үндсэн ажил, албан тушаалын ажил үүргийг гүйцэтгүүлэх ёстой. Гэтэл өөр ажилд шилжүүлэх үндэслэл нь хуульд тусгагдсан хэдий ч ажилтныг тэр чигт нь өөрөөр хэлбэл, бүрмөсөн шилжүүлсэн ажил, албан тушаалд үлдээх явдал гарсаар байдаг. Энэ тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох зүйл, заалтын агуулга зөрчигдөж ажилтны эрх хөндөгдөж байна. Хөдөлмөрийн тухай хуулийн 32-34 дүгээр зүйлд заасан ажилтныг өөр ажилд шилжүүлэх гурван үндэслэлээс хамгийн түгээмэл, буруу хэрэглэгддэг зохицуулалт

нь ажлын зайлшгүй шаардлагаар өөр ажилд шилжүүлэх зохицуулалт юм. Ажлын зайлшгүй шаардлага гэдгийг тайлбарласан Улсын дээд шүүхийн тайлбар байхгүй. Харин доктор, профессор Б.Уранцэцэг “Ажлын зайлшгүй шаардлага нь ажил олгогчийн үйл ажиллагааг тасалдуулах, зогсоох сөрөг үр дагаварт хүргэж болохоор байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн осол гарах бодит нөхцөл байдал бий болсныг арилгаж, түүний хор уршгаас сэргийлэх, мөн уг бодит нөхцөл байдал бий болсноор нэгэнт гарсан сөрөг үр дагаврыг нь даруй арилгаж хэвийн байдал тогтоох, түүнчлэн улс орон буюу бүс нутагт бий болох нь тодорхой болсон байгалийн гамшиг буюу үйлдвэрлэлийн ослын нөхцөлийг арилгах буюу эдгээрийн үр дагаврыг багасгах, арилгахад чиглэгдсэн үйл ажиллагааг хийхээс өөр аргагүй байдлыг ойлгож болно”¹⁵³ гэжээ.

Ажилтныг өөр ажилд шилжүүлэхээр хуульд тусгагдсан үндэслэлүүдээс сул зогсолт, ажлын зайлшгүй шаардлага гэсэн хоёр үндэслэлээр шилжүүлэхэд тодорхой хугацаа үйлчилдэг.

Хүснэгт 1. Өөр ажилд шилжүүлэх үндэслэл

Ажлын зайлшгүй шаардлага	Сул зогсолт
<p>Байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх, тэдгээрийн үр дагаврыг арилгах зэрэг зайлшгүй шаардлага гарсан болон байгууллагын хэвийн ажиллагааг алдагдуулахад хүргэсэн урьдчилан мэдэх боломжгүй бодит нөхцөл байдал бий болсон тохиолдолд ажил олгогч нь ажилтныг хөдөлмөрийн гэрээнд заагаагүй өөр ажилд 45 хүртэл хоногийн хугацаагаар шилжүүлж болно.</p>	<p>Сул зогсолтын үед ажилтныг байгууллага дотроо хөдөлмөрийн гэрээнд заагаагүй ажилд, эсхүл өөр байгууллагад түр хугацаагаар өөртэй нь тохиролцсоны үндсэн дээр шилжүүлэн ажиллуулж болно.</p>

Ажил олгогч санаачлан ажилтныг өөр ажилд шилжүүлэн ажиллуулж байх үед ажилтантай үндсэн ажил, албан тушаал дээр нь байгуулсан хөдөлмөрийн харилцаа хэвээр хүчинтэй үргэлжилнэ. Өөрөөр хэлбэл, уг харилцааг ажил олгогч санаачлан цуцлах эрхгүй. Гэтэл

зарим аж ахуйн нэгж, байгууллагад чиг үүрэг өөрчлөгдөх, өөр байгууллага нэгдэх зэрэг тохиолдол бүрт ажилтныг нэгээс нөгөө байгууллагад шилжүүлэн ажиллуулах, ажилтны үндсэн ажил, албан тушаал дээр тогтоосон хөдөлмөрийн харилцааг ажил олгогч санаачлан дуусгавар болгож тухайн ажилтны эрхийг зөрчиж байна.

¹⁵² Доктор, профессор Уранцэцэг.Б “Өөр ажилд шилжүүлэх гэж албан хаагч буюу ажилтны хөдөлмөрийн харилцаа хуульд заасан үндэслэлээр түр өөрчлөгдөөд эргэж хуучин байдалдаа орох” гэж тайлбарласан.

¹⁵³ Уранцэцэг.Б. “Хөдөлмөрийн тухай Монгол Улсын хууль (Онол, арга зүйн тайлбар”. УБ., 2001, 73 дахь тал.

Тохиолдол 1.

Эрүүл мэндийн харьяа нэгэн агентлагийн мэргэжилтэн А-г 2013 оны 2 дугаар сарын 20-ны өдрөөс үүрэгт ажлаас нь хун амын төрөлт, нас баралтын мэдээ, мэдээлэл, дүн шинжилгээ харцуцсан ажилтнаар шилжүүлэн ажиллуулах тушаал гаргасан.

Шилжүүлэн ажиллуулах тухай шийдвэр (тушаал) гаргахдаа хэт удаан ажилласан, ажлын зайлшгүй шаардлагыг харгалзан үзжээ. А ийнхүү шилжсэнээр миний нэмэгдэл хасагдсан гэдэг үндэслэлээр шүүхэд хандсан

Шүүх өөр ажилд шилжүүлсэн нь хууль зүйн үндэслэлгүй, А-ийн хууль ёсны эрх зөрчигдсөн гэж дүгнэжээ.

Эх сурвалж, Шүүхийн шийдвэр, 2013-2014 он.

Жишээ нь:

Сүүлийн үед ажилтныг ажилд томилох гэсэн нэр томъёо гаргаж, бүтцийн өөрчлөлтөөр ажлын байр хасагдсан, орон тоо цөөрсөн, ажлын байр өөрчлөгдсөн зэрэг тохиолдолд ажилтны хөдөлмөрийн гэрээг цуцлахгүйгээр ажилтныг ажилд томилох тухай гэсэн тушаал гаргаж байна. (Эрдэнэс Таван толгой компанийн захирлын 2016.03 сарын тушаалаас)

Ажилтныг ажилд томилох гэдэг нь ямар утгатай нь ойлгомжгүй бөгөөд иргэн ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээ байгуулсан бол ажилтан байхаар Хөдөлмөрийн тухай хуулийн 3 зүйлд заасан. Гэтэл тушаалын агуулгыг харвал, бүтцийн өөрчлөлт хийгдэж байгаатай уялдуулан нэр бүхий ажилтнуудыг өөр ажилд шилжүүлж, хөдөлмөрийн гэрээг шинэчлэн батлахыг үүрэг болгожээ.

Энд гарсан өөр нэг алдаа нь ажилтныг өөр ажилд шилжүүлэх үндэслэлд бүтцийн өөрчлөлт хамаарахгүй. Хэрэв өөр ажилд ажилтныг шилжүүлэх бол хөдөлмөрийн гэрээг шинэчлэхгүй, харин өөр ажилд шилжүүлэх тухай шийдвэр гаргана.

Мөн өөр ажилд шилжүүлэн томилох гэсэн цоо шинэ зүйлийг гаргаж энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 32-34 дүгээр зүйлийг зөрчих бөгөөд улмаар шийдвэр гаргахдаа шилжин

очих албан тушаалыг тодорхой заадаггүй, хугацаа тогтоодоггүй, хуульд заасан шалтгаан үүсээгүй байхад өөр ажилд ажилтныг шилжүүлэх зэрэг нийтлэг зөрчил байна.

Албан хаагчийн албан тушаал хадгалагдах зохицуулалтыг: Тодорхой ажил эрхэлж байгаа ажилтан өвдөх, өвчтэй хүн асрах, ээлжийн амралтаа эдлэх зэрэг бодит шалтгаанаар эрхэлж буй ажил, албан тушаалаасаа түр хөндийрэх шаардлага гарна. Харин энэ үед түүний хөдөлмөрийн харилцаа нь албан хаагчийг эргэж ажлын байрандаа ирж үргэлжүүлэн ажиллах хүртэлх хугацаанд нь хэвээр хадгалагдах явдлыг ажил, албан тушаал хадгалагдах зохицуулалт гэнэ¹⁵⁴ гэж тодорхойлсон.

Хөдөлмөрийн тухай хуулийн 35 дугаар зүйлд ажилтны ажил албан тушаалыг хадгалагдах үндэслэлүүд тусгагдсан. Эдгээр үндэслэлийн аль нэг нь ажилтанд бодитой бий болсон бол ажил олгогч түүний ажил албан тушаалыг хадгалах үүрэгтэй. Харин ажил олгогч энэ зохицуулалтыг зөв хэрэглэхгүй, улмаар ажлын байр нь хадгалагдаж буй ажилтны хөдөлмөрийн харилцааг дуусгавар болгосоор байна.

Жишээ:

ЧД-ийн 18 хорооны нэгэн өрхийн эмнэлгийн эмч Э-г амаржсаны амралттай, уг амралтын хугацаа дуусахад 4 сар дутуу байхад төсөв хасагдаж, ажлын байрны чиг үүрэг өөрчлөгдсөн гэдэг үндэслэлээр (үүнийгээ бүтцийн өөрчлөлт гэж тайлбарласан) хөдөлмөрийн гэрээг 2014 онд цуцалжээ.

Эндээс харвал, ажил олгогч бүтцийн өөрчлөлтөд шинэ үндэслэлүүд нэмэх хэлбэрээр хөдөлмөрийн гэрээг цуцалж байна. Үүнд, ажлын байрны чиг үүрэг өөрчлөгдөх, төсөв хасагдсан, орон тоо хэмнэх гэх мэт үндэслэлийг бүтцийн өөрчлөлттэй адилтган хөдөлмөрийн гэрээг цуцалж байна.

Ажлын байрны чиг үүрэг өөрчлөгдсөнийг бүтцийн өөрчлөлт хэмээн Хөдөлмөрийн тухай хуулийн 40.1.1 дэх заалтыг үндэслэн ажлаас халсан ажилтныг ажилд нь эгүүлэн тогтоосон шүүхийн шийдвэр 2014 онд гарсан.

Эх сурвалж, Шүүхийн шийдвэр, 2013-2014 он.

¹⁵⁴ Уранцэцэг Б. "Хөдөлмөрийн эрх зүй хичээлийн сургалтын гарын авлага". УБ., 2012, 57 дахь тал.

Ажилд нь эгүүлэн тогтоох зохицуулалт нь хөдөлмөрийн харилцаа нь дуусгавар болсон иргэн дуусгавар болгосон үндэслэлийг хууль бус гэж үзэн шүүхэд хандан улмаар ажилд нь эгүүлэн тогтоох тухай шийдвэрийг шүүх гаргаж хүчин төгөлдөр болсон тохиолдолд хэрэглэгдэнэ. Түүнчлэн үйлдвэрлэлийн осол буюу мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуугийн тэтгэвэр тогтоолгон хөдөлмөрийн гэрээ нь дуусгавар болсон иргэн эдгэрч группээсээ гарснаас хойш 1 сарын дотор хуучин ажил, албан тушаалдаа орж ажиллах хүсэлтийг гаргах үед уг зохицуулалт хамаарна.

Гэвч хуулийн дээрх зохицуулалт төдийлөн сайн хэрэгжиж чадахгүй байгааг судлаачид бүтээлдээ дурджээ.

*Зарим удирдах албан тушаалтан хэтэрхий дураараа аашилдагийг Биокомбинат ТӨҮГ-ийн захирал 2012 онд нэг дор 6 цехийн эрхлэгч, нэг лабораторийн эрхлэгчийг, 2013 онд албаны дарга, ерөнхий технологичийг ажлаас тус тус халж, эдгээр албан тушаалтныг үндэслэлгүйгээр халсан тухай шүүхийн 8 шийдвэр гарсаар байтал өдий болтол гүйцэтгэхээс татгалзаад сууж байгааг жишээ болгож болох юм.*¹⁵⁵

Хөдөлмөрийн тухай хуулийн 44 дүгээр зүйлд заасан ажил албан тушаалыг түдгэлзүүлэх зохицуулалтын гол онцлог нь ажилтны хөдөлмөрийн харилцааг дуусгавар болгох бус харин түр зогсоож байгаа үйлдэл бөгөөд уг зохицуулалтыг ажил олгогч дангаар дур мэдэн хэрэглэж ажилтны хөдөлмөрийн харилцааг түр зогсоох эрхгүй юм.

Уг зохицуулалт хэрэглэгдэх үндэслэл нь Хөдөлмөрийн тухай хуульд бусад хуульд тусгагдсан. Жишээ нь, ЭБШХ-ийн 75 дугаар зүйлд албан үүргээс түр түдгэлзүүлэх үндэслэлийг: сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч албан үүргээ үргэлжлүүлэн биелүүлэх нь

хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүн таслах ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй үндэслэл байвал хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь прокурорын зөвшөөрөлтэйгээр, шүүх, прокурор нь тэднийг албан үүргээ биелүүлэхийг түр түдгэлзүүлэх эрхтэй, албан үүргээ биелүүлэхийг түр түдгэлзүүлэх шийдвэрийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн ажилладаг албан байгууллагад хүргүүлэх бөгөөд байгууллагын удирдлага уг шийдвэрийг 3 хоногийн дотор хэрэгжүүлж, энэ тухай хариу мэдэгдэнэ, түдгэлзүүлэх арга хэмжээг цаашид хэрэглэх шаардлагагүй бол шийдвэр гаргасан албан тушаалтан түүнийг хүчингүй болгож, холбогдох байгууллагад нэн даруй мэдэгдэнэ гэж заасан. Энэ нь түдгэлзүүлэх эрх прокурор, шүүгч, мөрдөн байцаагчид байх, тэдний гаргасан шийдвэрийг ажил олгогч биелүүлэх хэлбэр нь холбогдох шийдвэр гаргаж эргэн мэдэгдэх, харин түдгэлзүүлэх шалтгаан арилсан бол прокурор, шүүгч, мөрдөн байцаагч шийдвэрээ хүчингүй болгож албан хаагч ажил үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэнэ гэсэн агуулгыг илэрхийлнэ.

Энэ мэтээр Хөдөлмөрийн тухай хууль дахь зохицуулалтын хэлбэрүүдийг зөв хэрэглэх нь нэг талаас маргаан гарахаас сэргийлэх, нөгөө талаас хууль хэрэглэх соёлыг төлөвшүүлэхэд нэмэртэй билээ.

Хөдөлмөрийн эрх зүйн зохицуулалтын хэлбэрүүдийг зөв хэрэглэхгүйгээс ажилтны эрх зөрчигдөх нь цөөнгүй байгаа. Энэ нь нэг талаас хуулийн зохицуулалтыг зөв хэрэглэхгүй байхтай холбоотой байна.

Ажил олгогч хөдөлмөрийн эрх зүйн зохицуулалтын хэлбэрүүдийг хэрэглэхдээ шийдвэрээ үндэслэлтэй гаргах, түүнийгээ шийдвэртээ илэрхийлэхийг шаардах гол зорилго нь эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн ажилтан тухайн шийдвэрийн үндэслэлийн талаар тодорхой, ойлгомжтой мэдээлэл өгөхөд оршино. Өөрөөр хэлбэл ажилтан ажил олгогчийн тухайн шийдвэрийг хууль ёсны үндэслэлтэй гаргасан эсэхийг болон тэрхүү үндэслэл нь үнэхээр тухайн шийдвэр гаргах үндэслэл мөн үү гэдгийг мэдэх боломж олгох юм. Ингэснээр тухайн нөхцөл байдалд ажил

¹⁵⁵ "Монгол Улсын төрийн албаны шинэтгэлийн явц, үр дүн хандлага" судалгааны тайлан. УБ., 2014. Ред: Ч.Энхбаатар. 40 дэх тал.

олгогчоос гаргасан шийдвэр нь энэхүү асуудлын хамгийн зөв шийдвэрийн хувилбар байсан байсан эсэхийг эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа ажилтан мэдэх боломжтой болно. Тухайн шийдвэр гаргаж буй бодит нөхцөл байдалд, асуудлын агуулгыг хамаарсан шийдвэр гаргахдаа захиргаа зөвхөн өөрийн үзэмжээр, дур зоргоороо асуудлыг шийдэх бус, хуулийн эрх хэмжээний сонголтын хүрээнд зөв сонголт хийж шийдвэр гаргасан эсэх нь ажил олгогчийн шийдвэрийн үндэслэлээр

тодорхой болох юм. Шийдвэрийн үндэслэл тухайн шийдвэрийн эрх зүйн үйлчлэл шууд чиглэсэн этгээд болон эрх, ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдэд зориулагдаж байгаа тул шийдвэрийн үндэслэл нь дээрх субъектүүдэд ямар нэг эргэлзээ төрүүлэхгүй тодорхой ойлгомжтой байх ёстой юм. Гэтэл эдгээр шаардлагуудыг хангаж чадахгүй байгаа гол шалтгаан шийдвэр гаргаж буй албан тушаалтнуудын хууль хэрэглээний чадвар хангалтгүй байгаатай холбоотой юм.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ИРГЭНИЙ ДАВХАР ХАРЬААЛЛЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА



Монгол Улсын Их Сургуулийн
Хууль зүйн сургуулийн
магистрант

Б.ЦЭНГЭЛ

Иргэний харьяалал нь төр ба иргэн хоёрыг холбож буй улс төр, эрх зүйн тогтвортой холбоос юм. Харин энэхүү холбоосын агуулга нь төрийн зүгээс баталгаажуулж өгсөн иргэний эрх, эрх чөлөө, төрийн өмнө хүлээх үүргийг олон улсын хэм хэмжээнд уялдуулсан үндэсний хууль тогтоомж, эрх зүйн бусад актаар зохицуулагддаг байна.

Иргэний харьяалал нь хувь этгээдийн эрх зүйн байдлын анхдагч ба үндсэн элемент юм. Өөрөөр хэлбэл, иргэний харьяалал нь нийгмийн харилцаанд оролцох эрх зүйн байдлыг тодорхойлогч, төрийн хамгаалалтанд эрх, эрх чөлөө эдлэх, үүрэг хүлээх суурь болдог.

Иргэний харьяалалтай болох, харьяаллаа алдахтай холбогдсон бүх асуудал нь улс гүрний тусгаар тогтнолтой холбоотойгоор тэдгээрийн үзэмжээр зохицуулагдаж байдаг хүний эрхийн чухал асуудал юм.¹⁵⁶

Улс бүрийн хууль тогтоомжийн зөрүүтэй байдлаас үүдэн нэг хүн хоёр буюу түүнээс дээш иргэний харьяалалтай болсноор төр, иргэний хоорондын улс төр, эрх зүйн холбоос алдагдаж, тухайн хүн эрхээ эдэлж, үүргээ биелүүлэхэд зөрчил үүсдэг.

Монгол Улсад өнөөдрийн байдлаар

хөрсний зарчимтай улсад төрсөн, цусны зарчимтай улсын иргэнээс төрсөн, гэрлэлтээр иргэнээ болгодог улсын иргэнтэй гэр бүл болсон, гадаадын иргэнд үрчлүүлсэн, давхар харьяаллыг хүлээн зөвшөөрдөг болон тодорхой тохиолдолд хүлээн зөвшөөрдөг улсын иргэний харьяалалтай болох зэргээс үүдэн иргэний давхар харьяалалтай монгол хүний тоо ихсэх төлөвтэй байна.

Өнөөгийн байдлаар албан бус мэдээллээр хилийн чанадад Монгол Улсын 120000 орчим иргэн ажиллаж, амьдарч байна.

Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар 2001 онд байгуулагдснаас хойш 170 гадаадын иргэн Монгол Улсын иргэний харьяалалтай болж, Бүгд Найрамдах Казахстан Улсын иргэний харьяалалтай болохоор 20544, бусад улсын харьяалалтай болохоор 1657 иргэн Монгол Улсын иргэний харьяаллаас гарч, Бүгд Найрамдах Казахстан Улсын иргэний харьяалалтай байсан 1739, бусад улсын иргэний харьяалалтай байсан 8 хүн Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгосон байна.

2015 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар Монгол Улсын иргэнээс төрсөн 16 хүртэл насны 48 гадаад улсын иргэний харьяалалтай 2184 хүүхэд (АНУ-1279,

¹⁵⁶ Пунцагдаш.О. 2002 он. Иргэний харьяалал (олон улсын эрх зүйн асуудал). УБ. Урлах эрдэм. х-8

БНСУ-297, ОХУ-172, Япон-102, ХБНГУ-43, ИБУИНВУ-39, БНХАУ-29, бусад-223), Монгол Улсын иргэний харьяаллаас гарсан 10 гадаад улсын 343 иргэн (БНКазУ-256, БНСУ-34, ХБНГУ-32, бусад-21), Монгол Улсын иргэнээс төрсөн 16-гаас дээш насны 28 гадаад улсын 227 иргэн (ОХУ-67, АНУ-66, БНКазУ-26, бусад-68), нийт 2754 монгол үндэстэн Монгол Улсдаа хувийн хэргээр оршин суух зөвшөөрөлтэй ажиллаж, амьдарч байна.

Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд 1998 оноос хойш гадаад улсын иргэнтэй гэр бүл болсон нийт 5904 иргэн бүртгэгдсэн.

Эдгээр хүмүүсээс иргэний давхар харьяаллаа бүртгүүлээгүй, тухайн улс нь өөрийн иргэнээ болгосон тул хувийн мэдээлэл гэсэн үндэслэлээр манай улсын дипломат төлөөлөгчийн газруудад мэдэгддэггүйн улмаас хэдэн хүн иргэний давхар харьяалалтай болсны бодит тоон үзүүлэлтийг гаргах боломжгүй юм.

Иргэний давхар харьяалал

Иргэний харьяалал. Хүн амьд явах, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох зэрэг эрх эдэлж, үүрэг хүлээх, нийгмийн харилцаанд оролцох анхдагч суурь нь иргэний харьяалал юм. Иргэний давхар харьяалал үүссэнээр харьяалах улсуудын хуульд заасан эрх, үүргүүдийн хооронд зөрчил бий болно.

Аливаа улсад хувь хүний эрх зүйн байдлыг тухайн хүний иргэний харьяаллаар нь тодорхойлдог. Иргэний харьяалал гэж төр, иргэний хооронд харилцан эрх, үүргээр нөхцөлдсөн эрх зүйн тогтвортой холбоог хэлнэ. Энгийнээр хэлбэл, хувь хүн төрийн ивээлд байж түүгээр хамгаалуулна гэсэн үг юм.

Иргэний харьяалал нь зөвхөн тухайн улсын нутаг дэвсгэр дээр амьдарч буй хүмүүст бус, харин тухайн улсын иргэд, мөн гадаад улсад байгаа иргэдэд ч хамаарна. Иргэний харьяалалтай байх нь нутаг дэвсгэрээр хязгаарлагдахгүй, улсын дотор болон хилийн чанадад олон улсын харилцаанд хувь хүний эрх зүйн байдлыг тодорхойлно.

Иргэний харьяалалтай болох ба түүнийг алдах аргууд. Иргэний харьяаллыг төрснөөр (гарал үүслээр), олон улсын гэрээний үндсэн дээр эрх олгох замаар, зарим тохиолдолд реинтеграцийн (эрх сэргээх) замаар болон шан харамж болгох маягаар олж авч болно. Реинтеграц гэж иргэний харьяаллаас хууль бусаар хассан шийдвэрийг хүчингүй болгох тохиолдолд, шан харамж болгох нь тухайн улсад онцгой гавьяа байгуулсных нь төлөө иргэний харьяалалтай болгох юм.

Иргэний харьяалалтай болох үндсэн арга нь төрснөөрөө (филиац, filiation) иргэний харьяалалтай болох юм. Олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ ба зарчмуудаар хүүхэд бүр иргэний харьяалалтай болох эрхтэй. 1959 оны Хүүхдийн эрхийн Тунхаглалын 3 дахь зарчмын агуулга, 1966 оны Иргэний ба улс төрийн эрхийн тухай Пактын 24 дүгээр зүйлийн 3 дахь заалт, Хүүхдийн эрхийн тухай 1989 оны Конвенцийн 7 дугаар зүйлийн 1 дэх заалтын дагуу хүүхэд ямар ч нөхцөл байдалд харьяалалгүй болох ёсгүй.

Төрснөөр иргэний харьяалалтай болох нь. “цусны эрх” (jus sanguinis) ба “газар хөрсний эрх” (jus soli) гэсэн хоёр зарчимтай бөгөөд зарим улсын хууль тогтоомж холимог системийг тогтоосон нь бий. “Цусны эрх”-ийн (үндэстний зарчим) зарчим ёсоор хүүхдийн иргэний харьяалал нь түүний эцэг, эхийн иргэний харьяаллаар тодорхойлогдох бөгөөд төрсөн газраас хамаарахгүй. Харин “газар хөрсний эрх”-ийн дагуу иргэний харьяалалтай болох нь хүүхдийн төрсөн газар нутгаар тодорхойлогдох бөгөөд түүний эцэг, эхийн иргэний харьяаллаас хамаарахгүй.

Төрсөн газраар иргэний харьяаллыг тогтоох стандарт ялгаатай байдаг. Тухайлбал; Английн хуулиар английн усан онгоцонд төрсөн хүүхэд усан онгоц хаана байснаас үл шалтгаалан английн иргэн байна. Харин Америкийн хуулиар хүүхэд усан хил дотор нь байгаа усан онгоцонд төрсөн бол америкийн иргэний харьяалалтай болдог. Хэрвээ хүүхэд Английн усан онгоц Америкийн боомтод байх үед төрвөл англи, америкийн иргэний давхар харьяалалтай болно. Төрсөн хүүхдийн эцэг, эх англи, америкийн иргэн биш, цусны зарчмаар

иргэний харьяалал тогтоодог улсын иргэд бол тэдний иргэний харьяаллыг авах бөгөөд эцэг, эхийн иргэний харьяалал өөр өөр бол, иргэний 4 давхар харьяалал үүсэх боломжтой.¹⁵⁷

Эрх олгох журмаар иргэний харьяалалтай болох арга нь аливаа улсын эрх бүхий байгууллагын акт болон олон улсын гэрээний үндсэн дээр иргэний харьяалалтай болох юм. Иргэний харьяаллыг эрх олгогдох журмаар олж авах нь тухайн хүн өөрийн санаачилгаар хүсэлт гарган сайн дурын үндсэн дээр иргэний харьяалалтай болох явдал.

Зарим улс орнуудын практикт үндэстний, шашны ба улс төрийн янз бүрийн шинж байдлаар хууль тогтоомждоо ялгаварласан шинжтэй нөхцөл тавих байдлаар иргэний харьяалалтай болох асуудлыг зохицуулсан байдаг. Энэ нь тодорхой үндэстэн эсхүл гарал үүсэлтэй хүмүүсийн тухайд иргэний харьяалалтай болоход нь давуу байдал олгох эсхүл хөнгөлөлт үзүүлэх байдлаар илэрхийлэгдэнэ. Тухайлбал; репатриантуудын тухай Израилийн 1950 оны хуульд Израиль улсад байнга оршин суухаар ирж буй жүүд хүн бүр тус улсын иргэний харьяалалтай болох эрхтэй гэж тогтоосон байдаг.

Иргэний харьяаллын тухай олон улсын эрх зүйн хэм хэмжээний өнөөгийн нөхцөл байдалд иргэний харьяалалтай болох эрх олгохтой холбогдсон харилцаа нь ерөнхийдөө тухайн улсын тусгаар тогтнол, бүрэн эрхийн хүрээний асуудал билээ. Ингэхдээ иргэний харьяаллын хүрээнд олон улсын эрх зүйн хэм хэмжээ нь улсуудын дотоод хэрэгт үл оролцох зарчимтай зэрэгцэн оршдог.

Олон улсын гэрээний үндсэн дээр иргэний харьяалалтай болох ба өөрчлөх. Зарим тохиолдолд энх тайвны гэрээ байгуулах, нутаг дэвсгэрийн асуудлаарх хэлэлцээрийн үед, хоёр эсхүл хэд хэдэн улс нийлж нэг улс үүсгэх (жишээ нь: БНАГУ ба ХБНГУ нэгдэхэд) эсхүл нэг улс задарч хэд хэдэн улс бий болоход (жишээ нь: ЗСБНХУ задрахад), нутаг дэвсгэр нэг улсаас нөгөө улсад шилжихэд, хөрш улсууд нутаг дэвсгэрийн тодорхой хэсгийг солилцоход, нутаг дэвсгэр өөрчлөгдөхөд тохиолддог. Ийм маягаар олон улсын шинэ субъект үүссэнээр шинэ иргэний

харьяалалтай болж болно.

Давхар харьяалалтай хүний иргэний харьяаллаас гарах эрх чөлөөг 1930 оны Гаагийн Конвенцийн 6 ба 7 дугаар зүйл болон олон иргэний харьяалалтай болох тохиолдлыг хорогдуулах тухай 1963 оны Европын Конвенцийн 2 дугаар зүйлд тунхагласан байдаг.

Хуулиар иргэний харьяаллаас хэрэг үүсгэхгүйгээр шууд хасах тохиолдол, тухайлбал; гадаад улсад ялангуяа өмнө нь иргэний харьяалалтай байсан улсдаа тодорхойгүйгээр удаан хугацаагаар байсан шалтгаанаар бий болдог. Мөн иргэний харьяаллын эрх олгох үед худал мэдээлэл өгсөн, иргэний эрхээ ноцтой зөрчсөн гэх мэт шалтгаан байдаг. Ийм зохицуулалт Канад, Ирланд, Судан, Венесуэль, Болгарын хууль тогтоомжид бий.

Нэгдсэн Үндэстний Байгууллага 1961 онд Иргэний харьяалалгүй хүмүүсийг цөөлөх тухай конвенцийг баталсан. Энэ конвенцийн зорилго байнга оршин суугаа улс нь иргэний харьяалалгүй хүмүүст иргэний харьяалал олгох, эрх зүйн байдлыг нь тааламжтай тогтоох, сайн дураар иргэний харьяаллаас гарахад иргэний харьяалалгүй болох тохиолдлыг арилгах юм.

Иргэний давхар харьяаллын тухай ойлголт Иргэний давхар харьяалалтай байх бол хувь хүн нэгэн зэрэг нэгээс илүү улсын иргэний харьяалалтай байхыг давхар харьяалал гэдэг. Өөрөөр хэлбэл; иргэний давхар харьяалалтай болох нь зөвхөн улсуудын хууль тогтоомжоос үүдэлтэй.¹⁵⁸

Иргэний давхар харьяалалтай иргэн гэж тусгаар тогтносон, бүрэн эрхт хоёр буюу түүнээс дээш улстай улс төр-эрх зүйн хамааралтай болсон бөгөөд тэдгээр нь тухайн иргэнийг өөрийн улсын иргэний харьяалалтай хэмээн хүлээн зөвшөөрөх¹⁵⁹ явдал хэмээн тайлбарласан байдаг. Олон улсын эрх зүйн номонд улс гүрний иргэний харьяаллын хуулиудын зөрүүний улмаас нэг хүн хоёр юмуу түүнээс дээш улсын иргэний

¹⁵⁸ Пунцагдаш. О. 2002 он. Иргэний харьяалал (олон улсын эрх зүйн асуудал), УБ. х-14

¹⁵⁹ Нарангэрэл.С. 2008 он. Эрх зүйн эх толь бичиг УБ, Адмон, х-494

¹⁵⁷ Han Depei. 1999 он. Олон улсын эрх зүй. Wuhan. х-95

харьяалалтай болохыг хэлнэ.¹⁶⁰ Нэгээс дээш иргэний харьяалалтай байхыг хоёрдмол харьяалал, давхар харьяалал, олон харьяалал гэх зэргээр томъёолсон байдаг.

Толь бичгээс үзвэл “хоёр нь нэг дээр нэгийг нэмсэн тоо, хоёрдмол нь хоёр талтай шийдвэр”, “давхар нь зэрэг зэрэг”¹⁶¹ гэж тайлбарласан байна. Харин гадаад улсын нэр томъёоны “multiple nationality”, “plural nationality”, “множественное гражданство”, “多重国籍 duochongguoji” нь олон харьяалал, “dual citizenship” “двойное гражданство” “双重国籍 shuangchongguoji” нь хоёр, хос харьяалал гэж орчуулагдаж байна. Сурах бичгүүдэд иргэний хоёр харьяалал гэж нэг хүн хоёр улсын харьяалалтай байхыг, олон харьяалал гэж нэг хүн нэгэн зэрэг хоёроос дээш харьяалалтай байна гэж тайлбарласан байна. Тиймээс иргэний давхар харьяалал гэсэн нэр томъёог хэрэглэлээ.

Улс бүр өөрийн иргэний харьяаллын хуульд үндэслэн, хувь хүний иргэний харьяаллыг тогтоодог. Бодит байдал дээр улс бүрийн иргэний харьяаллын зарчим ялгаатайгаас, хүн олон иргэний харьяалалтай байх боломжтой болж иргэний харьяаллын зөрчилдөөн үүсдэг. Олон улсын эрх зүйд хүн нэг зэрэг олон иргэний харьяалалтай байхыг иргэний харьяаллын идэвхтэй зөрчилдөөн, харьяалалгүй байхыг иргэний харьяаллын идэвхгүй зөрчилдөөн гэдэг. Идэвхтэй зөрчилдөөн бол түүний аль улсын иргэний харьяаллыг баримтлахыг, идэвхгүй зөрчилдөөн бол ямар хууль баримтлахыг тогтоох болдог.

Иргэний харьяаллын идэвхтэй болон идэвхгүй зөрчилдөөн улс бүрийн иргэний харьяалалтай болох, иргэний харьяаллаа алдах журам ялгаатай байдгаас үүсдэг.¹⁶²

Идэвхтэй зөрчилдөөний үед улс бүрийн зөрчилдөөний хууль ялгаатай нөхцөл байдлыг олон ангилж, дараах аргуудаар шийдвэрлэдэг.

¹⁶⁰ Хосбаяр.О. Дүгэрсүрэн.М. 1999 он.Олон улсын эрхзүй. УБ. х-86

¹⁶¹ Цэвэл.Я. “Цэвэлийн ногоон толь”, Дэлгэрэнгүйг <http://tsevel.toli.query.mn>харна уу

¹⁶² Дэлгэрэнгүйг [http://\(baike.baidu.com/view/1282071.htm](http://(baike.baidu.com/view/1282071.htm) харна уу.

Хоёр эсвэл олон харьяалалтай бол өөрийн улсын иргэний харьяаллыг эхэнд нь тавина.¹⁶³ Улс бүр хэн түүний иргэн болохыг шийдвэрлэх эрхтэй, өөр улсын зөрчилдсөн хуулийн заалтыг дагах үүрэггүй.

Хоёр болон олон харьяалал нь бүгд гадаад улсын бол улс бүрийн туршлага өөр өөр боловч үндсэндээ:

А. Тухайн хүний оршин суугаа эсвэл байнга оршин суудаг улсын иргэний харьяалал тэргүүнд байх.

Б. Иргэний харьяалал авсан дарааллыг баримтлах. Эхний харьяалал давуу гэсэн үндэслэл нь эрх авснаа баримтлах, гэвч төрснөөрөө харьяалал авах үед нэгэн зэрэг олон харьяалалтай болвол аль нь эхнийх гэдгийг ялгах аргагүй. Сүүлийнх нь давуу гэсэн үндэслэл нь тухайн хүний сонголт. Мөн адил төрснөөрөө харьяалал авах үед нэгэн зэрэг авдаг тул ялгах аргагүй болдог.

В. Тухайн хүний хамгийн нягт холбоотой улсын иргэний харьяаллыг сонгох. Хамгийн тохиромжтой арга шиг боловч тогтооход өмнөх хоёроос амаргүй байдаг. Тогтооходоо аль улсад төрсөн, хаана оршин суух бүртгэлтэй, хаана байнга оршин суудаг, аль улсын улс төрийн эрхийг эдэлдэг, аль улсад үйл ажиллагаа явуулдаг гэх мэт. Заримдаа тухайн хүний субъектив байдал, өдөр тутмын үйлдэл, сэтгэл зүйн байдал аль улс руу хандлагатай зэргийг ч судлах болдог.

Дэлхийн 172 оронд хийсэн судалгаанаас үзэхэд 52 улс (БНХАУ, БНСУ, БНАСАУ) иргэний давхар харьяаллыг хүлээн зөвшөөрдөггүй, 49 улс (Америк, Англи, Болгар, Канад, Франц, Унгар, Итали, Мексик, Шинэ Зеланд, Орос, Румын, Словак, Швейцарь, Турк) иргэний давхар харьяаллыг шууд зөвшөөрдөг, 71 улс (Австри, Чех, Герман, Япон, Польш, Испани, Тайланд) иргэний давхар харьяаллыг хүлээн зөвшөөрдөггүй боловч онцгой тохиолдолд зөвшөөрдөг байна. Үүнээс зарим улсын судалгааг тухайн

¹⁶³ Xu Xianyu. 1999 он. Зөрчилдөөний эрх зүй, Шанхай, х144

улсын иргэний харьяаллыг авч болох нөхцөлөөр нь гаргав.

Иргэний давхар харьяаллын үндэсний зохицуулалт

1911 онд Монгол Улс үндэсний тусгаар тогтнолоо тунхагласнаар хөрш орнуудтай харилцах гадаад бодлогынхоо чиг хандлагыг тодорхойлж, Дундад Иргэн Улс, Хаант Орос улсуудтай найрамдлын харилцаа тогтоох, бусад улс орнуудтай худалдаа, үйлдвэрийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, тус улсын нутаг дэвсгэрт түр болон удаан хугацаагаар худалдаа, үйлдвэр эрхлэгч гадаадын иргэдийн үйл ажиллагааг зохицуулах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байжээ.

Улмаар 1921 онд Үндэсний ардчилсан хувьсгал ялснаар Засгийн газраас оршин суугч гадаадын иргэний эрх, үүргийг тогтоохын хамт гадаадын иргэнд оршин суух тэмдэгт бичгийг олгох, үйлдвэр, худалдаа эрхлэх, хууль зөрчигчдөд хариуцлага хүлээлгэх, элчин сайд, консулын газрыг байгуулах зэрэг бусад холбогдох дүрэм заавар тогтоолуудыг баталжээ.

Тухайлбал; “Гадаадын иргэдийг БНМАУ-ын харьяат болгох дүрэм, заавар” 1926, 1930, 1931 онуудад гаргасан. Засгийн газраас Монгол Улсын харьяат болохыг хүссэн гадаадын иргэдийг цэгцлэх үүднээс, улс хоорондын гэрээ хэлэлцээрүүдэд нийцүүлэн 1926 онд БНМАУ-ын Гадаад явдлын яамнаас “Тус улсын хязгаарын дотор суугаа гадаад улсын харьяат нарыг дагуулан авах тухай тогтоосон дүрэм”-ийг баталжээ. Өгүүлэн буй үед Улсын Их, Бага хурал, Засгийн газраас гадаадын иргэдийг Монгол Улсын харьяат болгохдоо монгол овогтнууд, үндэс угсаа өөр гадаад улсын иргэд гэсэн хоёр ялгавартайгаар хэлэлцэн шийдвэрлэсэн байна.

1911 онд Монгол Улс тусгаар тогтнолоо сэргээн тунхаглаж, үндэсний эв нэгдлийн үзлийг баримтлан монгол овогтнуудыг дагаар оруулж эхэлсэн бөгөөд энэ талаар заримыг цухас дурдвал:¹⁶⁴ Монгол Улс гадаад бодлогынхоо хүрээнд Барга, Өвөрмонгол, Буриад Тагна Урианхай зэрэг монгол

үндэстний нэгдэн нийлэх гэсэн чин эрмэлзэл, тэдний дотор өрнөсөн эрх чөлөөний хөдөлгөөнийг дэмжсэн арга хэмжээг хэрэгжүүлснээр 1912 онд Өвөрмонголын олон чуулган, хошуудаас 30,000 гаруй иргэн дагаар орсон бөгөөд 1916 онд 200, 1919 онд 500 өрх Баргаас тус тус нүүн ирж, 1921 оны 05 дугаар сарын 13-нд Шилийн голын чуулганы үзэмчин хошууны хутагт Эрдэнэ бандит гэвш, цорж Жигмидданзанжамц Богд гэгээн хааны соёрхолд багтахгаар цөөн хэдэн шавь нарыг дагуулан ирж дагаар орсон байна.

1940 оны байдлаар 6117 барга, 4909 торгууд, 50708 казах, 156811 буриад Монгол Улсад дагаар орж тархан суурьшсан байна.

Монгол Улсын Үндсэн хуулиудын иргэний харьяаллын асуудлаарх заалтууд:

1940 онд батлагдсан БНМАУ-ын Үндсэн хуулийн 23 дугаар зүйлийн 13-д Бага хурлын Тэргүүлэгчид нь “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын харьяат болгон авах явдлыг биелүүлэх;”¹⁶⁵

1960 онд батлагдсан БНМАУ-ын Үндсэн хуулийн 34 дүгээр зүйлийн Т-д Ардын Их Хурлын Тэргүүлэгчид нь “БНМАУ-ын иргэн болгож авна. Мөн БНМАУ-ын иргэнээс гарахад зөвшөөрөл олгоно;”¹⁶⁶

1990 онд батлагдсан БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулийн 19 дугаар зүйлийн 11-д БНМАУ-ын Ерөнхийлөгч нь “БНМАУ-ны харьяат болгох, харьяатаас гаргах, харьяатаас хасах асуудлыг шийдвэрлэнэ”¹⁶⁷

1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуулийн 15 дугаар зүйлийн 1-д “Монгол Улсын иргэний харьяалал хийгээд харьяат болох, харьяатаас гарах үндэслэл, журмыг гагцхүү хуулиар тогтооно.”; 2-т “Монгол Улсын иргэнийг харьяатаас хасах, эх орноосоо хөөх, өөр улсад шилжүүлэн өгөхийг хориглоно.”; 33 дугаар зүйлийн 1-ийн 9-д Монгол Улсын Ерөнхийлөгч “Монгол Улсын харьяат болгох, харьяатаас гарах, тус улсад орогнох эрх олгох асуудлыг шийдвэрлэх”

¹⁶⁵ Амарсанаа.Ж, 2012 он, Монгол Улсын Үндсэн хуулийн товчоон. УБ, Адмон, х416

¹⁶⁶ Амарсанаа.Ж, 2012 он, Монгол Улсын Үндсэн хуулийн товчоон. УБ, Адмон, х453

¹⁶⁷ Амарсанаа.Ж, 2012 он, Монгол Улсын Үндсэн хуулийн товчоон. УБ, Адмон, х480

¹⁶⁴ Мэндсайхан.Х, 2012 он, МУ дахь гадаадын иргэдийн харьяаллын асуудал, УБ, Соёмбо, х101-104

үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ¹⁶⁸ гэж тус тус заасан байна.

Үндсэн хуулиудад иргэний харьяаллын асуудлыг шийдвэрлэх эрх бүхий субъект, зарчмыг тусгаж байсны дагуу иргэний харьяаллын асуудлыг шийдвэрлэх, дүрэм, журам, заавар, тусгайлсан хууль батлагдаж байсан.

1959 оны Сайд нарын Зөвлөлийн 18 дугаар тогтоолоор баталсан Гадаадын иргэдийн БНМАУ-ын иргэн болгох зааврыг шинэчилж, БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн 1974 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 369 дүгээр зарлигаар БНМАУ-ын Харьяатын тухай хуулийг батлав. Энэ хууль нь 13 зүйлтэй бөгөөд тус хуулийг хэрэгжүүлэхийн тулд Сайд нарын Зөвлөлийн 1975 оны 181 дүгээр тогтоолоор БНМАУ-ын Харьяатын хууль биелүүлэх зааврыг баталжээ.¹⁶⁹

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1987 оны 41 дүгээр зарлигаар БНМАУ-ын харьяатын тухай хуулийг шинэчлэн баталсан.¹⁷⁰ Энэхүү хуулийн 7 дугаар зүйлд БНМАУ-ын иргэн хүн гадаад улсын харьяат байхыг хүлээн зөвшөөрөхгүй байх тухай заасан.

“Харьяатын тухай” Монгол Улсын 1995 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хууль нь 1995 оны 07 дугаар сарын 15-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

Давхар харьяаллын талаар Анхны олон улсын чанартай шийдвэрийн эхлэл бол 1958 оны 08 дугаар сарын 25-ны өдөр БНМАУ-ын Засгийн газар Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын Засгийн газраас хоёрдмол иргэдийн асуудлыг захицуулах талаар байгуулсан конвенц юм.

Олон улсын жишгийг харгалзан манай улс 1970-аад оноос зарим улстай, тухайлбал, ЗСБНХУ, БНПАУ (1975), БНАГУ, БНУАУ (1977), БНБАУ (1983)-тай хоёрдмол харьяалал үүсэх тохиолдлыг арилгах асуудлаар гэрээ, хэлэлцээр, 1994 онд

“Сайн дураараа шилжин суурьших болон хөдөлмөрийн гэрээгээр БНКАЗУ-д ирсэн хүмүүсийн иргэний харьяаллын асуудлыг зохицуулах тухай Монгол Улс, БНКАЗУ-ын хоорондын гэрээ”-г тус тус байгуулсан.

Казах иргэдийн иргэний харьяаллын асуудлыг шуурхай шийдвэрлэх үүрэг бүхий ажлын хэсгийг Засгийн газрын 1997 оны 186 дугаар тогтоолын дагуу Хууль зүйн сайд, Гадаад харилцааны сайд, Эрүүл мэнд, нийгэм хамгааллын сайдын хамтарсан тушаалаар байгуулсан бөгөөд 1999 оны 06 дугаар сараас ИБМУТ-д казах иргэдийн иргэний харьяаллын асуудлыг дагнан хариуцсан тасаг байгуулсан.¹⁷¹ 2015 оны байдлаар 56370 хүн иргэний харьяаллаас гарч, 1739 хүн иргэний харьяаллаа сэргээн тогтоолгосон байна

Өнөөгийн зохицуулалт

Монгол Улс иргэний харьяаллын асуудлыг хөндсөн олон улсын томоохон гэрээ, хэлэлцээрүүдийн оролцогч билээ. 1948 оны Хүний эрхийн бүх нийтийн Тунхаглалын заалтуудын дундаас улс орнууд нийтгээр хүлээн зөвшөөрсөн заримыг онцолж болох юм. Тухайлбал: “1. Хүн бүр харьяат болох эрхтэй. 2. Хэн ч өөрийн харьяаллаа эсхүл өөрийн харьяатаа өөрчлөх эрхээ дур зоргоор алдах ёсгүй” (15 дугаар зүйл). Мөн энэхүү баримт бичгийн 13 дугаар зүйлд: “1. Улс дотор хүн бүр чөлөөтэй шилжилт хөдөлгөөн хийх, оршин суух газраа сонгох эрхтэй. 2. Хүн бүр ямар ч орныг, түүний дотор өөрийн орныг орхин гарах ба өөрийн орондоо буцаж ирэх эрхтэй” хэмээн тодорхойлсон байдаг.¹⁷²

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын конвенцийн 24 дүгээр зүйлд “Аливаа хүүхэд арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ болон төрсөн байдлаар алагчлагдахгүйгээр өөрийн гэр бүл, нийгэм, төрийн зүгээс насанд хүрээгүйнхээ хувьд шаардлага бүхий хамгаалалт эдлэх эрхтэй. Хүүхэд төрсөн даруй бүртгэгдэж, нэртэй болох ёстой. Хүүхэд бүр иргэний харьяалалтай болох эрхтэй”, Хүүхдийн

¹⁶⁸ Амарсанаа.Ж. 2012 он, Монгол Улсын Үндсэн хуулийн товчоон. УБ, Адмон, х495

¹⁶⁹ Давааням.А, Мэндсайхан.Х, Нэргүй.Ц, 2008 он, ГИХАЗА-ны тогтолцоо, УБ, ЖСК, х80

¹⁷⁰ Пунцагдаш.О. 2002 он. Иргэний харьяалал (олон улсын эрх зүйн асуудал). УБ. Урлах эрдэм. х-108

¹⁷¹ Пунцагдаш.О. 2002 он. Иргэний харьяалал (олон улсын эрх зүйн асуудал). УБ. Урлах эрдэм. х-122

¹⁷² Төрийн мэдээлэл. Тусгай дугаар. Монгол улсын олон улсын гэрээ. УБ. 2005. Х.45.

эрхийн тухай конвенцийн 7 дугаар зүйлд “Хүүхэд төрмөгцөө бүртгүүлэх, төрсөн цагаасаа нэр авах, иргэний харьяалалтай болох, түүнчлэн эцэг, эхээ боломжийн хэрээр мэдэх, хайр халамжийг нь хүртэх эрх эдэлнэ. Оролцогч улсууд эдгээр эрхийг, ялангуяа хүүхэд иргэний харьяалалгүй болох тохиолдолд үндэсний хууль тогтоомж, холбогдох олон улсын баримт бичгийн дагуу хүлээсэн үүрэгтээ нийцүүлэн хэрэгжүүлнэ” гэж тус тус заасан байдаг.

Монгол Улсын иргэд дараах нөхцөл шалтгааны улмаас гадаад улсын иргэний харьяалалтай болж, иргэний давхар харьяалал үүсгэж байна. Үүнд:

- Харьяатын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “эцэг, эх нь хоёулаа Монгол Улсын харьяат байсан үед төрсөн хүүхэд Монгол Улсын нутаг дэвсгэрт буюу түүний гадна төрснөөс хамаарахгүй Монгол Улсын харьяат байна” гэж заасны дагуу Монгол Улсын иргэний харьяаллыг хэвээр хадгалж байна. 1998 оноос хойш эцэг, эх нь хоёулаа Монгол Улсын харьяат тэдний дундаас гадаад улсын нутаг дэвсгэрт төрсөн 4880 хүүхэд иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэгдснээс хөрсний зарчмаар иргэний харьяалал авдаг АНУ, БНСУ, Япон, ИБУИНВУ, Канад, Ирланд, Франц зэрэг улсад хоёрдмол харьяалал үүсгэсэн 2184 хүүхэд Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газраас Монгол Улсад оршин суух зөвшөөрөл авсан байна.
- Харьяатын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Эцэг, эхийн аль нэг нь Монгол Улсын харьяат, нөгөө нь гадаад улсын харьяат бол Монгол Улсын нутаг дэвсгэр дээр төрсөн тэдний хүүхэд Монгол Улсын харьяат байна. Хэрэв хүүхэд гадаад улсын нутаг дэвсгэр дээр төрсөн бол хүүхдийн иргэний харьяаллыг эцэг, эхийн харилцан бичгээр тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ” гэж заасан. 1998 оноос хойш эцэг, эхийн аль нэг

нь Монгол Улсын харьяат, нөгөө нь гадаад улсын харьяат Монгол Улсын нутаг дэвсгэрт төрсөн 1889 хүүхэд, хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газарт гадаад улсын нутаг дэвсгэрт төрсөн 653 хүүхэд иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгүүлсэн байна. Энэ нь давхар харьяалал үүсгэж байна. Мөн гадаад улсын харьяалал авсан үндэслэлээр Улсын бүртгэлийн ерөнхий газар, хилийн чанад дахь дипломат төлөөлөгчийн газрууд холимог гэр бүлээс төрсөн хүүхдийг иргэний бүртгэлд бүртгэдэггүй. Энэ байдлаас хэдэн иргэнээ алдаж байгаа, хэдэн хүүхдийн эрх хохирч байгаа судалгаа байхгүй байна.

- Иргэний давхар харьяаллыг хүлээн зөвшөөрдөг улсын иргэнтэй гэр бүл болсон Монгол Улсын иргэн тухайн улсын иргэний харьяалалтай болж байна. Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд 1998 оноос хойш гадаад улсын иргэнтэй гэр бүл болсон нийт 5904 иргэн бүртгэгдснээс БНСУ 3769, БНХАУ 360, Япон 338, ОХУ 214, АНУ 200, ХБНГУ 159, ИБУИНВУ 150 иргэнтэй гэр бүл болсон байна. АНУ, ИБУИНВУ, Итали, БНСУ-д гэр бүл болоод 3 жил болсон тохиолдолд иргэний харьяалалтай болдог.
- Харьяатын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Гадаадын иргэн эхнэр, нөхрийн үрчлэн авсан Монгол Улсын харьяат 16 нас хүрээгүй хүүхэд Монгол Улсын харьяат хэвээр байна”, 2 дахь хэсэгт “Хэрэв гадаадын иргэн, эхнэр, нөхөр нь Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авах үед түүний иргэний харьяаллыг өөрчлөх хүсэлт гаргавал үрчлүүлж буй эцэг эхийн саналыг харгалзан тухайн хүүхдийн иргэний харьяаллыг шийдвэрлэж болно” гэж заасан нь зөрчилдөж байна. Гадаадын иргэнд үрчлэгдсэн хүүхдүүд үрчилж авсан эцэг, эхийн иргэний харьяалалтай болж байна. 1999 оноос хойш Монгол Улсын

иргэний харьяалалтай 261 хүүхдийг гадаадын иргэнд үрчлүүлсэн.

- Монгол Улсын иргэнээс төрсөн 16-гаас дээш насны 227 иргэн Монгол Улсад оршин суух зөвшөөрөлтэй байна. Монгол Улсад оршин суудаггүй давхар харьяалалтай иргэдийн мэдээлэл байхгүй байна.
- Иргэний давхар харьяаллыг хүлээн зөвшөөрдөг улсын иргэн болсон Монгол Улсын иргэн тухайн улсынхаа иргэний харьяаллыг авахдаа энэ талаар Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газарт мэдэгддэггүй, нөгөө талаас иргэнээ болгож буй улсын хувьд нэгэнт иргэний давхар харьяаллыг хүлээн зөвшөөрдөг учраас манай улсын иргэний харьяаллаас гарсан байхыг шаарддаггүй нь иргэний давхар харьяаллыг үүсгэх нэг нөхцөл болдог.
- Зарим улсууд гадаадад амьдарч байгаа үндэстэн нэгтнээ өөрийн улсад шилжин суурьшихад иргэний харьяаллыг хялбаршуулсан журмаар олгодог. Тухайлбал ХБНГУ, Грек, Израиль. Эдгээрийн нэгэн адил Бүгд Найрамдах Казахстан Улс хүн амынхаа казах үндэстний эзлэх хувийг нэмэгдүүлэх төрийн бодлого хэрэгжүүлснээр 2000 оноос хялбарчилсан журмаар иргэний харьяаллаа олгож эхэлсэн бөгөөд уг журмын дагуу тус улсын иргэний харьяалалтай болохыг хүссэн хүнээс өөрийн үндсэн улсын иргэний харьяаллаас гарсан байхыг шаарддаггүй. Бүгд Найрамдах Казахстан Улсад шилжин суурьшсан Монгол Улсын иргэдээс 23017 иргэний хоёрдмол харьяаллын зөрчлийг арилгасан бөгөөд 2015 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар 2728 иргэн хоёрдмол харьяалалтай байна.

Бусад улс орнуудтай харьцуулахад монголчуудын өндөр хөгжилтэй орнуудад очиж суурьшиж байгаа шалтгаан нь ерөнхийдөө адил төстэй боловч онцлог шинж нь Монгол Улсын иргэний харьяаллаас гарагчдын дийлэнх нь дээд

боловсролтой хүмүүс байдаг. 2001 оноос хойш Бүгд Найрамдах Казахстан Улсын иргэний харьяалалтай болсон иргэдийг оруулалгүйгээр гадаадын 20 улсын иргэний харьяалалтай болох зорилгоор нийтдээ 1637 хүн Монгол Улсын иргэний харьяаллаас гарсан байна. Энэ хугацаанд нийтдээ гадаад 5 улсын 170 иргэн Монгол Улсын иргэний харьяалалтай болсон.

*Монгол Улсын иргэний харьяаллаас гарсан болон иргэний давхар харьяалал үүсгэсэн тохиолдолд хуульд заасан ямар эрх хязгаарлагдах талаар:*¹⁷³

- Монгол Улсын хилээр нэвтрэх, оршин суухдаа виз авах, баримт бичиг бүрдүүлж, бүртгүүлэх - Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсад нэвтрэх гадаадын иргэн Монгол Улсын визийг зохих журмын дагуу авсан байна”; 24 дүгээр зүйлийн 24.1-д “Монгол Улсад 30 хоногоос дээш хугацаагаар ирсэн түр ирэгч, хувийн хэргээр оршин суугч болон энэ хуулийн 32.2-т заасан гадаадын иргэн тус улсад орж ирсэн өдрөөс хойш ажлын 7 өдрийн дотор иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлнэ”;
- Газар өмчлөх, ашиглах эрх хязгаарлах - Газрын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т зааснаар Бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба улсын тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно, мөн хуулийн 44 дүгээр зүйлд зааснаар Монгол Улсад байнга (183 хоногоос дээш хугацаагаар) оршин суугаа гадаадын иргэн, **харьяалалгүй** хүнд газрыг зөвхөн гэр бүлийн хамтын хэрэгцээний нь зориулалтаар ашиглуулах асуудлыг дуудлага худалдааны зарчмаар тухайн шатны Засаг дарга шийдвэрлэнэ;

¹⁷³ Судалгааны тайлангийн эмхтгэл. ХЗҮХ. УБ.2014 он (2012-2013)1, х-631

- Галт зэвсэг өмчлөх эрхгүй - Галт зэвсэг өмчлөх тухай хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу "...гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын нутаг дэвсгэрт галт зэвсэг өмчлөхийг хориглоно";
- Монгол Улсын иргэний үнэмлэх, үндэсний гадаад паспорт эзэмших эрхгүй- Харьяатын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 3-т "Гадаад улсын нутаг дэвсгэр дээр оршин суугаа Монгол Улсын харьяатаас гарсан хүний иргэний баримт бичгийг дипломат төлөөлөгчийн болон консулын газар хураан авч, иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар дамжуулан иргэний бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх бөгөөд тус байгууллага Иргэний бүртгэлийн тухай хуулийн 29.1-д заасан иргэний бүртгэл, мэдээллийн сан дахь холбогдох мэдээлэлд бичилт хийнэ"; Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д зааснаар "Монгол Улсад хувийн хэргээр оршин суух зөвшөөрлийг гадаадын иргэний хүсэлт, холбогдох байгууллагын санал, зөвшөөрлийг харгалзан иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага 5 хүртэл жилээр олгож, тухай бүр 3 хүртэл жилийн хугацаагаар сунгаж болно";
- Иргэний эрх зүйн чадварыг хуулиар хязгаарлах- Иргэний хуулийн 543 дугаар зүйлийн 543.1-д "Гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын иргэний нэгэн адил иргэний эрх зүйн чадвартай байна. Энэхүү чадварыг Монгол Улсын хуулиар хязгаарлаж болно";
- Сонгох, сонгогдох эрх- Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2-т "гадаадын иргэн Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын болон орон нутгийн хурлын сонгуульд сонгох, сонгогдох, ард нийтийн санал асуулгад оролцохыг хориглоно";
- Улс төрийн үйл ажиллагаа явуулах байгууллага байгуулах эрхгүй- Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2-т "гадаадын иргэн Монгол Улсын нутаг дэвсгэрт улс төрийн үйл ажиллагаа явуулах байгууллага байгуулах, түүнд элсэн орох, хөрөнгө, санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэргээр улс төрийн аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглоно";
- Монгол Улсын иргэнээс газар өмчлөх, эзэмших, ашиглалтандаа газар шилжүүлэн авах эрхгүй- Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1-д "газар өмчлөгч Монгол Улсын иргэн гадаадын иргэн, харьяалалгүй хүнд өмчийн газраа худалдах, арилжих, өвлүүлэх, бэлэглэх, барьцаалах зэргээр гадаадын хуулийн этгээд, гадаадын иргэн, харьяалалгүй хүний өмчлөл, эзэмшилд шилжүүлэх эрхгүй байна";
- Газрыг бусдад дамжуулан хөлслөх, дамжуулан түрээслэхийг хориглох- Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.9-д "иргэний өмчийн газрыг гэрээний үндсэн дээр хөлсөлж, түрээсэлж байгаа гадаадын хуулийн этгээд, гадаадын иргэн, харьяалалгүй хүн уг газрыг бусдад дамжуулан хөлслөх, дамжуулан түрээслэхийг хориглоно";
- Улсын хилийн бүсэд байнга оршин суух эрхгүй - Монгол Улсын Хилийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.5-д "улсын хилийн бүсэд гадаадын иргэн, харьяалалгүй хүн байнга оршин суухыг хориглоно";
- Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглуулах эрхгүй- Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2-т "тусгай хамгаалалттай газар нутагт гадаад улсын хуулийн этгээд олон улсын байгууллага, гадаадын иргэн,

харьяалалгүй хүн, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид газар ашиглуулахыг хориглоно”;

- Төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх эрхгүй - Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.5-д “гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг төрийн жинхэнэ албан тушаалд авч ажиллуулахыг хориглоно”;
- Хүний хөгжлийн сангаас тэтгэмж авах эрхгүй- Хүний хөгжлийн сангийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “сангаас хүн ам, өрхийн бүртгэлд бүртгэгдсэн, иргэний харьяаллын зөрчилгүй Монгол Улсын иргэнд хишиг, хувь хүртээнэ” гэж тус тус заасан байна.

Дүгнэлт

Нэг. Аль нэг улсын иргэн хилийн чанадад асуудалд орсон бол тухайн улсын элчин сайдын яам, консулын газар түүнд туслах үүрэгтэй. Харин нөгөө этгээд давхар харьяалалтай бөгөөд хоёрдогч улсын паспортоор зорчиж буй бол эхний улс нь оролцохоосоо татгалздаг. Учир нь өөр улсын дотоод хэрэгт оролцох сонирхолгүй байдаг. Харин хоёр дахь улс тухайн иргэнийг анхны улсын үүсэл гаралтай гэж үзэж дипломат хамгаалалт үзүүлэхээс татгалзах боломжтой. Энэ тохиолдолд иргэн хүн өөрөө хохирдог.¹⁷⁴

Иргэний давхар харьяалал нь зэвсэгт мөргөлдөөн, дайны байдлын болон бусад онц байдалд эх орондоо үнэнч хандах байдлыг эргэлзээтэй болгодог. Учир нь тэд өөр улсад үнэнч байх тангараг өргөдөг. Иргэний харьяаллын гол асуудал нь цэргийн алба хаших үүрэг байдаг. Харин энэ хоёр улсын хооронд асуудал үүсэх тохиолдол үндэсний аюулгүй байдал алдагдах өндөр магадлалтай гэж үздэг байна. Энхийн цагт ч мөн адил үндэсний аюулгүй байдал гэх үүднээс давхар харьяалалтай иргэний эрхийг хязгаарлах зүйл бий. Эдгээр дээрх үндэслэлээр төрийн алба, эсхүл тодорхой төрийн бодлоготой холбоотой албан тушаал хаших, төрийн нууцын зэрэглэлтэй мэдээлэлд хүрэх

боломжийг хязгаарлах зэрэг байдлаар эрхийг нь хязгаарладаг. Улсын нэгдмэл, бүрэн бүтэн байдал, улсын хүчирхэг байдалд сөргөөр нөлөөлнө гэх болгоомжлол давхар харьяаллыг эсэргүүцэх гол шалтгаан болсоор иржээ.¹⁷⁵

Зарим улс иргэнээ болгохдоо тухайлбал АНУ-ын иргэн болоход тангараг өргүүлдэг ба энэ тангаргийг зөрчих, өөрөөр хэлбэл АНУ-д үнэнч байх үүргээ алдагдуулахад харьяаллаас хасах үндэслэл болдог. Үүнд өөр улсын паспорт ашиглах, өөр улсад тухайн улсын иргэний үүргээ биелүүлэхэд АНУ-ын өмнө хүлээсэн үүргээс няцсан гэж үздэг. Харин давхар харьяаллыг хүлээн зөвшөөрч буй улсын цөөнгүй нь түүхэн болон үндэс угсааны хувьд холбоо бүхий улсуудад давхар харьяаллыг хүлээн зөвшөөрөх гэрээ байгуулах боломжтойгоор хуульчилсан байдаг. Тухайлбал; ЗХУ задарч гэр бүл, хамаатан садангаараа хил дамнан тархсантай холбоотойгоор ОХУ энэ асуудлыг зөвшөөрөхөд хүрсэн байдаг.¹⁷⁶

Монгол Улсын Үндсэн хуулийн 15 дугаар зүйлийн 1-д “Монгол Улсын иргэний харьяалал хийгээд харьяат болох, харьяатаас гарах үндэслэл, журмыг гагцхүү хуулиар тогтооно”, 2-т “Монгол Улсын иргэнийг харьяатаас хасах, эх орноосоо хөөх, өөр улсад шилжүүлэн өгөхийг хориглоно” гэж заасан тул нэгэнт үүссэн иргэний давхар харьяаллыг таслан зогсоох, иргэний давхар харьяалал үүсэх тохиолдлоос урьдчилан сэргийлэх зорилгоор Харьяатын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд иргэний давхар харьяалалтай иргэн тогтоосон хугацаанд иргэний харьяаллаа сонгох, сонгоогүй тохиолдолд иргэний харьяаллаа алдах зохицуулалт хийх нь зүйтэй байна. Ингэснээр насанд хүрсэн иргэний давхар харьяаллын зөрчлийг арилгах боломж бий болно.

Хоёр. Монгол Улсын хууль тогтоомжоор давхар харьяаллыг зөвшөөрдөггүй боловч де-факто давхар харьяалалтай болсон

¹⁷⁴ Судалгааны тайлангийн эмхтгэл. ХЗҮХ. УБ.2012 он (2003-2009)1, X-592

¹⁷⁵ Судалгааны тайлангийн эмхтгэл. ХЗҮХ. УБ.2012 он (2003-2009)1, X-593

¹⁷⁶ Судалгааны тайлангийн эмхтгэл. ХЗҮХ. УБ.2012 он (2003-2009)1, X-600

тохиолдлыг зохицуулах боломжгүй байна. Манай улс иргэний давхар харьяаллыг хууль зүйн үүднээс хүлээн зөвшөөрдөггүй ч гэсэн гадаад улсууд өөрсдийн иргэний харьяаллын хуулийг баримталснаас болоод амьдралд олон хүн иргэний давхар харьяалалтай болж байна. Тухайлбал; АНУ-д монгол эцэг, эхээс төрсөн хүүхэд АНУ-ын харьяат болдог, энэ тохиолдолд Монгол Улсад давхар харьяаллыг хүлээн зөвшөөрөхгүй гэсэн зохицуулалтын дагуу Монгол Улсын иргэний харьяалалтай болгохгүй байх нь АНУ-ын хуулийг баримтлаад Монгол Улсын Харьяатын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “эцэг, эх нь хоёулаа Монгол Улсын харьяат байсан үед төрсөн хүүхэд Монгол Улсын нутаг дэвсгэрт буюу түүний гадна төрснөөс хамаарахгүй Монгол Улсын харьяат байна” гэсэн заалтыг үгүйсгэж байгаа тул хуулиа дагавал гарцаагүй давхар харьяалал үүсгэж байгаа юм.

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.1.3 дугаар зүйлийн 3.1.3.3-т “Гадаадад төрж тухайн улсын иргэний харьяалалтай болсон иргэд, тэдний үр хүүхэд Монгол Улсад зорчих, оршин суух, суралцах, ажиллаж амьдрах, даатгалд хамрагдах таатай нөхцөлийг бүрдүүлнэ. Хоёрдмол харьяалал үүсч, төрөөс иргэдийн ашиг сонирхлыг хамгаалах баталгаа алдагдахаас сэргийлнэ” гэж тодорхойлсон байна.

Харьяатын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2-т “Эцэг, эхийн аль нэг нь Монгол Улсын харьяат, нөгөө нь гадаад улсын харьяат бол Монгол Улсын нутаг дэвсгэр дээр төрсөн тэдний хүүхэд Монгол Улсын харьяат байна. Хэрэв хүүхэд гадаад улсын нутаг дэвсгэр дээр төрсөн бол хүүхдийн иргэний харьяаллыг эцэг, эхийн харилцан бичгээр тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ” гэж заасан боловч хөрсний зарчмаар иргэний давхар харьяалал үүсгэсэн хүүхдийн тоо өсөх хандлагатай байна. Мөн “Эцэг, эхийн аль нэг нь Монгол Улсын харьяат, нөгөө нь гадаад улсын харьяат бол Монгол Улсын болон гадаад улсын нутаг дэвсгэр дээр төрсөн тэдний хүүхэд Монгол Улсын харьяат байна” гэж цусны

эрхийн зарчмыг баримтлан өөрчлөхгүй бол гадаад улсын харьяалал авсан үндэслэлээр Улсын бүртгэлийн ерөнхий газар, хилийн чанад дахь дипломат төлөөлөгчийн газрууд холимог гэр бүлээс төрсөн хүүхдийг иргэний бүртгэлд бүртгэдэггүй. Энэ нь одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиа баримтлахгүй хүнд суртал үзүүлж байгаагаас иргэнээ алдаж, хүүхдийн эрх зөрчигдөхөд хүргэж байна.

Монгол Улсын иргэний харьяалаас гарсан болон иргэний давхар харьяалал үүсгэсэн тохиолдолд хуульд заасан ямар эрх хязгаарлагдах зохицуулалтуудаас харахад насанд хүрсэн хүний зарим эрхийг хязгаарлаж байгаа бөгөөд эдгээр нь иргэний давхар харьяалаас үүсэх зөрчилдөөнийг бий болгоно.

Харьяатын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 4-т “Монгол Улсын харьяат хаана оршин сууж байгаагаас үл хамааран төрийн ивээлд байж, зөрчигдсөн хууль ёсны эрх, ашиг сонирхлоо хуулийн дагуу хамгаалуулна” гэж заасан боловч иргэний давхар харьяалал үүсгэсэн иргэд хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулж чадахгүй, ялангуяа Монгол Улсад байгаа иргэний давхар харьяалалтай хүүхдүүд нийгмийн халамж, эрүүл мэндийн даатгалд хамрагдаж чадахгүй, цэцэрлэг, сургуульд бүртгүүлэх боломжгүй, хүндрэлтэй байдал үүсээд байна.

Иргэний хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Иргэний эрх зүйн бүрэн чадамж буюу иргэн өөрийн үйлдлээр өөртөө эрх олж авах, үүрэг бий болгох чадвар насанд хүрснээр буюу 18 наснаас бий болно” гэж заасан. Швед-18, Аргентин-18, Бельги-18, Бруней-18, Тайланд-18, Япон-22, Финлянд-22, Сингапур- 21, БНСУ-22 гэх мэт тодорхой нас хүртэл хүлээн зөвшөөрдөг.

Иймд хүүхдийн эрх зөрчигдөхөөс сэргийлж, иргэнээ алдахгүй байх үүднээс хүүхдийг насанд хүртэл нь иргэний давхар харьяаллыг хүлцэх буюу хүлээн зөвшөөрөх нь зүйтэй байна.

Гурав. Монгол Улсын иргэний харьяалаас гарсан, иргэний давхар харьяалалтай хүүхдүүдийн эцэг, эхээс судалгаа авсан.

Судалгаанд хамрагдсан хүмүүс давхар харьяалал хүнд тухайн улсын харилцан визгүй зорчих нөхцөлөөр хил дамнан чөлөөтэй зорчих, нийгмийн халамжинд хамрагдах, хүүхдээ хөнгөлттэй нөхцөлөөр сурч боловсруулах, хөдөлмөр эрхлэх боломжийг бий болгох, өндөр цалин хөлс авах зэрэг давуу тал бий болгоно. Гэвч төрөл саднаасаа хол байх, эх нутагтаа зорчиход виз, оршин суух зөвшөөрөл авах, нийгмийн халамж, тэтгэвэр авахад хүндрэлтэй, газар эзэмших, өмчлөх эрхгүй, орон сууцны хөнгөлөлттэй зээлэнд хамрагдах боломжгүй гэх мэт хүндрэл үүсдэгийг бичсэн байна. Иргэний давхар харьяалалтай монгол иргэнд эдийн засгийн, чөлөөтэй зорчих гэх мэт боломж бий болох ч өөр улсад үнэнч байна гэсэн тангараг өргөчихөөд Монгол Улсын хуулийг зөрчин, давхар эрх эдлэх нь үндэсний аюулгүй байдалд хортой, шударга бус үйлдэл юм. Заавал гадаад улсын иргэний харьяаллыг авахгүйгээр тухайн улсад оршин суух зөвшөөрөл авч, амьдрах боломж байдаг. Монгол Улсын иргэнтэй гэр бүл болж Монгол Улсад амьдарч байгаа 75 улсын 1388, цагаачлан амьдарч байгаа 14 улсын 1928 иргэн оршин суух зөвшөөрөлтэй байна. Монгол Улсын иргэнээс төрсөн хүүхдүүд, монгол үндэстэн олон тоогоор оршин суух гадаад улсад монгол хэлээр олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслийг нэвтрүүлэх, монгол хэл, соёл уламжлал, зан заншлын талаар сургалтын төсөл хэрэгжүүлэх,¹⁷⁷ тэднийг дэмжих шаардлагатай байна. Гадаад улсад байгаа Монгол иргэдийн, оюутны нийгэмлэг, холбоо гэсэн 113 төрийн бус байгууллага, радио үйл ажиллагаа явуулж байна.⁵⁹ Монгол Улсын иргэний харьяаллаас гарсан иргэдэд хялбаршуулсан журмаар виз, оршин суух зөвшөөрөл олгодог, иргэний харьяаллыг сэргээн тогтоодог болох нь зүйтэй байна. Мөн монгол угсаатан гэдэг утгаараа эх орондоо эргэн ирэхэд дээрх иргэдэд Монгол Улсын хилээр орох, гарах,

сурч, боловсрох, эмчлүүлэх, хөрөнгө оруулах, ажиллах, амьдрахад хөнгөлттэй нөхцөл бий болгож болох юм. Эдгээр монгол угсаатандаа “Хөх гэрэгэ” гэх оршин суух үнэмлэхийг 10 жилийн хугацаагаар олгож, сунгах эрх зүйн зохицуулалтыг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд оруулж болно.

Санал:

Дээрх дүгнэлтээс үндэслэн Харьятын тухай хуульд заасан «Монгол Улсын харьяат нэгэн зэрэг гадаад улсын харьяат байхыг хүлээн зөвшөөрөхгүй» гэж заасан боловч давхар харьяалал үүсгэсэн иргэдийн асуудлыг шийдвэрлэх дараах зохицуулалтыг оруулах саналтай байна. Үүнд:

“Монгол Улсын насанд хүрсэн иргэн гадаад улсын иргэний давхар харьяалалтай байхыг хүлээн зөвшөөрөхгүй.”

“Монгол Улсын иргэний харьяалалтай хүүхэд 18 насанд хүртлээ гадаад улсын иргэний давхар харьяаллыг хэвээр хадгалж болно.”

“Гадаад улсын иргэний давхар харьяалалтай Монгол Улсын насанд хүрсэн иргэн энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс нэг жилийн дотор аль нэг улсын иргэний харьяаллыг сонгосон байна”

“Тогтоосон хугацаанд аль нэг улсын иргэний харьяаллаа сонгоогүй тохиолдолд Монгол Улсын иргэний харьяаллаа алдана”.

Энэ нь хүүхдийн төрснөөр бий болох Монгол Улсын иргэний харьяаллаа алдахгүй байх, үндэсний аюулгүй байдал талаасаа насанд хүрсэн иргэний харьяаллын идэвхтэй зөрчилдөөн үүсэхээс урьдчилан сэргийлэх, бодит байдалд бий болсон иргэний харьяаллын зөрчлийг арилгах, хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлэх зэрэг асуудлыг шийдвэрлэх гарц гэж үзэж байна.

¹⁷⁷ Судалгааны тайлангийн эмхтгэл. ХЗҮХ. УБ.2014 он (2012-2013) 3, Х-630-634

МОНГОЛ ХЭЛЭЭР ЗӨВХӨН МАНАЙ ХУУДАСНАА

ХҮНИЙ ЭРХ БА НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНД: ТЭНЦВЭРТЭЙ ХАРИЛЦААГ ХАНГАХЫГ ЗОРИХ НЬ

БРИГИТ ТӨҮБЭС¹⁷⁸

Оршил

Нийт хүн амын эрүүл мэндийн хамгаалал бол дотоодын болон олон улсын аль ч түвшинд олон нийтийн анхааралд байх чухал асуудал юм. Хүн амын эрүүл мэнд буюу 'нийтийн эрүүл мэнд' гэдэг нь худалдаа, үйлдвэрлэлийн ашиг, оюуны өмчийн хамгаалал, цэрэг дайны үйл гэдэг шиг олон ашиг сонирхолтой эн зэрэгцүүлэн авч үзвэл зохих амин чухал үйл хэрэг билээ (Дүрс 1-ийг үзнэ үү). Тухайлбал улсуудын харилцан тохирсон худалдааны хэлцэл нь сайн эмээр хангагдах бололцоог хангах хэрэгцээтэй, ялангуяа хөгжиж буй ертөнцийн орнуудад зөрчилдөж байна. Цаашилбал тамхины үйлдвэрлэл бүтээгдэхүүнээ худалдах сонирхолтой байхад

тамхи татах нь эрүүл мэндэд хор хөнөөлтэй гэдэг илэрхий нотолгоо бий. Эцэст нь байгаль орчны өөрчлөлт, уур амьсгалын өөрчлөлт, дайн самуун дэлхий дахинд хүн амын эрүүл мэндэд сүйрлийн нөлөөтэй билээ.

Хүний эрхийн өнцгөөс бол нийтийн эрүүл мэндийн хамгаалал нь шинж чанараараа хувь хүний ч бай, хамтын ч бай хүний эрх байж болох эсэх тухай тунгааж үзэх шаардлага байна. Үүнээс үзэхэд эрүүл мэндээ хамгаалуулах эрх нь нийтийн эрүүл мэндийн ойлголтыг агуулсан, жишээ нь тамхи, хүнс, ундааны үйлдвэрлэлийн ашиг сонирхлын эсрэг чиглэсэн хамтын хүсэл шаардлага байж олох юм (Дүрс 1-ийг үзнэ үү). Иймд доор нотолсноор эрүүл мэндээ хамгаалуулах



Дүрс 1. нийтийн эрүүл мэнд болон бусад ашиг сонирхлын хоорондын зөрчил

¹⁷⁸ Нийтлэгч Бригит Төүбэс нь Нидерлан Улс дахь Гронингений их сургуулийн Хууль зүйн факультетийн Олон улсын тэнхимд дэд професор, Рөүзалинд Франклины тэтгэлэгт судлаач юм. Тэрээр Интерсентиатай хамтран ном (жишээ нь. Европ дахь эрүүл мэнд ба хүний эрх, 2012 он) хэвлэн нийтлүүлэх зэргээр эрүүл мэнд болон хүний эрхийн салбарт өргөн хүрээтэй бүтээл, нийтлэл гаргаж ирсэн болно. Мөн тэрээр Олон улсын хууль зүйн нийгэмлэгийн Дэлхий нийтийн эрүүл мэндийн эрх зүйн хорооны дарга нарын нэг бөгөөд олон улсын эрх зүй, хүний эрх, эрүүл мэндийн хамгаалал хоорондоо уулзвар заагийн талаар судалгаа зохион байгуулдаг Даян дэлхийн эрүүл мэндийн эрх зүй Гронинген хэмээх хөтөлбөрийг үндэслэн байгуулсан хүн юм.

эрх нь дотоодын болон олон улсын орчинд нийтийн эрүүл мэндийн хамгаалалд ахиц гаргахад үүрэг гүйцэтгэх боломжтой байна.

Үүний зэрэгцээ нийтийн эрүүл мэндийн хамгаалал, мөн түүнтэй холбоотой эрүүл мэндээ хамгаалуулах эрх нь хувь хүний ашиг сонирхолтой зөрчилдөж болно. Өөрөөр хэлбэл эрүүл мэндээ хамгаалуулах эрх нийтийн эрүүл мэндийн шаардлагатай уялддаг бол энэ нь мөн хувь хүний эрх, тэр дундаа бие махбодын халдашгүй байдал,

хувийн амьдралтай байх, чөлөөтэй зорчих зэрэг эрхүүдийг эдлэхтэй зөрчилдөж болно [1]. Энэ зөрчилдөөн ялангуяа халдварт өвчин болон ‘эрүүл мэндийн эсрэг заналхийлэл’ гэгчээс урьдчилан сэргийлэх шаардлагатай үед илрэн гардаг. Жишээ нь олон нийт бүхэлдээ халварт өвчний тархалтаас хамгаалуулах эрхтэй байхад хувь хүнд хувийн амьдралтай байх, хөндлөнгийн онц шаардлагагүй оролцооноос хамгаалуулах эрх бас бий (Дүрс 1-ийг үзнэ үү). Тиймээс бид зохиол бүтээлд бага анхаардаг хүний эрхийн эрх зүй дэх нэгэн чухал зөрчлийн асуудлыг хөндөж байна[2].

Бид энэ зөрчлийг шийдвэрлэх арга зам болон эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг төрийн эрүүл мэндийн бодлогын тодорхой хэлбэрийн арга хэмжээг зөвтгөхөд ашиглаж байгаа үед хэрхэх ёстой вэ гэдгийг тодруулах хэрэгтэй байна[3]. Энэ нь дэлхийн нийтийн эрүүл мэндийн асуудлаарх конвенц батлах тухай сүүлийн үед гарах болсон уриалгатай холбоотой юм. Дэлхий нийтийн болон дотоодын шинжтэй эрүүл мэндийн тэгш бус байдал ихэсч байгаад түгших болсноор олон тооны судлаач, иргэний нийгмийн байгууллагын зүгээс Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ)-аас боловсруулсан Дэлхий нийтийн эрүүл мэндийн суурь конвенц (ДНЭМСК)-ийг батлахыг зөвлөх болов[4]. Энэ сүлжээнээс ДНЭМСК нь эрүүл мэндээ хамгаалуулах эрхэд үндэслэхийг зөвлөж буй бөгөөд эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг дэлхийн эрүүл мэндийн эрх зүйн маргаанд гол хэм хэмжээ болгож байгаа юм[5]. Тиймд хэрэв бид эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг олон улсын орчинд түлхүү чухалчлан тавихыг хүсвэл, түүний чадамж болон бусад эрх, ашиг сонирхолтой үүсч болзошгүй зөрчлийн талаар тод төсөөлөлтэй байх нь зүйтэй.

Эдгээр асуудалтай холбогдуулан тодорхой ойлголт өгөх үүднээс энэ нийтлэлд нийтийн эрүүл мэнд болон хүний эрхийн хоорондын олон янзын холбоо хамаарлыг ил болгохыг зорьлоо. ‘Нийтийн эрүүл мэндийн’ ойлголтын утгыг тодруулах зорилгоор

энэ ойлголтын түүхэн хувьсал болон энэ чиглэлд олон улсын түвшинд гарсан өөрчлөлт хөгжлийг задлан шинжилснээр эхэлнэ. Дараа нь олон улсын худалдааны эрх зүй, олон улсын байгаль орчны эрх зүй зэрэг олон улсын эрх зүй дэх олон янзын гэрээнүүдэд одоо байгаа ‘Нийтийн эрүүл мэндийн заалтуудыг’ авч үзнэ. Өөрөөр хэлбэл ‘нийтийн эрүүл мэнд’ хэмээх ухагдахуун олон улсын эрх зүйн эдгээр салбарт хэрхэн суусныг тайлбарлах юм. Түүний дараа эрүүл мэндээ хамгаалуулах эрх нь нийтийн эрүүл мэндийн шаардлагыг тусгаж байгаа эсэх болон эрүүл мэндээ хамгаалуулах эрх нь хүний эрхийн стандартын хувьд одоо байгаа нийтийн эрүүл мэндийн заалтуудыг олон улсын эрх зүйн дагуу батжуулж чадах эсэхийг мэдэхийн тулд тэдгээр шаардлагын хүчин чадал ямар болохыг шинжлэх замаар хүний эрхийн эрх зүйн хүрээнд эргэн ярих болно. Үүгээр би эрүүл мэндээ хамгаалуулах эрх нь олон улсын худалдаа, хувийн үйлдвэрлэл, цэрэг дайны нөлөө бүхий хүчнүүдийн эсрэг хамтын шаардлага байж чадах эсэх, хэрэв чадах бол яаж гэдгийг нарийн авч үзнэ. Дараа нь энэ хандлага дахь зарим зөрчилтэй байж болзошгүй асуудлуудад анхаарал хандуулах юм. Үүний тулд нийтийн эрүүл мэндийг хамгаалах хэрэгцээ болон хувь хүний нууц, халдашгүй байдал, хувь хүний эрүүл мэндийн хамгаалалын хоорондын зөрчлийг задлан шинжлэх юм.

Энэ агуулгын хүрээнд хүний эрхийн эрх зүй болон олон улсын эрх зүй дэх нийтийн эрүүл мэндийн зайлшгүй болон хязгаарлах шинжүүдийг ерөнхийдөө ямар байдлаар авч үздэгийг товч тоймлох замаар тийм эрхүүдийг хэрхэн хязгаарлаж болохыг хөндөн ярих болно. Эдгээр ашиг сонирхлын тэнцвэрийг хэрхэн хангах болон ийнхүү тэнцвэр хангахад хүний эрхийн эрх зүйн гүйцэтгэх үүрэг юу байж болоход үнэлэлт өгснөөр энэ нийтлэл төгсөх юм.

Энэ нийтлэл дэх дүн шинжилгээ нь голлон хүний эрхийн стандартууд, хүний эрхийн хууль зүйн дискурст тулгуурлаж байгаа боловч үүнд дотоодын болон олон

улсын эрүүл мэндийн эрх зүй, нийгмийн анагаах ухаан, нийтийн эрүүл мэнд, эмчийн ёс зүй, мөн түүнчлэн олон улсын худалдааны эрх зүй, олон улсын хүмүүнлэгийн эрх зүй, олон улсын байгаль орчны эрх зүй зэрэг өөр олон мэдлэгийн салбарыг бас хамарна. Үүнд Нэгдсэн Үндэстний Байгууллагын хэмжээнд болон бүс нутгийн түвшинд (ялангуяа Европын Зөвлөл) баталсан хүний эрхийн гэрээ, конвенцийг нэгдсэн байдлаар нь хэлж байгаа юм. Энэ талбарын талаар бүхэлд нь тоймлохын оронд уг талбарын хүрээг тогтоож, тодорхойлолт өгөн, мөн тайлбарлах оролдлого хийв.

Нийтийн эрүүл мэнд ба дэлхийн нийтийн эрүүл мэндийн хөдөлгөөн

Хүний эрх, нийтийн эрүүл мэндийн хоорондын харилцаа холбооны талаар ярихаасаа өмнө бид ‘нийтийн эрүүл мэнд’ хэмээх нэр томъёоны үүсэл гарал, өгүүлэх утгын тухай хэдэн үг хэлэх нь зүйтэй юм. Үүслийнх нь тухай ярихад эртний соёл иргэншлүүдийн үеэс хойш олон нийтийн эрүүл мэндийн төлөөх олон түмний хариуцлагын ойлголт оршиж ирснийг бид ойлгож байна. Жишээ нь олон үеийн туршид зохистой эрүүл ахуй нь нийтийн эрүүл мэндийг сайжруулах үндсэн хүчин зүйл болохыг олон соёл иргэншилд мэдэж таньсан байв[6]. Түмэн олны тийм хүчин чармайлтын цогцыг их төлөв ‘нийтийн эрүүл мэнд’ хэмээх нэр томъёогоор илэрхийлдэг байна. Рөүзений хэлснээр орчин үеийн нийтийн эрүүл мэнд нь орчин үеийн аж үйлдвэрийн анхны орон болох 19 дүгээр зууны үеийн Англид анх үүсчээ[7]. Английн тухайн үеийн нөлөө бүхий нэгэн болох Эдвин Чадвик нь утилитарист гүн ухаантан Бентамын нөлөөг ихээхэн авсан хүн бөгөөд эрүүл ажилчин анги байх нь нийгэмд бүхэлд нь ач тустай гэсэн байр суурийг дэмждэг байв[8]. Тэрээр 1834 онд Ядуусын шинэ хуулийг батлахад оролцсон бөгөөд түүгээр Ядуусын хуулийн комисс үүсч, байгаль орчны нөхцөл байдал (усан хангамж, хог хаягдал зайлуулах) болон өвчин хоорондын холбоо хамаарлыг онцолсон илтгэл гаргадаг байжээ[9].

‘Нийтийн эрүүл мэндийн’ асуудал олон улсын хэмжээнд улам бүр хүчээ авав. Арилжаа, тээврийн хөгжлөөс шалтгаалан олон улсын түвшинд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зохицуулалтыг хангаж байх шаардлагатай боллоо. Олон улсын эрүүл мэндийн чиглэлийн байгууллага байгуулах анхны алхамыг 19 дүгээр зуунд хийжээ. Өргөн хүрээтэй Олон улсын ариун цэврийн бага хурлуудыг зохион байгуулснаар Олон улсын нийтийн эрүүл ахуйн газар (ОУНЭАГ) 1907 онд үүсчээ[10]. Үндэстнүүдийн Холбооны ивээлд орсон ОУНЭАГ-аас гадна өсөн нэмэгдэх болсон дэлхий нийтийн эрүүл мэндийн асуудлуудыг илүү зохистой шийдвэрлэх үүднээс ‘Үндэстнүүдийн Холбооны Эрүүл мэндийн байгууллага’ нэртэй өөр нэг байгууллага бий болсон байна. НҮБ байгуулагдах хүртэл энэ хоёр байгууллага зэрэгцэн оршсон юм[11].

1946 онд Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ) бий болж, 61 улс уг байгууллагын үндсэн дүрэмд гарын үсэг зурав. ДЭМБ-ийн үндсэн дүрэмд ‘нийтийн эрүүл мэнд’ гэдэг ойлголтыг илт тодорхойлоогүй боловч, уг байгууллагын цахим хуудаст дараах өргөн утга бүхий тодорхойлолт байна:

Нийтийн эрүүл мэнд гэдэг нь хүн амын дунд бүхэлд нь өвчнөөс сэргийлэх, эрүүл мэндийг хөхиүлэн дэмжих, нас уртасгах (нийтийн ч, хувийн ч) бүхий л зохион байгуулалттай арга хэмжээг хэлнэ. Энэ чиглэлийн үйл ажиллагаа нь хүмүүс эрүүл аж төрөх нөхцөлийг бүрдүүлэх зориулалттай бөгөөд хувь өвчтөн буюу өвчинд биш, нийт хүн амд чиглэсэн ажил байна. Иймд [анагаах ухаанаас ялгаатай нь] нийтийн эрүүл мэнд нь бүх тогтолцоонд анхаарч, тодорхой нэг өвчнийг устгахаар хязгаарлахгүй юм[12]. (дөрвөлжин хаалтан дахь бичвэрийг нэмж оруулсан болно)

Энэ тодорхойлолт нь ‘нийтийн эрүүл мэнд’ өвчтөн хувь хүн буюу өвчинд анхаарахгүй, олон хэмжигдэхүүнийг агуулна гэсэн санаа илэрхийлж байна. ДЭМБ-ын нийтийн эрүүл

мэндийн талаарх ерөнхий үзэл ойлголтоос үзвэл энэ нь дархлаажуулалт, халдварт өвчний хяналт, механикжуулсан тээврийн хэрэгслийн аюулгүй байдал, хөдөлмөрийн эрүүл ахуй, ундны цэвэр ус, эх хүүхдийн эрүүл мэнд, зүрхний титэм судасны өвчин ба саа, тамхидалтаас сэргийлэх арга хэмжээ зэрэг асуудлыг хамарч болох юм[13].

‘Нийтийн эрүүл мэндийн’ үндсэн анхаарал нь дотоодын түвшинд байх боловч, ДЭМБ даяаршлын үр дүнд нийтийн эрүүл мэндэд нөлөөлөх хүчнүүд улсын хилийн чанадаас ирэх боломжтой буюу орж ирдэг болохыг хүлээн зөвшөөрсний үндсэнд ‘дэлхийн нийтийн эрүүл мэнд’ хэмээх томъёоллыг хэрэглэж байна[14]. Дэлхийн нийтийн эрүүл мэндийн нэг чухал хэмжигдэхүүн бол халдварт өвчний тархалт төдийгүй илүү ерөнхийлөн хүний хүчин зүйлээс буюу байгалийн гамшгийн улмаас үүдсэн зэвсэгт мөргөлдөөн, био терроризм, цөмийн аюул зэрэг эрүүл мэндэд хөнөөл бүхий нөлөөлөлд мөн анхаарал хандуулдаг ‘дэлхий нийтийн эрүүл мэндийн аюулгүй байдал’ гэгч юм[15]. Шинэ олон улсын эрүүл мэндийн дүрэмд (ОУЭМД, 2005 онд нэмэлт өөрчлөлт орсноор) энэхүү илүү өргөн арга хандлага тусч өвчний явцуу хүрээнд төдийгүй өргөн хүрээтэй эрүүл мэндийн аюулгүй байдалд заналхийлэх аюулд анхаарах болжээ (Мөн энэ онцгой асуудлын талаар Зидарын бичсэнийг үзнэ үү).

Бүхэлд нь хамралгүйгээр ‘нийтийн эрүүл мэндийн’ талаарх ДЭМБ-ын үзэл ойлголтын нэгэн шинэ хэмжигдэхүүн нийгэм эдийн засгийн тэгш бус байдалд анхаарах тухайд хамаарна. Үүнтэй холбоотойгоор ‘хүмүүсийн төрж, өсч, аж төрж, ажиллаж, өтөлж буй нөхцөл’ гэх мэт ‘эрүүл мэндийн нийгмийн шийдвэрлэх хүчин зүйлс’ гэгчид улам бүр ач холбогдол өгөх болж байна[16]. Өвчин, архаг хууч, хөгжлийн бэрхшээл, мөн түүнчлэн эрүүл мэндийн нийгэм, эдийн засгийн тэгш бус байдал зэрэг нь ерөнхийдөө нийтийн эрүүл мэндийн чухал асуудлыг бүрдүүлж байгааг улам бүр онцлох болов. Энэ маргааны

голлох судлаач болох Лоуренс Гостиноос ишлэвэл:

(...) нийтийн эрүүл мэндийн хэрэглэгдэхүүний багцаас үүдэн гарсан хүн амын түвшний стратеги, бүх нийтэд зориулсан бүрэн боломжтой, хүртээмжтэй, чанартай эрүүл мэндийн үйлчилгээ, эрүүл мэндийн нийгмийн шийдвэрлэгч хүчин зүйлсийг шийдвэрлэх эрүүл мэндийн салбараар хязгаарлагдахгүй өргөн хүрээтэй цогц бодлого зэрэг эрүүл мэндийн наад захын нөхцөлүүдийг бүх нийтэд баталгаажуулахад дэлхий даяараа хүчин чармайлтаа чиглүүлбэл зохино[17].

Үүгээрээ Гостин нийтийн эрүүл мэнд болон чанартай, хүртээмжтэй эрүүл мэндийн үйлчилгээ, мөн бусад эрүүл мэндийн холбогдолтой үйлчилгээ үзүүлэх хэрэгцээ шаардлага хоорондоо холбоотой болохыг тогтоож байна.

Үүнийг хүний эрхийн эрх зүйтэй дахин холбовол: ‘эрүүл мэндийн аюулгүй байдал’, ‘эрүүл мэндийн нийгэм, эдийн засгийн тэгш бус байдалд’ өгсөн энэ ач холбогдлоос үүдэн ‘эрүүл мэндээ хамгаалуулах эрх’ нь ДЭМБ-ын үндсэн дүрэмд зааснаар тэдгээр шаардлагыг олон улсын хэмжээнд хэрхэн батжуулж, бэхжүүлж болох вэ гэсэн асуулт урган гарч байна. Халдварт өвчний тархалтын явцуу асуудалд анхаарах нь хувь хүний иргэний болон улс төрийн эрхтэй зөрчилдөөн үүсгэж болзошгүй юм. Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, эрүүл мэндийн тэгш бус байдлыг шийдвэрлэх нь нөгөөтэйгүүр тийм зөрчилдөөнийг гарцаагүй бий болгохгүй ч иргэний болон улс төрийн эрхээс тусдаа орших эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн гол бүрэлдэхүүнд тулгуурладаг. Энэ нийтлэлийн дүгнэлтэд нотлохын хувьд хэрэв дэлхийн нийтийн эрүүл мэндийн асуудлыг хүний эрхийн өнцгөөс зохистойгоор шийдвэрлэхийг хүсвэл бид хүний эрхэд нэгдмэл байдлаар хандаж, иргэний болон улс төрийн эрх, эдийн засаг, нийгэм соёлын эрхийн аль алиных нь ач холбогдлыг

анхааран хоёр хэмжигдэхүүнийг хоёуланг нь шийдвэрлэх нь зүйтэй юм.

Олон улсын нийтийн эрх зүй дэх ‘нийтийн эрүүл мэндийн’ шаардлага

Эрүүл мэндээ хамгаалуулах эрхэд нийтийн эрүүл мэнд хэрхэн тусдагийг ярилцахын урьд бид нийтийн эрүүл мэнд нь олон улсын нийтийн эрх зүйн бусад хэдэн салбарт хэрхэн туссаныг авч үзэх шаардлагатай байна. Олон улсын эрх зүйд худалдаа, арилжаа, оюуны өмчийн хамгаалал, тээвэр, цэрэг дайны үйлийн ашиг сонирхол зэрэг бусад ашиг сонирхолтой харшуулсан нийтийн эрүүл мэндийн хамгаалалд холбогдох олон заалт, тайлбар бий. Нэг тодорхой жишээ дурдвал Тамхины хяналтын талаарх суурь конвенц удиртгал хэсэгтээ гишүүн улсууд нь нийтийн эрүүл мэндийг хамгаалах эрхдээ тэргүүлэх ач холбогдол өгнө гэж заажээ[18]. Энэ бол талуудын нийтийн эрүүл мэндийг хамгаалах эрмэлзэл болон энэ тохиолдолд тамхины үйлдвэрлэлийн ашиг сонирхол, худалдааны холбогдолтой төрийн ашиг сонирхолтой харьцуулбал ихээхэн жин дарж байгаа энэ ашиг сонирхлыг хамгаалах төрийн үүргийг илэрхийлж байна. Тамхины хяналтын талаарх суурь конвенц нь тамхины хяналттай холбоотой дотоодын хэдэн тохиолдолд тун чухал үүрэг гүйцэтгэсэн болохыг дор өгүүлнэ.

Бүхнийг нуруулгүйгээр энэ хэсэгт олон улсын эрх зүй дэх нийтийн эрүүл мэндийн одоо байгаа зүйл заалтын талаар жишээ татах болно[19]. ДЭМБ-ын хүрээнд батлагдсан Олон улсын эрүүл мэндийн дүрмээс эхлэвэл тэдгээр нь эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн нийтийн эрүүл мэндийн бүрэлдэхүүн хэсэг болон хувь хүний иргэний болон улс төрийн эрхийн хамгааллын хооронд зөрчилдөөн үүсч болзошгүйг илэрхий тусгасан байна. Олон улсын эрүүл мэндийн дүрэм нь эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг тусгаж, нийтийн эрүүл мэндэд үүссэн эрсдлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, түүнд хяналт тавих, хариу үйлдлийг үзүүлэхэд чиглэнэ (2 дугаар зүйл). Үүний зэрэгцээ уг дүрэмд иргэний болон улс төрийн эрхийг

харгалзан үзэж, уг дүрэм нь хүмүүсийн эрхэм зэрэг, хүний эрх, эрх чөлөөг бүрэн хүндэтгэн сахих байдлаар хэрэгжих ёстой гэснээрээ нийтийн эрүүл мэндийн онцгой байдлын үед хүний эрхийг хамгаалахын чухал болохыг онцолсон байна (3-1 дэх хэсэг). Уг баримт бичигт хувь хүний иргэний болон улс төрийн эрхийн талаар хэд хэдэн заалт орсон байна. Жишээ нь ирэх, явах үеийн эрүүл мэндийн арга хэмжээний талаар 23 дугаар зүйлд аялагчдын урьдаас мэдээлэл авч зөвшөөрөл өгөх эрхийг онцлов[20]. Гэхдээ эдгээр эрх хэрхэн бодитоор хэрэгжихийг тодорхой илэрхийлсэнгүй бөгөөд энэ чиглэлд цаашид судлах зайлшгүй шаардлага байна[21].

Нийтийн эрүүл мэндийн хамгаалал нь Дэлхийн Худалдааны Байгууллагын тогтолцоонд зохицуулсанчлан мөн олон улсын худалдааны эрх зүйд тодорхой үүрэг гүйцэтгэнэ[22]. Энд нийтийн эрүүл мэндийн хамгаалал нь худалдааны эрх чөлөө, оюуны өмчийн хамгаалал, ерөнхийдөө арилжааны ашиг сонирхлын эсрэг чиглэнэ.

Олон улсын бараа худалдааг зохицуулсан Тариф, худалдааны ерөнхий гэрээний (ТХЕГ)[23] ХХ(b) хэсэгт хүн, амьтан, ургамалын амь нас, эрүүл мэндийг хамгаалахад шаардлагатай арга хэмжээ авахыг гишүүн улсууддаа зөвшөөрчээ. Энэ заалтад гишүүд нийтийн эрүүл мэндийн асуудалд тэргүүлэх ач холбогдол өгч болохыг тогтоосон байна[24]. Энэ заалтыг маш чухал гэж үзсэн тул, эрүүл мэндийн хамгааллын илүү тодорхой журам тусгасан шинэ гэрээг батласан нь Эрүүл ахуйн болон ургамалын эрүүл ахуйн арга хэмжээний талаарх гэрээ (ЭАУЭАГ) юм. Энэ гэрээгээр хүн, амьтны эрүүл мэндтэй холбоотой ‘эрүүл ахуйн арга хэмжээ’, ургамлын эрүүл мэндтэй холбоотой ‘ургамлын эрүүл ахуйн арга хэмжээг’ зохицуулна.

Дэлхийн худалдааны байгууллагын олон хэрэг маргаанд ТХЕГ-ний ХХ(b) хэсгийн заалтын дагуу авах хамгаалалтын асуудлыг авч үзсэн байдаг[25]. Жишээ нь ЕС-Asbestos –ийн хэрэгт Канад улс хризотил чулуун хөвөнгийн утас болон энэ чиглэлийн чулуун

хөвөн орсон бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдах, тараан борлуулах, оруулж ирэхийг хориглосон Францын хуулийг эсэргүүцсэн байна. Канад улс Францын дээрх хууль тодорхой франц орлуулах бүтээгдэхүүний тусын тулд Канадын чулуун хөвөнг ялгаварлан гадуурхаж байна гэж маргажээ. Дэлхийн Худалдааны Байгууллагын Хариуцлагын болон Давж заалдах хороод хоёулаа Европын Комисс Францын арга хэмжээ нь хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалахад зайлшгүй шаардлагатай байсныг нотолсон гэж үзжээ[26]. Энд бид нэг гишүүн онц хөнөөлтэй байж болзошгүй барааг улс оронд нь өөр нэг гишүүн оруулж ирэх гэснийг таслан зогсоохын тулд нийтийн эрүүл мэндийн шаардлагыг хэрхэн хэрэглэснийг харж болно.

Эдгээр зүйл заалтыг хэрэглэх нь Тариф, худалдааны ерөнхий гэрээний бусад гишүүнд худалдааны сөрөг нөлөөтэй байж болно. Лестерийн хэлснээр гишүүддээ нийтийн эрүүл мэнд болон нийгмийн бусад ашиг сонирхлыг хамгаалахыг зөвшөөрөх, мөн эдгээр бодлогыг бусад гишүүний худалдаа, ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөх байдлаар ашиглахаас урьдчилан сэргийлэх хоёрын хоорондох тэнцвэрийг олох нь чихал юм.27 Энэ заалтыг зөвхөн гишүүн улсын нийтийн эрүүл мэндэд бодит аюул занал байгаа үед л хэрэглэдэг байх нь чухал байна.

Дэлхийн Худалдааны Байгууллагын хууль зүйн тогтолцоон дахь нийтийн эрүүл мэндийн асуудлуудыг авч шийдвэрлэдэг өөр нэг бүтэц нь оюуны өмчийн эрх зүй болон TRIPS гэрээ гэгч баримт бичгийн тухай юм[28]. TRIPS гэрээний нийтийн эрүүл мэндийн нэгэн чухал хэмжигдэхүүний хувьд эмийг энэ гэрээний дагуу патентжуулдаг тул маш олон эм ялангуяа хөгжиж буй орнуудын өвчтнүүд хэрэг дээрээ авч дийлэхээргүй байгаа юм. Худалдааны эрх зүйн нийтийн эрүүл мэндийн бусад хэмжигдэхүүнээс ялгаатай нь хүний эрхийн судлаачид энэхүү патентийн дүрэм болон эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн зөрчилдөөнийг онцгойлон авч үздэг[29]. Олон судлаач,

төрийн бус байгууллага дээрх шударга бус байдлыг шийдвэрлэхэд эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн гүйцэтгэх боломжит үүрэг ролийг судлан үзсэн байдаг[30]. Дэлхийн Худалдааны Байгууллагын хүрээнд ийм баталсан зүйл байхгүй боловч Дохагийн Тунхаглалд уг асуудлыг хүлээн зөвшөөрч байгааг тэмдэглэсэн нь:

Бид TRIPS Гэрээ гишүүдийг нийтийн эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээ авахыг хориг тавихгүй, тэгэх ч ёсгүйг хүлээн зөвшөөрч байна. Мөн түүнчлэн TRIPS Гэрээний хэрэгжүүлэх амлалтаа дахин илэрхийлэхийн сацуу уг Гэрээг Дэлхийн Худалдааны Байгууллагын гишүүдийн нийтийн эрүүл мэндийг хамгаалах, тэр дундаа бүх хүнд эмийн хүртээмж байдлыг хөхиүлэн дэмжих эрхийг дэмжих байдлаар тайлбарлаж, хэрэгжүүлэх боломжтой буюу ёстой болохыг баталж байна.[31]

Тамхины суурь конвенцтэй нэг адилаар, Дохагийн Тунхаглалд нийтийн эрүүл мэндийг хамгаалах гишүүн улсуудын эрхийг хүлээн зөвшөөрчээ.

Нийтийн эрүүл мэндийн хамгаалалтай зөрчил үүсдэг TRIPS Гэрээний өөр нэг хэмжигдэхүүн бол тамхины хяналт юм. Австрали Улс 2011 онд Тамхины савлагааны хуулийг баталж тамхины цулгүй савлагаа буюу худалдааны тэмдэгт, шошгогүй савлагааг нэвтрүүлжээ. Үүний зорилго нь тамхидалтын эсрэг ухуулах байдлаар нийтийн эрүүл мэндийг сайжруулах, ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенцийн дагуу хүлээсэн тодорхой үүрэг хариуцлагаа биелүүлэхэд оршиж байлаа[32]. Австрали Улс Тамхины савлагааны хуулийг баталсантай холбогдуулан Украин, Гондурас, Доминиканы Бүгд Найрамдах Улс, Куба, Индонез улсын гомдол мэдүүлснээр Дэлхийн Худалдааны Байгууллагын таван хэрэг маргаанд хариуцагч болов[33]. Дэлхийн Худалдааны Байгууллагын эрх зүйн хэд хэдэн хэмжигдэхүүн энд хамааралтай байсан ч TRIPS Гэрээ энэ маргаантай тохиолдолд гол үүрэг гүйцэтгэсэн байна. Тухайн тохиолдолд

Австрали Улсын Тамхины савлагааны хууль нь Австрали улсын хилийн гадна бүртгэлтэй барааны тэмдэгтийг хамгаалаагүй бөгөөд тамхитай холбоотой худалдааны тэмдэгтийн хэрэглээнд үндэслэлгүй хориг саад тавьсан гэж маргажээ[34]. Эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн үүднээс үзвэл цулгүй савлагааны тохиолдол бол хүн амынхаа эрүүл мэндийг өөр улсын худалдааны ашиг сонирхлоос (магадгүй хөгжих эрх) хамгаалахыг зорьсон улс орны тод жишээ юм.

Тамхины хяналтын суурь конвенцтой холбогдон Нидерланд улсад гарсан нэгэн сонирхолтой тохиолдлоос нийтийн эрүүл мэндийн ашиг сонирхлыг худалдааны ашиг сонирхлын эсрэг хэрхэн дэнсэлж болохыг харж болно. 2014 оны 9 дүгээр сард ‘засгийн газрын тамхины эсрэг бодлогод үзүүлж буй зохион байгуулалттай тамхины хэт их лоббиг таслан зогсоохын’ тулд Залуучуудын тамхидалтаас урьдчилан сэргийлэх сан Нидерландын вант улсын эсрэг эрх зүйн маргаан эхлүүлжээ[35]. Энэ хэрэг Тамхины хяналтын тухай суурь конвенцийн 5(3) дахь хэсэг болон түүнээс үүдэн гарсан журамд үндэслэсэн байна. Уг журамд төрөөс тамхины эсрэг бодлогоо арилжааны болон тамхины үйлдвэрлэлтэй холбоотой бусад ашиг сонирхлоос хамгаалахыг шаардсан байна. Мөн уг хэрэг Нидерланд улсын үндсэн хууль, тус улсын нэгдэн орсон гэрээнд баталгаажуулсан эрүүл мэндээ хамгаалуулах эрхэд тулгуурласан байна. Нидерланд дахь монист тогтолцооноос шалтгаалан Тамхины хяналтын тухай конвенц ч, бусад хүний эрхийн баримт бичгүүд ч шүүхийн үйл явцад хэрэглэхийн тулд дотоодын хууль тогтоомжид туссан байх шаардлагагүй юм. Уг хэрэг ямар үр дүнд хүрэхээс үл хамааран эндээс ижил төстэй хэргүүдэд нийтийн эрүүл мэндийн ашиг сонирхлыг олон улсын худалдааны ашиг сонирхолтой тэнцвэртэй авч үзнэ гэсэн сонирхолтой прецедент бий болж байна. Энэ нь Тамхины хяналтын тухай суурь конвенц нь нийтийн эрүүл мэндийн хамгаалалд илүү ач холбогдол өгөх нэгэн хүчирхэг хэрэгсэл болж болохыг харуулж байгаа юм. Үүнээс нийтийн эрүүл мэндийн асуудалд

чиглэсэн өөр гэрээ, жишээ нь архаг өвчин дэлхийн хэмжээнд өсөн нэмэгдэж байгаа болон үүнтэй холбоотой хүнс, ундааны үйлдвэрлэлийн эргэлзээтэй үүрэг ролийг шийдвэрлэх баримт бичиг боловсруулах хэрэгцээ байгаа эсэх асуулт гарч ирнэ[36].

Мөн олон улсын хүрээлэн буй орчны эрх зүйд хүрээлэн буй орчин болон эрүүл мэндийн хамгааллын хоорондын холбоо хамааралд улам бүр анхаарал тавих болов[37]. Озоны давхаргыг хамгаалах тухай Монреалийн Протокол (1987 он), Хорт хаягдалын хил дамнуулсан зөөвөрлөлт болон зайлуулалтын хяналтын тухай Бейзеллийн Конвенц (1989 он), Биологийн төрөл зүйлийн талаарх Конвенц (1992 он), Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх НҮБ-ын Киотогийн суурь конвенц (1997 он), Тодорхой химийн хорт бодис, пестицидийг олон улсын худалдаанд урьдчилсан мэдээлэл авсны үндсэнд зөвшөөрөл өгөх журмын талаарх Роттердамын конвенц (1997 он), Тэсвэртэй органик бохирдуулагч бодисын талаарх Стокгольмын конвенц (2002 он) зэрэг хүрээлэн буй орчны талаарх олон талт олон гэрээнд эрүүл мэндийн хамгааллын асуудал тусчээ[38]. Жишээ нь Тэсвэртэй органик бохирдуулагч бодисын талаарх Стокгольмын конвенцод хүний эрүүл мэнд, байгаль орчныг тэсвэртэй органик бохирдлоос хамгаалахыг гол зорилгоо болгосон байна[39]. Фон Шридингийн илэрхийлснээр байгаль орчны гэрээнүүдийг эрүүл мэндийг хөхиүлэн дэмжих зорилгоор хэрэглэж болох юм[40]. Эсрэгээр нь эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг ч мөн олон улсын байгаль орчны эрх зүйн дагуу хүрээлэн буй орчны хамгааллыг дэмжих зорилгоор хэрэглэж болно. Зэвсэгт мөргөлдөөнийг зохицуулсан хууль тогтоомжийн хувьд эрүүл мэндийг хамгаалах тухай олон заалт туссан байдаг. Женевийн Конвенцууд болон нэмэлт Протоколуудад эмнэлгийн үйлчилгээг аюулгүй, тасралтгүй хүргэх, эмнэлгийн ажилтан зэвсэгт мөргөлдөөний үед мэргэжлийн үүднээс төвийг сахих, цэргийн олзлогдогчийн эрүүл мэндийг хамгаалах тухай зэрэг олон зохицуулалт туссан байдаг[41]. Гэвч

нийтийн эрүүл мэндийн хамгаалалд хамгийн хамааралтай нь байгаль орчны хамгаалалд чиглэсэн I Нэмэлт Протоколын 55 дугаар зүйл юм (олон улсын зэвсэгт мөргөлдөөний үед хэрэглэх):

Дайны үед байгаль орчныг өргөн тархсан, удаан хугацааны, ноцтой хохирлоос хамгаалахад анхаарал тавина. Энэ хамгаалалд байгаль орчинд тийм хэмжээний хохирол учруулах, түүгээр хүн амын эрүүл мэнд буюу оршин тогтнолд хөнөөл үзүүлэх зорилготой буюу тэгэх боломжтой дайн байлдааны арга, хэрэгсэл хэрэглэхийг хориглох орно[42].

Зэвсэг эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж чадна гэдэг санаа ч мөн Химийн зэвсгийн тухай конвенц, Биологийн зэвсгийн тухай конвенц зэрэг зэр зэвсгийн тухай конвенцуудын үндэс болж байна[43].

Эцэст нь агаарын эрх зүйд бид агаарын хөлөгт байгаа хүний эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах тухай хэд хэдэн заалт туссаныг харж болно. Жишээлбэл Иргэний агаарын тээврийн тухай конвенцийн 14 дүгээр зүйл өвчний тархалтаас урьдчилан сэргийлэх тухай дараах байдлаар заажээ:

Гэрээ байгуулсан улс бүр урвах тахал, гэдэсний хижиг, салхин цэцэг, чичрэг өвчин, тахал болон гэрээ байгуулагч улсууд үе үе тодорхойлсон бусад халдварт өвчин агаарын нислэгээр тархахаас урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй арга хэмжээ авахаар зөвшөөрөх бөгөөд үүний тулд гэрээ байгуулагч улс агаарын хөлөгт хэрэглэх эрүүл ахуйн холбогдолтой олон улсын зохицуулалтад хамаарах байгууллагуудтай нягт зөвшилцөлд байна[44].

Халдварт өвчнийг тархахаас сэргийлэхийн тулд нисэх буудалд, агаарын хөлөгт авах арга хэмжээ нь зорчигчдын иргэний болон улс төрийн эрхтэй зөрчилдөж боломжтой нь тодорхой байна. Нийтийн эрүүл мэндийг хамгаалах шаардлага болон иргэний болон улс төрийн эрхийн хоорондын зөрчилдөөнийг хожим ярих болно.

Эрүүл мэндээ хамгаалуулах эрх худалдааны болон бусад ашиг сонирхлын эсрэг нийтийн эрүүл мэндийн шаардлага болох нь

Бид одоо дээрх нөхцөл байдлуудад эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг олон улсын эрх зүйн дагуу нийтийн эрүүл мэндийн одоо байгаа шаардлагад хүч нэмж нийтийн эрүүл мэндийн нэмэлт шаардлага болгон тавьж болох эсэх, болох бол хэрхэн яаж гэсэн асуулт руу оръё. Зарчмын хувьд эрүүл мэндээ хамгаалуулах эрх нь засгийн газраас эрүүл мэндээ шаардан тавих хувь хүний эрүүл мэндийн шаардлагыг тусгадаг. Тийм шаардлага нь тодорхой эрүүл мэндийн үйлчилгээ, эм, тийм үйлчилгээний санхүүгийн эргэн төлбөр, мөн эрүүл мэндийн шийдвэрлэгч хүчин зүйлс болох усаар хангагдах, хүрээлэн буй орчны эрүүл мэнд, хөдөлмөрийн эрүүл ахуй болон эрүүл ахуйн холбогдолтой мэдээлэлд хүрэх хүртээмж зэргийг багтаана. Хувь хүний тийм шаардлагаас гадна эрүүл мэндээ хамгаалуулах эрх нь нийтийн эрүүл мэндийн шаардлагыг хамрах эсэх, үүгээрээ төр засгаас үндэсний эрүүл мэндийн бодлого хэрэгжүүлэх, олон нийтийн эрүүл мэндийг бүхэлд нь сайжруулахыг шаарддаг эсэх тухай асуудал үүсч байна. Эрүүл мэндийн салбарын хөгжлөөс шалтгаалан энэ нь мэдээж тун бодитой шаардлага санагдах нь аргагүй. Мейэр, Мори хоёрын хэлснээр бол:

Эмнэлгийн тусламж үйлчилгээ авах хувь хүний эрхэд дагнан найдахын оронд нийтийн эрүүл мэндийн хамтын эрхийн талаар урьдчилан төсөөлснөөр (нийгмийн түвшинд хүний эрхийн үүднээс хэлэлцэж) даяаршлын эрүүл мэндийн шударга бус хөнөөлт үр нөлөөг бууруулах болно[45].

Хэрэв эрүүл мэндээ хамгаалуулах эрх нь нийтийн эрүүл мэндийн шаардлагыг тусган дэлхийн нийтийн эрүүл мэндийн эрх зүйн нэг гол хэм хэмжээ болвол дээр дүрсэлсэнтэй адил тохиолдлуудад түүнийг хэрхэн хэрэгжүүлвэл зохихыг авч үзэх нь чухал байна. Эдгээр жишээнд олон улсын худалдаа, оюуны өмчийн хамгаалал, цэрэг дайны хэрэг зэрэг ашиг

сонирхолтой зөрчилдөж болзошгүй нийтийн эрүүл мэндийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх эсэх тухай асуулт үүдэн гарав. TRIPS-ийн маргаануудаас гадна бол эрүүл мэндээ хамгаалуулах эрх нь тийм ашиг сонирхлуудын эсрэг нийтийн эрүүл мэндийн нэмэлт шаардлагын байр сууринд хараахан хүрээгүй байна. Эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг тийм байр сууринд хэрэглэхийн тулд үүнийг дотоодын зах зээлийг импортын өрсөлдөгч бараа бүтээгдэхүүнээс халхлахын тулд гэх мэт ямар нэг протекционист шалтгааны үүднээс биш зөвхөн цэвэр нийтийн эрүүл мэндийн тусын тулд хэрэглэх нь чухал юм. Үүнтэй холбоотойгоор бусад эрхтэй зөрчил гарч болзошгүйг анхаарвал зохино.

Нийтийн эрүүл мэнд болон худалдааны ашиг сонирхлын хоорондын зөрчлийг жишээ нь нийтийн эрүүл мэнд болон хөгжих эрхийн хоорондын зөрчил гэдгээр тайлбарлаж болно. Нөгөөтэйгүүр эдгээр нийтийн эрүүл мэндийн заалтыг хэрэглэж буй гишүүд үүнийг эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн маргаан гэж тодорхойлж байхад тийм үндэслэлийн улмаас бараагаа борлуулахад нь хориг тавиулсан гишүүд бараагаа экспортлох боломжоо алдсан нь хөгжилд нь саад учруулж буй учир өөрийн ард түмний хөгжих эрхийг онцлон харж болно. Энэ зөрчилдөөн хөгжингүй улс хөгжиж буй орны эсрэг (хөгжих шаардлага) нийтийн эрүүл мэндийн шаардлага хэрэглэсэн нөхцөлд тухайлан ноцтой болж магадгүй юм. Үүнтэй холбоотойгоор Дэлхийн Худалдааны Байгууллагын тогтолцоо болон хүний эрхийн тогтолцооны хоорондох энэхүү эдрээтэй харилцааг дорвитой судлаагүй хэвээр байна.

Иймэрхүй үзэл санааны шинжтэй асуултуудаас гадна мөн шийдвэрлэх шаардлагатай үйл явцын шинжтэй асуудлууд байна. Эрүүл мэндээ хамгаалуулах эрх нь хувь хүний эрхийн хувьд нийтийн эрүүл мэндийн хамтын шаардлагыг хэрхэн тусгах боломжтой вэ гэсэн асуулт гарч ирж байна. Хүний эрхийг бид хувь хүний эрхийн хүрээнд авч үзсэн учир одоо байгаа механизм болон тэдний талаарх өөрсдийнхөө ойлголт төсөөллийг өөрчлөхөд амаргүй байх болно.

Энэ нь гэхдээ одоо байгаа хувь хүний эрх хамтын эрхийн төлөвт огт шилжих боломжгүй гэсэн үг бас биш. Галенкампын авч үзсэнээр, бид эрхийг материаллаг байдлаар бүлгийн хувь гишүүдэд оноож хардаг байхад үйл явцын байдлаар бол хамтаараа санаа тавьдаг[46]. Шүүхийн хариуцлагад хүрэхээр хувь хүний эрхүүдийг холбосон баглаа, багц хэлбэрээр өртсөн бүлгийн ашиг сонирхлыг ойлгох боломжтой санагдана.

Үүнтэй холбогдуулан үүнээс Европын Нийгмийн Хартийн(ЕНХ) хяналтын байгууллага болох Европын нийгмийн эрхийн хороо (ЕНЭХ)-ны хэрэг маргаан зохицуулах хуулийг сөхөж үзэх санаа төрөв.

Үүний хамтын гомдлын механизм нь хүн амын бүлгийн эрүүл мэндийн холбогдолтой ашиг сонирхлыг хэд хэдэн олон улсын төрийн бус байгууллага хамтран өмгөөлөх боломж олгодог юм[47]. Хамтын гомдлын механизмын хувьд энэ нь хүмүүсийн илүү том бүлэг, жишээ нь бичиг баримтгүй цагаачид, эсвэл нутгийн уугуул хүн амын бүлгийг төлөөлж чадна. Энэ хорооны хэрэг маргааны хууль нь бичиг баримтгүй цагаачдын эрүүл мэндийн үйлчилгээ авах боломж, Грек улс дахь уурхайчдын хөдөлмөрийн эрүүл ахуйн асуудал, цыганчуудын эрүүл мэндийн хамгаалал зэрэг олон төрлийн эрүүл мэндийн холбогдолтой асуудлыг хөндөж байсан юм. Жишээ нь, Европын Цыганчуудын Эрхийн Төв болон Болгар улсын хооронд гарсан (ECCCR v. Bulgaria) маргааныг шийдвэрлэхдээ Хороо Болгар Улс дахь Цыганчуудтай холбоотой эрүүл мэндийн тэгш бус байдлын ойлголтыг тодорхой анхаарч үзсэн байна. Үүндээ Хороо Болгар Улс цыган хүмүүст тулгараад байгаа эрүүл ахуйн шаардлага хангахгүй амьдралын нөхцөл, эрүүл мэндийн үйлчилгээ авахад үүсдэг хүндрэлээс нь үүдэн гарсан тодорхой асуудлуудыг шийдвэрлэхийн тулд боломжит алхамуудыг аваагүй байна гэжээ[48].

Энэ бол нийтийн эрүүл мэндийн төлөө тодорхой шаардлага: эрүүл бус амьдралын нөхцөл бол хороо Европын Нийгмийн

Хартийн зөрчил гарсан гэж дүгнэхэд нөлөөлсөн чухал шалтгаан байв. Энэ хорооны шийдвэрүүд нь хууль зүйн заавал биелэх хүчин чадал байхгүй ч өөрийн нөлөөтэй бөгөөд адил төстэй хэргүүдийг шийдвэрлэж буй үндэсний шүүхэд тусах нөлөөтэй байж чадна.

Мөн биддэлхийн болон дотоодын нийтийн эрүүл мэндийн асуудлуудыг хайрцаглах хэм хэмжээ байдлаар эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг хэрэгжүүлэхийн тулд ямар нэгэн зохистой учир байх ёстой гэж дүгнэж болох юм. Хувь хүний эрх болохын хувьд энэ нь ерөнхийдөө хувь хүний эрүүл мэндийн асуудлыг шийддэг. Гэвч бүлгийн ашиг сонирхлыг эрхүүдийн багц болгон эвлүүлэх, мөн хамтын гомдол гарган шийдвэрлүүлэх шүүхийн болон шүүхийн шинжтэй механизм байгуулах боломж бий. Дэлхийн нийтийн эрүүл мэндийн асуудлын ач холбогдлын үүднээс авч үзвэл тийм механизм ихээхэн хэрэгцээтэй байна.

Эрүүл мэндээ хамгаалуулах эрх нь хувь хүний эрхийн эсрэг эрүүл мэндийн аюулгүй байдлын шаардлага болох нь

Дээр харуулсанчлан эрүүл мэндээ хамгаалуулах эрх нь нийтийн эрүүл мэндийн шаардлага байдлаар илэрч болж байхад энэхүү эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн нийтийн эрүүл мэндийн бүрэлдэхүүн хэсэг болон аюулгүй байх, эрх чөлөөтэй байх, бие махбодын хувь халдашгүй байх, хувийн болон гэр бүлийн амьдралтай байх эрх зэрэг иргэний болон улс төрийн эрхийн хооронд зөрчилдөөн байж болохоос гадна мөн эрүүл мэндийн хамгийн боломжит сайн үйлчилгээ авах эрхтэй ч зөрчилдөөн үүсч болно. Халдварт өвчний тархалт энэхүү зөрчилдөөн хэрхэн үүсч болдогийн илэрхий, бат нот жишээ болж байхад болзошгүй мөргөлдөөн хүн дээр туршсан био эмнэлгийн судалгаа хийдэг тогтолцоонд, мөн био сангийн хэрэглээ, эмийн туршилт, (албадан) вакцинжуулалт, (хүсэлтгүйгээр) баримт мэдээллийн сан үүсгэх зэргийн тухайд гарч болох юм[49]. Тийм зөрчилд хүргэдэг хатуу арга хэмжээнд цагдан болон хөл хорио,

өвчний албадлагын болон хүсэлтгүйгээр оношлох арга хэмжээ ордог. Тийм үйлдлийг эрүүл мэндийн үйлчилгээний байгууллагаас гадуур, жишээ нь шорон, хилийн саатуулах төвд явуулах магадлал бий нь тодорхой.

Энэ нь эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг (эсвэл нийтийн эрүүл мэндийн шаардлага) төр засгийн эрүүл мэндийн тодорхой үйл ажиллагааг зөвтгөхийн тулд хэрэглэвэл болгоомжлох нь зөв гэсэн үг[50]. Төр эрүүл мэндээ хамгаалуулах эрхэд үндэслэн эрүүл мэндийг хамгаалах үүрэгтэй боловч тиймэрхүү арга хэмжээгээ хувь хүний эрх, ашиг сонирхолтой тэнцвэртэй байдлаар хэрэгжүүлэх хэрэгтэй. Эндээс над нийтийн эрүүл мэндийн төлөө хувь хүний эрхийг түдгэлзүүлж болох эсэх, хэрэв болдог бол ямар хэмжээнд, хүрээнд, түүний хэрэгжилт байж болох вэ гэсэн асуулт гарч байна. Үүгээр би хүний эрхийн түдгэлзэл, хязгаарлалтын талаарх талбарт орж ирж байна. Энэ бол олон хэмжигдэхүүнтэй ярвигтай талбар юм.

Эрхийг түдгэлзүүлэхээс эхлэх нь: Европын хүний эрхийн конвенц (ЕХЭК), Иргэний болон улс төрийн эрхийн талаарх олон улсын пакт (ИУТЭОУП)-ын аль аль нь гишүүн улсуудыг гэрээгээр хүлээсэн үүргээ онцгой нөхцөл байдалд тохируулах боломж олгодог түдгэлзэх тогтолцоогоор хангаж өгсөн байна[51]. Эдгээр арга хэмжээ нь шинж чанарын хувьд түр зуурын шинжтэй бөгөөд зөвхөн зэвсэгт мөргөлдөөн, иргэний болон нийгмийн тогтворгүй байдал, хүрээлэн буй орчны болон байгалийн гамшиг, нийтийн эрүүл мэндийн онц байдал үүссэн зэрэг улс үндэстний амьдралд ноцтой аюул учрахад зэрэг онцгой нөхцөлд л зөвшөөрөгдөнө[52]. Хязгаарлалтаас ялгаатай нь тохируулан бууруулах арга хэмжээ нь эрхийн агуулгыг бүхэлд нь түдгэлзүүлэхэд хүргэдэг. Гэхдээ ИУЭОУП болон ЕХЭК-г амьд явах эрх, эрүү шүүлтгийг хориглох, боолчлолыг хориглох зэрэг бууруулж болохгүй хязгаарлагдмал тооны багц эрхийг зааж өгчээ[53]. Энэ нь онц байдал зарласан үед ихэнх эрхийг түдгэлзүүлж болохоор байхад тодорхой тооны эрхийг огт хөндөлгүй орхино гэсэн үг юм.

Энэ нийтлэлийн зориулалт ёсоор улс үндэстний амьдралд аюул заналхийлсэн нийтийн эрүүл мэндийн онц байдал гарсан тохиолдолд тиймэрхүү бууруулалтын үр дагавар ямар байхыг таамаглах нь чухал байна. ДЭМБ 2014 оны 8 дугаар сарын 8-ны өдөр Баруун Африкт гарсан Эболагийн дэгдэлт бол онцгой үйл явдал бөгөөд бусад улсад нийтийн эрүүл мэндэд эрсдэл үүсгэж байна хэмээн албан ёсоор зарлажээ[54]. Үүнд хамрагдсан орнууд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад ИУТЭОУП-д дурдсан эрхүүдийг түдгэлзүүлсэн талаар албан ёсоор мэдээлээгүй боловч [55] өвчтөн хувь хүний эрхийн өнцгөөс харвал тийм түдгэлзэл нь ямар үр дагавартай байж болзошгүй вэ гэсэн асуулт гарч байна. Үүнтэй холбогдуулан ИУТЭОУП, ЕХЭК-оос түдгэлзэх нь зарчмын хувьд эрх чөлөөтэй байх, аюулгүй байх, хувийн болон гэр бүлийн амьдралтай байх эрхүүдийг түдгэлзүүлсэн гэсэн үг болохыг тэмдэглэх нь зүйтэй.

Эболагийн хямралын үеийнх шиг гэх мэт эрүүл мэндийн үйчилгээний байгууламжуудад энэ нь өвчтнүүдийн хувь хүний эрхийг бүхэлд нь хүчингүйд тооцож болно гэсэн үг. Үүнээс үүдээд хувь хүмүүст чанга хатуу, магадгүй шаардлагагүй хориг хязгаар тавих нөхцөл үүсч болох юм. Энэ бол хүний эрхийн судлаачид судлууштай зөрчилдөөн юм.

Түдгэлзэл нь хүний эрхийг ор тас хайхрахгүй орхиход хүргэдэг байхад хязгаарлалт нь эрхийн мөн чанарыг хөндөхгүй бөгөөд болзошгүй хязгаарлалт нөлөөлөхгүй гэсэн агуулгатай байдаг.

ИУТЭОУП, ЭЗНСЭОУП, ЕХЭК-д туссан эрхүүдийг тухайн гэрээнд нь жагсаасан үндэсний аюулгүй байдал, нийгмийн аюулгүй байдал, нийтийн дэг журам, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, ёс суртахуун болон эрүүл мэндийн зэрэг тодорхой хууль ёсны зорилгоор хязгаарлаж болдог[56]. ИУТЭОУП-ын хүрээнд энэ тэнцвэржүүлэх үйлдлийг хүч нэмэгдүүлэхийн тулд, эрх хязгаарлах талаар НҮБ-ын Сиракузагийн

Зарчмаар зарим хэрэгтэй заавар өгсөн байна. Энэ багц журам зааврыг 1984 онд олон улсын эрх зүйн 31 эксперт хамтран боловсруулжээ. Энд ИУТЭОУП-ын дагуу хязгаарлалт, түдгэлзлийг хэрэглэх зааварчилгаа өгсөн ч хүртээмж, хамрах хүрээ нь илүү өргөн байж болох юм. Үүний 10 дахь хэсэгт:

10. Хязгаарлалт Пактын томъёолсны дагуу 'зайлшгүй' байхыг шаардах бүрт, энэ томъёолол нь хязгаарлалт:

(a) Пактын холбогдох зүйлд заасан хязгаарлах үндэслэлийн аль нэгд тулгуурласан,

(b) нийтийн буюу нийгмийн онц чухал хэрэгцээнд чиглэсэн,

(c) хууль ёсны зорилготой,

(d) тухайн зорилгодоо тохирсон хэр хэмжээтэй байх ёстой гэжээ.

Мөн 25 дахь хэсэг нь тусгайлан нийтийн эрүүл мэндийг хөндсөн нь:

Нийтийн эрүүл мэндийг төрөөс хүн амын буюу хүн амын хувь гишүүдийн эрүүл мэндэд заналхийлэх ноцтой аюулыг шийдвэрлэх арга хэмжээ авахын тулд тодорхой эрхийг хязгаарлах үндэслэл болгон хэрэглэж болно. Эдгээр арга хэмжээ нь өвчин буюу гэмтлээс урьдчилан сэргийлэх, эсхүл өвчтөн, гэмтсэн хүнд тусламж, үйлчилгээ үзүүлэхэд тухайлан чиглэсэн байх ёстой. [ач холбогдол нэмсэн]

26 дахь хэсэгт тодруулсан нь:

Дэлхийн Эрүүл мэндийн Байгууллагын Олон улсын эрүүл мэндийн дүрэмтэй зохих хамааралтай байна.

Сиракузагийн Зарчим нийтийн эрүүл мэндийн заалтуудын хэрэглээг өвчин тархахаас урьдчилан сэргийлэхээр тусгайлан авах арга хэмжээгээр хязгаарлаж, Олон улсын эрүүл мэндийн дүрэмтэй холбох холбоог тодорхойлдог байна[57].

Үүнээс гадна Европ тив дэх хүний эрхийн хамгийн нөлөөтэй гэрээ болох Европын Хүний эрхийн Конвенцийг авч үзэх хэрэгтэй.

Европын хүний эрхийн шүүх (ЕХЭШ)-ийн хэрэг маргаан шийдвэрлэх хууль нь зөвшөөрөл, хувийн амьдралын эрх зэрэг өвчтөний эрхэд улам бүр анхаарах болжээ[58]. Түүгээр зогсохгүй дээр өгүүлсэнчлэн ЕХЭШ нь олон хэрэг маргаанд хязгаарлах заалтууд, халдашгүй байх болон хувийн амьдралтай байх эрхийн хязгаарлалт нь эрүүл мэндийн үйлчилгээний бүтэц, хорих газрын нөхцөлд хэрхэн хэрэгжих вэ гэдгийг үнэлж байсан болно.

ИУТЭОУП-тай төстэй нь ЕХЭК нь улс орнууд хууль ёсны зорилго буюу конвенцийн 8-11 дүгээр зүйлд болон 4 дүгээр Протоколын 2 дугаар зүйлд тодорхойлсон зорилгыг хэрэглэж болно гэж заажээ. ‘Хууль ёсны зорилго’ хэмээх заалт нь бусад зорилгын дунд эрүүл мэнд буюу ёс суртахууны хамгааллыг багтаадаг. Ван Дийк болон Ван Хүүф-ийн тэмдэглэсэнээр, Старсбург дэх шүүх хууль ёсны зорилгын стандартаар конвенцод туссан эрхийн зөрчил гарсныг барагтай л бол тогтоож байгаагүй юм. Нэг шалтгаан нь энэ стандартын үнэлгээ ‘ардчилсан нийгэмд зайлшгүй’ хэмээх гурав дахь стандарттай холбож ялангуяа хэр хэмжээний хэрэглээгээр хэрэгждэгээрээ зарим талаар нийтлэг түгээмэл байдгаас шалтгаалдаг байж болно[59].

Гэхдээ энэ онцгой асуудлаар өмнө Санден, Бахман нарын сөхөж байсанчлан, ЕХЭШ хэд хэдэн хэрэг дээр халдварт өвчтэй хүнийг хорих талаар авч үзэж байсан билээ. Санден, Бахман нар энэ талаар их өргөн хүрээтэй олон хэргийг өгүүлдэг юм.

Ноён Энхорни Шведийн эсрэг хэмээх гол хэрэгт жишээ нь ЕХЭШ ЕХЭК-ийн 5(1) дэх хэсгийн бие махбодын хувьд эрх чөлөөтэй, халдашгүй байх эрхийн цар хүрээг ХДХВ-ийн халдвартай хүнийг заавал хорих үүднээс авч үзсэн юм[60]. Шүүхээс дараах байдлаар тогтоожээ:

Халдварт өвчнийг тархахаас урьдчилан сэргийлэхийн тулд хүнийг хорих хууль зүйн үндэслэлийг үнэлэх эн тэргүүний шалгуур

нь халдварт өвчин тархах нь нийтийн эрүүл мэнд болон аюулгүй байдалд заналхийлэх эсэх, мөн үүнээс хөнгөн арга хэмжээг үзээд нийтийн ашиг сонирхлыг хамгаалахад хангалтай биш гэж тогтоосны үндсэн дээр халдвартай хүнийг хорих нь халдвар тархахаас сэргийлэх эцсийн арга хэмжээ мөн эсэхээс хамаарна[61]. (ач холбогдол нэмэгдсэн)

Нийтийн эрүүл мэндийн шалтгаанаар хорихыг эцсийн гарц гэж харсан бол шүүх Сиракузагийн Зарчмаас илүү чанга хандлага баримтлах байсан бололтой. Энэ тохиолдолд арай зөөлөн арга хэмжээг авч үзээгүйгээс үзвэл шүүх ноён Энхорныг хорих нь эцсийн гарц гэж үнэмшээгүй байна[62].

Нэг жил зургаан сар хорих болсноор Шведийн эрх баригчид өрсөлдөх ашиг сонирхлын хооронд шударга тэнцвэрийг бариагүй болохыг тэмдэглэжээ. Шүүхийн ойлгосноор энэ хорих хугацаа нь ДОХ-ын вирус тархахаас урьдчилан сэргийлэх нийгмийн хэрэгцээ шаардлагад хангалттай дүйцэхгүй байжээ[63].

Өмнө дурдсанчлан эрх хязгаарлах нь хүн оролцуулсан био анагаах ухааны туршилт, био-банкийн хэрэглээ, эмийн туршилт, (албадан) вакцинжуулалт, (хүсэлтээс гадуур) баримт мэдээллийн сан гэх мэт нийтийн эрүүл мэндийн асуудлуудад үүрэг гүйцэтгэж болох юм. Энэ талбарт чиглэл буюу санаа өгч болох нэгэн чухал Европын баримт бичиг бол 1997 онд Европын Зөвлөлөөс баталсан Хүний эрх болон био эмийн Европын Конвенц (‘Овиздогийн конвенц’) болон түүний хувилах, шилжүүлэн суулгах, био эмнэлгийн судалгаа болон эрүүл мэндийн зоилгоор ерөнхий туршилт хийх тухай нэмэлт протоколууд нь юм[64]. Хязгаарлалтын хувьд энэ гэрээ нь ЕХЭК-д байдаг хязгаарлалтын тухай заалттай адил төстэй заалтыг 26 дугаар зүйлдээ тусгажээ. Гэхдээ энэ заалт нь Био эмнэлгийн конвенц дахь хэд хэдэн зүйлд хамааруулалгүй, хязгаарлалт, түтгэлзүүлэшгүй эрхийн

хооронд сонирхолтой холимог бий болгосон тул эрх хязгаарлах харьцангуй цөөн боломжийг гишүүн улсуудад олгожээ[65].

Санаа зовох нэгэн чухал онцгой асуудал бол хөгжиж буй улсуудад хүн дээр хийдэг клиник туршилтыг тойрсон ёс зүйн болон хууль зүйн асуудал байна. Өрнөдийн байгууллага, компаниуд сүүлийн жилүүдэд хөгжиж буй орнуудыг туршилтын газар болгон ашиглах нь ихэслээ[66]. Тэр дундаа дээр дурдсан Европын Зөвлөлийн био эмнэлгийн судалгааны талаарх протокол нь 3 дугаар зүйлдээ ‘судалгаанд оролцож буй хүн төрөлхтний ашиг сонирхол, эрүүл мэнд нь нийгмийн буюу шинжлэх ухааны гол ашиг сонирхлоос дээгүүр байна’ [67] гэжээ. Энэ гэрээ, нэмэлт протоколуудыг сахин биелүүлэхэд хяналт тавих механизм байхгүй байгаагаас энэ баримт бичиг практикт хэрхэн хэрэгжиж болохыг урьдаас төсөөлөхөд хэцүү юм. Гэхдээ тийм туршилтад оролцож байгаа ялангуяа хөгжиж буй оронд буй хүмүүсийн эрхийг хамгаалах зорилгоор энэ баримт бичгийн хамрах хүрээ, чадамжийг нарийн шинжлэн судлах нь үр бүтээлтэй ажил болох билээ.

Эцэст нь эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг өөрийг нь хязгаарлах боломжид бас анхаарал хандуулах нь зүйтэй. Дээр хэлсэнчлэн эрүүл мэндээ хамгаалуулах эрх нь нийтийн эрүүл мэндийн шаардлага байдлаар хамтаар эдлэвэл хувь хүний хамгийн боломжит эрүүл мэндийн үйлчилгээ авах эрхтэй, өөрөөр хэлбэл эрүүл мэндээ хамгаалуулах хувь хүний эрхтэй зөрчилдөнө. Тийм учраас эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн мөнөөх хамтын хэмжигдэхүүн нь магадгүй эрүүл мэндээ хамгаалуулах хувь хүний эрхтэй зөрчилдөнө. Халдварт өвчин нийтийн эрүүл мэндэд аюул болж заналхийлэх нөхцөлд өвчтөн хувь хүний хэрэгцээ шаардлагыг хайхрахгүй өнгөрөх нь хялбар байх юм. Эдийн засаг нийгмийн эрхийг хязгаарлах нь тухайн эрхэд хамаатай мөн уг чанар буюу угийн хариуцлагад нөлөөлөх ёсгүй гэсэн ойлголтод анхаарах нь ихсэх болжээ[68].

Эндээс нийтийн эрүүл мэндийн ашиг сонирхлын үүднээс арга хэмжээ авч байгаа нөхцөлд зайлшгүй шаардлагатай эрүүл мэндийн үйлчилгээ авах хувь хүний эрхэд нөлөөлөх ёсгүй болох нь харагдаж байна. Хэрэв энэ хандлагыг мөнөөх Эболагийн хямралын агуулгын хүрээнд авч тавьбал нийтийн эрүүл мэндийн тусын тулд хэрэгжих хөл хорио нь хөл хоригдсон хүмүүсийн наад захын эмнэлгийн тусламж үйлчилгээ авах эрхийг тасралтгүй хэрэгжүүлэх боломж өгөх ёстой гэсэн утга илэрхийлэх юм.

Түүнээс гадна ЭЗНСЭОУП дахь эрүүл мэндээ хамгаалуулах эрх гэх мэтийг хамруулсан хязгаарлалтын тогтолцоог ажиглах нь үр бүтээлтэй ажил болно. Эрүүл мэндээ хамгаалуулах хувь хүний эрхийг нийтийн эрүүл мэндийн төлөө хязгаарлаж болох уу? ЭЗНСЭОУП-ын 4 дүгээр зүйлд дараах хязгаарлах заалт оржээ:

Аливаа улсаас энэхүү Пактын дагуу хангах ёстой эрхийг эдлүүлэхдээ эдгээр эрхэд зөвхөн хуульд тодорхойлсон ёсоор хязгаарлалт тогтоож болох бөгөөд энэ нь эдгээр эрхийн уг чанарт нийцсэн, ардчилсан нийгэмд гагцхүү нийтийн сайн сайхан байдалд туслах зорилготой байх ёстой гэдгийг энэхүү Пактад оролцогч улсууд хүлээн зөвшөөрнө.

Эрхийн шинж чанарын ойлголтод эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн мөн чанартай төсөөтэй зүйл байна. Эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн талаарх 14 дүгээр Ерөнхий тайлбарт 4 дүгээр зүйл нь ерөнхийдөө дараах зорилгыг агуулсан гэсэн нь:

Төрөөс хязгаарлалт тавихыг зөвшөөрөх гэхээсээ илүүтэй хувь хүний эрхийг хамгаалахад оршино. Тиймээс жишээ нь ХДХВ(ДОХ мэт халдварт өвчтэй хүмүүсийн чөлөөтэй зорчихыг хориглох буюу хорионд хийж, эмчид засгийн газрыг эсэргүүцсэн гэх хүмүүсийг эмчлэхийг зөвшөөрөхөөс татгалзсан,

эсхүл үндэсний аюулгүй байдлын үүднээс буюу нийтийн дэг журмыг сахиулахын тулд олон түмний халдварт өвчний эсрэг дархлаажуулалт явуулаагүй гишүүн улс 4 дүгээр зүйлд тодорхойлсон элемент бүртэй холбогдуулан тийм ноцтой арга хэмжээ авсны үндэслэлийг тайлбарлах үүрэгтэй[69]. (ач холбогдол нэмсэн)

Тиймээс авсан арга хэмжээнийхээ үндэслэлийг тайлбарлах төрийн хувьд энэ заалтын хязгаарласан тайлбараа нотлох үүрэг хариуцлага юм. Эрүүл мэндийн наад захын буюу үндсэн үйлчилгээ авах эрхийг хөндөлгүй орхих нь зүйтэй гэж илэрхий илтгэсэн байдаг. Цаашилбал 14 дүгээр Ерөнхий тайлбарт төр нийтийн эрүүл мэндийн хязгаарлалт тавихдаа тийм арга хэмжээ авах нь хууль ёсны зорилгын тусын тулд байна гэдгийг нотлох байдлаар үндэслэлийг нь тайлбарлах учиртайг дараах байдлаар тайлбарлажээ:

Тийм хязгаарлалтыг Пактаар хамгаалагдсан эрхийн мөн чанарт нийцүүлэн олон улсын хүний эрхийн стандарт зэрэг хуульд зааснаар, хууль ёсны зорилгын дагуу тавьсан ашиг сонирхлын тулд ардчилсан нийгмийн нийтлэг сайн сайхныг хөхиүлэн дэмжих зайлшгүй шаардлагаар хэрэгжүүлэх ёстой.

Энэ илэрхийлэл нь ИУЭОУП-ын дагуу орсон хязгаарлалтын заалтууд дахь хэл найруулга, хандлагатай маш төстэй байна.

Товчхондоо хүний эрхийн эрх зүйд нийтийн эрүүл мэндийн төлөө тавьсан нийтийн эрүүл мэндийн хязгаарлалт нь хувь хүний эрхийн шинж, мөн чанартай зөрчилдөх ёсгүй, хэр хэмжээ нь таарсан, хууль ёсны зорилгод чиглэж, зөвхөн ардчилсан нийгмийн ашиг сонирхлын тусын тулд авсан байх ёстой гэсэн ерөнхий ойлголт байгаа санагдана. Бүхэлдээ нийгэм дэх олон нийтийн эрүүл мэндийн ашиг тусад чиглэсэн арга хэмжээ авах үедээ эдгээр шаардлагыг харгалзан үзэх юм байна.

Нийтийн эрүүл мэнд ба хүний эрх: тэнцвэртэй харилцаанд зорих нь

Бид өвчний хэлбэр өөрчлөгдөх, тэр дундаа зарим нь аж төрөх хэвшилтэй холбоотой байх, мөн улс орнуудын хоорондох эрүүл мэндийн тэгш буй байдал ихэсч байгаа гэхчлэн дотоодын болон дэлхий нийтийн эрүүл мэндийн чиглэлд олон тооны хүнд сорилтуудыг үзэж байна. Түүгээр зогсохгүй олон орон хүрээлэн буй орчны доройтол, уур амьсгалын өөрчлөлт, олон улсын хэмжээний шилжилт хөдөлгөөн, хотжилт, дотоодын зөрчил мөргөлдөөний эрүүл мэндэд үзүүлэх хортой нөлөөтэй тэмцэлэх ажээ. Энэ бүхэн нь дэлхий даяар хувь хүний, мөн ялангуяа орхигдсон, ядуу хүмүүсийн эрүүл мэнд, сайн сайханд нөлөөлж байна. Хүний эрхийн өнгөөс харвал хүний эрх нь хувь хүний эрхийг хүндэтгэн сахихын зэрэгцээгээр нийтийн эрүүл мэндийг хэрхэн үр нөлөөтэй дээшлүүлж болох вэ гэсэн асуулт урган гарна.

Эрүүл мэндээ хамгаалуулах эрх нь дэлхий нийтийн болон дотоодын нийтийн эрүүл мэндийг хамгаалахад хоёрдмол боловч улам бүр амин чухал болох үүрэг гүйцэтгэдгийг дээр тайлбарласан билээ. Гэхдээ эрүүл мэндээ хамгаалуулах эрх нь эрүүл мэндийн шаардлагыг хүч нэмэгдүүлэх байдлаар энэхүү ашиг сонирхлыг худалдааны, оюуны өмчийн хамгаалал, цэрэг дайны үйлийн ашиг сонирхолтой тэнцвэржүүлж болохоор байна. Энэхүү эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн ирээдүйд гүйцэтгэх бололцоотой үүрэг рольд илүү няхуур анхаарал хандуулах нь чухал байна. Эрүүл мэндээ хамгаалуулах эрх нь ерөнхийдөө хувь хүний эрх байхын зэрэгцээ хамтаараа эдэлдэг хувь хүний эрхүүдийн баглаа холбоос гэж томъёолох боломж бий. Ингэж ойлгосноор энэ эрх нь жишээ нь тамхины үйлвэрлэл, цэрэг дайны үйлийн ашиг сонирхол, хүрээлэн буй орчны бохирдлын сөрөг үр нөлөө, эсвэл бохирдол үүсгэгч тодорхой үйлдвэрлэлийн эсрэг тавих хамтын шаардлагын үүрэг гүйцэтгэж болно.

Мөн түүний зэрэгцээ энэ нь халдварт

өвчнөөс урьдчилан сэргийлэх зэрэг эрүүл мэндийн аюулгүй байдлын асуудал чиглэж байхад эрүүл мэндээ хамгаалуулах эрх буюу нийтийн эрүүл мэндийн шаардлага өвчтөний болон бусдын хувь хүний эрхүүдийн хооронд зөрчил гарах магадлал бий. Тийм нөхцөлд хувь хүн хувийн амьдралтай байх, эрх чөлөөтэй байх эрхтэй боловч мөн хамгийн боломжит эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах эрхтэй байдаг. Бид бүгд Баруун Африк Эболагийн сүүлийн хамгийн том дэгдэлтээс үүдсэн ноцтой сорилтыг даван туулах гэж байгааг айдаст автан ажиглаж байв[70]. Эдгээр болон мөн адил төстэй дэгдэлтүүд нь хүний эрхийн эрх зүйн дагуу ихээхэн хүчирхэг бэрх нөхцөлийг бий болгож байлаа. Гэтэл нийтийн эрүүл мэндийг хамгаалах шаардлага, мөн тэдгээртэй зэрэгцэн олон нийтийн эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг хамгаалах хууль зүйн хариуцлага байдаг. Нөгөөтэйгүүр өвчтөн, түүний гэр бүлийн хувь хүний эрхийг хүндэтгэн сахих шаардлага ч байна.

Дээрх Эболагийн дэгдэлттэй холбогдуулан Хүний эрхийн манаач (Human Rights Watch) хүний эрх, хуваагдашгүй, харилцан хамааралтай, уялдаатай болохыг чухалчлан эдийн засаг, нийгэм, соёлын эрх, иргэний болон улс төрийн эрхэд анхаарч хүний эрхийн эрх зүйд нэгдмэл арга хандлага хэрэглэж байгааг ажиглахад сонирхолтой байна[71]. Нөгөөтэйгүүр эрүүл мэндийн ажилтнуудыг халвараас хамгаалах, хөл хорионы хэрэглээг хязгаарлах, өвчний дэгдэлтийн үеийн жендэрийн хэмжигдэхүүнийг шийдвэрлэх, хямралыг зохицуулах аюулгүйн хүчин наад захын эрхийг хүндэтгэн сахих баталгааг хангах хэрэгцээний ач холбогдлыг онцолж эрүүл мэндээ хамгаалуулах эрхэд хандуулж байна. Хүний эрхийн манаач (Human Rights Watch) байгууллага ‘донор засгийн газрууд олон улсын туслалцаа, хамтын ажиллагаагаар эдгээр засгийн газруудад эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг хангах, тахлын илүү өргөн үр нөлөөг шийдвэрлэх хүчин чармайлт гаргахад нь дэмжлэг үзүүлэх нь зүйтэй’ гэжээ[72]. Мөн түүний зэрэгцээ энэ байгууллага ‘олон улсын хүний эрхийн

эрх зүйгээр нийгмийн онц байдлын нэрийн өмнөөс хүний эрхийг хязгаарлахдаа хууль ёсны бөгөөд баримт нотолгоонд суурилсан, хэр хэмжээ нь тохирсон байхыг шаарддаг’ болохыг онцолж иргэний болон улс төрийн эрхэд хандуулж байна. Энэ агуулгын хүрээнд дээрх өвчний дэгдэлтийн үед тогтоосон хөл хорио нь дээрх шаардлага, стандартад нийцэхгүй байгаад зовниж байгаагаа илэрхийлж байна[73].

Ийм хүний эрхийн нэгдмэл хандлага нь иргэний болон улс төрийн эрх, эдийн засаг, нийгэм соёлын эрхийг аль алийг нь харгалзан үзсэнээрээ нийтийн эрүүл мэндийн асуудал үүсэхэд, ялангуяа эрүүл мэндэд заналхийлэл учрах үед хамгийн тэнцвэртэй хариу арга хэмжээ мэт санагдана. Дээр өгүүлсэнчлэн эрхүүдийн хооронд зөрчилдөөн гарвал, одоо байгаа хязгаарлалтын болон хэсэгчлэн бууруулах заалтууд, одоо бэлэн байгаа заавруудын хүрээнд эрхүүдийн тэнцвэрийг хянуур тогтоосон байна. Хүний эрхийн тогтолцоонд бүхэлд нь эрх бууруулах зохицуулалтын илүү нарийн боломжоор өвчтөний эрхийг, тэр дундаа эрх чөлөөтэй байх, хувийн болон гэр бүлийн амьдралтай байх эрхийг бүрэн хязгаарлаж болохыг ойлгож авах нь чухал юм. Эдгээр стандартын дунд уялдаа бий болгох, эдгээр хязгаарлалтыг хэрхэн зүй зохистой хэрэглэх талаар гүнзгий ойлголтод хүрэхийн тулд нэмэлт судалгаа хийх шаардлага байна.

Талархал

Би Лора Ниада болон Андраз Зидар нарт санал, сэтгэгдлээ хуваалцан тусласанд талархал илэрхийлж байна. Мөн Гронингений их сургуулийн Хууль зүйн факультетийн Олон улсын тэнхмийн хамтран зүтгэгчид, ялангуяа Андре Хүүг, Антенор Халло де Вольф нарт үнэтэй зөвлөгөө өгсөнд баярлаж байна. Мөн энэ нийтлэлийн эхний хувилбарт хэл зүйн санал зөвлөгөө өгсөнд Каролин Галагхерт талархсанаа илэрхийлье.

Тодруулах нь

Энд зохиогч сонирхлын зөрчилтэй зүйл тусгаагүй болно.

Ишлэл

1. Inter alia, Brigit Toebes, Mette Hartlev, Aart Hendriks, and Janne Rothmar Herrmann, eds, *Health and Human Rights in Europe* (Cambridge: Intersentia, 2012), 101–2.

2. See, for example, Thérèse Murphey, *Health and Human Rights* (Oxford: Hart, 2013), in particular Chapter 2: ‘Is Human Rights Prepared?’, 58.

3. See, also, the interesting observations by Murphey, who speaks about ‘human rights preparedness’. Ibid., inter alia at 72.

4. JALI Health, Joint Action and Learning Initiative on National and Global Responsibilities for Health, <http://www.jalihealth.org> (accessed 18 August 2014). See also JALI (FCGH Research Questions, January 2014 update, [http://www.jalihealth.org/research/docs\(JALI%20Research%20Questions.pdf](http://www.jalihealth.org/research/docs(JALI%20Research%20Questions.pdf) (accessed August 2014). The International Journal of Human Rights 501 Downloaded by [124.158.88.13] at 01:44 04 February 2016

5. Lawrence O. Gostin, *Global Health Law* (Cambridge, MA: Harvard University Press, 2014), 20–31.

6. George Rosen, *A History of Public Health* (Baltimore, MD: John Hopkins University Press, 1993), 2–3, originally published in 1958 by MD Publications Rosen.

7. Rosen, *A History of Public Health* (1993), 170. See also Brigit Toebes, *The Right to Health as a Human Right in International Law* (Antwerpen: Intersentia (Hart 1999), 8–11.

8. H.E. Sigerist, *Medicine and Human Welfare* (New Haven, CT: Yale University Press (Oxford University Press, 1941), 90.

9. Rosen, *A History of Public Health* (1993), 176 and 196–8.

10. H.D.C. Roscam Abbing, *International Organizations in Europe and the Right to Health Care* (Deventer: Kluwer, 1979), 91. See also Toebes, *The Right to Health as a Human Right in International Law*, 12.

11. Toebes, *The Right to Health as a Human Right in International Law*, 11–13.

12. WHO, *Public Health*, [http://www.who.int/trade/glossary/story076\(en\)](http://www.who.int/trade/glossary/story076(en)) (accessed May 2014).

13. Ibid.

14. Ibid.

15. WHO, ‘The World Health Report 2007: A Safer Future-Global Public Health Security in the 21st Century’, [http://www.who.int/whr\(2007\(en\)\(accessed September 2014\)](http://www.who.int/whr(2007(en)(accessed September 2014)). Sophie Harman, *Global Health Governance* (Routledge Global Institutions Series, No. 60, 2012), 19–23. See also Global Health Security Initiative, [http://www.ghsi.ca/english\(index.asp](http://www.ghsi.ca/english(index.asp) (accessed August 2014). See also Oskar N.T. Thoms and James Ron, ‘Public Health, Conflict and Human Rights: Toward a Collaborative Research Agenda’, *Conflict and Health* 1, no. 11 (2007).

16. WHO, *Social Determinants of Health*, [http://www.who.int/social_determinants\(en\)](http://www.who.int/social_determinants(en)) (accessed August 2014).

17. Gostin, *Global Health Law*, 412.

18. WHO Framework Convention on Tobacco Control, Preamble. It was adopted by the World Health Assembly on 21 May 2003 and entered into force on 27 February 2005, [http://www.who.int/fctc\(en\)\(accessed September 2014\)](http://www.who.int/fctc(en)(accessed September 2014)).

19. While the treaties of the International Labour Organization also have relevance in this field, they have not been taken into consideration in this section.

20. Article 23(3), *International Health Regulations* (see also Article 31(2)). See also Articles 42 and 45(1) of the IHR.

21. See also the contribution by Zidar elsewhere in this special issue.

22. See also World Health Organization and World Trade Organization, *WTO Agreements & Public Health*, A joint study by the WHO and the WTO Secretariat, 2002, [http://www.wto.org/english/res_e\(booksp_e\(who_wto_e.pdf](http://www.wto.org/english/res_e(booksp_e(who_wto_e.pdf) (accessed September 2014); and Wemos (European Health Alliance (Physicians for Social Responsibility, World Trade Organization: Implications for Health Policy, April 2000.

23. General Agreement on Tariffs and Trade 1994 (GATT), [http://www.wto.org/english/docs_e\(legal_e\(06-gatt_e.htm](http://www.wto.org/english/docs_e(legal_e(06-gatt_e.htm) (accessed September 2014).

24. Article XX, sub-paragraph (b). World Health Organization and World Trade

Organization, WTO Agreements & Public Health, 11.

25. Simon Lester, Bryan Mercurio, and Arwel Dabies, *World Trade Law*, 2nd ed. (Oxford: Hart, 2012), 380.

26. *Ibid.*, 381–4.

27. *Ibid.*, 364.

28. WTO, Agreement on Trade-Related Aspects of Intellectual Property Rights, adopted in 1994 at the Uruguay Round of GATT.

29. See, for example, Jennifer Sellin, *Access to Medicines: The Interface Between Patents and Human Rights: Does One Size Fit All?* (Antwerp: Intersentia, 2014).

30. See, for example, *Sur International Journal on Human Rights* 5, no. 8 (2008), http://www.surjournal.org/eng/conteudos/getArtigo8.php?artigo=8,artigo_chaves.htm (accessed September 2014). See also Report of the Special Rapporteur, Paul Hunt, 'Mission to the World Trade Organization', CESCR, UN Doc. E/CN.4(2004/49(Add.1, 1 March 2004. E/CN.4(2004/49(Add.1, [http://www.who.int/medicines/areas/human_rights\(E_CN_4_2004_49_Add_1.pdf](http://www.who.int/medicines/areas/human_rights(E_CN_4_2004_49_Add_1.pdf) (accessed September 2014).

31. DOHA Declaration, para. 4, http://www.wto.org/english/thewto_e/minist_e/min01_e/mindecl_trips_e.htm (accessed September 2014). 502 B. Toebes Downloaded by [124.158.88.13] at 01:44 04 February 2016

32. Parliament of Australia, Flagpost, Australia's WTO Plain Cigarette Packing Case: An Update, 8 July 2014, [http://www.aph.gov.au/About_Parliament/Parliamentary_Departments/Parliamentary_Library/FlagPost\(2014\(July\(WTO_plain_cigarette_packaging_case](http://www.aph.gov.au/About_Parliament/Parliamentary_Departments/Parliamentary_Library/FlagPost(2014(July(WTO_plain_cigarette_packaging_case) (accessed August 2014).

33. WTO, Dispute Settlement: Dispute DS 434, Australia – Certain Measures Concerning Trademarks and Other Plain Packaging Requirements Applicable to Tobacco Products and Packing, [http://www.wto.org/english/tratop_e/dispu_e/cases_e\(ds434_e.htm](http://www.wto.org/english/tratop_e/dispu_e/cases_e(ds434_e.htm)) (accessed August 2014).

34. *Ibid.*

35. Youth Smoking Prevention Foundation, information in English,

[http://www.stichtingrookpreventiejeugd.nl\(2014\(09\(dutch-government-taken-to-court-for-illegal-contacts-with-tobacco-industry](http://www.stichtingrookpreventiejeugd.nl(2014(09(dutch-government-taken-to-court-for-illegal-contacts-with-tobacco-industry) (. For the summons see [http://www.stichtingrookpreventiejeugd.nl/wpcontent/uploads\(2014\(09\(08-09-2014-Dagvaarding-Stichting-Rookpreventie-Jeugd-v.-Staat-der-Nederlanden.pdf](http://www.stichtingrookpreventiejeugd.nl/wpcontent/uploads(2014(09(08-09-2014-Dagvaarding-Stichting-Rookpreventie-Jeugd-v.-Staat-der-Nederlanden.pdf) (accessed September 2014).

36. For an initiative see World Obesity Forum, Recommendations towards a Global Convention to Protect and Promote Healthy Diets, May 2014, [http://www.consumersinternational.org/news-and-media\(resource-zone\(recommendations-towards-a-global-convention-to-protect-and-promote-healthy-diets\)\(accessed](http://www.consumersinternational.org/news-and-media(resource-zone(recommendations-towards-a-global-convention-to-protect-and-promote-healthy-diets)(accessed) September 2014).

37. Yasmin von Schirnding, William Onzivu, and Andronico O. Adede, 'International Environmental Law and Global Public Health', *Bulletin of the World Health Organization* 80, no. 12 (2002): 970–4.

38. *Ibid.*, 970.

39. Article 1, Stockholm Convention on Persistent Organic Pollutants (2002).

40. Von Schirnding, 'International Environmental Law and Global Public Health', 970.

41. Brigit Toebes, 'Healthcare on the Battlefield: In Search of a Legal and Ethical Framework', *Journal of International Humanitarian Legal Studies* 4 (2013): 197–213.

42. Article 55, Additional Protocol I to the Geneva Conventions, adopted 8 June 1977.

43. Biological Weapons Convention, opened for signature on 10 April 1972; Convention on the Prohibition of the Development, Production, Stockpiling and Use of Chemical Weapons and on their Destruction, adopted 30 November 1992; Biological Weapons Convention, opened for signature on 10 April 1972.

44. Convention on Civil Aviation (Chicago Convention), adopted 7 December 1944.

45. Benjamin Mason Meier and Larisa M. Mori, 'The Highest Attainable Standard: Advancing a Collective Human Right to Public Health', *Columbia Human Rights Law*

Review 37 (2005): 101–21, at 102, [http://www.unc.edu/%7Emeierb\(Meier%20&%20Mori,%20The%20Highest%20Attainable%20Standard%20%282005%29.pdf](http://www.unc.edu/%7Emeierb(Meier%20&%20Mori,%20The%20Highest%20Attainable%20Standard%20%282005%29.pdf) (accessed May 2014).

46. Marlies Galenkamp, 'Collective Rights', in SIM Special No. 16 (Utrecht: Netherlands Institute of Human Rights, 1995), 53–102, at 70–1.

47. For an overview of all the decisions see the website of the European Committee of Social Rights: http://www.coe.int/t/dghl/monitoring/socialcharter/Complaints/Complaints_en.asp (accessed March 2014).

48. ECSR, *ECCR v. Bulgaria* (complaint no. 46(2007), para. 49. For an overview of all the decisions see the website of the European Committee of Social Rights: http://www.coe.int/t/dghl/monitoring/socialcharter/Complaints/Complaints_en.asp (accessed March 2014).

49. Mette Hartlev, 'Patients' Rights', in Toebes et al., *Health and Human Rights in Europe*, 111–44, at 125.

50. See also Murphey, *Health and Human Rights*, 58–84.

51. RULAC, *Derogations from Human Rights Treaties in Situations of Emergency*, [http://www.geneva-academy.ch/RULAC\(derogation_from_human_rights_treaties_in_situations_of_emergency.php](http://www.geneva-academy.ch/RULAC(derogation_from_human_rights_treaties_in_situations_of_emergency.php) (accessed September 2014). Derogation clauses are provided for in Article 4 of the ICCPR, Article 15 of the ECHR, and Article 27 of the American Convention of Human Rights (ACHR).

52. For an elaborate study on this matter see Anna-Lena Svensson McCarthy, *The International Law of Human Rights and States of Emergency* (The Hague: Martinus Nijhoff Publishers, 1998).

53. Art. 15 ECHR: Art. 2 (life), Art. 3 (torture), Art. 4.1 (slavery), Art. 7 (no punishment without law); Art. 4 ICCPR: Arts 6 (life), 7 (torture), 8 (slavery, paragraphs I and 2), 11 (contractual obligation), 15 (criminal offence), 16 (recognition before the law) and 18 (freedom of thought, conscience and religion). *The International Journal of Human Rights* 503 Downloaded by [124.158.88.13] at 01:44 04 February 2016

54. WHO, 'Statement on the Meeting of the International Health Regulations Emergency Committee Regarding the 2014 Ebola Outbreak in West Africa', [http://www.who.int/mediacentre/news/statements/2014/ebola-20140808\(en\)](http://www.who.int/mediacentre/news/statements/2014/ebola-20140808(en)) (accessed September 2014).

55. See https://treaties.un.org/Pages/ViewDetails.aspx?src=TREATY&mtdsg_no=IV-4&chapter=4&lang=en (accessed September 2014).

56. The ICCPR can be limited in the interests of public health: 12(3) (freedom of movement), 18(3) (freedom of religion and belief), 19(2) (freedom of expression), 21 (peaceful assembly) and 22 (2) (freedom of association), and the following rights can be limited in the interests of public health in the ECHR: Arts 8–11. The ICESCR contains a general limitation clause (see below).

57. UN Commission on Human Rights, *The Siracusa Principles on the Limitation and Derogation Provisions in the International Covenant on Civil and Political Rights*, 28 September 1984, E/CN.4(1985/4), <http://www.refworld.org/docid/4672bc122.html> (accessed September 2014).

58. See also Hartlev, 'Patients' Rights'.

59. Van Dijk et al., *Theory and Practice of the European Convention on Human Rights*, 4th ed. (Antwerp: Intersentia, 2006), 339–40.

60. See also Alastair Mowbray, 'Compulsory Detention to Prevent the Spreading of Infectious Diseases', *Human Rights Law Review* 5, no. 2 (year): 387–91.

61. ECtHR 25 January 2005, *Enhorn v. Sweden*, no. 56529(00), para. 41.

62. *Ibid.*, para. 55; Hartlev, 'Patients' Rights', 126.

63. *Ibid.*, para 55; Hartlev, 'Patients' Rights', 126.

64. *European Convention on Human Rights and Biomedicine (Oviedo Convention)*, adopted in Oviedo in 1997.

65. Articles 11–14, 16–17 and 19–21.

66. Michael Igoumenidis and Sophia Zyga, 'Healthcare Research in Developing Countries: Ethical Issues', *Health Science Journal* 5, no. 4

(2011): 243–50.

67. Article 3, Additional Protocol to the Convention on Human Rights and Biomedicine, concerning Biomedical Research.

68. For an elaborate discussion see Amrei Мьller, *The Relationship between Economic, Social and Cultural Rights and International Humanitarian Law* (Leiden: Martinus Nijhoff Publishers: 2013), 124–8.

69. UN Committee on Economic, Social and Cultural Rights (CESCR), General Comment 14 on the Right to the Highest Attainable Standard of Health, UN Doc. E/C.12(2000(4), 11 August 2000, para. 28.

70. Centres for Disease Control and Prevention, ‘2014 Outbreak in West Africa’, <http://www.cdc.gov/vhf/ebola/outbreaks/guinea/> (accessed September 2014).

71. As emphasised in the Vienna Declaration and Programme of Action, as adopted by the World Conference on Human Rights in Vienna

on 25 June 1993, <http://www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/Vienna.aspx> (accessed January 2015).

72. Human Rights Watch, ‘West Africa: Respect Rights in Ebola Response’, 15 September 2014, <http://www.hrw.org/news/2014/09/15/west-africa-respect-rights-ebola-response> (accessed September 2014).

73. Ibid.

Эх сурвалж:

The International Journal of Human Rights, 2015, Vol. 19, No. 4, 488–504, <http://dx.doi.org/10.1080/13642987.2015.1044814>

Монгол хэлнээ орчуулсан:

Хүний эрхийн Үндэсний Комиссын референт Ө.Ундрах

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ЗОЧНЫ ЯРИА

ИРГЭД ХҮНИЙ ЭРХИЙГ ТУНХАГ ХЭМЭЭН БОДДОГ БАЙЛАА



Хүний эрх сэтгүүлийн зочны яриа буланд Хүний эрхийн Үндэсний Комиссын анхны гишүүн асан Гүүширийн Далайжамцыг урьж Комиссыг анх байгуулж байх үеийн хүний эрхийн нөхцөл байдал, хүний эрхийн зөрчилтэй хэрхэн тэмцэж байсан талаар ярилцлаа.

-Та Хүний эрхийн Үндэсний Комиссын анхны гишүүдийн нэг. Таныг анх гишүүнээр томилогдон тангаргаа өргөх үед Монгол Улсад хүний эрхийн нөхцөл байдал ямар байв?

-2001 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр Хүний эрхийн Үндэсний Комиссын анхны гишүүдийг УИХ-аас томилж, 2 дугаар сарын 2-ны өдөр тангаргаа өргөснөөр албан ёсоор Комиссын үйл ажиллагаа эхэлсэн түүхтэй. Комиссын гишүүд тангаргаа өргөж, ажлын албаа бүрдүүлээд 3, 4 дүгээр сараас ажилдаа шуурхайлан орсон юм даг. Биднийг ажлаа эхлэх үед үндэсний хэмжээнд хүний эрхийн төлөв байдлыг судлан тогтоох аятайхан боломж гарч ирсэн нь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Засгийн газрын шугамаар хэрэгжүүлсэн томоохон төсөл байв. Уг төслийн хүрээнд олон баг гарч улс орон даяар хүний эрхийн төлөв байдлын судалгааг хийсэн. Түүнчлэн Комиссоос эхний шатанд хэрэг бүртгэх мөрдөн байцаах ажиллагаа,

хорих байгууллага дээр хүний эрхийн төлөв байдал ямар байгааг тогтоохоор удирдамж гарган хэд хэдэн хяналт шалгалт хийсэн юм.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилтээр хүний эрхийн төлөв байдлыг тогтоохоор улсын хэмжээнд хийсэн судалгааны тайланг, Комиссын хийсэн хяналт шалгалтын дүнтэй нийлүүлж, нэгдсэн дүгнэлтийг 2002 оны эхээр гаргаж дуусгасан. Энэ судалгаагаар Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар баталгаажсан хүний эрх, эрх чөлөө зөрчигддөг байдал улс орон даяар түгээмэл байна гэдэг дүгнэлт гарсныг анхны илтгэлдээ маш тодорхой дурдаж УИХ-д өргөн барьж байлаа. Хүний эрх цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар зэрэг хүчний байгууллагуудад илүүтэйгээр зөрчигддөг нь тогтоогдсон.

Тэр үед иргэд эрхээ хамгаалах мэдлэг дутмаг, хүний эрхийн ойлголт тааруу, хүний эрхийг тунхаглалын чанартай зүйл

гэж боддог байлаа. Хүний эрхийн ойлголт, хандлага нийт иргэдийн дунд төлөвшиж чадаагүй тийм л үе байсан.

-Аливааг шинээр бий болгоно гэдэг хэцүү. Та Комиссын гишүүнээр томилогдох үедээ хүний эрхийн төлөв байдлын талаар ямархуу төсөөлөлтэй байсан бэ?

-Би Ерөнхийлөгчийн тамгын газарт олон нийттэй харилцах, захидал харилцааны асуудлыг эрхэлсэн ажилтан байлаа. Тиймээс иргэдтэй байнга уулздаг. Ерөнхийлөгчийн Тамгын газарт ирсэн бүх захидалтай танилцаж байсны хувьд хүний эрхийн нөхцөл байдлын талаар тодорхой хэмжээний мэдээлэлтэй байсан. Энэ маань ч хүний эрхийн Комиссад ажиллах суурь болж өгсөн байх гэж боддог юм. Ерөнхийлөгч намайг санал болгосны дагуу УИХ-аас томилсон.

-Хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын анхны илтгэлийг би саяхан уншсан. Тэнд бичсэнээр хорих газруудад хүний эрх дээд зэргээр зөрчигддөг, маш олон ялтан нас барсан тухай дурдсан байсан. Яг газар дээр нь очиж ажилласан танаас асуумаар байна л даа. Нөхцөл байдлыг дүрсэлбэл?

-Би урд тогтолцооны үед прокурорт ажилладаг байсан. Тэр үедээ прокурорын шугамаар хорих цагдах байгууллагуудыг шалгадаг л байсан. Гэхдээ тэр үед харьцангуй гайгүй байдаг байсан. Зах зээлийн харилцаанд шилжсэн шилжилтийн үед нэг хэсэг хорих байгууллагуудын үйл ажиллагаа доголдсон. Тэр үед улс орны эдийн засгийн байдал ч хүндэрсэн байсан шүү дээ. Хоригдлууд өлсгөлөнгийн байдалтай байдаг учраас, тураалаар нас барах явдал их байсан. Нөгөө талаар хорих байрнуудын нөхцөл байдал муудсан, байшин барилга нь элэгдэж чанарын шаардлага хангахаа больсон байлаа.

Өмнөх тогтолцооны үед хорих газруудад хоригдлуудыг залхаах, цээрлүүлэх бодлого барьдаг байсан болоод ч тэр үү хорих байрнууд салхи жавар орох боломжгүй, харанхуй, чийг ихтэй баригдсан байсан. Ялангуяа Ганц худаг гэж нэрлэдэг төв хорихын нөхцөл байдал үнэхээр хэцүү байсан. Тэнд очсон хүн өвчин тусахгүй байхын аргагүй. Харанхуй, чийгтэй, бохир

заваан, нэвширсэн муухай үнэртэй өрөөнд хоригдлууд олноор шахцалдан хоригддог байсан. Ялтнууд тураал ч гэлтгүй янз бүрийн хүнд өвчнөөр үхэх тохиолдол маш их байсан. Монгол Улсын нэгдэн орсон гэрээ конвенц, Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөө хамгийн доод түвшиндээ хүрчихсэн байсан учраас эрс арга хэмжээ авах нь зүйтэй гэж Комисс үзсэн.

Тэгээд бид УИХ, Засгийн газар, олон улсын байгууллагуудад цагдан хорих төвийг нэн яаралтай шинэчлэхгүй бол болохгүй байна. Хорих газрууд залхаан цээрлүүлэх газар болсныг илтгэсэн. УИХ, Засгийн газраас энэ асуудалд онцгойлон анхаарч төв хорихыг 4 дүгээр цахилгаан станцын өмнө барих шийдвэр гаргаж, төсөв мөнгийг шийдвэрлэж байлаа. Бусад хорих байгууллагуудын нөхцөл байдлыг ч гэсэн сайжруулах арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлсэн. Тэгээгүй бол нөхцөл байдал их доод түвшинд хүрсэн байсан.

-Комиссын анхны илтгэлд эрүүдэн шүүж буй асуудлыг нэлээн хурцаар тавьсан байдаг. Ямар эрүү шүүлтийг хэрэглэд байсан юм бэ?

-Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд эрүүдэн шүүх явдал голчлон гардаг байсан. Ихэвчлэн зодох, айлгах сүрдүүлэх, үндэслэлгүйгээр ял тулгах явдал байсан. Шууд батлагдаагүй ч гэсэн хоригдож байгаа хүмүүсээр зодуулдаг, тамлуулдаг явдал байсан гэдгийг хоригдлуудтай хийсэн ярилцлагаар тогтоогоод дөнгөж байгуулагдаад байсан Прокурорын дэргэдэх мөрдөн байцаах албанд шилжүүлж байлаа. Түүнээс гадна цагдан хорих төвүүдэд эрүү шүүлтийн шинж чанартай зүйлүүд байсан. Сахилгад хорихдоо хэтэрхий хүнд нөхцөлд байлгадаг зөрчил түгээмэл байсан. Хоригдлуудыг залхаан цээрлүүлж байх ёстой гэсэн ерөнхий хандлага тэр үед байсан учраас тэдэнтэй хатуу ширүүн харьцах, эрүү шүүлт хэрэглэдэг явдал байсан болов уу. Хорихын зарим ажилтнууд хоригдлуудыг зодох нүдэх явдал гардаг байсан учраас энэ асуудлыг хурцаар гарган тавихаас өөр арга байгаагүй.

-Тэр үед шоронд хоригдож байсан нийт хүмүүсийн хэдэн хувь нь эрүүл мэнд, амь

насаараа хохирсон бэ? Ийм судалгааг гаргасан уу?

-Нарийвчилсан судалгааг гаргаагүй. Одоотой харьцуулбал эрүүл мэндээрээ хохирох, амь насаараа хохирох явдал их байсан. Өлсгөлөнгөөр үхнэ гэдэг чинь юу гэсэн үг вэ? Огт хоол өгөхгүй байсаар байгаад алчихсан хэрэг бас биш шүү дээ. Хүнд, хатуу ширүүн нөхцөлд зарим үед эрүү шүүлтгийн чанартай арга хэрэглэсэн ч байж болох байдалд байлгаснаар тураалд орж бие нь сульдаад, улмаар хүндээр өвчлөөд үхэх явдал гарч байсан.

-Хүний эрхийн Үндэсний Комисс хэмээх шинэхэн байгуулагдсан байгууллагын хүмүүс хяналт шалгалт хийх гээд очиход хууль сахиулах байгууллагынхан та бүхнийг хэрхэн хүлээж авч байв?

-Ер нь гайгүй шүү. Ялангуяа хүчний байгууллагынхан биднийг харьцангуй гайгүй хүлээж авдаг байлаа. Харин гадаадын хөрөнгө оруулалттай байгууллагууд захиргааны дээд шатны байгууллагуудын зөвшөөрөлтэйгөөр хүлээж авна гэж дургүйцэх, эсэргүүцэх тал мэр сэр гарсан. Ер нь нэг зүйлийг тодруулж хэлэхэд хүчний байгууллагууд өөрсдийнхөө зарим үйл ажиллагааг эрүүдэн шүүлт биш гэж маргах явдал байсан нь хүний эрхийн ойлголт, хандлага суугаагүй байсантай л холбоотой байсан гэж үздэг.

-Комиссын тухай хуульд Комиссын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй бүх байгууллагад саадгүй нэвтэрнэ гэсэн заалт бий. Өөрсдийн байгууллагынхаа зөрчлийг нууж хаацайлахын тулд та бүхний ажилд илт саад хийсэн тохиолдол гарч байв уу?

-Гадаадын хөрөнгө оруулалттай компани дээд шатны байгууллагаас зөвшөөрөл ав гэж буцаасан нэг тохиолдол гарсан. Тэр компани бол “Бороо гоулд” компани. Тус байгууллага дахь хөдөлмөрлөх эрхийн нөхцөл байдал болон байгаль орчныг бохирдуулж байгаа нөхцөлийг тогтоохоор очиход Улаанбаатарт байгаа төв захиргаанаас зөвшөөрөл аваад ир гэж буцааж байсан удаатай. Бид төв захиргаанд нь “Комиссын тухай хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхийн тулд зөвшөөрөл

авдаг ёс байхгүй” гэдгээ хэлж ойлгуулсан. Анхны тохиолдол учраас бид бүхэн тусгай арга хэмжээ авахуулаагүй, албан бичгээр болон утсаар мэдэгдэл хүргүүлээд дахиж ийм үйлдэл гаргахгүй байхыг анхааруулсан. Түүнээс хойш ийм тохиолдол гараагүй.

-Та тангаргаа өргөснөөс хойш хүний эрхийн ямар чиглэлээр дагнан ажиллаж байсан бэ?

-Комиссын гишүүдэд хүний эрхийн чиглэлээр хариуцуулан мэргэшүүлэх ажил үүргийн хуваарь байсан. Би гэхэд эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хариуцан ажиллаж байсан. Надад ажлаасаа үндэслэлгүй халагдлаа, цалингаа хугацаандаа тавихгүй байна. Өмчлөх эрхэнд халдлаа, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрх, тэтгэвэр тэтгэмж авах эрхээ эдэлж чадахгүй байна. Сурч боловсрох эрхээр хангагдахгүй байна гэсэн гомдол ирдэг байсан. Үүнээс хөдөлмөрлөх эрх маш их зөрчигддөг байсан. Харин өмчлөх эрхийн гомдол хааяа нэг ирдэг байсан. Комиссын гишүүний хувьд тэдгээр зөрчил гаргасан байгууллагуудад зөвлөмж, шаардлага хүргүүлж, зөрчлийг засуулдаг байв.

-Таны сэтгэлийг эмзэглүүлсэн хамгийн ноцтой хүний эрхийн зөрчил юу байв?

-Уул уурхайн компаниуд олборлолт хийж байгаль орчныг сүйтгэхчээд нөхөн сэргээлт хийхгүй байх явдал их байлаа. Ялангуяа ОХУ-ын хөрөнгө оруулалттай Тосон Заамарт үйл ажиллагаа явуулж байсан “Алтан Дорнод” гэх мэт компаниуд байсан. Шаардлага хүргүүлэхээр ойлголоо засна гэж хэлчээд түүнийгээ биелүүлдэггүй байв. Сүүлд нь тус компани татвар төлөөгүй гэдэг нь татварын байгууллагын шалгалтаар тогтоогдож их хэмжээний торгууль тавиулангуутаа түүнийгээ эсэргүүцэж Монгол Улстай олон улсын шүүхээр тэмцэлдээд, захирал нь оргоод явчихсан гэж дуулдсан.

-Хүний эрхийн Үндэсний Комисс өнөөдөр улс орон даяар үйл ажиллагаагаа явуулдаг Үндэсний байгууллага болж чадсан. Харин өөрсдийн гэсэн ширээ сандал ч байхгүй шинэ байгууллагыг анх бий болгож ажиллах үед хэцүү, хатуу зүйл их л тулгарсан байлгүй.

-Комисс анх цөөхөн орон тоотой байгуулагдсан. Гурван гишүүнээс гадна 10 хүрэхгүй ажилтантай. Тэгсэн мөртлөө улсын хэмжээнд хүн бүрт хүрсэн үйл ажиллагаа явуулна гэдэг бэрхшээлтэй бөгөөд боломжгүй байсан. Тэр үед НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс санхүүжүүлсэн төслийн хүрээнд аймаг бүрт сайн дурын нэг ажилтныг төслөөс цалинжуулж ажиллуулсныг нь бид бүхэн өөриймшүүлж, тэднийг сургаж Комиссын олон нийтийн туслалцаагаар ажиллуулсан нь их нэмэр болсон. Тэд нэгд судалгаа хийх, хоёрт хүний эрхийн боловсролыг түгээх, сурталчлах, гуравт илэрсэн зөрчлийг бидэнд мэдэгдэх ажлыг хийдэг байсан. Тэднээс ирүүлсэн зөрчлийн талаарх мэдээллийн дагуу бид тухайн газарт нь очиж зөрчлийг засаж залруулах ажлыг хийж байлаа. Хүн, хүчийг нэмж өгөөч хэмээн УИХ, Засгийн газарт удаа дараа мэдэгдэж байсны дагуу бага багаар нэмсээр байгаад өнөөгийн түвшинд хүрчээ.

Өөр нэг асуудал нь орон байрны асуудал. Бидэнд анх төрийн ордны буланд хоёр гурван өрөө гарган өгч байрлуулж байгаад 2001 ондоо багтааж, одоогийн байрыг засаж янзалж өгсөн. Компьютер, техник тоног төхөөрөмжийг нь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс санхүүжүүлж авч өгсөн. Улсын төсвөөс конторын ширээ сандлыг нь авч өгч байлаа. Би НҮБ, Хүний эрхийн дээд Комиссарт зориуд баярлаж талархсанаа илэрхийлмээр байна. НҮБ-ын суурин төлөөлөгчийн газар, Хөгжлийн хөтөлбөрөөс маш их анхаарал тавьж байсныг цохож хэлэх хэрэгтэй.

Комиссын чадавхыг бэхжүүлэх төслийн олон улсын хоёр зөвлөх болох Петер Хоскин, Брайн Бүрдикен нар ээлжлэн ажиллаж байсан. Эдгээр хүмүүс Комиссын боловсон хүчнийг хүний эрхийн чиглэлээр сургахад асар их хүчин чармайлт гаргасан. Түүнчлэн Комиссын материаллаг баазыг бэхжүүлэх, техник тоног төхөөрөмжөөр хангахад ч их тусалж дэмжсэн. Комиссын ажилтнууд гэлтгүй орон нутгийн төр захиргааны байгууллагын ажилтнууд, төрийн бус байгууллагын ажилтнуудыг хүний эрхийн

талаар мэргэшихэд асар их нөлөө үзүүлсэн. Ингэж л хүний эрхийг хангах суурь тавигдсан даа.

-Хүний эрхийн ойлголт, хандлагыг ард иргэдэд суулгана гэдэг төвөгтэй байсан байх. Ямар стратеги барьж ажиллав?

-Комиссоос урт болон дунд хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулан, түүнийхээ хэрэгжилтийг хангаж ажилладаг байсан. Урт хугацааны зорилгодоо хүрэхийн тулд орон нутгийн засаг захиргааны байгууллагуудыг дайчлан ашигласан. Аймгуудын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэд Хурлын даргаар ахлуулсан, хуулийн мэргэжилтэй хүмүүс болон төрийн бус байгууллагын төлөөлүүдээс бүрдсэн зөвлөлийг байгуулж ажиллаж байлаа. Аймаг, орон нутагт очихдоо нөгөө зөвлөлийнхөнтэйгөө уулзаад ажилтай нь танилцаж зөвлөгөө өгөх, сургалт, семинар явуулах гэх зэргээр мэргэжил, аргагүйн талаар удирдамж чиглэл өгдөг байв. Мөн жилдээ нэг удаа зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нарыг Улаанбаатар хотод авчирч хүний эрхийн сургалтад хамруулж, ажлыг нь дүгнээд буцаадаг байв. Энэ ажил нь улс орон даяар хүний эрхийн ойлголт хандлагыг бий болгоход ихээхэн түлхэц болсон. Тэдгээр зөвлөлийн гишүүд Комисс уруу байнга холбогдон зөвлөгөө авч, ажлаа танилцуулах зэргээр ажлын уялдаа холбоо тогтоож эхэлсэн. 2007 онд НҮБ-ын төсөл дууссан учраас Орон тооны бус зөвлөлийг санхүүжүүлэх боломжгүй болж үндсэндээ татан буугдсан. Ж.Бямбадорж Комиссын даргаар томилогдоод аймаг бүрд ХЭҮК-ын орон тооны нэг ажилтантай болгосон нь Комисс үйл ажиллагаагаа улс орны өнцөг булан бүрд хүртээмжтэй явуулах боломж бий болгосонд талархаж явдгаа илэрхийлье.

-Хүний эрхийн Үндэсний Комиссын гурван гишүүн бүрэн эрх, чиг үүргээ хэрэгжүүлэхэд тулгардаг хамгийн гол бэрхшээлүүд юу байв?

-Бэрхшээлгүй юм гэж хаа байх вэ? Хүмүүс тэр үед хүний эрхийн ойлголтгүй байлаа. Тийм хүмүүст ойлгуулж ажиллахын тулд чамгүй их хүч чармайлт гаргах хэрэгтэй болно. Материаллаг баазтай болж чадаагүй,

боловсон хүчний хувьд хүч дутмаг байв. Арваадхан хүний бүрэлдэхүүнтэйгээр 21 аймаг, Улаанбаатар хотод хүрч ажиллахад үнэхээр хүндрэлтэй байсан. Энэ хүндрэл бэрхшээлтэй цаг үед НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Хүний эрхийн дээд Комиссарын газраас хэрэгжүүлсэн Комиссын чадавхыг дээшлүүлэх төсөл маш их хувь нэмэр болсон. Тэдний техник, эдийн засгийн туслалцаа, мэргэжлийн зөвлөхүүдийн хүчин чармайлтын үр дүнд тус Комисс өмнөө тавьсан зорилгоо амжилттай хэрэгжүүлж чадсан юм. 2002 оноос эхлэн орон нутагт хүний эрхийн нээлттэй өдрийг зохион байгуулсан нь чухал ач холбогдолтой болсон. Аймагт бүрд хүрч ажиллаж, хүний эрх гэдэг зүйлийг олон нийтэд ойлгуулж, анхны суурь мэдлэгтэй болгох ажлыг эхлүүлж байлаа. Бүх байгууллага, албан тушаалтан үйл ажиллагаагаа явуулахдаа хүний эрхийг хүндэтгэн хамгаалах ёстой юм байна гэсэн зөв ойлголтыг төлөвшүүлэхэд гол үйл ажиллагаагаа чиглүүлсэн нь тодорхой үр дүнд хүрсэн юм.

-Комисс хүний эрхийн ноцтой зөрчлүүдийг таслан зогсоох ажлыг хийгээд эхлэхээр эрхээ хангуулсан хүмүүс баяр талархлаа яаж илэрхийлж байв?

-Зөрчигдсөн эрх нь сэргээгдээд материаллаг хохирлоо нөхөн төлүүлж авсан, үндэслэлгүйгээр ажлаасаа халагдаад буцаж ажилдаа орсон хүмүүс бидэн рүү захидал ирүүлдэг, биечлэн ирж баярлаж талархсанаа илэрхийлдэг байлаа. Баяр талархлаа илэрхийлсэн цөөнгүй хүмүүс байдаг. Жишээлбэл, Эрдэнэ-Очир гэдэг иргэн хүн амины хэрэгт сэрдэгдэж ялын дээд хэмжээг таван удаа сонссоны эцэст Дээд шүүхээс хэргийг нотлох баримт алга хэмээн хэрэгсэхгүй болгож цагаатгасан байдаг юм. Хилс хэрэгт сэрдэгдэж, цаазын ялыг удаа дараа сонсож хохирсон Эрдэнэ-Очирын хохирлыг нөхөн төлүүлэхээр Хүний эрхийн Үндэсний Комисс 20 гаруй сая төгрөгийн нэхэмжлэлийг шүүхэд гаргаж, нэхэмжилсэн мөнгөнийхөө тал илүү хувийг улсаас гаргуулан түүнд өгүүлсэн. Эрдэнэ-Очир эцэгтэйгээ хамт Комиссод ирээд “Баярлалаа” хэмээн уйлж байсан.

Сүүлд Эрдэнэ-Очирт төр засаг анхаарлаа хандуулж, ажил албатай болгосон гэж дуулсан.

-Тэр хүнд хэргийг хүчээр хүлээлгэхийн тулд эрүү шүүлт тулгасан зүйл байдаг уу?

-Их удаан хорино гэдэг чинь эрүү шүүлт шүү дээ. Хорих байрны нөхцөл байдлыг ярилцлагын эхэнд дурдсан даа. Тийм орчинд 7 жил хоригдсон юм ш дээ.

-Хүний эрхийн Үндэсний Комисс хилсээр хоригдсон иргэний өмнөөс нэхэмжлэл гаргаад эд мөнгөний хохирлыг нь барагдуулсан гэдгийг хүмүүс дуулаад Комисс руу шуурч эхэлсэн үү?

-Ер нь бол ихэссэн. Мөн нэг жишээ хэлэхэд Төв аймгийн нэгэн иргэн хөөрөгний хулгайн хэрэгт сэрдэгдээд 3 жилийн хорих ял аваад шоронд хоригдсон байдаг юм. Хоригдсоноос хойш хоёр жил гаруйн дараа хулгайлагдсан гэх хөөрөг нь алдсан гэх айлыг нүүхэд нь орных нь ардаас олдсон байдаг. Хилс хэрэгт гүтгэгдсэн хүн нь би аваагүй хэмээн яаж ч хэлээд нэмэр байгаагүй. Хүчээр хэрэг тулгаад хорьсон байдаг. Тэгээд авсан ялынхаа 2 жил гаруйг нь эдэлчхээд байхад нь хөөрөг олдсон учраас хэргийг хэрэгсэхгүй болгож сулласан. Энэ хэрэгт манайхаас нэхэмжлэл гаргаж тодорхой хэмжээний нөхөн олговрыг олгуулж байсан.

-Хүний эрхийн байгууллагад ажиллахын хамгийн сайхан зүйл нь юу вэ?

-Хүний эрхийг хамгаалж, хүнийг баярлуулна гэдэг чинь өөрөө хамгийн сайхан үйл явдал шүү дээ. Иргэдэд эрхийнх нь талаар сайтар ойлгуулж ингэж хамгаалуулаарай хэмээн зааж зөвлөхөд нээрээ тийм юм байна шүү. Бид ийм эрхтэй юм байна, ингэж хамгаалдаг юм байна гэж баярладаг юм. Нөгөө талаар албан тушаалтнууд хүний эрхийг хангах, хамгаалах ажлыг үйл ажиллагааныхаа салшгүй хэсэг хэмээн ойлгож, хүний эрхийг зөрчихгүй байхуйцаар ажлаа явуулах мэдлэг чадвартай болох явдал юм. Олон түмний төлөө анхаарч эрхийг нь хамгаалдаг, баярлуулдаг ажил шиг сайхан зүйл хаана байх вэ?

-Хүний эрхийн асуудал нь асар өргөн хүрээтэй асуудал. Шинэхэн байгуулагдсан

Комисс ямар эрхийг нэн тэргүүнд хангуулах чиглэлээр ажилласан бэ?

-Нэн тэргүүнд хорих, цагдах байгууллагад шалгагдаж, ял эдэлж байгаа хүмүүсийн эрхийг хангуулах талаар, эрүүдэн шүүхтэй тэмцэх бүтэн жилийн цогцолбор арга хэмжээг хэрэгжүүлсэн. Яагаад гэхээр тэд нар чинь өөрийнхөө эрхийг хамгаалахаар шууд тэмцэх боломжгүй хүмүүс шүү дээ. Хоёрдугаарт эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх, хөдөлмөрлөх эрхийг хангуулах талаар илүү анхаарч ажиллах шаардлага гарч байв.

-Хүний эрхийг хамгаалагчдад юу гэж захираар байна?

-Хүний эрхийг хангахын тулд олон нийтийн дэмжлэг туслалцааг сайн авч ажиллах нь зүйтэй. Төрийн бус байгууллага, орон нутгийн засаг захиргааны байгууллагад тулгуурлаж, тэднийг идэвхжүүлэх замаар ажиллаж гэмээнэ үр дүнд хүрнэ шүү. Комисс

хуучнаа бодвол төвдөө 20 гаруй хүнтэй, аймаг бүрт нэг нэг ахлах мэргэжилтэнтэй болсон ч гэлээ энэ өргөн уудам нутагт жигд хүрч ажиллана гэдэг хэцүү. Материаллаг бааз, хүний нөөцийн асуудал нэг үеэ бодвол маш аятайхан болсон. Энэ бол олзуурхууштай баярлууштай зүйл. Хүний эрхийн байгууллагыг өнөөдрийн түвшинд хүргэсэн Комиссын үе үеийн удирдлагад би баярлаж явдаг. Гэхдээ орон нутгийн төр, захиргааны болон төрийн бус байгууллагын удирдах болон гүйцэтгэх ажилтнуудыг сургаж, энэ ажилд өргөнөөр оролцоход нь түлхэц өгвөл илүү өндөр үр дүнд хүрнэ гэж би боддог.

-Ярилцсанд баярлалаа.

Ярилцсан: Хүний эрхийн Үндэсний Комиссын хэвлэл мэдээлэл, сурталчилгаа хариуцсан ажилтан С.Будрагчаа

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГА ЭРХ ЧӨЛӨӨ НЬ ХЯЗГААРЛАГДСАН ХҮН БҮРТ ХҮРЧ АЖИЛЛАДАГ



Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэгийн Ази, Номхон далайн бүс нутгийг хариуцсан хөтөлбөрийн менежер, хатагтай Шазира Завави Монгол Улсад айлчлан ирээд байгаа юм. Түүнийг Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Гадаад хэргийн яам, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэгээс хамтран зохион байгуулсан “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмын үүрэг, ач холбогдол” сэдэвт хэлэлцүүлэг оролцож байх үеэр нь цөөн хором ярилцлаа.

-Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний байгууллагын талаар манай уншигчид төдийлөн ойлголтгүй байгаа. Та энэ талаар тодорхой мэдээлэл өгөхгүй юу?

-Аливаа улс орон НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 57-р чуулганаар баталсан “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколд нэгдэн орсноор нэг жилийн дотор эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний байгууллагыг байгуулах үүргийг олон улсын өмнө хүлээдэг. Монгол Улс 2014 оны 12 дугаар сарын 11-ний өдөр уг нэмэлт протоколыг соёрхон баталж, нэгдсэн бөгөөд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний байгууллагаа хэрхэн байгуулах талаар одоо идэвхтэй ажиллаж байна. Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын нэмэлт протоколд үндэсний байгууллагыг яг ийм загвараар байгуулна гэсэн нарийвчилсан заалт байдаггүй нь тухайн

улс орон өөрсдийнхөө үндэсний онцлогтоо тохируулан байгуулах боломж олгосон явдал юм.

Гэхдээ эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн нэмэлт протоколд урьдчилан сэргийлэх үндэсний байгууллага нь ямар шаардлагуудыг хангаж ажиллах ёстойг заасан байдаг. Тэр нь нэгдүгээрт хараат бус бие даасан байх, хоёрдугаар үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулах эдийн засгийн нөөц бололцоогоор бүрэн хангагдсан байх, гуравдугаарт ажилтан албан хаагчид нь чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ур чадвар, мэргэжлийн мэдлэг, ойлголтыг бүрэн эзэмшсэн байх ёстой. Дөрөвдүгээрт үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагын ажилтан, албан хаагчид нь жендерийн тэгш байдалтай, угсаатны болон цөөнхийн бүлгийн зохих төлөөлөлтэй байх ёстой. Тавдугаарт үндэсний байгууллагын статустай байх ёстой хэмээн тус тус заасан байдаг.

-Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний байгууллага үйл ажиллагаагаа

голчлон хаана чиглүүлж ажилладаг вэ? Миний хувьд хорих ангиудад төвлөрөх байх гэж ойлгож байна зөв үү?

-Урьдчилан сэргийлэх үндэсний байгууллагын онцлог нь хүний эрх, эрх чөлөө ямар нэгэн байдлаар хязгаарлагдсан буюу тухайн хүн өөрийнхөө дураар орхиод явж болдоггүй бүхий л газарт хүрч үйлчлэх, хамгийн гол нь тогтмол очиж хяналт шалгалт үзлэгээ хийж, урьдчилан сэргийлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлдэг. Энэ нь төвлөрсөн хорих анги, цагдан хорих төвөөр хязгаарлагдахгүй. Сэтгэцийн эмгэг өвчин судлалын төв, хүүхдийн болон ахмадын асрамжийн газрууд, архи мансуурах донтой өвчтөнүүдийг албадан эмчлэх төв, хүүхдийн хаяг тогтоох газар, түр саатуулах байрнууд, иргэний шилжилт хөдөлгөөний газар, түр хамгаалах байр зэрэг шүүхийн, захиргааны эсхүл эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр тухайн хүн өөрөө шууд орхин явах боломжгүй бүх газарт хүрч, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлж ажилладаг гэж ойлгож болно.

-Хэлэлцүүлэгт оролцогчдын илтгэлийг сонсож байхад эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний байгууллагын чиг үүргийг Монгол Улсын Их Хуралаас Хүний эрхийн Үндэсний Комиссод давхар хариуцуулахаар ажиллаж байна гэж ойлгогдлоо. Энэ зөв шийдэл мөн үү?

-Сүүлийн үед урьдчилан сэргийлэх үндэсний байгууллагаа байгуулж байгаа дэлхий даяарх чиг хандлагыг харвал дийлэнх нь хүний эрхийн үндэсний байгууллагадаа хэрэгжүүлж байна. Энэ нь өөрийн гэсэн давуу талтай. Тэр нь юу вэ гэхээр хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр тодорхой хэмжээний туршлага хуримтлуулчихсан, хяналт шалгалтын ажлыг хийгээд дадчихсан, мөн улсынхаа хууль сахиулах байгууллагуудтай хамтран ажиллаад, тодорхой харилцаа холбоо үүсгэчихсэн бат бөх суурь дээр байгуулж байгаа учраас мэдээж сайн хэрэг.

Монгол Улсын төрөөс энэхүү чиг үүргийг Хүний эрхийн Үндэсний Комисстоо өгч байгаа нь сайн хэрэг хэдий ч ингэснийхээ дараа ямар тусалцаа үзүүлэх вэ гэдэг нь

сонин байна? Урьдчилан сэргийлэх үндэсний байгууллага нь чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд их хэмжээний хөрөнгө мөнгө, хүний нөөц шаардаж байдаг. Тиймээс Монгол Улсын төрөөс ХЭҮК-г чиг үүргийг нь шууд хуваарилаад өгөх нь чухал биш. Харин Комиссын дотор бие даасан хэлтэс, бүр сайнаар төсөөлбөл тусдаа төсөвтэй, урьдчилан сэргийлэх, хяналт шалгалт хийхээр мэргэшсэн ажилтантай тусгай нэгж байдлаар байгуулбал зүгээр. Мөн урьдчилан сэргийлэх байгууллага нь Комиссын одоо байгаа бүтэц бүрэлдэхүүнтэй хэрхэн уялдаж ажиллах вэ? Хэрхэн харилцах вэ? Яаж үйл ажиллагаагаа явуулах вэ гэдгийг маш нарийн тооцоолж уялдуулсан хууль, журмыг гаргах хэрэгтэй. Үндэсний байгууллагыг шинээр байгуулж байгаа нь сайн хэрэг. Гэхдээ Комиссын гадаад, дотоод бүх хүчин зүйлсийг нарийн тооцох хэрэгтэй байх.

Нэмж хэлэхэд Монголын Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссод П.Оюунчимэг гишүүн байгаа нь хамгийн гол давуу тал юм. Энэ хүн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажлыг маш сайн мэддэг. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын ажлыг олон жилийн турш удирдан зохион байгуулж мэргэшсэн. Түүнчлэн Монгол Улс маш өргөн уудам газар нутагтай. Урьдчилан сэргийлэх байгууллага нь улсынхаа өнцөг булан бүрт хүрч ажиллах ёстой шүү дээ. Хэдийгээр Монгол Улсын ХЭҮК нь 21 аймагтаа нэг нэг ахлах мэргэжилтэнтэй байгаа нь урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэх сайн суурь болж өгч байгаа хэдий ч тэднийхээ чадавхыг бэхжүүлэх шаардлага тулгарч байгаа.

-Аливаа улс орнууд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний байгууллагаа байгуулахдаа гаргадаг нийтлэг алдаа юу вэ? Цаашид манай улсын хувьд юунд анхаарах шаардлагатай вэ?

-Юуны түрүүнд би алдаа гэж хэлмээргүй байна. Харин тулгардаг гол хүндрэл бэрхшээлүүдийг хэлье. Аливаа улс орны Засгийн газар нь урьдчилан сэргийлэх байгууллагаа байгуулахдаа оролцогч бүх талуудыг зөв тодорхойлж, тэдгээрийн оролцоог жигд хангаагүйгээс үүдээд хүндрэл, бэрхшээл гарч байсан тохиолдлууд бий.

Тухайлбал хууль сахиулах бүх байгууллагын төлөөллийг хэлэлцүүлэг, уулзалт, сургалт, цаашид эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг гаргахдаа урьж, жигд оролцуулаагүйгээс үүдээд үйл ажиллагаа нь доголдсон тохиолдол байдаг. Урьдчилан сэргийлэх үндэсний байгууллага шинээр байгуулагдаад үйл ажиллагаа явуулж эхэлснийг хууль сахиулах байгууллагууд нь мэдээгүй байснаас үүдэн чиг үүрэг, бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хүндрэл гарсан. Ер нь урьдчилан сэргийлэх үндэсний байгууллага нь тухайн улсынхаа хууль хяналтын байгууллагуудыг жигд оролцуулж, тэдний уялдаа холбоог нягтруулж гэмээнэ цаашид хамтарч ажиллах итгэлцэл төрж, үр нөлөө нь сайжирдаг давуу талтай. Өөр нэмж хэлэх зүйл гэвэл урьдчилан сэргийлэх үндэсний байгууллагын үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг бат бэх тогтоох ёстой. Байгууллагын эрх хэмжээ, чиг үүргийг нарийн тодорхойлж, хуульчлах ёстой байдаг. Тэгж гэмээнэ хүлээн зөвшөөрөгдөж үйл ажиллагаагаа хэвийн явуулдаг. Мөн төсөв санхүүгийн асуудлыг нь засгийн газраас хараат бус, үндсэн чиг үүргээ улс орон даяар хэрэгжүүлэхэд хангалттай хүрэлцэхүйц байдлаар тогтоож өгөх асуудлыг хуульчлах ёстой. Мөн үндэсний байгууллагын ажлын тайлагнал, зөвлөмжийн хэрэгжилтийг хэрхэн хангахыг нь хуульчилвал үр дүн өндөр байдаг.

-Урьдчилан сэргийлэх үндэсний байгууллагын Хүний эрхийн Үндэсний Комиссоос ялгардаг гол ялгаа нь юу вэ?

-Аливаа улсуудын хүний эрхийн үндэсний байгууллага нь хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн талаарх гомдол, мэдээлэл хүлээн аваад түүнийг хянан шалгаж, ямар нэгэн хариу үйлдэл үзүүлдэг. Харин урьдчилан сэргийлэх байгууллага нь хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн үйлдэл гарахаас урьдчилан сэргийлж, дээр дурдагдсан газруудад тогтмол үзлэг, шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүрт нь арилгуулах арга хэмжээг авч байдгаараа онцлог. Урьдчилан сэргийлэх байгууллага ямар нэгэн байгууллагыг шалгаж, зөрчил илрүүлээд тухайн байгууллага болон албан тушаалтныг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр буруутгаж ичгэвтэр байдалд

оруулахыг зорилго болгодоггүй. Харин нөхцөл байдлыг сайжруулах, алдаа дутагдал арилгахад гол зорилгоо чиглүүлдэгээрээ ХЭҮК-той адил байгаа.

-Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний байгууллага байгуулан амжилттай ажиллуулж байгаа орнуудын ойрын жишээ юу байна?

-Ази, Номхон далайн орнуудаас эрүүдэн шүүхийн эсрэг нэмэлт протоколд нэгдэн орсон улс цөөхөн байгаа. Гэхдээ энэхүү конвенцод нэгдэн ороод эрүү шүүлтийн эсрэг үндэсний байгууллагаа байгуулчихсан орны жишээг хуваалцъя. Үүнд Шинэ Зеланд, Мальдив, Камбож зэрэг улсыг дурдаж болно.

Мальдив Улсын эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний байгууллагатай Монгол Улс нэлээн төстэй байдлаар үйл ажиллагаагаа эхэлж байна. Хүний эрхийн Үндэсний Комисс нь урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлээд явж байна. Хүний эрхийн Дээд Комиссар Нави Пиллай Мальдивт айлчлах үеэрээ тус улсад урьдчилан сэргийлэх үндэсний байгууллагыг нь байгуулж өгсөн байдаг. Түүний дараа тус улсад эрүү шүүлтийн асуудлаар судалгаа хийж үзэхэд эрүүдэн шүүх явдал эрс багассан гэдэг нь тогтоогдсон. Дараагийн жишээ гэвэл шинэ Зеланд Улс. Тус улсын урьдчилсан сэргийлэх байгууллагыг нэг биш олон байгууллага хамтран хэрэгжүүлдэг. Гол зохицуулалтыг хийж, зангиддаг байгууллага нь хүний эрхийн үндэсний байгууллага нь байгаа. Зүүн өмнөд Азийн орнуудаас эрүү шүүлтийн эсрэг нэмэлт протоколд нэгдэн орсон орон байхгүй. Гэхдээ урьдчилан сэргийлэх байгууллага байгуулах талаар, идэвх зүтгэлтэй ажиллаж байгаа улс бол Индонез. Хэдийгээр тус улс нэмэлт протоколд нэгдээгүй ч бэлтгэл ажлаа маш өндөр түвшинд хангаж байна лээ. Би өнгөрсөн долоо хоногт тус улсад айлчилж үндэсний хэмжээний томоохон хуралд оролцсон. Маш их үр дүнтэй хурал болсон гэдгийг энд онцолж хэлмээр байна.

-Ярилцсанд баярлалаа.

Ярилцсан: Хүний эрхийн Үндэсний Комиссын хэвлэл мэдээлэл, сурталчилгаа хариуцсан ажилтан С.Будрагчаа

Тэмдэглэл

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



UIN.MN
СУДАЛГААНЫ САН

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс
Тусгаар тогтнолын талбай, Засгийн газрын XI байр, Ү давхар
Утас: 266506, 262902, Факс: 976-11-320284
Цахим хаяг: www.mn-nhrc.org, Цахим шуудан: info@mn-nhrc.org
Иргэдээс гомдол хүлээн авах,
хууль зүйн зөвлөгөө өгөх утас: 7000222

ISBN 99973-43-86-7

